

Алсаас дуурсагдахуй нутгийн минь анир

Архангай аймгийн Батцэнгэл сум
байгуулагдсаны 90 жилийн ойд зориулав.

НОГООН ДЭВТЭР

Зургаадугаар цуврал

**Эх болсон төрсөн нутгийнхаа сав орчлон, шим амьтны
үүсэл гарвалын алсаас дуурсагдах анирыгсонордсоноо
дээдлэн сүсэглэж ногоон торгоор баринтаглан
дэвтэрлэж олонд хүргэж буй Монголын Бурханы
Шашинтаны Төв Гандан хийдийн гавж Доктор, РН/D
нэрийг зүүгч Ц.Отгонбаяр**

Улаанбаатар, 2016 он

Хянасан: Ц.Бямбаа
Д.Саруул
П.Яньдий
П.Цэвэгмид
Г.Жалсрайжамц

Эх бэлтгэсэн: О.Ширавжамц
О.Ширавсингэ
Ж.Дагийжанчив
Ч.Мандалсүрэн

Printed for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ	6
ДАЙР БОР ХАЙРХАНЫ ТАЛААР ДУРЬДВААСУУ	11
МОНГОЛ ОРНЫ САН УНШИХУЙ.....	15
ДОЛООН БУРХАН ОДНЫ ТАХИЛГА.....	39
ХҮННҮ ГҮРНИЙ ТУХАЙ АРХЕОЛОГИЙН ОЛДВОР ТҮҮХИЙН ЭХ СУРВАЛЖААС МИНИЙ ТӨРСӨН НУТАГ, ХҮННҮ ГҮРЭН БОЛОН ЭЗЭНТ УЛСЫН ГАЛ ГОЛОМТ БОЛОХ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ АНУУ:	45
АЛТАН УРГИЙН ХААДУУД.....	59
АЛТАН ОРДНЫ ХААДУУД.....	62
ЦАГААДАЙН ХААНТ УЛС.....	63
ИЛ ХААДУУД.....	66
ЮАН УЛСЫН ХААДУУД	69
ХАЛХЫН САЙН НОЁДУУДЫН ЗАЛГАМЖ ВАН ГҮНГҮҮД	79
АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ГУРВАНТАА СУУРЬШСАН ИХ ХҮРЭЭНИЙ НҮҮДЭЛ	98
САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ҮЕ ЗАЛГАМЖЛАХ ВАН ГҮНГҮҮДИЙН БАС НЭГЭН БАРИМТ СЭЛТИЙГ ЖАГСААН БИЧВЭЭС ҮҮ.....	103
САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ХОШУУДЫН ЗАСАГ НОЁДЫГ ХҮСНЭГТЛЭН ҮЗҮҮЛБЭЭС.....	152
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ХУВААРЬ.....	165
ЗАЯГЭГЭЭН ЛУВСАНПЭРЭНЛЭЙН 365 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ХИЙСЭН ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ ДЭЭР ТАВЬСАН ЛАМ Ц.ОТГОНБАЯРЫН ИЛТГЭЛ	169

АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХАРЪЯАЛАГДАХ ШАШИН СҮМ ХИЙДИЙН БАЙРШИЛ /1990 ОНООС ХОЙШХИ БАЙДЛААР/.....	179
АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХАРЪЯАЛАГДАЖ БАЙСАН ШАШИН СҮМ ХИЙДИЙН БАЙРШИЛ /1937 ОНЫ БАЙДЛААР/	221
МИНИЙ БУУРАЛ АБУУ МИНУУ. Намтарчилсан баримтат найраглал.....	256
ТБАЛЖИРЖАНЦАН “МӨСӨН ШАГАЙН ХАРВАА” ШҮЛЭГ	313
АГУЙТ ХАЛЗАН ХАЙРХАН.....	315

Өглөгийн эзэн нутаг амьтай, төрийн түшээ,
Эрүүл мэндийн яамны төрийн нарийн
бичгийн дарга

АЮУРЗАНЫ ЭРДЭНЭТУЯА

ТОВЧ ЦАДИГ



БОЛОВСРОЛ:

- 1989 онд Анагаах ухааны дээд сургуулийг Хүний их эмч мэргэжлээр;
- 1998-2000 онд Удирдлагын академийг Төрийн удирдлагын арга зүй-зохион байгуулалт мэргэжлээр төгсч, Төрийн удирдлагын менежер цол;
- 2003-2005 онд Удирдлагын академид Төрийн удирдлагын магистр цол;
- 2003-2006 онд “Нийслэлийн хүн амд үзүүлэх хоёрдогч шатлалын эмнэлгийн тусламжийн өнөөгийн байдал, хэтийн төлөв” сэдвээр докторын зэрэг;
- 2007-2010 онд Үндэсний Тагнуулын академийг Эрх зүйч мэргэжлээр төгсч, Хууль зүйн ухааны бакалавр цол;
- Эх барих эмэгтэйчүүд, Хэт авиа оношлогоо, Эрүүл мэндийн удирдах ажилтнаар мэргэшсэн, Клиникийн профессор, Эрүүл мэндийн удирдлагаар Зөвлөх зэрэгтэй.

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1988-1989 онд Архангай аймгийн Нэгдсэн эмнэлэгт эмчээр;
- 1989-1996 онд Дорноговь аймгийн Цэргийн госпитальд Эх барих эмэгтэйчүүдийн эмч, тасгийн эрхлэгч;
- 1996-1998 онд Зэвсэгт хүчний Клиникийн төв эмнэлэгт Цусны станцын дарга;
- 2001-2013 онд Сонгинохайрхан Эрүүл мэндийн нэгдлийн дарга;
- 2013 оны 07 сараас Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалтын асуудлаар ном, гарын авлага, өгүүлэл, илтгэл зэрэг эрдэм шинжилгээний 60 гаруй бүтээлтэй. Төрийн түшээ, их хатдын залгамж халаа, эх нутаг нь элэг зүрхнээс нь уяатай байдаг эрхэм түшээ танд уншигч түмнийхээ өмнөөс чин сэтгэлээсээ баярлаж талархсанаа илэрхийлж байна.

М.Б.Ш.Т.Гандан хийдийн гавж нэрийг зүүгч Ц.Отгонбаяр

ӨМНӨТГӨЛ

Дал гаруй сая жилийн тэртээ хүмүүн төрөлтөн үүссэн гэж эрдэмтэд үздэг гэтэл тэр газар нь хаана вэ гэвэл биднийг өлгийдэн буй монгол газар шороог нэрлэдэг яалт ч үгүй тэр үеийн хүмүүсийн эд өлгийн дурсгалаар батлагддаг бол өнөө гайхамшигт үлэг гүрбэлийн эрин үе бас л энд байсныг өндөг, яс дээр нь хадан дээр гишгэж үлдээсэн үлэг гүрвэлийн мөр нь хүртэл өмнөговь аймагт одоо болтол зурайж харагдсаар байгаа билээ. Үүнтэй сацуу эртний хүмүүсийн хадан дээр үлдээсэн янз бүрийн сүг зургууд өөр оронд ховор байдаг ба бас л манайд олон байгаа нь эртний хүмүүсийн гал голомт нь ямар ч эргэлзээгүй монгол орон минь билээ.

Бурхан багшийн айлдсан Очирбээр огтлогч хэмээх их хөлгөн сударт:

Өндгөн ээцээс төрөгсөн ба

Умайн ээцээс төрөгсөн ба

Зөөлөн дулаан ээцээс төрөгсөн ба

Хувилаж төрөгсөн ба

гэж орчлонд төрөх хамаг амьтныг дөрөв ангилдаг шиг үйл буяныг эрхээр замбуулин тивд төрөхдөө хамгийн түрүүнд их азийн өндөрлөгт хүмүүн буй болжээ.

Цунами болдоггүй цул нутаг катарина болдоггүй алтай хангайн их нуруугаар хашигдсан, хавар намар өвөл зуны дөрвөн улирал ээлжлэн буй, халуун болж хойд мөсөн далай хайлсан ч хамгийн сүүлд усанд автах өндөрлөг газар болох ба зурхайн онолоор бол шороо, гал, хий, ус, төмөр, мод гэх таван махбодиос гал махбодийг нь авч нүүрэндээ галтай нүдэндээ цогтой хувьтай төрсөн бидний халуун элгэн нутаг минь билээ. Иймээс энэхүү нутгийнхаа сав шимийн талаар чухас төдий ч гэсэн дурьдах нь миний үүрэг гэж бодоод уншиж сонссоноо үр ач хойд үеийнхэндээ үлдээх маягаар

Би баатар боловч нэгэн үеийн баатар,

Бичиг баатар болвоос мянган үеийн баатар гэх цэцэн үг болон Агуу Эрдэмтэн алагшаа нутгийн Дандар лхаарамбын айлдсанчилэн :

Эмч эмч гээд өвчтөнийг оношлоод өгөх эмгүй бол ямар эмч гэхэв дээ

Номтой номтой гээд ноороглож үлдээн өвлүүлээгүй бол ямар эрдэмтэй гэхэв гэдэг шиг эрдэм авъяасгүй ч гэсэн оролдож зүтгэл гаргаж буйг болгоон соёрхоно уу.

Сайн бүгдийн эхлэл болох сайн цагийн мянган бурханы дөнгөж

нийтийн ёсоор бол Дөрөвдүгээр одоо цагийн Бурхан Шагжтүв заларч буй цаг гэх ба түүнээс 2500 жилийн өмнө Замбуулинд заларсан өнгөрсөн цагийн Бурхан болох Санжа-Одсүрэнгийн талаар түвдийн эрдэмтэн Лондол ренбүүчигийн нотлон бичсэн Цагийн хүрдний номлол замбуулинд дэлгэрсэн түүх хэмээх сударт Өмнөд энэтхэгийн карнатака мужийн амрападийн Балдан брайбун суварганы түүх өгүүлэхүйд энэхүү суваргыг Санжаа Одсүрэн Бурханы үед зохиогдсон болохыг тайлбарлан гаргасан байдаг нь Бурханы шашин өнө эртний уламжлалтайг харуулж байгаа ба энэ үеийн дурсгал ч мөн завхан аймгийн нутгаас монголын үндэсний олон нийтийн телевизийн гараг нэгтгэлийн захирал эрдэмтэн Г.Бадамсамбуу бээр Бурхан багш Шагжтүвийн ном номлохоос өмнө энэтхэг орон бүхэлдээ хойд зүгийн ари буюу гал махбодьтой үндэстэнгүүдийн Ведийн шаштир дэлгэрсэн кастийн системтэй байсан энэхүү номлол Ведийн шастирыг Энэтхэгийн түүхийг дөрвөн том дэвтэрболгон бичсэн Эрдэмтэн Радхакришни болон Эрдэмтэн Вангорд Левин нар судлан батлан гаргасан байдаг.

Тэрхүү гол махбодьтонгууд нь монголчуудын өвөг Тэнгэр язгуурт Вархман буюу Бярман, Кшастра буюу Хааны язгуур цэргийн жанжид түшмэлүүд, Вайшика буюу Худалдаач, Гар урчуул тариачдын язгуур, Шутра буюу Боолын язгуур гэж ангилж байсныг гэрчлэх хадан дээрхи Бярман, Хаан, Худалдаачин, Боолын сүг зураг олдсон нь Тэдгээр кастийн систем Ведийн шастирыг дэлгэрүүлэгчид манай дээдэс гэдгийг дэлхий дахинаа нотлон харуулж байгаа билээ. Энэтхэгийн түүхчид ч манай түүх монголчуудтай холбоотой гэдгийг хүлээн зөвшөөрч орчин үеийн ДНК-ийн шинжилгээгээр ч гэсэн угсаа гарал нэгтэй нь нотлогдон гарсан байдаг. Монголчуудын энэтхэгт үлдээсэн гурван цаг үеийг харуулсан эд мөрийн баримтыг дурьдбаасуу:

Анхдугаарт:

Могол хэмээх энэтхэгийн хойд хэсгийн үндэсний цөөнхийг хэлж болно. Монгол гэдэг үгийг эрдэмтэд янз бүрээр тайлбарласан байдаг хамгийн дөхүүлсэн тайлбарыг Эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн Мөнхгал буюу гал махбодьтой аричүүдийг хэлж байгаад үг сунжирсаар утгаа алдалгүй монгол болсныг баталсан нь миний сэтгэлд нийцсэн тайлбар болсон. Мөн дахин нэг баримт хэлбэл Бурханы багшийн эрхэм хоёр шавь Монголжибүү, Шаарийбүү хоёрын Монголжибүү нь монгол хүний хөвүүн гэж орчуулагдан тэр ч утгаараа амьдарч байсан бодит хүмүүн бөгөөд Бурхан багшид өргөл хүндлэл ихээр үзүүлсний буянаар монгол хүмүүн амны хишигтэй яваа бөгөөд орчлонгийн мандан бууралтай салшгүй холбоотой идэвхитэй байр суурь үзүүлсээр ирсэн. Энэ нь нэг

үхрийн эвэр дэлсвэл мянган үхрийн эвэр доргидогтой адил нэгэн хүмүүн монголчуудын төлөө буянаа зориулснаар өндөр дээд төрөлтөн болсон гэж ном зохиолд олонтаа гардаг билээ. Эдгээр үндэстний нэг онцлог бол гал шүтдэг бөгөөд галаа манаж унтраалгүй одоо болтол тахиж байгаад оршино. Тэд урт том нүүрсэн чулуун модыг асаан газарт булж шинийн нэгнээс арван таван хүртэл тасралтгүй уйгуулан сахидаг бөгөөд арван таванд гарган авч милха буюу галын баяр хийн дахин өөр шинэ мод газарт булан уйгуулсаар ирсэн жинхэнэ галч галын хаадууд юм. Жишээ нь Монголчууд Одхан хөвгүүнээрээ гал голомтоо сахиулдаг хууль дүрэмтэйг ч бид мэднэ.

Их богд Чингис хаан одхан хөвүүн Тулуйгаараа голомтоо сахиулснаар ойлгож болно. Миний нэрээр жишээ аваад үзэхэд ОТГОНБАЯР гэдгийн эхний Од гэдгийг эрдэмтэн О.Цэвэл ОТ гэхгүй ОД гэнэ гээд энэ нь гал гэсэн үг гээд тайлбарлахдаа эрт дээр гал үгүй үед тэнгэрээс од харваад бидэнд гал бэлэглэсэн гэж тэнгэр мод ниргээд гарсан их галыг унтраалгүй бага хүүхдээрээ сахиулж өөрснөө ан авдаа явдаг байсан. Иймээс Од гэдэг нь гал ба түүн дээр ХААН гэсэн үг нэмж ГАЛЫНХААН буюу ОДХАН гэж нэрийдсэн ба сүүлийн үед мила буюу галын баярыг нэмж ОДХАНБАЯР гэх болсон гэж тайлбарладаг Эдгээр могол язгуурын энэтхэгийн үндэсний цөөнхүүд өөрснийгөө монгол гэж нотлохыг оролдохоос гадна ганц нэг зул гэх мэт монгол үг хэллэгтэй хүмүүс эрт үеийн монголчуудын угсаа үндэс мөнөөр тогтохгүй урьд түүхийн баримт болж байна.

Хоёрдугаарт:

Кастын системийг үндэслэгч ведийн сургаалийг дэлгэрүүлэгчид нь өвөг дээдэс болох гал махбодьтой аричүүд байсан бол түүний дараа бурханы шашин энэтхэгт дэлгэрч Ашока тэргүүт номын хаадууд шашинд орж эрчимтэй дэлгэрч байгаад таван зуун жилийн дараа Вавур, Аквар тэргүүт монгол язгуурын хаадууд энэтхэгийг эзлэн авч ноёрхлоо тогтоож улмаар шашин соёл нь өөрчлөгдөв. Үүнийг бурханы шашинтангууд лалын аян дайн гэж нэрлэж байв.

Тэд байлдан түрэмгийлэхээс гадна Өрнө дорнын соёлыг нэгтгэн том эзэнт гүрэн байгуулж, мусилмаан, хиндү, Бурханы шашинтнуудыг нэгэн дор зангидаж байв. Түүний тод жишээ ул мөр бол тэр үед ирж суурьшсан энэтхэгийн хүн амын гучин хувийг дангаараа бүрдүүлж буй мусилмаан лалын шашинт ард түмэн бодитойгоор оршиж байгаа нь Манай Хувилай хаан хятадад дундад азиас хар ажилчин авчирч суурьшуулан эртний хятадын гурван улсаас үүдэлтэй үндэс язгуурыг нь сольсон мэт боловч орчин үед техникийн дэвшил онгоц, машин, компьютер зэргийг орон бүхэн авч ашигладаг шиг тэдгээр муслаам хаадууд тэр үеийн дэвшил болох

ажилчин ангийг буй болгож гадны уран дархчуулыг энэтхэгт суурьшуулан улс хоорондын соёлыг ойртуулж байжээ. Түүний бас нэгэн жишээ бол Дэлхийн долоон гайхамшгийн нэг Монгол угсаат Шагжаа хаан хатандаа зориулан босгосон Тажимахалын хэзээ ч давтагдашгүй уран барилгын хосгүй гайхамшгийг хэлж болно. Тэд энэтхэгийг эзлэн түрэмгийлсэн ч гэсэн дэлхийд хосгүй соёлын өвийг түгээсэн билээ.

Гутгаар нь:

Эзэн Чингис богд болон түүний залгамж хаадуудын үед хамрагдах энэтхэгийн хойд жаму кашмир муж ладакийн өндөрлөгт үлдсэн хоёр бөхөт монгол хүн харахаараа нулимс унагаад ч байгаа юм шиг байдаг монгол тэмээн сүргийг хэлж болно. Тэдгээр нь эзэн богд Чингис хаан болон түүний үр удмын хаадуудын цаст гималайн уулсыг эр зориг гарган атан тэмээтэй давсан түүхийн баримт болно. Ер нь эх дэлхийн таван тивийн өөр хоорондоо зүс царай болон ёс заншил харилцан адилгүй хүмүүн төрөлхтөнийг махбодиор нь ангилдаг монгол язгуурын хүмүүсийг гал махбодтой гэх ари үндэстэн гэдэг ба бөгсөн дээрээ хөх толботой төрдөг юм. Эдгээр гал махбодтой буюу манайхны хэлдгээр нүүрэндээ галтай нүдэндээ цогтой монгол төрөлхтөн бусад усан махбодтой гэх орос европ, шороон махбодтой гэх хятад, хийн махбодтой гэх африкууд тус тусын махьбодийн онцлогтой байдаг.

Жишээ нь усан махбодтой орос хүмүүс төрхөөсөө аваад усанд дуртай тэндээс хүч тамир нь сэлбэгддэгээс гадна усны бүх төрлийн хүнсэнд дуртай наад зах нь оросууд архи уугаад шартдаггүй хол замд яваад амрахдаа заавал усны захад юмуу нам дор газар зогсдог гэх мэт бол Шороон махбодтой хятад хүмүүс өдөр их унтаж нарны энергийг шингээдэг ба үргэлж ус, хар цай уухаас гадна тослогтой зүйл харшилдаг, учир нь тос шороон махбодийг задлах түлхүүр болдог ба газар шороотой амь амьдралаа нягт холбосон байдаг.

Африк тивийн ямайка мэтийн үндэстэнгүүд хий махбодид хамрагдах ба тэд махбодийн онцлогоос шалтгаалан хөнгөн мөн амархан ядардаг ч түргэн сэхэл авч чаддаг байна дэлхийн ойрын зайн гүйлтэнд одоо болтол дэлхийн рекордийг эвдсээр байгаа ямайк нар цуцаад хэдхэн агшин дотор ахин сэхэл авч чаддаг онцлогтой учир барианд сааралтгүй гүйж чаддаг гэж эрдэмтэд тогтоосон байдаг.

Эдгээр хүмүүсээс гал махбодьтонгууд бусдаасаа илүүрхсээр ба энэхүү дэлхийн мандал бууралтай салшгүй холбоотой байдаг. жишээлбэл гарамгай жанжин удирдагчид бүгд л ари гаралтай байна Хамгийн эхний түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн хүн бол Бурхан багшийн эрхэм шавь архад Монголжиибүү буюу Монгол хөвүүн болой.

Түүний дараагаар Хүннүгийн их Модун хаан, Европ тивд Тэнгэрийн ташуур Атилла Ортойз хаан (Атилла гэдэг нь Хаантай адилхан эрхтэй гэсэн үг ба ижил мөрөнг бас л монголын маань мөрөнтэй ижилхэн гэж ийн нэрлэсэн гэдэг бол Ортойз гэдэг нь хайнаг сарлагын эрлийз ортоом гэдэг шиг европийн цагаан хүннүчүүдийг монгол, европийн эрлийз ортойз гэж нэрлэх олон эрдэмтэд байдаг) Мөнхүү эзэн Чингис хаан,Түүний удам дамжсан алтан ургийн хаадууд, Чойжи одсэр Өндөр гэгээн,Зая гэгээн, Ламын гэгээн зэрэг номт мэргэд,орчин үежүүлэх юм бол Эверестэд анхлан гарсан ширваа Дэнзэнноргио,Марксизмын онолыг үндэслэгч Маркс,түүнийг амьдралд хэрэгжүүлэгч В.И Ленин, Наполеон жанжин, А. Гитлер зэрэг нь дэлхийн хүмүүс бөгөөд бүгд ари үндэстэн бидний өвөг дээдэс болох нь нотлогдсон байдаг. Бидний өвөг дээдэс маань Дэлхийн түүхийг эхлэл болох юмуу оройлон түүх бичилцсээр ирсэн гайхамшигт замналтай. Түүхээ мэдэхгүй бол ойд төөрсөн сармагчин лугаа адил хэмээн үзэж аль болох төрсөн нутгийнхаа үүх түүхийг энд тэндээс эмхэтгэн үзэж дуулснаа цуглуулан бичсэн төдийхнөө та бүхэнд толилуулж байна.

М.Б.Ш.Т.Гандан хийдийн гавж нэрийг зүүгч Ц.Отгонбаяр

ДАЙР БОР ХАЙРХАНЫ ТАЛААР ДУРЬДВААСУУ

Анхны домог нь Эрт дээр цагт тоглохын талд наадам хийгээд олон хошууны нэртэй сайн хүлэг морь уралдсан том бат оршил наадам болж, тэрхүү наадамд хэн ч тоохгүй даахь дайртай өвгөн ноёны бор морь түрүүлэн ирж нутаг хошууныхаа нэр алдрыг өргөж алдаршуулж байгаад нас эцэс болоход нь түүний толгойг олон мэргэд шинжин үзэж энэхүү толгойг морины эзэн хаянхирваа бурханы орон хэмээн залж Дайр бор хайрхан хэмээн тахисаар ирсэн домог байдаг бол

“Монголын нууц товчооны-барим эх 1” хэмээх эрдэмтэн Чи.Үнэнч, Ч. Түмэнбаяр нарын тайлбарласан толь бичгийн 44 талд Харчугийн хөвгүүн Боржгиндай мэргэн, Монголжингоо гэргий дуу а зуу Боржгиндай мэргэний хөвгүүн Торголжин баян, Борогчин хоо гэргий, Боролдой соёлби залуу дуу дайр, бор хоёр хүлэг агтас дуу бөөөөөл эг. Торголжины хөвгүүн Дуу аа сохор, Добу мэргэн хоёр бөөөөөл эг хэмээн бичигдсэн нь Эзэн Чингис богдоос өмнө үеийн хамаг монгол магадгүй хүннүгийн үед хамрагдаж болох бичгийн дурсгалаас авч үзвэл манай өвөг дээдсийн хийморь тахилгын газар байж ч болох талтай. Яагаад гэвэл Архангай аймаг тэр тусмаа манай нутаг хүннүгийн өвөг дээдсийн голомт болохыг археологчид түүхчид баримтаар нотолсон учир өнө эртнээс шүтэгдэж ирсэн өвөг дээдсийн минь шүтээн хайрхан билээ. Энэхүү хайрхандаа зориулж түвд хэл дээр тахилгын судар зохиож Дээрхийн гэгээнтэн Далай багшийн дэргэдэх намжил дацангийн хансүр, Жүдо дацангийн хамба аграамба лхаарамба Жадоренбүчи багшаар ариутган шүүлгэсэн энэхүү судрыг та бүхэнд толилуулж байна.

	<p> བ་འདེབས། །སྦྱིན་སོགས་བགྱིས་པའི་བསོད་ནམས་ལ། །མ་རབས་ལྷགས་པོར་ཡ་རབ་ ལྷོད། །སྦྱིན་བདག་བགྱིས་པའི་མི་མང་རྣམས། །ཚེ་རིང་བར་ཚད་མེད་པར་ཤོག །དེ་ རིང་འདིར་འདུས་འགྲོ་བ་རྣམས། །ཚེ་བསོད་དབང་ཐང་ལོངས་སྦྱོད་སོགས། །ཤོར་ནས་ ཤོང་དུ་འཕེལ་བ་དང་། །བསམ་དོན་འགྲུབ་པའི་བཀྲ་ཤིས་ཤོག། །། ། རེ་པོད་རེ་བོ་རའི་གསོལ་མཚོད་ཞེས་བྱ་བ་འདི་ནི་སོག་ལུའ་གྱི་ནང་བ་སངས་རྒྱལ་གྱི་དབུ་ལས་ཁྱེད་ཀྱི་དགའ་ལྷན་ ཐེག་ཚེན་གྱི་དགའ་ལྷན་ལ་བཏུ་མིང་འཛིན་པ་འོད་ཉང་པ་ཡར་གིང་གི་རྟེ་ལོ་ཡོས་ལྷོ་པའི་ཚེ་ཧཱ་ཉིན་ཤེ་ནས་རྒྱ་གར་ </p>	4
--	---	---

བསྐྱེད་པོ།	<p> །། །འཕགས་པའི་ཡུལ་དབུ་ལ་ལྷན་རྒྱུད་སྦོད་གྲུ་ཚང་གི་སྒྲ་མ་དཔུམ་མཛད་བྱུང་དོ་མིན་པོ་ཚེ་མཚོག་གིས་བྱིན་རླབས་ ལྷུང་ག་གནང་བ་ཡིན་ལོ། །དག་ལེགས་འཕེལ། ཨ </p>	5
------------	---	---

МОНГОЛ ОРЧУУЛГА АНУУ

Урьд эзэн Чингис богдийн үед
Уралдаанд түрүүлж ирсэн морины
Одоо болтол нэр нь дуудагдсаар
Онгон дайр бор хэмээн алдаршив
Хангай нурууны салбар уул
Хаянхирваа Бурханы залрах орон
Хойд урьд тамир нийлэх бэлчир
Хувьтай монголын тахилын шүтээнд
Гадна тахилаа өмнө нь дэлгэе
Гагцхүү сүжгээр сэтгэлээ барья
Дээдийн идээ дэлхий дүүрч гэж
Дэлгэр сүсгээр мөргөн үйлдэе
Урьдын хураасан муу үйлээ
Умарталгүй бүгдийг санан номончилж Хойшдоо бүтээх
буян үйл дор
Хотлоороо баясан залбирч талбие
Өглөг өгөхийн агуу буянаар
Өөдгүй бүгдийг орхин сайжирч
Өглөгийн эзэн нөхөд бүгдийн
Өнөд барцадгүй наслах болтугай
Өнөөдөр энд цугларсан түмний
Өлзий хутаг төгс эдлэл дэлгэрч
Үеийн үед арвижсаар байхын
Үлэмжийн санаа нь дэлгэрэх болтугай

МОНГОЛ ОРНЫ САН УНШИХУЙ

ИТГЭЛ- Бурхан ном хийгээд чугуулганы дэгээд дор бодийн хутагийг олохуй хүртэл би бээр итгэмой (3 удаа уншина). Миний өглөг тэргүүтэн эдгээр бээр хамаг амьтаны тусын тулд бурхан бүтэх болтугай.(3 удаа уншина).

Хамаг амьтан амгалан хийгээд амгалангийн шалтгаан лугаа төгөлдөр болтугай.Хамаг амьтан зовлон хийгээд зовлонгийн шалтгаан лугаа хагацах болтугай.Хамаг амьтан зовлон үгүй амгалан лугаа үл хагацах болтугай.Хамаг амьтан ойр хол уурлах дурлахаас хагацаж тэгш дор орших болтугай.

ГАНДАНЛХАВЖАА- Буюу төгсбаясгалант зуун тэнгэр

Намо Гүрү Манзугохаяа

Төгсбаясгалантын зуун тэнгэрийн итгэлийн зүрхнээс

Маш цагаан шинэ тараг овоолсон мэт үүлийн үзүүрт

Номын хаан Бүхнийг айлдагч Сумадигирди

Хөвгүүд лугаа сэлт энэ орноо залран соёрх

Өмнийн огторгуйд арслант ширээ,лянхуа,сарны дээр

Гэтэлгэгч лам баясгалангийн цагаан мишээлтэй

Миний оюун сүсгийн буяны дээд орноо

Шашныг дэлгэрүүлэхийн тулд зуун галавт оршин соёрх

Мэдэгдэхүүний эн бүхнийг мэдэгч оюун таалалтай

Сайн хувьтын чихний чимэг болсон сайн

номлол зарлигтай

Алдаршлын цогоор үлэмж үзэсгэлэнт лагшинтай

Үзэн,сонсох,дурдахуйн хэргийг төгсгөсөнд мөргөмүй

Сэтгэлд зохистой элдэв тахилын усан, цэцэг хийгээд

Анхилуун үнэрт хүж, зул, үнэрт усан тэргүүтэн

Бодитой бэлтгэсэн, сэтгэлээр хувилгасан тахилын

үүлэн далай үүнийг

Буяны орны дээд тань дор тахил болгон өргөө.

Алин бээр тэргүүлэш үгүй цагаас хураасан

Бие,хэл,сэтгэл нүгэл юун үйлдсэн хийгээд

Ялангуяа гурван санваарын үл зохилдохуйн зүгүүдийг

Зүрхнээс хатуу гэмшлээр тус тус наманчилъя

Цөвүүн цаг үүнээ олонтаа сонсоод бүтээл дор хичээн

Найман номыг тэвчихээр чөлөө учралын хэргийг хийсэн

Итгэл таны ахуй их зохионгуй дор
Ба бүрэн саналын угаас даган баясмуй.
Гэтэлгэгч лам дээдэс та нугуудын
Номын биеийн огторгуйд айлдал энэрлийн үүлний үзүүрт
Ямар мэт зохистой номхотгогдохууны газар дэлхийд
Аяндаа бүтсэн номын хурыг буулган соёрх.
Би бээр хэдий чинээ хураасан буян үүгээр
Шашин амьтан бүхнээ алин туслах хийгээд
Ялангуяа Гэтэлгэгч Сумадгирдийн
Шашны зүрхэн өнөд гийгүүлэх болтугай

МОНГОЛ ОРНЫ САН

Би ямагт нэгэн эгшин дор нэг нигуурт хоёр мутарт Арьяабал
бурхны дүрийг эрхшээмой.

Ариусгалын тахил балан гадаад дотоод нууцын
Агуу сүсэгтнүүдийн мөнхийн мэлмийг дүүрч
Цувралтгүй билэг билгийн рашааны усан далай
Цалиглан давлах тахил мэт болтугай.

Умаа хум Умаа хум Умаа хум

Аяа агуу хүчит бүрэг хангай хийгээд
Алдарт бүрэн Орхон Сэлэнгэ мөрөн
Асарлах уул урсах ус бүхнээ оршсон
Ачит их навдаг шавдаг бүгдийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Онон Алтай хавийн их уулс ус
Олноо алдартай Увс их арал тэргүүт
Ихэнх уул усан бүхнээ оршсон
Илч этгээдийн хамаг шадвагийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Хэнтий улаан сүрэг болон
Хэрлэн Туул Хөлөн тэргүүт
Догшин уул усан бүхнээ оршсон
Дорно зүгийн шавдаг бүхнийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Аяа
Умар зүгийн монгол орны их сүлдэн тэнгэр
Уул хангай ханы дөрвөн их тэнгэр
Эх хөвгүүн гадаад дотоод түшмэл
Элчис үйлчний нөхдийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Бас бус дөрвөн зүг найман зовхисын
Бараантан шовхрох их хайрхан
Ус гол их мөрөнд оршсон
Улс орны тэнгэр шавдаг хамгийг ариусгая
Умаа хум Умаа хум Умаа хум
Ялангуй ба бүрний нөхөр сэлт
Ямарваа шүтээн мөр үйл хамаг гуравнаа
Алинд ч оршсон энэ зүгийнхээ
Алдарт орны тэнгэр хамаг шавдагийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Хангай ханы аймагт харъяалагдсан
Хань болох Идэр Тэрх хоёр
Хас өлзийт Цагаан нуур Чулуутын
Хамаг шавдаг орны тэнгэрийг ариусгая

Умаа хум Умаа хум Умаа хум

Даллага авах

Хоёр түүтгэрээс ариуссан номын шим
Хэлбэрэлт үгүй бат бүхний суурь
Өндөр үгүй бат бүхний суурь
Өнөөдрийн эдээр даллан авъя

Хурай Хурай Хурай

Ариун огторгуйн төв хүчнээс
Алаглах солонго зуран хээлсэн мэт
Өмнүүрхэн ургах хишиг бүгдийг
Өнөөдрийн эдээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Асар арвин төгс долоон эрдэнээр
Аварга их тивүүдийг эрхшээгч
Өнхрөх хүрдийг эрхшээгч хишгийг
Өнөөдрийн эдээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Олноо өргөгдсөн хаанаас эхлээд
Оргил эхт Гангын урсгал мэт
Өнөд үргэлжлэх хишиг буяныг
Өнөөдрийн идээр даллан авмуй

Хурай Хурай Хурай

Гурван сургаалийн ёзоорыг баригч хөвүүн
Гунхашгүй мөчрийн үзэсгэлэнт нахиа
Хоёр зэргийн эцэст хүрсэн үрээр

Хосгүй үзэсгэлэнт төгс номын хишиг ба
Үхлийн эзний аймгийг ч ялсан
Үхэлгүй бүтээх насны хишиг
Өнөд оршоох буян заяаг ч
Өнөөдрийн эдээр даллан авмуй
Хурай Хурай Хурай

ГЭГДОР БУЮУ СААД ТОТГОР УЧ РУУЛАГЧДАД ӨРГӨХ ТАХИЛГА.

Нэгэн агшинд би бээр гурван ертөнцийг эзэгнэх хилэнт дүрийг
эрхшээмой

Өөрийн тааллын ХУМ үсгээс гэрэл цацарч хилэнтийн
чугуулганыг урин залж өмнийн огторгуйд оршоомой

УМ -БАЗАР -МАХА- ГОРДО- РАЗА- СА-ВА-РЭ- ВА-РА-
БАЗАР-СА-МАЯ -ЗА-ЗА
ХУМ -

Билиг билгийн галтгуу бадран очлоод

Бараан мунхаг хүсэл бүгдийг шатаагаад

Уурт хилэнт аюул бүгдийг дарж

Ухаант баатар алдраа дурсгаж

Буруу тэрсүүдийг барин номхотгож

Бурханы язгуурт дийлэн мөргүүлж

Номхорсон тэрсүүдийг дахин залж

Ном ёсчилон тахил өргөмү

УМ-БАЗАР- МАХА -ГОРДА- РАЗА- СА-ВА-РЭ -ВА -РА-

САДА-ГАРАМ- АРГААМ -БРАЙДИЙН -ЗА -СУХА Дахин

зүйж уншихуй

АРГААМ,БААДЭЭМ,ВҮСБИ,ДҮЙВИ, АЛОГЭ,

ГАНДЭ,НЭВДЭ, ШАВДА БРАЙДИЙН ЗА СУХА

Магтаал ануу

ХУМ

Хоосон чанар хоёр үгүйн агаараас

Хорвоогийн явдлыг ёсчилон гүйцээгч

Арга мэргэн аюунгүй лагшинг

Авир сүрээр бадраагчид мөргөмү

Билгийн амгалан тогтвортойн агаараас

Бүхий л лагшин бөх бат хүчтэй

Зарлагын лууны хүрхэрэх дуунаар
Зөвхөн эрхэндээ хураагчид мөргөмү

Хосгүй билгийн авъяасаар цэнгэж
Хорт мэс элдэвийг гартаа барин
Муу сэтгэлийг үндсээр нь таслагч
Могойн хороор цэнгэгчид мөргөмү

Галавын гал мэт бадарсан хорвоогоос
Гайхамшигт баатар мэт хөлөөр бүжигч
Нар сар бадарсан мэт хилэнт мэлмийгээр
Нааш сөрөгчдийг номхруулагчид мөргөмү

Дотоод энергээ гал мэт бадрааж
Дохих цахилгаан мэт соёоо нь гялалзаж
Аймшигт луу мэт архиран дурсгагч
Аюултайг номхотгогч таныг магтая

УМ-БАЗАР-АМРИТА-ХУМ гэж ариулаад
УМАА -САВАВА- ШҮДЭ-САРВА -ДАРМА-САВАВА –
ШҮДЭ-ХУМ гэж арвидуулаад

Хоосон чанарын агаарт УМ үсгээс гарсан их эрдэнийн сав
агуууужим нугуудын дотор УМ үсэг гэрлэн дор шингэснээс
тэнгэрийн зайгаар бүрдсэн балан идээ тунгалаг их амгалантай
үүдэх болмой. УМ-АГАРОМУ-ХАМ-САРВА-ДАРМА-НАМ-АДЪЯА-
НҮДВА-НАДДАМ-УМААХУМ-СУХА гэж гурав уншиж адислаад

Өөрийн таалалын ХУМ үсгээс гэрэл цацран хатууд оршихуйн
зан үйлд хориг саад болох бүгдийг өмнөө авчирмой

УМ-САРВА-ВИГНА-НАМА-САРВА-ДАТА-ГАДА-ВО-ЮУ-ВИ-
ШҮ -МҮХИ-БА-ЯА-САРВААН-ДАДХАМ-ҮДГАДЭ-ВАРАНА-ХЭМ-
ГАГАНА-ХАМ-СУХА

гэж гэгдорийг өөр лүгээ харуулан барьж нар зөв гурав эргүүлэн
таринаа гурав уншина

УМ-СҮМВАНИ-СҮМВАХАМ-ГЭРХАНА-ГЭРХАНА
ХУМ-ГЭРХАНА-ВАЯА-ГЭРХАНА-ВАЯА-АНА-ЯАХА-ВАГА-
ВАНА-ВИДА-РАЗА-ХУМ-ПАД гэж гэгдороо цааш харуулан нар
буруу гурав эргүүлэн таринаа гурав уншин гаргана.

Хот мандлыг газарт байгуулж
Хосгүй бурхадыг бүгд сонсон

Сахих үед маань саад бололгүй
Салаж одмой өөр газарт

Бурханы зарлигийг эс дагваас
Билигт очир бадарсанаар
Бүгдийн толгойд мэс хүрвээс
Бүртийх ч зүйлгүй болохыг санаарай

УМА-СҮМВАНИ -СҮМВАХАМ-ГЭРХАНА-ГЭРХАНА -ХУМ-
ГЭРХАНА-ВАЯА-ГЭРХАНА-ВАЯА- АНА-ЯАХА -ВАГА ВАНА-ВИДА
-РАЗА-ХУМ-ПАД

Гэж гүгэл үнэртүүлж ,юунгар цацаад хонх дуугаргана.

Дээр дор зүг бүхэнд очирлож
Дэргэд таван өнгийн гал мэт бадарч
Зай завсаргүй хүрээлэн битүүлж
Зангидсан хорлон хүрээнээс бүү хэтэр

УМ-БАЗАР-РАГЧА-РАГЧА

ТҮЙ БУЮУ УГААЛ ӨРГӨХҮЙ.

Тэгүүнчилэн ирэгсэн бурхан бүгд бээр надад илт авшиг хайрлан
соёрх хэмээбээс бурхадын таалалаас гойгарму буюу цагаан
баринтагт тэнгэр тэргүүт охин тэнгэр нугууд бээр рашаан дүүрсэн
Бумба бариад-

Тэр мэт бурхан мэндэлмэгц
Тэнгэр нугууд угаал өргөсөн адил
Тэнгэрийн ариун рашаан дор
Тэгүүнчилэн би бээр угаал соёрхоё

УМА-САРВА-ДАТА-ГАДА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-А-ХУМ
ТҮЙ буюу угаал өргөхүй

Бурханы лагшин зарлиг таалал хир үгүй ч
Бусдын бие хэл сэтгэлийг ариулахын тухайд Бурханы лагшинд
угаал өргөснөөр

Бүхий л хүмүүний сэтгэл ариустугай

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Огоот төгс лагшинт тан дор
Орчлонгийн хүлээс үгүй ч гэсэн
Адаг биднийг ариулахын тухайд
Ариун усаар соёрхол өргөө
УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-

ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ-ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА
Эрхэм бурхан шавь нугуудад
Эрдэнийн бумбандах ариун усаар
Сэтгэл зохисоор дүүргэх лус нь
Силнэнгийн дуутай хамт угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-

ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО -ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА
Өглөгийн чанарт энэ усаар
Өөдгүй хармын хирийг угааж
Өгөгдэхүүн болсон цэвэр усаар
Өөр бусдад угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-

ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ-ГО-ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА
Шагшаабодийн чанарт усаар
Шантрах муу гэмээ ариулаад
Сахилын цэвэр энэ усаар
Сахиагүй бүгдэд угаал өргөмү

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-

ААХУМ

ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ-ГО-ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Тэсвэрийн чанарт энэ усаар
Тэсэшгүй уурын гэмээ ариулааад
Асралын чанарт энэ усаар
Амьтан бүхэнд угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ - ГО - ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА
Хичээлийн чанарт энэ усаар
Хойшлуулахын залхууг арилгаад
Хичээнгүйн цэвэр рашаанаар
Хотлыг шамдуулах угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ-ГО-ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА
Самадийн чанарт энэ усаар
Саад алгасрал гэмийг арилгаад
Бясалгалын үнэрт энэ усаар
Бясалгаагүй түмэнд угаал өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ-ГО-ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА
Ухааны чанарт энэ усаар
Ухаараагүйн гэмийг арилгаж
Увидаст энэ рашаанаар
Ухааны хур буулган өргөмөй

УМАА-САРВА-ДАТА-ГАДА- ВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ
ДЭДАГ-ГҮЛА-ЦҮНВА-МЭДГИ-ГО-ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО

УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

Угаалын дээд цог төгөлдөр
Таалал ханьцасгүй энэ усыг
Билгээр адислан рашаалснаар
Бүгд хүсэл биелүүлж хайрла

УМАА-САРВА-ДАТА-ГАДА-АВЭХИ-ГАДА-САМАЯ-ШРИ-
ААХУМ
ДЭДАГ-ГУЛА-ЦҮНВА-МЭДГИ -ГО-ЗАНЛА-ДЭРАВ-ГОВА-
ГҮЧИЙН-ОО
УМ-ХУМ-ДАРАМ-ХЭРЭ-А-ГАЯА-БИ -ШОДО-НА-ЕЭ-СУХА

МАНДАЛ ӨРГӨХ ЁСОН ОРШВОЙ.

Орон дэлхийг өргөн айлтгомой. **Ум базар бүмэ-а-хум**
Их эрхэт алтан дэлхий . **Ум базар рэ-хэ а-хум**

Гадуур төмөр уулаар эргэн тойрон хүрээлсний төвд, Уулсын хаан Сүмбэр уул, Дорноо үлэмжийн биет, Өмнөө Замбуу тив, Өрнөө Үхэр эдлэгч тив, Умараа Муу Дуут тив болон Биет хийгээд Үлэмж биет завсрын тив, Дохиурт хийгээд Бус дохих завсрын тив, Хэлбэрэлт хийгээд Дээд мөрт зорчигч завсрын тив, Муу дуут хийгээд муу дуутын нөхөр завсрын тив, Эрдэнийн уул, Галбарагча мод, Гаминдини үнээ. Эс тарьсан тутарга, Хүрд эргэнэ, Чандмань эрдэнэ, Хатан эрдэнэ, Түшмэл эрдэнэ, Заан эрдэнэ, Морь эрдэнэ, Баатар эрдэнэ, Их сангийн хумх, Үзэсгэлэнт эх, Эрхич эх, Дууч эх, Бүжигч эх, Цэцгэн эх, Хүжирч эх, Үнэртэн эх, Наран, Саран, Эрдэнийн шүхэр, Хамаг зүгээс сайтар ялгагч ялгуусны тэмдэг, Төв дунд тэнгэр хүмүүний хотол төгс цог учрал бүрдсэн эдгээрийг ачит ёзоорын ба дамжлага сэлтийн цог төгс лам дээдэс хийгээд, Итгэлт нигүүлсэнгүй Арьяабал нөхөр лүгээ сэлтэд өргөмүй. Их нигүүлсэнгүйгээр амьтаны тусад таалан соёрхоо. Таалан соёрхоод би тэргүүтэн хамаг амьтныг адистэдлэн соёрхоо.

Газар дэлхийг анхилам хүжсээр сүрчин цэцэг дэлгээд
Сүмбэр уул, дөрвөн тив, нар сараар чимэглэсэн үүнийг
Гэтэлгэгч бурханы гайхамшигт орноо зоригдон өргөснөөр
Сац амьтан бүхэн арилсан орноо эдлэхүй болтугай

Тус амгалан гарахын орон шашин өргөжин дэлгэрснээр
Шашиныг баригч төрөлхтөн бүгдийн бие батжин сайжирч
Түйтгэрт амьтан бүхэнд амгалан жаргалан гарахын орон

Шагжамүнийн шашин өнө мөнхөд орших болтугай

Богд тойн ламын нас сүүдэр машид батжаад
Буянт цагаан үйлс арван зүгт дэлгэрэх ба
Зонхабын шашины зул гурван газрын амьтдыг
Зүдрээгч мунхагийг ашид гийгүүлэх болтугай

Буяныг ихэд дэлгэрүүлэгч төгс баясгалант Их хөлөгний хийд
Сансрын эцсийг хүртэл оршин өргөжин үйлс нь дэлгэрээд
Саруул оюунт олон мэргэд үргэлжид хурдан чуулаад
Бахдам номлол бүтээлийг шинийн саран мэт арвижуулсугай

Багш шавь нугуудын ном лугаа зохилдох шалтгаан
Ямар мэт санаснаар сэтгэлчлэн бүтэх хийгээд
Барчид саад өвчин, ад, тотгорлогчийн чуулган
Ямар мэт буйг амирлуулан адистлэн соёрхоо.

Дээд их эрдэнэ бодийн сэтгэл
Эс төрсөн нь төрөх болтугай
Эрт төрсөн нь доройтолгүй
Дээш дээш арвижих болтугай

Орон үүнд өвчин, мэсний аюул, зуд турхан зэрэг
Үл зохилдон доройтуулагчийн нэр ч гаралгүй
Оройн дээд Зонхабын шашин зүг бүхнээ дэлгэрээд
Үймрэгч амьтан бүхнээ амгалан жаргалан төгс болтугай

Өмөг болсон их нигүүлсэхүй, энэрлийн мөн чанарт бээр
Би тэргүүтэй хамаг амьтаны харшлах шалтгааныг арилгаж
Өвчин,ад,хилэнцийн түйтгэрийг сайтар амирлуулаад
Балартуулагч гэм хирээс нүдийг илааршуулан адистэдлэ

Эцэг,Эх хамаг амьтан амгалан лугаа төгс болтугай
Энэлгээт муу заяаны орон бүгд үргэлжид хоосроод
Энэрэлт Бодьсадбын аль ч газарт оршсоноор
Эндүүрэлгүйгээр тэдний ерөөл бүтэх болтугай

Өглөгийн эзэн нөхөр сэлт нүгүүдийн
Нас үүнээ санасан хэрэг бүтэх бөгөөд
Өмөг бус зэтгэр амирлан, өлзий хутаг
Номчилон санаснаар бүтэх болтугай

Гайхамшигт Бодьсадба сэлт Бурхадын адистэд ба
Аяа шүтэн барилдлага хуурмаг үгүй үнэн хийгээд
Гагц бас миний ариун санааны хүч чадлаар
Асар ариун ерөөлийн орон энэ нь бүтэх болтугай

Бишрэнгүйгээр мөргөж, тахиж, наминчилсан хийгээд
Бишрэнгүйгээр даган баясаж, дуртган залбирсанаар
Бишрэнгүйгээр өчүүхэн буян юу хураасан бүгдээ
Бишрэнгүйгээр би бээр бодийн уг доор зориулмой

Хотол хүслийн баялаг нь зуны далай мэт арвижиж
Хориг гэм үгүй язгуурын явдал үргэлжид тасралтгүй
Хоног өдөр бүхэнд Зонхабын шашны номын дуу дуурсаж
Хотол чуулганы цогоор цэнгэхийн өлзий хутаг орштугай

Умаа сарваан дата гада раднаа мандала хам ниряа даряами

ЦАГААН ДАР ЭХ ОРШВОЙ.

Ум хутагт гэтэлгэгч дар эх дор мөргөмүй.
Орчлонгоос гэтэлгэгч дар эх,
Дүдари бээр найман аюулаас гэтэлгэгч
Дүүри бээр өвчнүүдээс тонилгогч
Гэтэлгэгч эх дор мөргөн магтаму

Цагаан лянхуагийн дунд агсан
Саран өнгөт дэвсгэрийн дээр
Очирын завилалыг зохиогч эх
Дээдийг өгөгч эх дор мөргөмүй.

Намрын саран мэт өнгөт
Саран түшлэгэн дор араараа түшсэн
Хамаг чимгүүдийг огоот төрсөн
Удвал барианаа мөргөн магтму

Арван зургаан насан лугаа төгөлдөр биет
Туулсан хамаг бурхануудын эх
Хүссэнийг өгөгч дээд биеийг баригч эх
Хутагтай гэтэлгэгч эх дор мөргөмүй
Цагаан гэрэл лүгээ цагаан хүрдэт эх

Чамайг хувийн төдий магтах нь
Ба бүрэн бодь хутгийг бүтээхэд
Энэ цагаас барьж бодь хутаг хүртэл
Үл зохилдохуй зүгнүүдийг амирлуулан
Зохилдохуй шалтгааныг хотол төгсгөн соёрхоо
Хэмээн гэтэлгээгч цагаан дар
Эхийн магтаал үүнийг богд Гэндэнжамц бээр зохиов.

АДИСТЫН ДЭЭДИЙГ ХАЙРЛАГЧ ЭХ

Адистын дээдийг хайрлагч ихэс багш нар болон
Авралын хурыг буулгагч амирлангуй ба догшин тэнгирс
Барцад бүхнийг арилгагч дагнис чойжин нугууд
Бишрэнгүй бээр бие сэтгэлээрээ мөргөн залбирья
Ариун сэтгэлээр бэлдсэн тахилын чуулганыг
Агуу огторгуйд дүүрэн түгээн дэлгэрүүлж
Алс хэтээс хурсан нүгэл хилэнцийг тэвчин
Аливаад дуурсагдах буяныг даган баясмуу

Асар дэлгэр номын хүрдийг эргүүлэн соёрхооч
Ачит тэр хүрд орчлонгийн эцэс хүртэл оршиг
Аяа үүгээр гийсэн буяны алив цогцос
Анхлан бүхний ухааныг гийгүүлэн тэтгэж

Ашид билгийн гэгээг гэрэлтүүлэхээр зорь тугай
Мунхаг цагийн их харанхуйгаар бүрхэгдсэн энэлсэн
Муу заяаны туйлыг нигүүлсэнгүй сэтгэлээр авар
Үйлийн үрийн гасланг сэтгэлээр боловсорсон

Үнэхүү зовлонгийн их түймрийг намжааж
Өш хонзонгийн зовлонт сэтгэлийг арилган

Өрөвч ухааны гайхамшигт цогцос дэлгэрэх болтугай

Аврагтун аврагтун үнэн итгэлт дээдэс минь
Болгоогтун болгоогтун их нинжин сан минь
Эндүүрэл алгасралгүй эртний зарлиг сонс
Эхлэн таалан соёрхож авралаар түргэн тэтгэ

Ариун шашны гэрэл арван зүгт дэлгэрч
Амьтан бүхэн амгалангийн цогийг дуурсган
Алмад түүтгэрийг зогсоох билгийн хутгийг
Асар түргэн дэлгэрүүлж хайрла

Дээд гурван эрдэнийн адистэд хийгээд
Дээдийн номын урвалтгүй барилдлагааны хүч
Хүндэтгэн сүслэн сахих бидний үйлсээр
Хүсэл бүхэн сэтгэлчлэн бүтэх болтугай
Аврал бүхнийг хураасан багшийн адистэдээр
Ахуй үесийн доройтол бүхэн амирлаж
Хорвоод сайн үйлс сүндэрлэн бүтэж
Хотлоороо цэнгэхийн өлзий орштугай

БУРХАНЫ ШАШИН ДЭЛГЭРЭХИЙН ЕРӨӨЛ

Баатар долоон бурханд мөргөмү
Амьтны тусд урьд би
Аль бэрх хатуужлыг эдлээд
Амар жаргалаа зориулсны хүчинд
Ариун шашин өнөд бадартугай

Өвчтөний тусд урьд би
Өөрийн амь амьдралыг зольж

Үгээгүү амьтныг эмнэсний тулд
Үнэн шашин өнөд бадартугай

Эхнэр хийгээд хөвгүүд охид
Эд эрдэнэ, хөлөг хэрэгслээ ч
Эгнэгт гэгээрлийн төлөө зольсноор
Эрхэм шашин өнөд бадартугай

Эцэг, эх, ширвага, брадига
Энэрэлт бурхан, арш дээдэст
Эндэлгүй би вээр тахил өргөснөөр
Эрдэнэ шашин өнөд бадартугай

Олон сая галавт би
Онц элдэв зовлонг амсч
Оюун гэгээрүүлэх номыг эрснээр
Онол шашин өнөд бадартугай

Асар нарийн ёс журам
Аливаа хатуужлыг үргэлж сахин
Арван зүгийн бурхадыг тахиснаар
Аврал шашин өнөд бадартугай

Эргэж буцахгүй хичээл зүтгэлээр
Эсрэг хүчин бүхнийг ялж
Эндүүрч төөрөгсдийг аварсан тул
Эрдэмт шашин өнөд бадартугай

Хүлцэл тэвчээрийг үргэлж эрхэмлэн
Хөнөөлт сэтгэлийн өвчинд баригдсан
Хөөрхий дордсыг уучлан хайрласнаар
Хүндэт шашин өнөд бадартугай

Ганга мөрний хумхийн тоо шиг
Дээд түвшний дияан бясалгалыг
Гаргууд сайн эзэмшсэн тул
Гайхамшигт шашин өнөд бадартугай

Билиг ухаан нээхийн тулд
Бэрх хатуужлаар аглагт сууж

Бичиг шаштир судалсны хүчинд
Бишрэлт шашин өнөд бадартугай

Өршөөлт энэрлээр мах цус
Өнө амьдрлаа ч огоот зориулж
Үе мөчөө харамгүй өгснөөр
Үнэн ном машид дэлгэртүгэй

Алдас нүгэлтнийг урьд би
Агуу хайраар асран сэнхрүүлж
Аль зохих замд нь оруулснаар
Алдаршгүй номын өглөг арвижтүгэй

Арга билгийн хүчээр би
Атхаг үзлээс бусдыг чөлөөлж
Ариун үнэнд залуурдсаны тулд
Авралт ном үлэмж дэлгэртүгэй
Хураах дөрвөн үйлсээр би
Хорсол тачаалын галаас аварч
Хор хилэнцийн хүчийг ялснаар
Хувьт шавь нар минь өнөд орштугай
Буруу зөрүү номтныг би
Буртагт үзлийн уснаас гэтэлгэж
Буцалтгүй үнэн үзэлд оруулснаар
Буянт нөхөд минь өнөд бишэртүгэй

Бурхан шашин үүрд бадартугай

ЗАЯ БАНДИДА ЛУВСАН ДАНЗАН ПҮЛЖИНЖИГМЭДИЙН ТӨРӨЛ ТУТМЫН ЗАЛБИРАЛ

Хутагтын оронд бурхан заларч
Хувьтай түмэнд увдис хайрлахад
Эрдэнийн элс өргөн барьж бодь сэтгэл үүтгэсэн
Эзэн хаан Жамсим Жамбад залбирнам

Бурхан багшийн номын рашаанаар
Бүх дэлхий нийтээр чийглэгдэх

Гаслант хүмүүсийг зовлонгоос тэтгэгч
Гайхамшигт хаан Ашока-д залбирнам

Эрдэнэ гуравт хувиралтгүй сүсэглэж
Энгийн нүдэн дор энэрхүйн хүү шиг тэтгэн
Чөлөө учрал бүрдсэн оронд мэндэлсэн
Чимэг үзэсгэлэнт Това Самбууд залбирнам

Хутагтын орны дээдсийн хөрөнгөнөөс
Хувиар хүмүүст өглөг тэргүүтнийг гүйцээж
Арчаагүй түмний тусад үр эд хайрлагч
Агуу Шумбугаараад залбирнам

Цаст түвдийн баруун хойд зүгийн
Цагийн муугийн Ладак шавь нарыг
Хилэнт дүрээр номхотгон зассан
Хосгүй ловон РаднаСэдэд залбирнам
Энэтхэг орны өндөр язгуурт мэндэлж
Энэлсэн түмэнг гангийн рашаанаар сэрүүцүүлж
Дээдсийн мөргийг нээгч тэрэг орчлонгийн нүдэн
Даяанч Лодойдамбын өлмийд залбирнам

Байдал нь шагшаа бодь лугаа төгөлдөр
Бясалгал ухаан нь үнэрт зандан мод адил
Дэлбээлэх цэцгийн үнэр нь анхилам
Дээдэс Содном Балтүв дор залбирнам

Цог төгөлдөр охин тэнгэрийн адистэдээр
Чугуулган үйлсийн их далайд

Цэцнээр гатлах онгоцыг жолоодогч
Чандмань эрдэнэ бүдэн гэгээнд залбирнам

Цаст түвдэд залрах замыг анхан нээж
Цуут ванчин богд Ашоко хэмээд лүндэгнэж
Амьтны тусыг хийж мөнгөн суврага бүтээсэн
Ар халхын хөндүүлэн цохур ноёнд залбирнам

Хоёр дээдэс ванчин далай ламын
Хувь төгөлдөр шавиар илт үнэлэгдэж
Ариун номын хурыг нутагтаа буулгагч
Алдарт Зая Лувсанпэрэнлэйд залбирнам

Урьдын дээдсийн мөрөөрТөвдэд заларч
Урсах гангын рашааныг нутагтаа салаалан
Агь тарнийн номыг эцэгслэн агууг сахигч
Аглаг даяанч Лувсаннамжилд залбирнам

Хол тасран түрүүлэх ажнай хүлэг шиг
Хосгүй ядам сахиустай гүн нөхөрлөж
Судар тарнийг эндүүрэлгүй эцэслэсэн
Суут Лувсан Жигмэд Доржид залбирнам

Зая бандидын алдарт шашны хэнгэргийг
Замхрал үгүй арвидуулж зохиох үүрэгт
Амьтныг тэтгэгч билэг төгөлдөр багш
Ачит Лувсан Няндаг дор залбирнам

Хувилгаан журамт лагшинг эргэшээж
Хөг яруу зарлигаар олонд алдаршсан
Шоронд залравч энэрэхүйн таалалтай
Шамдалт дээдэс Жамбацэрэнд залбирнам

Ардчиллын ногоо Монголд үрсэлж
Ардууд сүсгээр хойд дүрийг хайхад
Далай багшаас Архангайд энэ хэмээсэн
Данзанпүлжин Жигмэд дор залбирнам

Учир шалтгаан бүрдсэн Монголд
Уг санааг ерөөлчилөн бүтээсэнд
Зая Бандидын дүр бүхэнд залбирнам бид
Заяат дээдийн номын дэлгэрүүлж адисла

ДҮНШАГ БУЮУ УНАЛЫГ НАМИНЧЛАХУЙ

Хамаг амьтан цаг цагт цаглашгүй ачит лам багшдаа итгэмүү
Бурханд итгэм үү Дээдийн номд итгэм үү Хурсан хуврагуудад итгэм
үү

Их Багш ялж төгс нөгцсөн, түүнчлэн заларсан, дайснаа дарсан,
үнэхээр төгссөн, цогт ялгуулсан бурхан Шагжтүвийн өлмийд мөргөм үү.

Түүнчлэн заларсан очирын зүрхээр сайтар эвдэгч танаа мөргөм
үү Түүнчлэн заларсан эрдэнийн гэрэл цацруулагч танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан лусын эрхшээлт ялгуулсан танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан баатаруудын өмөгт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан баясгалант цогт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан гал эрдэнэ танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан эрдэнэ саран гэрэлт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан үзсээр их туст танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан саран эрдэнэт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан хиргүй тунгалаг танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан цогийг хайрлагч танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан асар ариун явдалт танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан ариунаар өгөгч танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан усан тэнгэр танаа мөргөм үү

Түүнчлэн заларсан усан тэнгэрийн тэнгэр танаа мөргөм
Түүнчлэн заларсан сайн цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан цогт зандан танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан хязгааргүй жавхлант танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан цогт гэрэлт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан гаслан үгүйн цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан хурьцахуй үгүйн хөвүүн танаа
мөргөм үү
Түүнчлэн заларсан цогт цэцэгт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан ариун гэрлээр нэн цэнгэн илт мэдэгч танаа
мөргөм үү
Түүнчлэн заларсан лянхуан гэрлээр нэн цэнгэн илт мэдэгч
танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан эдийн цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан дурьдахуйн цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан цогт билэг найраг нь ихэд даяар алдаршсан
танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан эрхт оройн ялсаны тэмдэг хаан танаа
мөргөм үү
Түүнчлэн заларсан сайтар дарагч цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан дайснаа машид ялсан танаа
мөргөм үү
Түүнчлэн заларсан сайтар даран ажирсан цогт танаа мөргөм үү
Түүнчлэн заларсан эрдэнийн лянхуагаар сайтар дарагч танаа
мөргөм үү
Түүнчлэн заларсан дайснаа дарж үнэн төгссөн бурхан, эрдэнэ
хийгээд лянхуан дээр сайтар саатан заларсан уулсын хаан хэмээх
алдарт танаа мөргөм үү
Тэдгээр бурхад тэргүүтэй 10 зүгийн ертөнцийн оронд түүнчлэн
заларсан, дайснаа дарсан, үнэнхүү төгссөн, ялж төгс гэтэлсэн
бурхан аль төдий заларсан бөгөөд ахуй залран буй ялж төгс нөгцсөн
тэдгээр бурхад намайг таалалдаа багтаан соёрх оо.
Миний энэ нас хийгээд эхлэлийн хязгаар үгүй төрлөөс
Энэ орчлонд орчин төөрсөн төрөл тутамдаа
Элдэв хилэнцэт үйл үйлдсэн хийгээд
Элдэвлэн бусдыг хилэнцэт үйл үйлдэхэд хүргэсэн
Эл бас хилэнцэт үйлэнд даган баяссан буюу
Тахил шүтээний эд буюу
Түүнчлэн бурсан хуврагийн эд бөгөөд
Арван зүгийн бурсан хуврагуудын
Алив эдэд шунан булаах хийгээд

Аль бусдаар булаалган үйлдэх ба
Аль хэн нэгэн булаан үйлдэхүйд даган баяссан
Завсаргүй таван нүглийн үйл үйлдсэн буюу
Зориуд бусдыг үйлдэхэд хүргэсэн хийгээд
Заримууд үйлдэн байхуйд даган баяссан
Арван хар нүглийн мөрд чанх орсон хийгээд
Арван хар нүглийн мөрд бусдыг оруулсан ба
Аль бусад орж байхуйд даган баяссан юм уу
Аль нэг хилэнцэт үйлийн түйтгэрээр
Ашид миний сэтгэл тамд очих буюу
Адгуусны төрөлд одох эсвэл
Ашид өлсөн цангах бирдийн орноо төрөх
Бурхан заларч номоо номлоогүй
Бурангуй харанхуй буйд оронд төрөх буюу
Тэрс номлолт лалын орноо төрөх
Урт наст тэнгэрийн орноо төрөх ба
Улмаар эрхтэн дутуу болон төрөх
Угаас буруу үзлийг баримтлагч болох
Бурхан заларч номоо номлохуйд
Баясах сэтгэл үл төрсөн гэх мэт
Барагдашгүй муу үйлийн түйтгэр буй тэдгээр бүхнээ
Билгэ билгүүнт бурхан Билгэ билгүүний мэлмийн Их эрхэт
Үнэн шалгуурын мөн чанарт
Үнэн болгоолтоор болгоогч тэдгээрийн мэлмийн өмнө
Гэмшин наминчилмуй Арилган наминчилмуй
Үл нуух болой. Үл хаацайлах болой
Хойшид ч таслан боомтильё.
Ялж төгс нөгцсөн бурхан бүгд намайг таалалдаа багтаан соёрх
Миний энэ төрөл хийгээд
Магад эхлэлийн хязгаар үгүй цагаас
Мунхран мунхран орчлонд орчин орчин
Төрөл бүхэндээ бусдад ядаж түдэвч
Адгуусны оронд төрсөн амьтаст
Өчүүхэн төдий идээ хоол өгсөн буяны ёзоор юу буй
Өөрөө би Шагшаабадыг сахисны буяны ёзоор юу буй
Үнэн ариун явдал мөрөөр явсан буяны ёзоор юу буй
Үнэнхүү гэтлэхүйн мөрд бусдыг оруулан
Үйл сайны үрийг боловсрохуйд найралдсаны буяны ёзоор юу буй
Өөртөө дээд бодийн сэтгэлийн үүсгэсэн буяны ёзоор юу буй
Өнөд ханьцашгүй билгэ билгүүний буяны ёзоор юу буй тэр
бүхнээ нэгнээ хураан цогцлуулж Ханьцаш үгүй Үнэлш үгүй

Дээдийн ч дээд Багшийн ч багшид Тэр бүхэлд зориулан басхүү
Тэнцэшгүй үнэн төгс бодь хутгийг олохын тулд зориулъя.

Ямар мэт урьд цагт заларсан бурхад төгс зориулсан хийгээд

Ямар мэт ирээдүйд залрах бурхад төгс зориулах хийгээд

Ямар мэт өдгөө залран буй ялж төгс нөгцсөн бурхад

Ямар мэт төгс зориулсан тэр мэт Би бээр өдгөө зориулъя

Хилэнц унал бүгдийг тус тусад нь наминчилъя

Хэн буян үйлдэнэ тэр бүхэнд даган баясья

Хамаг Бурхадад номоо номлохыг сануулан дуртгая

Хэзээд соёрхол талбия

Ханьцашгүй дээд билгүүнийг би олох болтугай

Хүмүүний дээд одоо залран буй ялгуулсан бурхад аль

Хэдүй заларсан хийгээд ирээдүйд залрах

Сайшаалт эрдэмт хязгааргүй далай мэт бүхэнд

Сайтар алга найралдуулан залбираад авралыг ихэд айлтгам уу би

Ум сарва дата гада идам гүрү радна манда-ла хам-нир-яа

да-яа-ми

ЖИВШАГ БУЮУ ЕР УНАЛЫГ НАМИНЧЛАХУЙ

Ү ха-лаг. Очир баригч их багш тэргүүтэй 10 зүгт залран буй
хамаг бурхан, бодьсадва нар хийгээд ариун аяга тахимлэг (гэлэн)
нар минь намайг таалалдаа багтаан соёрх оо!

..... хэмээх нэрт миний эхлэл үгүй цагаас төрөл тутамдаа
өдгөөг хүртэл хүсэл шунал уур хилэн мунхагийн эрхээр бие
хэл сэтгэлийн үүднээс 10 хар хилэнц нүгэл юуг үйлдсэн хийгээд
завсаргүй 5н нүгэл үйлдсэн хийгээд завсаргүй 5нүглийн шадар 5
нүглийг үйлдсэн хийгээд

Ангид гэтэлгэгч санваартай харшилсан

Бодьсадвын сурталтай харшилсан

Тарнийн тангарагтай харшилсан

Эцэг эхээ үл хүндэтгэсэн

Орон хийдийн хамба багшийг үл хүндэтгэсэн

Ариун явдалт буяны садан юуг үл хүндэтгэсэн

Чухаг дээд гуравт хорлол үйлдсэн

Дээдийн номыг тэвчсэн

Хутагтан хуврагуудыг басамжилан доромжилсон

Амьтанд хорлол үйлдсэн тэргүүтний

Хилэнц нүглийн үйлийн чуулган хэдийн чинээ үйлдсэн хийгээд
бусдыг үйлдэхэд хүргэсэн, бусдууд үйлдэхүйд даган баяссан
тэргүүтэй Товчилбоос илт өндөр (тэнгэр ба хүмүүний төрөл)

хийгээд тонилохуйн (орчлонгоос оюун санаагаараа гэтлэх) тотгор болсон орчлонгийн төрөл хийгээд муу заяаны шалтгаан болсон гэм уналын цогц хэдий чинээлэг би үйлдсэн тэр бүхнээ Очирт их багш тэргүүтэй 10 зүгт залран буй бурхан, бодьсадва нар хийгээд ариун хуврагуудын мэлмийн өмнө гэмшин наминчилъя.

Үл нуух болой.Арилган наминчилъя.Хойшид ч таслан боомтилъё.Гэмшин наминчилж амгалант оронд зорчоод үл гэмшсэн, үл наминчилсан нь үгүй болой.

Арван зүгийн бурхад бодьсадба
Ачит, Барэдига, сурч боловсорсон
Амьтан бүгдийн буян аль бээрч
Аминчилан би бээр даган баясаму
Орчлонд хаана ч зул болон бадарч
Оройноос бурхан болохоор яаралгүй
Номой дорой над мэт бүгдэд
Номын хүрдийг зогсолгүй эргүүлэн
Гаслангаас гэтэлгэх замыг заан
Гагцхүү хамаг амьтны амгалангийн тулд
Галав олон оронд тоосны тоотой адил
Гар хумхилгүй залбирч үйлдэе би
Мөргөн тахин номончилан
Мөнхүү даган дурдан баясан залбирснаар
Өчүүхэнч төдий буян юу хурааснаа
Өрөвч энэрлээр бодь дор зориулмой

МЭГЗЭМ

**Мэгмид зэвий дэрчин жанрайсиг
Дэмид чинбу банбу жамбиян
Ганжин хайвй зүгжин зонхава
Лувсан дагби шавла солбаандэв**

ДОЛООН БУРХАН ОДНЫ ТАХИЛГА

Эрт цагт Бурхан багш бээр долоон одны өмнө идээний дээд, зул, хүж, цэцэг, хадаг зэргийг төрөл бүрийн үр жимсийн хамт бэлтгэн долоон үеэр өргөж байжээ. Үүнчилэн бид долоон одны тахилга хийхдээ эхлээд итгэл, сан уншиж цагаан дэвсгэр дээр долоон одны байрлалаар тахил байрлуулан зургаан тарни, зургаан мутарлагын адис үйлдэн ийн унших нь:

Ялж төгс нөгцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан үнэхээр тугуулгасан Бурхан Намсаг дор мөргөн тахин номончилмой

ЖИ:

Номын чанар их амгалангийн уужим хот мандалаас

Намсаг Бурхан ялж төгс нөгцөгсөн бээр

Бүхнээс хутагтын орчлонг болгоон

Бурханы эрдэмд төгс боловсров

Дамлин хэмээх од ануу:

Дээд бурхадын хувилгаан

Дансүрэн арш танд тахил өргөө

Дансүрэн арш танд сүслэн мөргөө

Та ануу зүүн зүгийн одны эзэн

Миндүг, нарма, го, лаг, намсо

Мөнхүү жал, гаг,хэмээх долоон од

Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Өвчин зовлон барчид бүгдийг арилгаж

Өөдлөн нас урт эдлэл арвижиж

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цаг учрал хотол чуулган

Эрхэм баясгаланг олох болтугай

Тарни ануу:

НАМО САМАНДА БУДАНАМ УМ-АМРИТА-ЯА-ЕЭ-СУХА

Долоон удаа уншиж мөргөнө.

Ялж төгс нөгцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан үнэхээр тугуулгасан Бурхан Зүгдэр дор мөргөн тахин номончилмой

2:ЖИ:

Их амгалан билэг билгийн ордноос

Илт тугуулгасан Зүгдэр бурхан Эрдэнийн язгуурын орчлонд

Эрдэм бүгдийг гүйцээн соёрхов

Гүман хэмээх од ануу:

Гэтэлгэгч Бурхадын хувилгаан

Дансран арш танд тахил өргөө

Дансран арш танд сүслэн мөргөө
Та ануу зүүн зүгийн одны үндэс
Тэрхүү Мэндүг тэргүүт од гараг
Өнөөдөр энд залран соёрхож
Өглөгийн эзэд нөхөр сэлтийн
Өвчин зовлон барчид бүгдийг арилгаж
Өөдлөн нас урт эдлэл арвижиж
Эрх мэдэл язгуур дамжлага
Элдэв цаг учрал хотол чуулган
Эрхэм баясгаланг олох болтугай

Тарни ануу:

НАМО-САМАНДА-БУДАНАМ

УМ-ЦЭНДА-ХУМ-НИ-СУХА Долоон удаа уншиж мөргөнө

Ялж төгс нөгцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан
үнэхээр тугуулгасан Бурхан Тамжиджав дор мөргөн тахин
номончилмой

3.ЖИ:

Билэг билгийн номын хот мандалаас

Бурхан ялж төгс нөгцөгсөн тамжиджав

Наран саран дэлгэрсэн орчлонд

Ном бүгдийг төгс гүйцээв

Лүйшүн хэмээх гараг ануу:

Лавтай Бурханы хувилгаан

Дансран арш танд тахил өргөө

Дансран арш танд сүслэн мөргөө

Та ануу урд зүгийн одны эзэн

Тэрхүү чү,дэ,бо,мэ,наг,сарэ, сага од Өнөөдөр энд залран соёрхож

Өглөгийн эзэд нөхөр сэлтийн

Өвчин барчад бүгдийг арилгаж

Өөдлөн насжиж эдлэл арвидан

Эрх мэдэл язгуур дамжлага

Элдэв цог учрал хотол чуулган

Эрхэм дээд баясал олох болтугай

Тарни ануу:

НАМО-САМАНДА-БУДА-НАМ

УМ-НИ-МИ-РИ-НЭ-ЛА-ГАДА

НАВАРА-ПҮР-ДҮСҮ-СУХА

Долоон уншиж мөргөнө

Ялж төгс нөгцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан

үнэхээр тугуулгасан Бурхан Хорвоонжиг дор мөргөн тахин номончилмой

4.ЖИ:

Их амгалангийн орд харшаас
Илт туулсан Бурхан хорвоонжиг
Гэмээ ухаардаггүй хорвоод
Гэгээн эрдэм буянаа төгсгөв
Вүнгү хэмээх од ануу:
Винайн төгсгөсөн
Бурханы хувилгаан
Дансран арш танд тахил өргөө
Дансран арш танд сүслэн мөргөө
Та ануу урд зүгийн одны эзэн
Тэрхүү чү,дэ, тэргүүт однууд
Өнөөдөр энд залран соёрхож
Өглөгийн эзэд нөхөр сэлтийн
Өвчин барчад бүгдийг арилгаж
Өөдлөн насжиж эдлэл арвидан
Эрх мэдэл язгуур дамжлага
Элдэв цог учрал хотол чуулган
Эрхэм дээд баясал олох болтугай

Тарни ануу:

НАМО-САМАНДА-БУДА-НАМ
УМ-БИДА-СУХА

Долоон удаа уншиж мөргөнө

Ялж төгс нөгцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан
үнэхээр тугуулгасан Бурхан Сиртүв дор мөргөн тахин номончилмой

5:ЖИ:

Номын чанарын уужим мандалаас
Номын хаан сиртүв бурхан
Ариухан сайхан бээр орчлонд заларч
Авшиг увидасыг туйлд нь болгоов
Линчин хэмээх од ануу:
Лавтай Бурханы хувилгаан
Дансран арш танд тахил өргөө
Дансран арш танд сүслэн мөргөө
Та ануу баруун зүгийн одны эзэн Тэрхүү:лхацам,нон,нүв, чүдод
Чүмод жишин, дошин одод
Өнөөдөр энд залран соёрхож
Өглөгийн эзэд нөхөр сэлтийн
Өвчин барчад бүгдийг арилгаж

Өөдлөн насжиж эдлэл арвидан
Эрх мэдэл язгуур дамжлага
Элдэв цог учрал хотол чуулган
Эрхэм дээд баясал олох болтугай.
Тарни:НАМО-САМАНДА БУДАНАМ
УМ-БАРА-ДЭЗА-РА-МА-РА-НА-СУХА
Долоон удаа уншиж мөргөнө.

Ялж төгс нөгцөгсөнтэгүүнчилэн ирэгсэнд айныг дарагсан үнэхээр
тугуулгасан Бурхан Одсүрэн дор мөргөн тахин номончилмой.

ЖИ

Их амгалан билэг билгийн агаараас
Илт туулсан Бурхан Санжа Одсүрэн
Номонд сүсэглэн орчлон дээр
Ном бүгдийг төгс гүйцээв
Хүгү хэмээх од ануу
Хүчит Бурхадын хувилгаан
Дансран арш танд тахил өргөө
Дансран арш танд сүслэн мөргөө
Та ануу баруун зүгийн одны эзэн
Тэрхүү зүгийн одод бүгд
Өнөөдөр энд залран соёрхож
Өглөгийн эзэд нөхөр сэлтийн
Өвчин барчад бүгдийг арилгаж
Өөдлөн насжиж эдлэл арвидан
Эрх мэдэл язгуур дамжлага
Элдэв цог учрал хотол чуулган
Эрхэм дээд баясал олох болтугай

Тарни

НАМОСАМАНДА БУДАНАМ
УМ-САРВА-ДАРА-САМАЯ-СУХА
Долоон удаа уншин мөргөнө

Ялж төгс нөгцөгсөн тэгүүнчилэн ирэгсэн дайныг дарагсан
үнэхээр тугуулгасан Бурхан Шагжтүв дор мөргөн тахин номончилмой

ЖИ:

Их амгалант номын ордноос
Илт туулсан Бурхан шагжтүв тэргүүт
Индранил эрдэнийн орчлон дээр
Их оточийн эрдэм төгсгөв
Погүн хэмээх од ануу
Пагва хутагтын хувилгаан
Дансран арш танд тахил өргөө

Дансран арш танд сүслэн мөргөө
Та ануу хойд зүгийн одны эзэн
Тэрхүү мондү, мондэ, түмдод
Түммад, намдүй тагар брани
Тэргүүт хойд зүгийн одод бүгд
Өнөөдөр энд залран соёрхож
Өглөгийн эзэд нөхөр сэлтийн
Өвчин барчад бүгдийг арилгаж
Өөдлөн насжиж эдлэл арвидан
Эрх мэдэл язгуур дамжлага
Элдэв цог учрал хотол чуулган
Эрхэм дээд баясал олох болтугай.

Тарни ануу:

НАМА САМАНДРА-БУДА НАМ
УМ-СА-ВА-ДА-СА-РА-МЭЗА-СУХА

Долоон удаа уншиж мөргөнө

Даллага ануу:

Арван зүгийн архад бүгдийн

Адис жинлав нас буяны даллан авъяа

Хурай хурай хурай

Дээрх огторгуйд залран буй

Тэнгэр долоон одын нас буянг даллан авъяа

Хурай хурай хурай

Завсар орчлонгийн нар сар

Найман их гарагийн нас буяныг даллан авъяа

Хурай хурай хурай

Миндаг нарма тэргүүт хорин найман Магнай их оддын насан
буянг даллан авъяа

Хурай хурай хурай

Эртний Энэтхэг түвд монголчуудын

Энх тунх насан буяныг даллан авъяа

Хурай хурай хурай

Орон бүгдийн төгс эдлэлийг авч

Ойр таарах барцадыг арилгаж

Өвчин ад бүгдийг хөөж

Өнө мөнхийн насан хутагтийг даллан авъяа

Хурай хурай хурай

Буяны төгөлдөр нөхрийг тааруулж

Бусад морь мал машид элбэг

Орчлон сан баялаг бүгд

Ойртуулан арвижуулан дамжуулан авъяа

Хурай хурай хурай

Өлзий хутаг зуны далай мэт
Өнө мөнхөд орших болтугай
Өвчин зовлон зуд турхангүй
Өнөд насан хутаг дэлгэрэх болтугай
Өлмийн лянхуа бат оршиж
Өнөр баян болох болтугай

ХҮННҮ ГҮРНИЙ ТУХАЙ АРХЕОЛОГИЙН ОЛДВОР, ТҮҮХИЙН ЭХ СУРВАЛЖААС МИНИИ ТӨРСӨН НУТАГ, ХҮННҮ ГҮРЭН БОЛОН ЭЗЭНТ УЛСЫН ГАЛ ГОЛОМТ БОЛОХ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ АНУУ:

ТҮҮХИЙН ЭХ СУРВАЛЖ, АРХЕОЛОГИЙН ОЛДВОРУУД

МЭӨ III-II зууны заагт хүннүчүүд их говийн урд талаар, Шар мөрний бор тохой, Ордос хавиар нүүдэллэн амьдарч байгаад Түмэн Шаньюгийн үед Орхон, Онги, Туул голын сав газарт ирж суурьшжээ. Хүннү нарын түүхийг судалж, танин мэдэхүйн эргэлтэнд оруулах эхлэл ердөө хоёр зуугаадхан жилийн өмнөөс тавигдсан юм.

2000 гаруй жилийн тэртээ бичигдсэн Хятадын түүхэн сурвалж, тухайлбал эртний Хятадын түүхч Сыма Цяны бичсэн "Ши-Жи" хэмээх түүхийн тэмдэглэлийн "Сюнь-ну Жуан" (Хүннүүчүдийн эцэг) гэсэн бүлэгт хүннүчүүдийн тухай нилээд дэлгэрэнгүй өгүүлсэн буй.

"Ши-Жи" нь МЭӨ 85 он хүртэлх урт хугацааны түүхэн үйл явдлыг багтааж, ялангуяа МЭӨ 209 онд Хүннү улсын Шаньюгийн ширээнд суусан Модун Сайн хааны эцэг Түмэнгээс эхлээд Модуны шууд угсааны хоёр ч хааны үеийг бүхэлд нь хамарч байгаа учраас Хүннү улсын мандан бадарсан цаг үеийг гаргах анхны дурсгал бичиг яах аргагүй мөн юм.

Түүнчлэн МЭӨ 206 оноос МЭ 9 онд тогтож байсан Цянь Хан (Түрүү Хан), МЭ 9 оноос 220 онд байсан Хоу Хан (Хойд Хан) нарын улсын түүхийг багтаасан Хан Шу (Хан улсын түүх) хэмээх он дарааллын бичиг нь Хүннүчүүдийн талаар мэдээлэл авч болох хоёр дахь эх сурвалж юм. Модун Шаньюгийн хаанчлал МЭӨ 209 онд эхэлж, 174 онд дууссан болохоор дээрх бичгүүдэд тэмдэглэгдсэн хүннүчүүдийн тухай мэдээ сэлт нь Модун Шаньюйн үйл амьдралтай шууд холбогдох учиртай. Гурав дахь эх сурвалж бичиг нь Ухуань, Сяньби, Хүн нарын талаар нилээд дэлгэрэнгүй мэдээлсэн "Гурван улсын түүх" хэмээх 65 бүлэгтэй түүхэн тэмдэглэл юм. Басхүү 627-649 онд Хаан сууж байсан, Тан улсын эзэн хаан Ли-Ши-Миныйдирдлаган дор бичигдсэн 130 бүлэгтэй он дарааллын бичгийн дугаарт хүннүчүүдийн тухай тодорхой өгүүлсэн буй.

Хорьдугаар зууныг хүртэл зөвхөн дээр дурьдсан хятад эх сурвалжийг ашиглан хүнчүүдийн түүхийг судалж байв. 1743 онд Францын судлаач Дегинь Хүн, Түрэг нарын гарлын тухай зохиол бичсэн нь Хүн судлалын эхийг тавьсан гэж тооцогддог байна.

Чухамдаа тэр цагаас эхлэн Хүнчүүдийн гарлын тухай ихээхэн шуугиан дэгдэж, урьд нэгэн цагт (IV зууны) Европ тивд Ромын эзэнт улс, Византыг донсолгосон Гунну нар болон Ази тивд төр улсаа байгуулж асан Хүннү (Хятад сурвалжид Хунну гэдэг) нар нэг аймгийнхан мөн эсэх талаар маргацгаасан нь Хүннү судлалд томоохон түлхэц өгсөн билээ.

Хүн (Хүннү), Гунну нар нэг омог аймгийнхан гэдгийг эдүгээ нэгэнт нотолжээ. Европ зүгт очиж уусаж алга болсон Гунну нарын тухай шууд аваад хэрэглэх эртний түүхэн сурвалж одоо хир олноогүй байна.

Алтайн чанад дахь Долоон усны хөндийгөөс одоогийн Байгаль далайгаас Түмэн газрын урт цагаан хэрэм хүртэл хадгалагдан үлдсэн нүүдэлч зоны аугаа их эзэнт гүрний түүхийн дурсгал бол Хүн улсын үеийн булш бунхан, хөшөө, хот балгадын туурь, хадны сүг зураг, бичээс зэрэг ил далд эх сурвалж манай оронд Хүн улсын үеийн олон булш бунхан байдгийн дотроос Шаньюй нарын ихсийн газар нь Ноён уул, Хүнүйн гол, Гол мод, Манханы Тахилтын шил зэрэг газарт байдгийг эрдэмтэд судлаачид нээн илрүүлжээ. Түүхчлэн хүннүчүүдийн хэл, соёлын тухай эрдэмтэн мэргэд янз янзаар тайлбарлахыг оролдож, цөөнх нь тэднийг түрэг хэлтэн, олонхи нь, ялангуяа Хятадын судлаачид монгол хэлтэн хэмээн үзэж нотолсонтой эдүгээ дэлхийн эрдэмтэд санал нэг байгаа юм. Мэдээж хэрэг өөр санаа бодолтой судлаачид ч буй.

Эрин зууны босгон дээр Ази тивийн өргөн уудам тал нутагт Хүннү нүүдэлчин аймаг оршин амьдрахын эрхэнд эвсэлдэн нэгдэх, яаж тулалдах, нийлж уусах, тасарч төрхөө олох зэрэг олон талт нэгдэл хөдөлгөөний үр дүнд давамгайлж гарч ирсэн нь хүннүчүүд байжээ. Түүнээс хойш монгол нутаг дээр Сяньби (Сүмбэ), Түрэг, Кидан, эцэст нь монгол туургатан улс болон тогтнохдоо соёлын хувьд нэг нэгнээсээ залгамжлан авсан зүйл багагүй хүнчүүдийн түүх соёлын дурсгалд Түрэг үг тааралдах ахул Хүн нарыг Түрэг хэлтэн байсан мэтээр өрөөсгөл дүгнэх нь зүйд үл нийцнэ. Тэр цагийн нүүдэлчин олон аймгийн зонхилхи нь монгол хэлтэн Хүн гүрний давамгайлах аймаг нь (Хиад-Монгол), Шаньюй нар нь энэ аймгаас гаралтай Хятадын түүхийн он дарааллын бичигт байгаа зарим үг монгол хэлний үндсийг хадгалсан зэрэг нь Хүнчүүд Монгол хэлтэн болохыг давхар баталж буй хэрэг. Модунг нас барснаас хойш 70 жилийн дараа Хан улсын нэгэн элч Чжэн-Цянь (МЭӨ 114 он) дундад Азийн олон аймагт явж ирээд Давань (Фэрган, Аньси, Терфи) аймгийнхан улсын Шаньюй нь пайзтай элч нарыг дотночлон үзэж уналга хүнсээр хангах мөртлөө, мөнгө торго өгөхгүй бол бидэнд

юу ч олдохгүй байлаа гэж бичсэн байдаг. Манж Чин улсын түүхч Юян-Цянь хятадын түүхийн эл сурвалжуудыг харьцуулан үзээд Хүнчүүдийн хэл бичиг нь хятадых лугаа адилгүй хэмээжээ.

МЭӨ 250-245 онд Фунань (Кампучи)-д зараалаар очиж байсан Хятадын элч буцаж ирээд "Фунаньчууд ном судраа тусгайлан хадгалдаг, тэдний бичиг нь Хүннүгийн бичгийг санагдуулах бөлгөө" хэмээснийг гурван хаадын түүх хэмээх он дарааллын бичигт тэмдэглэн үлдээсэн байдаг.

Академич Ч.Далай "Хүн нар бичиг үсэгтэй байсныг батлах бас нэг баримт бол Хүн нар Европ тийш нүүж очсоны дараа удаан хугацаагаар Хүн бичгээ хэрэглэж явсан явдал юм" хэмээжээ. Хүн нар чухам ямар төрлийн бичиг хэрэглэж байсан талаар олон янзын таамаглал байдаг боловч сүүлийн үеийн судалгаануудад "Руни" бичиг хэрэглэж байсан гэдэгтэй шинжээчид үндсэндээ санал нийлж нотлох баримтыг зангидан батлаж байна. "Хойд төрийн түүх" хэмээх сурвалж бичигт "Хүн улсын их жанжин нар бичиг сайн мэддэг байсан" хэмээн бичсэн буй.

Хятадын "Вэй-Ши" (Вэй улсын түүх) хэмээх сурвалжид хятад үсгээр Хүнчүүдийн хэлээр тэмдэглэсэн "Сю-жи Ти-лей ГяньПү-Гү Та-Гу-Дань" гэсэн өгүүлбэр байдгыг академич Н.Ишжамц Пүгү таугдана гэж уншаад 'дилэгэд' хэмээснийг эдүгээ ч монгол хэлнээ хэрэглэж буй жилийх, чилийх;'таугдана' хэмээснийг 'туугдах, зугтаах' гэсэн үгтэй дүйцүүлэн уншаад Сүжи хэмээхүй нь одоо хэрэглэгдэхээ больсон 'цэрэг' хэмээх бүхүй монгол үг, 'пүгү' хэмээхүй нь сурвалж бичигт цөөнгүй олддог хүний нэр хэмээн тайлбарласан байна. Архелогич эрдэмтэд 1983 онд Булган аймгийн Бүрэг хангай нутагт Хүн улсын үеийн булшнаас архелогийн олон тооны олдвор олсны дотор хөөмөл аргаар хийсэн алтан эдлэл алтан дүрс хэдэн руны үсэг олсон байна. Уг руны үсгийг эрдэмтэн Сумъяабаатар финик, герег, арамей, этрүс, еврей, монгол, уйгар, солонгос, эртний түрэг гэх мэт хориод төрлийн хэлийг судлаад "хаану (шаану) тамга" гэсэн монгол Ойрд, Түрэг хэлтэнд аль алинд нь ойлгогдох үг болохыг тайлсан байна. Энэ бүхнээс харвал Хүннүчүүд өөрийн гэсэн бичиг үсэгтэй байсан нь гарцаагүй бөгөөд харамсалтай нь нүүдэлчин улсууд өөрийн соёлын дурсгалаа хадгалах боломж хомс байснаас тэрхүү соёл нь эрин цагийн урсгалд гээгдэн үрэгдсэн ажгуу. Хүн нар бүх үеийнхээ турш дан ганц мал аж ахуй эрхлээд ганц нэгээр амьдарч байсан бус хот суурин ч байгуулж байжээ. Тухайлбал Модун Шаньюй Орхоны их цагаан тохой хангай нурууны төгсгөл хавьд лүнчин буюу луу хотыг барьж байсан тухай мэдээ сурвалж байдаг.Тэд өвөлдөө мөргөлийн сүмтэй байсны ул мөрийг

эрдэмтэн археологчид нэгэнтээ судлан тогтоосон билээ. Тухайлбал монгол нутагт байгаа Гуа дов, тэрэлжийн дөрвөлжин хэмээх хэрэм, барс хот, Баянбулагийн туурь зэргийг нэрлэж болно. Эдгээрээс үзвэл Хүннүчүүд нүүдлийн болон суурьшмал шинжийг хослуулсан аймаг байжээ. Модун Сайн хаан урагш хойш, баруун, зүүн тийш байлдан дагуулсан төдийгүй Европын олон улс оронтой өргөн харилцаатай байсны гэрч баримт олдсоор байна. Тухайлбал Ноён уулын 6 дах булшнаас Грек -Бактрын гаралтай торгон эд гарсан нь үүнийг нотолж байна. Тийм хол орших оронтой харилцаатай байсан тул, хөрш зэргэлдээ хятад улстай дан ганц байлдаж байсан мэтээр ойлговол өрөөсгөл болно. Тэгээд ч Хүннүчүүдийн ихэс дээдсийн булш бунханаас өмнөд хөршийн өдий төдий эд өлгийн зүйлс гардаг нь маш өргөн харилцаатай байсныг илтгэнэ. Ийнхүү Ази, Европын олон улс оронтой өргөн харилцаатай байсан нь Хүннүчүүдийн түүх соёл урлаг уран баримал хөгжихөд түлхэц болжээ. Тухайлбал Ноён уулын булшнаас ноосон нэхмэл, барааны үлдэгдэл, нэхмэл хийхээр бэлтгэсэн утас гарсныг лабораторын аргаар шинжлэхэд тэмээ хонины ноосыг маш жигд ээрсэн утас байсан байна. Үүнийг зөвхөн оньсон хүрд хэрэглэж ээрсэн байхаас биш гар аргаар хийх боломжгүй юм. Энэ бүхнээс харахад Хүннүчүүд малынхаа ноосоор нэхмэл үйлдвэрлэх арга техниктэй байсан байна. Бас Ноён уулын булшнаас гаж сонин амьтад хээ угалзыг тэгш хэмийн зохиомжоор байрлуулсан утас ороох аргаар хийсэн хатгамал хөрөг бүхий ширмэл ширдэг гарчээ. Хүнчүүд алтаар маш нарийн эдлэл хийж байв. Жишээ нь ноён уулаас олдсон хутганы алтан шармал иш, хазаарын алтан шармал товруу, хүний алтан дүрс зэрэг архелогийн олдворууд энэ дүгнэлтийг батална. Түүнчлэн янз бүрийн зориулалтын шавар ваар, сав, модон сийлбэр зэргийг дурьдаж болно.

Хүннүчүүд

Хятадын "Ши-Жи" хэмээхүйд МЭӨ 2000 гаруй жилийн урьд "Шань-жун Хяньюнь, Хуньюй гэдэг аймгууд умард хил залгаа нутагт нүүдлэн амьдардаг адуу, үхэр, тэмээ бог малтайгаас гадна илжиг, луус сайн үүлдрийн адуу өсгөдөг байжээ. Бичиг үсэггүй хууль журмыг амаар зарлан сул чөлөөтэй дайн дажингүй цагтаа малаа маллахын зэрэгцээ ан аваар хөөцөлддөг. Уулгалах дайн хийхийн тулд цөм цэргийн сургууль хийн Нум сум, сэлэм жадаар зэвсэглэн тулаанд амжилт олохооргүй бол ухрах бөгөөд ухрах нь тийм ичгүүртэй явдал биш байв. Ноос, арьсан эдээр гэрээ бүрэн бие биеэ нэрээр нь дуудах заншилтай бөгөөд алдар цол гуншин

байхгүй" гэхчлэн тэмдэглэн үлдээжээ.

Угтаа Хяньюнь, Хуньюй гэдэг нь нэг аймгийн нэр бөгөөд МЭӨ 2000-гаад жилийн тэртээ байсан хятадын Тан улсын үед тэднийг Хуньюй, МЭӨ 1127-247 онд байсан Жоу улсын үед 'Хяньюнь' МЭӨ 246- 206 онд байсан Цинь улсын үед 'Хүннү' гэж нэрлэх болсон ажээ. Энэ бүхнээс Модун хааны үеээс урагш 2000 гаад жилийн өмнө Хүнчүүд адуу, үхэр, тэмээ бог мал илжиг сайн үүлдэрийн адуу өсгөж байсан нь тодорхой байна. Илжиг, луус бол суурьшмал иргэдийн эдэлгээний амьтад тул Хүнчүүд дөрвөн цагийн эргэлтэнд нүүгээд байсангүй суурьшмал байдалтай байсныг гэрчилнэ. Тэгэхлээр манай босгон дээр мандан бадарч байсан Модун Сайн хааны Хүн гүрний үед хагас суурьшмал тэрхүү байдлаа алдаж байсан хэмээх үндэсгүй юм.

Хүнчүүд бас "Ши-Жи"-д бичсэн шиг бичиг үсэггүй байсангүй. Хүнчүүд малаа маллахын хажуугаар ан хийдэг, дайнд бэлтгэж цэргийн сургууль хийдэг байжээ. Бүүр хүүхэд ахуй үеэсээ харваж, намнахад суралцаж жил бүрийн намар их ав хомрого зохиохын хамт хүн малаа тоолдог байсан нь цэргийн нэгдсэн зохион байгуулалтад орох урьдчилсан нөхцөл болж байлаа. Эдгээр МЭӨ 2000 оны үед хамаарагдах бөгөөд Хүн нар өөдөлж уруудахын аль альныг амссаар МЭӨ 3-р зуунтай золгох үед 24 аймгийн холбоонд нэгдэх шатандаа ороод байсан ч нэгэн дор жолоодох хүнийг дээд тэнгэр харахан заяагаагүй байв. Энэ үед Хүннүчүүд Хянганы нурууны баруун үзүүр, Ордос хавиар нутаглаж баруун талаараа Юэчжи, Дорнод талаараа Дунху аймгуудтай хаяа нийлэн оршиж байлаа.

Төв Азийн өргөн уудам нутаг дах нүүдлийн энэхүү гурван аймгийн аль нэг нь түүхэн хувь заяагаараа цойлон гарч ирэх нь ойртож байв. Энэ үед буюу МЭӨ 307 оноос Хятадын хаан эзэгнэж ирсэн Жаогийн угсааныхан засгийн эрхийг ёс төдий барьж байсан бөгөөд нарийндаа бие биетэйгээ шөргөлдсөн муж улсуудын холбоо төдийхөн байв. Ийнхүү Ази тивийн нүүдэлчин аймаг зон олны мандаж уруудаж байсан он жилүүд улиран одож МЭӨ 246 оны босгон дээр тулж ирэв. Энэ үед хятадын хязгаар нутгийн Цинь хэмээх муж улсын захирагч Ин Чжэн бусдын дундаас цойлон гарч ирээд зэргэлдээх зургаан улсыг мохоон эрхшээлдээ оруулан их Цинь хятад улс байгуулах үндэс суурыг тавьснаар нүүдэлчин аймаг улсуудын гадаад нөхцөл байдал тун ч таагүй болж ирэв. Хүнчүүдийн нэгэн зурвас үеийн буурал доройтол нь Ин Чжэний явуулсан бодлоготой шууд холбоотой байв. Их Цинь улсыг байгуулж Цинь Ши-Хуандий буюу анхны эзэн хаан хэмээн өргөмжлөгдсөн Ин Чжэн болон Модуны эзэнт Хүн улсын Түмэн Шаньюй хоёр нэгэн цаг үед амьдарч тус тусын улсын хувь заяаг атгаж байсан бөгөөд

гайхалтай нь хоёул хоёр хоёр хүүтэй, тэдний хувь тавилан нь тун ч төстэйгөөр төгссөн түүхтэй бөлгөө. Ин чжэн бол агуу их шинэтгэгч байсан хэдий ч харгис хэрцгийгээрээ зард гарч хятадын эртний гүн ухаантан Күнзийн сургаалийг номлогч 500 эрдэмтдийг амьдаар нь газарт булж, цөлөхийг нь цөлж цагаан хэрмэн дээр ажиллуулан, цаазалж харгис бурангуй ёс тогтоосноос түүний байгуулсан улс амархан мөхсөн юм. Цинь Ши-Хуандий хэдий харгис хүн байсан ч цагаан хэрмийг босгох ажлыг үргэлжүүлэх Хүннү нарыг Ордос хавийн нутгаас нь шахан зайлуулах зэрэг алсын бодлого явуулснаараа Хятад улсын хувьд түүхэн гавъяа байгуулсан эзэн хаанд тооцогддог.

Хүннүчүүд хөөгдсөн нь

Ази тивийн нүүдэлчин улсууд түүхэн хувь заяагаараа мандах нь мандаж, уруудах нь уруудаж байсан он жилүүд улиран одож МЭӨ 246 онтой золгоод байлаа. Цинь улс хүчирхэгжин мандаж хөрш зэргэлдээх нүүдэлчин улсуудад аюул учруулж эхэлсэн тэр үед Хүннүчүүд шар мөрний бор тохой ордос хавиар нүүдэллэн 24 аймгийн нэгдсэн холбооны улс болов. 24 аймгийн зонхилогч нарын хуралдайгаар Түмэнг Шаньюйд өргөмжлөв.

Хүннүчүүдийн урд талаар Цинь улстай хиллэж, Дорнод талаар хөрш аймгууд аюул учруулах болж баруун талаар нь Кушан аймаг залган цэцэглэж байв. Түмэн Шаньюй төрийн алтан жолоог чанга атгах чадвараар сулхан байсан хэдий ч төр улсынхаа болон цэргийн чиглэлтэй зарим нэг шинэтгэлийг хийсэн нь хожим Хүн гүрэн мандан бадрахад их тус болжээ. Түмэн Шаньюйн үед Хүн улсын аймгийн зонхилогчдын зөвлөл (хуралдай) буй болж нүүдэл суудал дайн тулаан хөрш улс оронтой харилцах зэрэг улс гүрнийхээ хувь заяатай холбоо бүхий асуудлыг хамтран шийддэг нэгэн журам тогтсон байна. Энэ бол төр улсын үйл хэргийн шинэчлэл байлаа. Гэвч дээд тал нь түм доод тал нь хэдэн мянган цэргийг гаргаж чадахуйц аймгийг нэгтгэн захирна гэдэг санасан зоргоор бүтэх амар ажил биш билээ. Хээр тал нутгийн хүмүүс эрт дээр үед эрх дураараа нүүдэллэн амьдарч ирсэн тул суурьшмал улсуудын иргэд шиг нэгэн гарт хялбар хумигдаж өгөхгүй байв. Гэвч Түмэн Шаньюй Хүн улсыг хөрш зэргэлдээх нүүдэлч хийгээд суурин улсуудтай эн зэрэгцэхүйц өөрийн гэсэн өвөрмөц зохион байгуулалттай уугуул ус суугуул нутагтай бичиг соёлтой улс болгож чадсан юм.

Шаньюйн хатныг Яньжи хэмээн өргөмжилдөг байв. Түмэн шаньюйн анхны Яньжигеас ууган хүү төрснийг Модун хэмээн нэрлэв. Тэр үед тогтсон ёсоор ахмад хүү нь үе залгамжлах эрхтэй байжээ.

Шаньюйн үе залгамжлагч Модун нь эцгийгээ амьд сэрүүн байхад зүүн гарын Жуки хэргэмийг эдлэх төр улсдаа хоёр дах зиндаанд багтах хүн болов. Түүний мэндэлсэн он тодорхой боловч харь газар барьцаанд очихдоо 14-16 орчим настай байснаас хөөж үзвэл МЭӨ 234 онд төрсөн болж таарах нь. Түмэн Шаньюйн анхны Яньжи буюу Модуны эх залуугаараа нас барж Шаньюй хоёр дахь эхнэрээ авч бас нэг хүү төрүүлсэн байна. Шаньюйн Яньжийн эцэг нь төрийн их нагац (төрийн заргач) хэргэм эдэлдэг улсдаа гурав дах зиндаанд багтах эрх дархтай болдог тул шинэхэн яньжин талынхан зээ хүүгээ хожим Шаньюйн ширээнд суулгах холын бодол өвөрлөж Модунг холдуулах арга сүвэгчилэх болсон байна. Түмэн Шаньюй ч залуу эхнэр Яньжийнхаа үгнээс гарахаа байж хүүгээсээ хөндийрэх болов. Яг тэр үед МЭӨ 214 онд эзэн хаан Цинь Ши Хуандий Хүн улс Цинь улсын төрийг булааж магадгүй хэмээн болгоомжилж, гарамгай жанжин Мэнь тэнь ийг бэлтгэж хүн улс уруу довтолгож ялав.

Модуны хувь заяа

Хүнчүүдийн бууран доройтож байгааг Юэчжи, Дунху мэтийн нүүдэлчин хүчирхэг аймгууд ажиглан харж байлаа. Цинь улсын цэргийн жанжин Мэнь Тянь-ийн дарангуй их цэрэгт хүнчүүд хөөгдөн хүч нь ихэд сарнисан үеийг ашиглан Юэчжийн ван Кидолу Түмэн Шаньюйд элч илгээж, эв найртай байхын баталгаа шаардлаа. Энэ нь хунтайж хөвгүүдийхээ аль нэгийг барьцаанд ирүүл гэсэн үг байв. Эл шаардлагаас эс биелүүлбээс дайн тулаанд хүрэх тул тэртээ тэргүй хүнд байдалд орсон Шаньюй зарим аймгийн зонхилогч нарынхаа эсэргүүцлийг үл хайхран Модунг барьцаанд явуулснаар Яньжи болон Сюйбу аймгийнхны зорилго биеллээ.

Түмэн Шаньюй анхны Яньжигаа өөд болсноос хойш Хүн улсын тэргүүлэх гурван аймгийн нэг Сюйбу аймгийн зонхилогчийн охиныг Яньжигаа болгон авч хүүтэй болсон билээ.

Хүн улсын ёс журмаар бол Шаньюйд ахмад хүү нь үе залгамжлагч төдийгүй улсдаа Шаньюйн дараа орох зүүн гарын жуки хэргэмтэй, түмтийн ноён байх ёстой учраас Модун энэнд багтаж байлаа. Гэтэл Шаньюйн залуу Яньжи, мөн Сюйбу аймгийхан Модунг ямар нэгэн аргаар зайлуулж, оронд нь дүүг нь үе залгамжлагч болгохоор хуйвалдаж байсныгаа Юэчжийн эзний элч зардас ирснээр хэрэгжүүлэх боломж олдсон нь тэр байлаа. Тийнхүү 10 гаруйхан настай Модун Юэчжи нарт хойт эхийнхээ түлхээсээр барьцаалагдав.

Юэчжийн ван Кидолу их дайн тулаан хийж байж Модунг олзолсон мэт аашилж, харь газрын элч зардсыг хүлээн авч найр

хийхдээ Модунг заавал байлцуулан хэрвээ Хүнчүүдийн талаас хэн нэгэн хилийн дээс зөрчих аваас толгой чинь ойчих болно гэдгийг байнга сануулдаг байсан агаад гавлаар чинь аяга хийнэ шүү, үлгэрлэвэл үүн лүгээ адил гээд урьд нь хилийн будлианы үед шархдаж олзлогдсон Хүн улсын нэгэн мянгатын ноёны мөнгөлсөн гавал аяганд сархад хийж, зочин гийчдэд барьдаг байжээ. Тэгээд заримдаа уг аягыг дээш өргөн, эргүүлж тойруулан харж, бахаа хангаад "Модун! хүү минь! Чи хүн улсын Шаньюйн үе залгамжлагч, зүүн гарын Жуки, хунтайж тул нэгэн мянгатын ноёноос өөр хүн юм. Тийм болохоор хунтайжийн гавлыг мөнгөөр биш алтаар чимэглэнэ шүү дээ!" гэдэг байжээ.

Харь газар, харийн хүмүүсийн харгис хатуу доромжлол, гадуурхал бага балчир Модуны ааш араншинд огцом өөрчлөлт оруулж хэрсүүжүүлэн ухаан бодлыг нь тэлж байлаа. Кидолу ван нэгэн удаа Хан улсын эзэн хааны элчийг хүлээн авч, их найр хурим үүсгэн цэнгэж асан хөл хөдөлгөөн ихтэй, анхаарал сарнисан үеийг ашиглан шөнийн түнэр харангуй эхэлмэгц Модун Юэчжийн мянганы газрыг сааталгүй давхидаг Тэнгэрийн хэмээн алдаршсан гайхамшигт хүлгийг сэм унаж, зугатаан үүрээр хилийн дээс алхан байхуйд Хүн улсын Сюйбу аймгийн зонхилогч, Түмэнгийн хадам эцэг зориудаар илгээсэн нэгэн мянгат Юэчжийн хил зөрчиж байв. Хараа бараагаа харах өндөрлөгүүд дээр хуурай ойд харгана, аргал овоолон бэлтгэж дайсан хил зөрчмөгц асаан дохио өгөхөд дараагийнх нь асах зэргээр хоромхон зуур нутгийн гүнд мэдээ хүргэдэг аргыг нь хүнчүүдээс эзэмшсэн Юэчжийн хилийн харуулынхан "дайсан довтлов, барьцааны хүний тоглойд автугай!" гэсэн дохио болгож, анхныхаа түүдгийг асаан мэдээлж ахуй мөчид Модун төрөлх газар шороон дээрээ баттай гишгэж, нутгийнхаа гүн тийш салхи татуулан давхиж явав. Цэрэггүй ганц бяцхан хүүд Юэчжийнхэн, Яньжийн талынхан ялагдсан нь энэ буюу. Хэрэв Модун алагдсан бол хойт эх болох Яньжигас төрсөн эцэг нэгт дүү нь үе залгамжлагч болох бөгөөд зүүн гарын Жуки хэргэмийг эдэлж, Яньжигийн эцэг Сюйбу аймгийн зонхилогч түмтийн ноёны зэрэг дэв ахиж, төр улсдаа гуравт орох байв. Түмэнгийн анхны Яньжийн эцэг амьд сэрүүн, төрийн их нагацын зэрэг дэвээ эдэлсээр байсан тул залуу Яньжийн эцгийг Бага нагац хэмээн өргөмжилж байжээ. Яньжи болон бага нагац нар өөрсдөдөө төдийгүй ургийн урагтаа уршиг тарих санаа сэдэж, гай гамшиг чирсэн юм. Модун барьцаанаас зугатаж, гэнэт хүрч ирсэн нь түүнийг алуулсан хэмээн тооцож, бодож санаснаа гүйцэтгэхээр зэхэцгээж байсан хүн бүхэнд хүчтэй цохилт, гэнэтийн явдал болсон нь гарцаагүй.

Үе залгамжлагч, зүүн гарын Жуки

Түмэн Шаньюй эцэг нь юм болохоор хүүгээ эр зориг гарган барьцаанаас мултарч ирсэнд баярлан, Орхоны их цагаан тохойд төрийн найр хийх хугацаа заан товлож, харин дөрвөн аймгийн зонхилогч, ихэс ноёдод зар хүргүүлсэнд тэр болгон шалтаг заан хуралдайд ирдэггүй хязгаар нутгийн Луули вангууд хүртэл цөм цугларсан нь Шаньюйг гэхээсээ Модуны амнаас үг сонсох, байдлыг тандах гэсэн сэтгэлдээ хөтлөгдөн товлосон өдөр нь морилон ирцгээжээ. Найр наадам эхлэхийн урьд өдөр хорин дөрвөн аймгийн түмтийн ноёдын их хурилдай болж, түүн дээр эцэг Шаньюй ахмад хүү Модуныгаа магтаж, үе залгамжлагч бөгөөд зүүн гарын Жуки хэмээн зарлахад Модун энэ хэргэм цолоос татгалзаж, Хэрэв эцэг минь та зөвшөөрвөл өөрийн гэсэн эдлэн газраа заалгаж авъя хэмээжээ.

Ямар учраас татгалзсан нь тодорхойгүй боловч түүний цааш цаашдын үйл явдлаас заншлан хөөж үзэхүл тэрбээр хэзээ нэгэн цагт эцгийн ор суух ахмад хөвүүн гэдгээ тооцоолж, сэтгэлийн гүнд тээж яваа бодлоо хэрэгжүүлэхэд сайтар бэлтгэх гэсэн нэгэн зорилгыг хадгалсан мэт санагдана. Их хуралдай дээр эцэг Шаньюйгаас эхлээд хорин дөрвөн аймгийн ихэс ноёдууд хэргэм зэргээс татгалзаж болохгүй хэмээн Модуныг ятгасан ч зүтгэсээр байгаад Юэчжитэй хил залгаа, түмэн цэрэг гаргаж чадах эдлэн газрыг заалган авч, наадамд ч оролцолгүйгээр тэр өдрөө бие хамгаалах цөөн цэрэгтэйгээр мордсон байна. Ер нь Модунг "ер бишийн хүүхэд" гэгцгээж, ойртох нь ойртож, холдох нь холдож, дөлөх нь дөлж, битүүхэндээ Хүн улсын хорин дөрвөн аймгийхан хоёр хуваагдаж байв. Баримт сэлтэд тэмдэглэснээр, улсынхаа гурав дахь зиндааны хүн болох баруун гарын Жуки Гийгун хүртэл Модуны талд орсоноор Түмэн Шаньюй ганцаардан, өөрийн хадам Суйбу аймгийн зонхилогч бөгөөд улсын бага нагац зэрэг цөөн тооны вангуудыг түшиглэхээс өөр замгүй болсон ажээ. Түмэн Шаньюй тэргүүтэй Хүн улсын тэрхэн мөчийн цаг үеийн байдал ийм байв. Өөрөөр хэлбэл хагарлын замд эргэлт буцалтгүй оржээ. Энэ явдлаас хойш хэдэн жил өнгөрсөн ч Хүн улсын гадаад, дотоод байдалд анхаарал татахуйц онцгой өөрчлөлт гарсан эсэх талаар эх сурвалжид тэмдэглэсэн нь үгүй билээ.

МЭӨ 213-209 оны хооронд Модун өөрийн эдлэн газартаа амьдрах хугацаанд Тэлэнгид аймгийн нэгэн сурвалжит ноёны охиныг хатнаа болгон авч, морины зүс нийлүүлэх, дуут сумны

дохиог өчилгүй дагах гэхчлэнгээр цэргийн цоо шинэ шинэтгэл хийж байв. Тухайлбал өрнө этгээдэд дан цагаан морьтой, умардад хар морьтой, өмнөдөд саарал морьтой, дорнодод хул морьтой цэргүүд байрлах, эсвэл гэнэт зүсэм зүсмээр гарч ирэх гэхчлэнгээр цэргийн зохион байгуулалт хийсэн нь тэдний сүр хүчийг ихэд нэмэгдүүлжээ. Дуут сум гаргасан явдал тухайн цагийн зэр зэвсгийн оргил нь болж, цэргүүдээ нэгэн сумны дор нэгтгэх гэсэн арга байв. Ан авын явдал хэдийгээр хүнчүүдийн нэг эх үүсвэр төдийгүй дайн тулаан хийх томоохон сургууль болдог болохоор, түүнд Шаньюйгаас эхлээд бүгдээрээ анхаарал хандуулдаг, бэлтгэлийг сайн базаадаг байсан хэдий ч эмх замбараа муутай явагддагыг өөрчилж, цэргийн зохион байгуулалттайгаар авлалт хийх санааг Модун анх сэдэж туршсан юм.

МОДУН САЙН ХААНЫ НАМТАРТ ХОЛБОГДОХ ОН ЖИЛҮҮД

МЭӨ 307 он

Жао улсын угсааны их ван Ву-Лин Цагаан хэрмийг Иньшан уулын хормойгоор босгож эхлэв.

МЭӨ 255 он

Хүн улсын Түмэн Шаньюй төрөв. Хятадын Жао улс мөхөж, Хан улсын хаанчлал эхлэв.

МЭӨ 246 он

Ин Чжэн өөрийгөө анхны хаан гэсэн утгаар Цинь Ши-Хуандий хэмээн өргөмжлүүлж, Хятадын төвлөрсөн улсыг байгуулав.

МЭӨ 240 он

Цинь Ши-Хуандий түмэн газрын урт цагаан хэрмийг үргэлжлүүлэн босгож эхлэв.

МЭӨ 226 он

Цинь улс Юэчжи аймагтай холбоо тогтоов. Цинь Ши-Хуандий зүүн муж улсуудыг өөртөө нэгтгэв.

МЭӨ 214 он

Цинь Ши-Хуандий Мэн Тян жанжныг 100000 цэрэгтэйгээр умард хил тийш явуулж, хүннүчүүдээс Ордос, Иньшан зэрэг газрыг булааж эхлэв.

Хүн Улсын Түмэн Шаньюй харъяат албатаа авч зугтаан их говийн хойд талд гарав. Мэнь Тян хилийн дагуу хот тосгон барих ажлыг эхлүүлэв. Түмэн Шаньюй Юэчжи аймгийн анхны шаардлагаар хүү Модунгаа барьцаанд хүргүүлэв.

МЭӨ 213 он

Модун Юэчжигийн эзэн Кидулогийн Тэнгэрийн Хүлэг-ийг унаж зугатаж ирэв. Модун үе залгамжлагч хэргэмээс татагалзаж, өөрийн эдлэн газраа заалгав.

МЭӨ 212-208 он

Модун байлдааны дуут сум зохиож, цэрэг дарга нараа өчилгүй дагах зохион байгуулалтад оруулав.

МЭӨ 210 он

Цинь Ши-Хуандий нас барж, үе залгамжлагч ахмад хүү Фу-Су нь амиа золиослон удаах хүү Ху-Хай нь эзэн хаан болов. Мэнь Тянь жанжин шоронд амиа хорлов.

МЭӨ 209 он

Хүн улсын төрийн их ав хомрогын үеэр Модун эцгээ харван алж, Шаньюй болов.

МЭӨ 208 он

Модун Сайн Хаан Дунхугийн эзэн Гэхүтүтэй байлдаж ялав.

МЭӨ 207 он

Цинь угсааны сүүлчийн хаан Лю Баньд бууж өгөв.

МЭӨ 206 он

Хятадын Хан улсын хаанчлал эхэлж, Лю Бань /Гао Цзу өндөр өвөг цол авч/эзэн хаан болов.

МЭӨ 205-204 он

Модун Сайн Хаан Ордос дахь Лэүфань, Баян аймгуудыг эзэлж уугуул нутгаа буцааж авав.

МЭӨ 203-202 он

Модун Сайн хаан хойд хилээ анхаарч, Хуньюй, Кюеше-Кипчак, Диплин аймгуудыг байлдан эзлэв.

МЭӨ 202 он

Хятадын иргэний дайн Гао Цзу эзэн хааны ялалтаар дуусав. Хүнчүүд Хан улсын хилийн Май хэмээх цайз бэхлэлтийг бүсэлж, цайзын захирагч Хань Синь Модунд бууж өгөв.

МЭӨ 200 он

Модун Сайн хааны цэрэг давшилж, хойд Шаньсигийн нийслэл Цзиньян хотод тулж ирэв.

Гао Цзу эзэн хаан их цэргээ хөдөлгөн байлдахаар мордоод Пинчен хотын ойролцоох Байдын хэмээх тосгоны дэргэд Модун Сайн хааны цэрэгт бүслэгдэв. Гао Цзу эзэн хаан Модун Сайн хаанд элч илгээж, Энх ураг барилдах-ыг санал болгож, хэлцэл хийснээр бүслэлтээс гарав.

МЭӨ 198 он

Хан улсын эзэн хаанаас Модунд нотлох бичиг ирүүлэв.

МЭӨ 177 он

Модун Сайн хаан их цэргээ авч Юэчжийг байлдан ялалт байгуулан одоогийн Дундад Азийн дорнод хэсгийг өөртөө нэгтгэв.

МЭӨ 174 он

Модун Сайн хаан /Шаньюй/нас барж, түүний ахмад хүү Гиюй эцгийн ор суув.

МЭӨ 158 он

Хан Улс хилийн боомтоо хааж, хэлцлийг зөрчсөн учир Гюньчен Шаньюй дайн зарлав. МЭӨ 157 он
Эзэн хаан Вань Ди нас барж, Цзин Ди ор залган суув.

МЭӨ 154 он

Хан Улсын дотоодын самуун дарагдав.

МЭӨ 152 он

Цзин Ди эзэн хаан умард хилийн боомтуудыг нээж, Хүн улстай чөлөөт худалдаа хийхийг зөвшөөрөв.

МЭӨ 126 он

Хүн улсыг байгуулагч Чэньли Гуту- Модун Сайн хааны ач Геньчин Шаньюй их өвгийнхөө үйл хэргийг амжилттай хэрэгжүүлээд насан хутгийг олов.

Хүннү улс

МЭӨ 3-р зуунд эртний нүүдэлчин аймгийнханы байгуулсан Төв Ази дахь анхны нэгдсэн төр улсыг үндэслэгч нь Түмэн Шаньюй билээ. 'Шаньюй' гэдэг нь өнөөгийн ойлголтоор 'удирдагч эзэн' 'хаан' гэсэн утгатай үг юм. Хүннү нар өнөөгийн Монгол улсын нутгаар төвлөрөн дорно зүгт Хянганы нуруу, өрнө зүгт Алтайн уулс, умардад Байгаль нуур, өмнөдөд өнөөгийн Өвөр Монголын Ордос нутаг хүртэл тархан нүүдэллэж байв. Хүннү нар мал аж ахуй голлон эрхлэхээс гадна ан ав хийдэг байжээ.

Түмэн Шаньюй

Их Хүннү гүрнийг үндэслэгчийн төрсөн он нь тодорхойгүй. МЭӨ 209 он хүртэл улсаа удирдаад, төрсөн хүү Модуньдаа залгуулсан.

Түмэнгийн үеэс эхлэн Хүннү нар засгийн эрхийг үе залгамжлан барих болсон. Өөрөөр хэлбэл засгийн эрх эцгээс хүүд шилжих болжээ.

Түмэн Шаньюй төр улс, цэргийн талаар зарим нэг шинэтгэлийг хийсэн. Тухайлбал түүний үед "Хүннү Улсын 24 аймгийн

Зонхилогчдын Зөвлөл" буюу "Хуралдай" буй болж, нүүдэл суудал, дайн тулаан, хөрш улс оронтой харилцах харилцаа зэрэг улс гүрнийхээ хувь заяатай холбоотой амин асуудлыг хамтран шийддэг журам тогтжээ.

Модун Шаньюй

Түмэн Шаньюйн хүү. МЭӨ 234 оны үед төрж, МЭӨ 209-176 онуудад улсаа удирдсан. Модуны үед Хүннү гүрэн хөгжлийнхөө дээд цэгт хүрсэн. Модун сайн хаан Хүннү гүрний нутгийг өргөтгөн тэлж, баруунаа Юэчжи хэмээх аймгийг эзлэн, өмнө зүгт Хятадад булаагдсан урт цагаан хэрмээс хойшхи нутгийг эргүүлэн авч, "Газар бол төрийн үндэс" хэмээн сургамжилжээ. Модун аравт, зуут, мянгат, түмт гэж хуваасан хуяг бүхий морин цэрэгтэй байсан бөгөөд хүн, мал, багаж зэвсгийн тооллого явуулан, алба татвар тогтоох, сурвалжитны үе улирах эрхийг бэхжүүлэх зэрэг хэд хэдэн шинэтгэл хийжээ.

Үжүлү Жоди

Түмэн Шаньюй-гаас эхэлж тоолбол Хүннү гүрний 18 дахь хаан болох бөгөөд жинхэнэ нэр нь Нэньжияс, оны цол нь Үжүлү Жоди юм. Үжүлү Жоди Хүннү гүрэн 'баруун' 'зүүн'-д хуваагдаад 50 шахам жил болж, гадны хүчинд автаж эхэлсэн улсыг хүлээн авч, МЭӨ-8 оноос МЭ-13 онуудад улсаа удирджээ. Тэр хаан суумагцаа тал тал тийш довтлон байлдалгүй, улсынхаа дотоод байдлыг засан тохируулж, хөрш Хан улстайгаа найрсаг байхыг эрмэлзэж байв. Хөрш улсууд нь ч Хүннү гүрэнтэй эв найрамдалтай байхыг хичээх болсонд Үжүлү Жодигийн хаанчлалын гол ач холбогдол оршино.

Нүүдэллэсэн Хүннүчүүд

Хүннү гүрэн МЭӨ 55 онд 'умард' 'өмнөд' болон хуваагдсанаасаа хойш 2-р зууны эхээр хүчирхэгжсэн Сяньби хэмээх улсад захирагдах болсон байна. Харин бие дааж үлдсэн хүннүчүүдийн нэг хэсэг нь 155 оноос эхлэн өрнө зүгт буюу Европ тив тийш нүүдэллэсэн юм. Хүннүчүүд нүүдэллэн явахдаа зам зуур тохиолдох зарим ард түмнүүдийг байлдан дагуулж, заримыг нь өрнө зүгт шахсаар 4-р зууны дунд үеэс Европ тив даяар 'Гунну' хэмээх нэрээр гарч иржээ. 'Гунну' нь 'Хүннү' гэсэн нэр европчуудын дуудлагаар ялимгүй өөрчлөгдсөн хэрэг юм.

Атилла хаан

434 оноос эхлэн хаанчилсан Хүннү нарын хаан. 406 оны орчим төрж, 47 насалж, 19 жил төрийн эрх барьсан. Язгууртан дээдсийн мэдэлд хуваагдан захирагдаж байсан хүннүчүүдийг

өөрийн удирдлаган дор нэгтгэж, нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ Чингис хаан, түүний хөвгүүд, ач нарын байгуулсан Монголын их гүрний дараа орох улсыг, тэднээс зургаан зууны өмнө Европоор төвлөрүүлэн байгуулсан юм. Энэ гүрэн өрнө зүгт Рейн мөрөн, дорно зүгт Ижил мөрөн, умар зүгт Балтийн тэнгис, өмнө зүгт Адриатын тэнгис, Ирантай хиллэж, герман, славян, скиф болон бусад нүүдэлчин ард түмнийг засаглаж байв. Атилла хааны үед Хүннү аймгуудын холбоо хамгийн их хүчирхэгжсэн. 430 оны үед Аттилийн хүннү нар ойролцоогоор 600 000-700 000 орчим байсан гэдэг.

Хүннү Улсын Шаньюй нарын үе залгамж

1. Түмэн /МЭӨ 209он хүртэл Шаньюй суув/
2. Түмэнгийн хүү Модун /МЭӨ 209-174 онд хаан суув/
3. Модуны хүү Гиюй (оны цол нь Лаошан) /МЭӨ 174-161/
4. Лаошан Гиюйн хүү Гюньчен /МЭӨ 161-126 он/
5. Гюньчен Ичишь /МЭӨ 126-114/
6. Ичишийн хүү Увэй /МЭӨ 114-105 он/
7. Увэйгийн хүү Ушылу (оны цол нь Эрр Шаньюй) /МЭӨ 105-103/
8. Увэйгийн дүү Гулиху /МЭӨ 103-101/
9. Гулихугийн хүү Зүйдиху /МЭӨ 101-97 он/
10. Зүйдихугийн хүү Хулгу /МЭӨ 96-85/
11. Хулгугийн хүү Хуяньти /МЭӨ 85-69/
12. Хуяньтигийн дүү Хюйлюй-Цюанькай /МЭӨ 68-60/
13. Ушылугийн ач хүү Туцитан (оны цол нь Уянгуди)
14. Хюйлюй-Цюанькайн хүү Гихэушань (оны цол нь Хуханье) /МЭӨ 58-31 он/
15. Гихэушанийн хүү Дяотаомагао (оны цол нь Фүжүлэй Жоди) /МЭӨ 29-20 он/
16. Дяотаомагаогийн дүү Зюймисюй (оны цол нь Соужэ Жоди) /МЭӨ 19-11 он/
17. Зюймисюйн дүү Зюймогюй (оны цол нь Гюйю Жоди) /МЭӨ 11-8 он/
18. Зюймогюйн дүү Нэньжияс (оны цол нь Үжүлү Жоди) /МЭӨ-8 МЭ-13он/
19. Хянь (оны цол нь Үлэй Жоди) /МЭ 14-18 он/
20. Юй (оны цол нь Худурши) /МЭ 19-46 он/
21. Умардын Шаньюй Пуну /46он/
22. Өмнөдийн Шаньюй Убабихэу /46он/

Хүн улс умард, өмнөд хэсэгт хуваагдаж өмнөд хэсэг нь Хятадад дагаар орж, умард хэсэг нь Сяньбид эзлэгдэв.

АЛТАН УРГИЙН ХААДУУД

Алтан ураг

'Алтан ураг' гэдэг бол монгол хаадын угсааны сурвалжит овог юм. Алтан ургийн хамгийн ууган нь Бодончар бөгөөд тэр бээр 10-р зууны эцсээр олон монгол аймгийн ихэнхийг нь захирч байжээ. Бодончараас улбаалан, Тэмүжинээр буухиалан Лигдэн хүртэлх Монголын бүх их хаад цөм 'Алтан Ураг'-аас эх сурвалжтай билээ.

Хамаг Монгол

М.Э ний 8- аас 9-р зууны үед монголчуудын овгийн байгуулал задарч, аймгуудын холбоо байгуулагдан, төрийн нэгдэл буй болж эхэлжээ. Чухам энэ үеэс эхлэн Монголын түүхэн хөгжлийн төв Гурван голын бэлчир буюу Онон, Хэрлэн, Туул голын сав газарт шилжсэн бөгөөд улмаар Монгол аймгуудын холбоо өргөжин хөгжсөөр "Хамаг Монгол Улс" байгуулагдсан түүхтэй. Хамаг Монгол Улс 1101-1206 оны дундах 100 гаруй жилийн хугацаанд оршин тогтнож байв.

Хабул хаан

Хамаг Монголыг үндэслэгч. 1101 онд төрж, 1130 онд хаанд өргөмжлөгдсөн. Хабул бол Хамаг Монгол Улсын эдийн засаг, цэргийн хүчийг зузаатгаж, улмаар Мэргэд, Хэрэйд, Найман зэрэг тэр үеийн томоохон аймгуудтай холбоо тогтоож, Зүрчидийн Алтан Улсаас удам угсаа, ард олноо сэргийлэн хамгаалж явсан эх оронч хаан юм. Хамаг Монгол Улс байгуулагдаагүй бол Их Монгол Улс байгуулагдахад бэрхшээл учрах байв. Тиймээс Хамаг Монгол улсыг байгуулсан нь Хабул хааны түүхэн гавьяа мөн билээ.

Амбагай хаан

Хамаг Монгол улсын хоёрдугаар хаан. Хабул хааны угсааны Сэнгүн Билгийн хүү. 1150-иад оны сүүл үе хүртэл улсаа удирдсан. Амбагай Хамаг Монголын төрийн зохион байгуулалтанд өөрчлөлт оруулж, 'тайш' хэмээх хааны дараа орох эрх мэдэлтнийг буй болгожээ. Тайш нь цэргийн хэргийг голлон мэддэг байв. Амбагай хааныг охиноо бэр болгож өгөхөөр очиход нь Татар аймгийнхан барьж, Алтан Улсад хүргүүлсэн бөгөөд Алтан Улсын хаан Амбагай

хааныг 'модон' илжгэнд хадаж' цаазалжээ.

Хотул Хаан

Хамаг Монголын гуравдугаар хаан. Хабул хааны хүү. 1150-иад оны сүүлч хүртэл улсаа удирдсан. Түүхэнд ер бусын хүч чадалтай, зоригтой баатар эр байсан хэмээн тэмдэглэгдсэн байдаг. Алтайн Улстай удаа дараалан тулалдаж, газар нутгаа хамгаалан тэмцэж, ялалт байгуулж явжээ.

Чингис хаан /1162-1227/

Монголын Нэгдсэн Улсыг үүсгэн байгуулагч, төрийн гарамгай зүтгэлтэн, цэргийн суут жанжин. Жинхэнэ нэр нь Тэмүүжин бөлгөө. Тэмүүжин Хамаг Монголыг нэгтгэн захирч, 1189 онд "Чингис хаан" хэмээн өргөмжлөгджээ. Яагаад гэвэл Заваа Дамдин гавжийн хорхойнжон буюу монголын түүхийн дэвтэрт Цагаан шувуу нисэн ирж өргөөг гурав тойрон чингэс чингэс хэмээн дуу гарсны улмаас дээд тэнгэрийн дохио хэмээн эзэн хааны алдрыг ийн хэмээн нэрийдэв. Энэ нь хоёр янзын улбаатай Нэгдүгээрт :Лувсан Иш шаврангийн нотолгоогоор монгол хүмүүн гадаад их анаваадын далайгаас хун шувуун сүрэг болон энэхүү орчлонд анхлан ирсэн тийм ч учраас хүмүүний ам цангадаг нь найман гишүүн төгөлдөр амтат далайгаа санагалзан буй хэрэг хэмээдэг бол

Хоёрдугаарт: Монголын нууц товчоонд Бërто чоно Гуа марал хоёр тэнгис далайг гатлан гэдэг нь одоогийн Байгаль далайг гатлан онон мөрний хөвөөнд ирж суурьшив гэдэг тэгээд 10 -р үе Боржигдой мэргэн таалал төгссөний Алунгоо хатан шөнө унтаж байхад тэнгэрээс галт шувуу нисэн ирж маш их гэрэл гарган цацруулан хатны бие давхар болсон гэдэг гэвч эцэггүй хүүхэд байхгүй гэж ад шоо үзэн Малиг баяны хүүхэд гэж төрсөн хөвүүн Бодончарыг ах нар нь гадуурхан хөөж тэрбээр хээрээр гэц хийн явахад харцаггай шувуу хоол унд зөөн өгч туслаж байсан нь шувуудтай монголчуудын төрөл удам хамаатай байгааг гэрчилэн буй нотолгоо гэж эрдэмтэд үздэг билээ. Чингис хаан 1205 оны эцсээр Гурван Мэргэдийн холбоо, Татар, Найман, Хэрэйд зэрэг монгол угсааны аймгуудыг нэгтгэж, нэгдсэн улс байгуулах нөхцлийг бүрдүүлсэн байна. Ази, Европын олон орныг довтолж, ард иргэдэд нь аюул занал учруулж байсан боловч тэдгээр аян дайн нь тэр бүр эзлэн түрэмгийлэх шинжтэй байгаагүй юм. Шудрага ёс тогтоох, хил хязгаараа бэхжүүлэх; улс төр, эдийн засгийн харилцаагаа ашигтайгаар шийдвэрлэх; нэгэн гарт зангидах зэрэг олон зорилт Чингис хаанд байжээ. Чингис хааны байлдан дагуулалтаас үүдэн олон улс орон өнөөдрийн өнгө төрхөө олсон.

Чингис өнөөгийн ардчиллын бэлэгдэл болсон "Их хуралдай"-гаар асуудлыг шийдвэрлүүлж, "Их Засаг" хуулийг гаргаж, төрийн бичгийг санаачилсан билээ.

Өгөөдэй хаан /1186-1241/

Монголын эзэнт гүрний хоёрдугаар хаан, Чингисийн гуравдугаар хүү. 1229 онд хаанд өргөмжлөгдмөгцөө Монголын төрийн зохион байгуулалтын талаар хэд хэдэн арга хэмжээ авч, гүйцэтгэх үүргийг тодорхой болгон, "Хааны санд хураах улсын нэгдсэн албан татварын хууль"-ийг гаргажээ. Улсын өртөөг өргөжүүлж, нийслэл Хар Хорумыг хөгжүүлсэн байна. Говь цөлд худаг гарган, "Өнчдийг тэтгэх сан" байгуулжээ. Өгэдэй хааны үед Умард Хятад, Ижил мөрний Болгар, Рязаний Вант Улс, Польш, Унгарыг байлдан дагуулсан юм. Тэр бээр эзэлсэн орнуудад ноёрхолоо бэхжүүлж, ард түмнийг нь захирах бодлогоо чангатгаж байв.

Зүчи хаан. /1178-1227/

Монголын эзэнт улсын бүрэлдэхүүнд багтаж байсан Зүчийн улсын эзэн. Чингис хааны ууган хүү. Хаан эцгээ дагаж олон удаагийн дайн тулаанд оролцож явсан боловч Зүчи хүчирхийллээс аль болох зайлсхийхийг оролддог байжээ. Чингис хаан эзэлсэн Сартуул улсаа Зүчийн мэдэлд өгч, улмаар тэр улс Зүчийн улс гэгдэх болжээ. Зүчийн улс өргөжин тэлж, хожим 'Алтан Ордны Улс' болсон бөгөөд 1221-1227 онд Зүчи тэр улсынхаа хаан байв.

Зүчийн улс

Монголын Эзэнт улсын бүрэлдэхүүнд багтаж байсан Зүчийн улс нь Эрчис мөрнөөс Амударьяа мөрний адаг, Хоризм, Сырдарьяа мөрний адаг хүртэлх нутагт оршин тогтнож байв. Монголын Юан гүрний үед бие даасан байдалтай болжээ. Юан гүрний үед бие даасан байдалтай болжээ. Зүчийн ахмад хүү Бат тус улсыг өргөтгөн тэлж, 1243 оноос Зүчийн улс 'Алтан Ордны улс' гэгдэх болжээ.

Алтан Ордны улс

Монголын эзэнт улсын нэг хэсэг. Бат хаан тэргүүтэй Монголын ихэс дээдэс баруун замд хийсэн аян дайныхаа дараа Ижил мөрний адагт нутагшин захиргаандаа оруулсан газар орныг 1243 оны үеэс эхлэн "Алтан ордны улс" хэмээн нэрлэх болжээ. Энэ их гүрэнд

Эрчис мөрнөөс Днепр хүртэлх газар нутаг, Хоризм, Сырдарьяа мөрний доод урсгал, Ижил мөрний Булгар, Кипчакийн тал, Крым,

Умард Кавказ зэрэг газар багтаж байв. Анхны нийслэл нь одоогийн ОХУ-ын Астрахан хотын ойролцоо байсан Батын Сарай хот юм. Алтан ордны улс 200 гаруй жил оршин тогтносон.

АЛТАН ОРДНЫ ХААДУУД

Зүчи, Бат нарын үед Монголын Их хааны захиргаанд байсан боловч Бэрх хааны үеэс бие даасан байдалтай болж, удалгүй Монгол гүрнээс бүрмөсөн тусгаарлагдан салжээ.

1. Зүчи (1223-1227)
2. Бат (1227-1255)
3. Сартаг (1255-1257)
4. Улаагчи (1257)
5. Бэрх (1257-1266)
6. Мөнхтөмөр (1266-1282)
7. Туда-Мөнх (1282-1285)
8. Тулабуга (1285-1290)
9. Тогтао (1290-1312)
10. Узбек (1312-1342)
11. Тинибек (1342)
12. Жанибек (1342-1357)
13. Бердибек (1357-1361)
14. Кули (Кульна) (1361)
15. Нуруз (1359-1361)
16. Хидырь (Хизрь) (1361-1362)
17. Орд Шейх (1361-1362)
18. Мердуд (1361-1362)
19. Төмөрхожа (1361-1362)
20. Келдиберг (1363-1364)
21. Муридходжа (1363-1364)
22. Болдхожа (1362-1364)
23. Күтлүүгхожа (1362-1364)
24. Азизшейх (1362-1364)
25. Абдаллах (1364/1362/-1371)
26. Хасан (1366)
27. Мухамед-булаг (1371-1375)
28. 2-р Жанибек (1371-1375)
29. Тулунбек (1371-1375)
30. Хажичеркес (1371-1375)
31. Айбек (1371-1375)

32. Ала-хожа (1371-1375)
33. Харихан (1371-1375)
34. Арабшаг (1373-1378)
35. Хаанбег (1375-1378)
36. Үрүүс хаан (1375-1378)
37. Тогтамыш (1378-1395/1406/)
38. Бег болд (1395-1399)
39. Хайриджак (1395-1399)
40. Төмөрхүтлүг (1395-1399)
41. Шадибек (1400-1408)
42. Болдсултаан (1408-1410)
43. Төмөр хан (1410-1412)
44. Желал-ад-дин (1411)
45. Керимберди (1412-1417)
46. Кебег хаан (1414)
47. Жаббарберди (1416-1419)
48. Чекры-Оглан (1414-1416)
49. Иерем ферден (1416)
50. Дебриш хан (1417-1419)
51. Кадыр Берди (1414-1421)
52. Улуг Берди (1421)
53. Борак (1423-1428)
54. Давлет Берди (1426-1427)
55. Өлөг Мухаммед (1420-1424, 1428-1430)
56. Кичик Мухаммед (1430)
57. Сайд Ахмед (1430-1465)
58. Ахмад (1465-1480)

ЦАГААДАЙН ХААНТ УЛС

Цагаадай хаан 1242 он

Монголын эзэнт улсын бүрэлдэнхүүнд багтаж байсан Цагаадайн улсын эзэн. Чингис хааны хоёрдугаар хүү. Хаан эцгээ дагаж, Хятад, Хоризм улсыг дагуулах аян дайнд оролцжээ. Чингис хаан 1224 онд дөрвөн хөвгүүндээ эзэлсэн газар орноо хуваахдаа Цагаадай хүүдээ Дундад Азийн өргөн уудам нутгийг эзэмшил болгон олгожээ. Цагаадайн ордон Илийн хөндийд байсан боловч тэр өөрөө ихэвчлэн Өгөөдэй хааны ордонд суудаг байв. Цагаадай "Их Засаг" хуулийг улсынхаа дотор чандлан сахиулж байснаараа нэрд гарсан. Цагаадай монгол хууль, ёс заншилаа дээдлэн, Лалын

шашны зарим бурангуй ёсыг хатуу чанд хориглож байв. Хаан зам гүүр тавихад ихэд анхаарч байжээ.

Цагаадайн улс

Дундад Азид тогтнож байсан Монголын эзэнт улс. 1244 онд Чингис хаан дэд хөвгүүн Цагаадайдаа Алмалын болон Амударьяа, Сырдарьяа мөрний хоорондох уудам нутаг, Мавераннахр, Долоон нуур, Кашгарыг хамарсан нутгийг өгснөөр Цагаадайн улсын үүсэл тавигджээ. 14-р зуунд Цагаадайн улс Мавераннахр, Могулистан гэдэг хоёр хэсэгт хуваагджээ. Цагаадайн улсын суурин дээр Монгол угсааны хаан Доголон Төмөрийн улс байгуулагдсан түүхтэй.

Цагаадайн улсын хаад.

Цагаадай хаанаас хойшхи үеийн зарим хаадын нэр "монгол биш" мэт санагдаж болно. "Цагаадайн улс" хэмээх Монголын эзэмшил боловч ондоо хэл, соёл бүхий харь газар удаан сууж, тэр улсаа удирдсан тул Дундад Азийнханы, тэр тусмаа Лалын шүтлэгтнүүдийн нэр ус хаадын дунд түгээмэл болсон нь тэр. Хэдий тийм боловч тэд бүгд "алтан ураг"-ийнханаас уг сурвалжтай юм.

1. Цагаадай (1227-1242)
2. Хархүлэгү (1242-1247)
3. Есөнмөнх (1247-1252)
4. Хархүлэгү/хоёр дахин/(1251-1252)
5. Ургуна хатан (1252-1261)
6. Алагуй (1261-1266)
7. Мубарекшах (1266-1266)
8. Борак (1266-1271)
9. Никпей (1271-1272)
10. Тугтөмөр (1272-1274)
11. Дува (1274-1274)
12. Хунжиг (1307-1308)
13. Талигу (1308-1309)
14. Кебек (1309-1309)
15. Эсэнбөх (1309-1318)
16. Кебек дахин(1318-1326)
17. Ильчигидай
18. Дуватөмөр
19. Тармаширан
20. Синжар
21. Женкши

22. Бузун
23. Есөнтөмөр
24. Али /Өгөөдэйн удам/
25. Мухамед
26. Казань
27. Данишменш /Өгөөдэйн удам/(1346)
28. Буян Кули
29. Туклук Тимур (1348-1362)
30. Ильяс Хожа (1362)
31. Хызр Хожа (1389)
32. Шама жехань (1399)
33. Мухаммед (1408)
34. Накши Жехань (1415)
35. Вейсхан (1418)

Гүюг хаан /1206-1248/

Монголын эзэнт улсын гуравдугаар хаан, Өгөөдэй хааны ахмад хөвгүүн. 1235 онд Бат, Мөнх нартай өрнө зүг цэрэглэж, Орос ба Зүүн Европ хүрч, 1240 онд дорно зүг буцсан. Хаан суусныхаа дараа Ялавачаар Хятад орныг мэдүүлэн, Перс зэрэг газар цэрэг суулгажээ. Гүюгийг хаан байх үед Монголын өндөрлөгт ган гамшиг болж байв. Гүюг хаан аян дайны замд Самарканд хотын орчим нас баржээ.

Бат хаан /1208-1255/

Зүчийн улсын эзэн хаан. Чингис хааны ач, Зүчийн хоёрдугаар хүү. 1236-1243 онд Дорнод, Төв Европт довтолсон Монголын цэргийг удирдсан. 1227 онд эцгийгээ нас барсны дараа Зүчийн улсыг удирдаж, монгол цэргийн томоохон тулалдаануудад оролцсон байна. Тэр бээр 1236 онд Дешти Кипчакийг эзлэн, Рязань, Владимирийн вант улс, Переяславль, Чернигов, Киев хотуудыг байлдан дагуулжээ. Оросыг эзэлснийхээ дараа Польш, Унгар, Далмацид аян дайн хийж, 1243 онд Дунай мөрнөөс Эрчис мөрөн хүртэлх өргөн уудам нутагт "Алтан ордны улс-ыг Сарай нийслэлтэйгээр байгуулжээ. Бат хаан эзэлсэн орнуудынхаа хүн амаас алба татвар авч, худалдаа, гар урлал хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, "Их засаг" хуулийг чандлан мөрдүүлж, хотжих үйл явцыг дэмжиж байв.

Мөнх хаан /1208-1259/

Их монгол улсын дөрөв дэх хаан. Чингисийн отгон хүү Тулуйн ахмад хөвгүүн. Эх нь Хэрэйд аймгийн Сорхугтани беги. 1235 онд

Өгөдэй хааны зарлигаар Бат, Гүюг нартай өрнө зүгийн аянд мордож, Булгар, Кипчак, Оросыг байлдан эзэлж явсан. Хаан болоод алба татварын журмыг цэгцлэн, 100 толгой мал тутмаас 1 толгой мал татаж, 100 хүрэхгүй малтай өрхийг татвараас чөлөөлсөн. Мөн өртөөний албыг журамласан. Олон шашныг жигд дэмжих бодлогыг үргэлжлүүлэн, эзлэгдсэн орнуудын ард түмнийг шашин шүтлэгээр нь дамжуулан захирах бодлого баримталсан. Эх Монгол гүрнээ бэхжүүлэн, гадаадад шинэ улс орныг эзлэн авч, газар нутгаа тэлэн өргөтгөх бодлого явуулж байв. Дүү Хубилайдаа Хятад орныг захируулсан.

ИЛ ХААДУУД

Ил хаадын улс

13-р зууны хоёрдугаар хагаст Монголын байлдан дагуулагчид Иран, Ирак, Азербайджан, Армян, Туркестан, Гүржийн нутгийг эзэлснээр байгуулагдсан улс. Анхны нийслэл нь Тебриз хот байгаад 14-р зууны эхээр Иракийн Султан хотод шилжсэн. Хөлөг (1256-1265 онд хаанчилсан,) Абага (1265-1282), Аргун (1284-1291), Газан (1295-1304) хаадын үед Монгол гүрний захиргаанд байж байгаад Хайсан Хүлэг, Буянт хаан нарын үеэс эхлэн бие даасан байдалтай болж, цаашдаа бүрмөсөн салжээ.

Хөлөг Хаан /1256-1265/

Ил хаадын Монгол улсыг үндэслэн байгуулагч, эзэн хаан. Тулуйн хүү. Эх нь Сорхугтани беги. 13-р зуунд Монголын цэрэг Иран, Ирак, Азербайжан, Армян, Туркестан, Гүржийн нутгийг эзэлсэн бөгөөд хожим тэдгээр улсыг нэгтгэн захирчээ. Хөлөг хаан эвдэрч сүйдсэн хот тосгодыг сэргээн босгож, зам талбай, услалтын суваг, цэцэрлэгүүдийг өөд татаж, эрдэмтэн мэргэдийг хөхүүлэн дэмжиж, тэдэнд санхүүгийн туслалцаа үзүүлдэг байжээ. Хаан өөрөө мөнх тэнгэрийн шүтлэгтэй байсан хэдий ч шашны олон урсгалыг дэмждэг байв. Хөлөг хаан Монголын их дээдсийн эрхшээлийг хамгаалж, ноёрхлоо хэвээр хадгалахын тулд Ираны ноёлогч ангийнхантай зохицон амьдарч байжээ.

Абага хаан /1265-1282/

Ил хаадын Монгол улсын эзэн. Хөлөг хааны ууган хүү, эх нь Сүлдүсүн овгийн Есөнжин хатан. Хаан өргөмжлөгдөх үедээ Ил хаадын Монгол улсын эзэн. Их хаан Хубилайгаас зөвшөөрөл

аваагүй' хэмээн шалтаг тоочиж байсан нь Ил хаадын улс нь Монголын Юан улсаас хамааралтай' байсныг гэрчилнэ. Абага хаан, Алтан Ордны Мөнхтөмөр, Цагадайн улсын Борак, Сирийн Бундукдар болон, урвасан Румийн дээдсийг тухай бүрт нь гэсгээн дарж, ялж байсан нь түүний хаан төрийн удаан тогтнохын үндсийг бүрэлдүүлж байв. Тэр бээр цэргийн хүч, дипломат арга, заль мэх аль алиныг чадамгай эзэмшсэн хаан байсан тул Ватикан, Англи, Францын хаад элч илгээн хүндэтгэл үзүүлж байжээ.

Текүдэр хаан /1282-1284/

Кутуй хатнаас төрсөн, Хөлөг хааны долдугаар хөвүүн. Абага хааныг бие барсны дараа хаан ширээний төлөөх тэмцэл Хөлөг хааны хүү Текүдер, Абага хааны ууган хүү Аргун нарын дунд хүчтэй өрнөжээ. 1282 оны 6-р сард хаан ширээнд сууж, нэрээ Ахмед болгон өөрчлөв. Ил хаадын Монгол улсын хаадын дотроос Текүдэр анх удаа Лалын шүтлэгтэн болсон хэдий ч хаан суух хугацаа нь хоёр жил орчим л үргэлжилсэн юм. Учир нь Аргун түүнийг барьж, хаан ширээний төлөөх тэмцэлдээнийг тохоон байцааж, 1284 онд цаазаар авчээ. Түүний үхэл Лалын шашныг хүлээн зөвшөөрөөгүй Ил Хаадын улс дахь монгол дээдсийн эсэргүүцлийн илрэл байв.

Аргун хаан

Чингис хааны хүү Тулуй, Тулуйн хүү Хөлөг хаан, Хөлөг хааны хүү Абага, Абага хааны ууган хүү Аргун юм. Тэр бээр Абага хааны Каймиш-эгч хатнаас төржээ. Аргун хаан байх хугацаандаа хүн амын тооллого явуулж, дайнд явах эрсийн тоог гаргаж, сайн газартай 10 тариачнаас нэгийг нь цэрэгт бүртгэж байв. Хааны нэг сул тал нь алив багш нарт ихэд итгэн, тэдний зааврыг үг дуугүй биелүүлдэг байжээ. Аргун хаан бусдын газар нутгийг булаан эзлэх биш, зөвхөн өөрийн нутаг орноо хамгаалахын төлөө байлдаж байснаараа онцлог. Тэр бээр монгол сурвалжитнуудын эрх ашгийг хамгаалж, эзэлсэн орныхоо ноёдод буулт үл хийх бодлого баримталж байв. Олон шашныг жигд ивээн тэтгэж байжээ.

Гейхату хаан /1240-1295/

Ил хаадын Монгол улсын эзэн. Абага хааны хүү. Гадаадын түүхчид Кенжату гэх бөгөөд багш нар нь Рэнцэндорж хэмээх нэр өгчээ. Гейхату хааны амьдрал сайнтай, муутай. Аргуныг хаан байх үед Гейхату Рум хэмээх газар сууж, найр наадам үүсгэн, чөлөөт цагаа үзэсгэлэнт охидын дунд өнгөрөөдөг байжээ. Гейхату Ил Хаадын Улсад цаасан мөнгө гүйлгээнд гаргаж, тэр нь бүтэлгүйтжээ.

1294 онд Гейхату хаан Кура голын эрэг дээр нэг томоохон хот үүсгэн байгуулж, Күтлүг-Балык хэмээн нэрлэжээ. Хүчирхэг эмир ноёдын урвалт, цэрэг дайны амжилтгүй үйл ажиллагаа, хөндлөнгийн хүчний хатгалга зэрэгтэй холбоотойгоор Гейхату хаанчлалаа алдсан билээ.

Газан хаан /1271-1304/

Ил хаадын Монгол улсын эзэн. Аргун хааны хүү. Монголчуудын ноёрхолыг бэхжүүлэхийн тулд Ираны ихэс дээдэстэй ойртон, Лалын шашинд ойртож, "Судрын чуулган" хэмээх түүхэн бүтээлийг туурвисан Рашид-Ад-Дины тусламжтайгаар засаг захиргаа, эдийн засгийн шинэчлэл хийжээ. Цэрэгт бүртгэлтэй монголчуудаас цэргийн алба авч, тариачдыг газарт бэхлэх гэсэн Монгол ноёдын оролдлогыг бататгажээ. Газан хаан, Рашид-ад-дин нарын хүчин зүтгэл улс гүрний задран мөхөх үйл явцыг саатуулсан хэдий ч бүрмөсөн зогсоож чадаагүй юм. Газан хаанаас Ромын Папад монгол бичгээр илгээсэн 14 мөр захидал өдгөө Ватиканы нууц архивт буй.

Ил хаад

1. Хөлөг (1256-1265)
2. Абага (1265-1282)
3. Текүдер (1282-1291)
4. Аргун (1289-1291)
5. Гейхату (1291-1295)
6. Байду (1295)
7. Газан (1295-1304)
8. Өлзий (1304-1316)
9. Абу Сейд (1317-1327)
10. Арпа (1327-1335)
11. Муса (1336)
12. Мухаммед (1336-1338)
13. Туг төмөр (1338-1351)
14. Зэхэн төмөр (1339-1340)
15. Сати-Бег (1339)
16. Сулейман (1339-1344)
17. Нушрван (1344)

ЮАН УЛСЫН ХААДУУД

Юан улс

Хятадад төвлөрөн, 1271 оноос 1368 он хүртэл оршин тогтнож байсан Монголын эзэнт улс. 1271 онд Хубилай хаан улсынхаа нийслэлийг Бээжинд шилжүүлэн, 'Юан улс' гэж нэрлэжээ. 'Юан' гэдэг нь 'язгуурын' гэсэн утгатай. Хубилайгаас Тогоонтөмөр хүртэлх Монголын бүх хаад Хятад болон эзэлсэн бусад орнуудад ноёрхлоо бэхжүүлэхэд чиглэгдсэн улс төр, эдийн засаг, үзэл суртлын бодлого явуулж байв. Эзлэгдсэн орнуудын хүн ам, газар нутаг, хөрөнгө баялаг бүхэлдээ монгол хаадын өмч байжээ. Эдийн засаг, соёлын нэгдсэн үндэс суурьгүй, олон үндэстэн ястныг зэвсгийн хүчээр нэгтгэн захирсан тул Юан гүрэн 1368 онд Хятадын ард түмний бослогод цохигдон унасан юм.

Хубилай хаан /1215-1294/

Монголын Юангүрнийгүндэслэнбайгуулагч, Тулуйндөрөвдүгээр хүү. Эх нь Сорхугтани беги. 1264 онд өөрийн гол өрсөлдөгч, төрсөн дүү Аригбөхийгөө дарсны дараа Хятадын эзлэгдээгүй үлдсэн өмнөд хэсгийг байлдан дагуулж, ноёрхолоо бэхжүүлэх зорилт тавьсан. Хубилай хаан төр барьсан үеэ 1260 оноос эхлэн тоолж, оны цолоо " Жүнтүн" хэмээн хэмээн нэрлэжээ. Тэр бээр 1279 онд Сүн улсыг довтолж, Хятадын бүх газар нутгийг эрхэндээ авсан. Хубилайн үед худалдаа наймаа идэвхжиж, цаасан мөнгө хэрэглэх болжээ. Пагва хэмээх ламаар бичиг болгон хэрэглэв. Хубилай үндсэн Монгол нутгаа мал аж ахуйн орон хэвээр үлдээж, цэрэг эрсийг сургах түшиц газар болгон ашиглаж байв.

Өлзийт хаан Төмөр. /1265-1307/

1294-1307 онд хаан суув.

Монголын Юан гүрний хоёрдугаар хаан, Хубилайн дэд хөвгүүн Чингимийн гуравдугаар хүү. Эцэг Чингим нь 1285 онд нас барсан тул хаан ор суужээ. 1293 онд эх Монгол нутгаа сахин цэрэг захиран суугаад хунтайжийн тамгыг гардсан бөгөөд 1294 онд Хубилай хааныг нас барсны дараа ах Гамалатайгаа тэмцэлдэн ялж хаан болжээ. Өлзийт хаан хятад сайдыг төрд хэрэглэж; Япон, Аннам (Вьетнам)-д цэрэглэх явдлыг зогсоож, алба татварыг хөнгөлөн, хууль цаазыг цэгцэлжээ. Түүний үед улсын сан хөмрөг багасч, цаасан мөнгөний ханш унасан.

Хайсан Хүлэг хаан. /1281-1311/

1307-1311 онд хаан суув.

Монголын Юан гүрний гуравдугаар хаан, Хубилайн дэд хөвгүүн Чингимийн ач хүү. Өлзийт хаан Төмөрийн ах Дармабал Солонгосын Чэжү арал дахь монгол цэргийн захирагчаар сууж ахуйд түүний залуу агь Хайсан 1298 онд солонгос бүсгүйтэй гэрлэжээ. 1299 онд цэрэг ерөнхийлөн захирч, Хайдугийн талынханыг номхотгох дайнд гавьяа байгуулан, 1304 онд ван өргөмжлөгдсөн. 1306 онд Эрчис мөрөн зүг цэрэглэн орж, Хайдугийн хөвүүн Цэвэр тэргүүтнийг зайлуулаад 1307 онд Өлзийт хааныг нас барсны дараа хаан ор суусан. Тэр бээр дээдэст соёрхол ихээр хүртээж, одоогийн Хятадын Хэбэй мужийн Жүндү хотыг зассан зэрэг нь улсын санхүүг доройтоход хүргэсэн. Санхүүгийн хүндрэлийг арилгахын тулд зоосон мөнгө гүйлгээнд оруулж байв.

Буянт хаан Аюурбарбад /1285-1320/

1311-1320 онд хаан суув.

Монголын Юан гүрний дөрөвдүгээр хаан, Төмөр хааны ах Дармабалын дэд хөвгүүн. Хүлэг хаан Аюурбарбадыг хунтайж болгон өргөмжилж, хаан ширээ залгамжлуулахаар тогтжээ. Тэр бээр Хүлэг хааны үеийн санхүү доройтож, төр самуурсан байдлыг өөрчлөхөөр чармайж, зоосон мөнгийг гүйлгээнээс хасч, барилгын элдэв зардлыг зогсоожээ. Хятад иргэнийг хавчин хяхах бодлогыг зөөллөж, өөрийн цааз ёсыг зохиосон байна. Ядууст өглөг өгч, алба татвараас хөнгөлөх зэрэг дэвшилтэт бодлого явуулж байсан эрдэм номт Аюурбарбадыг "өршөөлт", нигүүлсэнгүй, ачлалт эзэн хаан" хэмээн өргөмжилсөн байдаг.

Гэгээн хаан Шадбал. /1303-1323/

1320-1323 онд хаан суув.

Монголын Юан гүрний тавдугаар хаан, Буянтхаан Аюурбарбадын хөвгүүн. 1316 онд Буянт хаан, Шадбалыг үеэл ах Хүслэнгийнх нь оронд хунтайж болгон өргөмжилжээ. Тэр бээр Юан гүрний хаадын дотроос их ор залгаахаасаа өмнө хүнд бэрхийг амсаагүй цорын ганц хаан билээ. Шадбал хаан бичгийн сургаалаар төрийг засах хүсэлтэй багш нарынхаа нэгэн адил тухайн цагийнхаа улс төрийн байдалд сэтгэл дундуур явсан тул байдлыг өөрчлөхөөр чармайж байв. Бичгийн хүмүүсийг төрд ихээр хэрэглэж, олон түшмэлийг тушаалаас огцруулсан нь олон он уламжилж ирсэн монголчуудын үе залгамжлах эрхэнд шууд халдсан явдал байв. Үүнээс үүдэн монгол ноёд төрийн эргэлт хийж, Шадбал хааныг хороожээ.

Есөнтөмөр /1276-1328/

1323-1328 онд хаан суув.

Хубилайн ач хүү Гамалагийн хөвгүүн. 1323 онд Баруун гарын чинсан Дамударын өргөмөл хүү Тэгш нар төрийн эргэлт хийхээр нууцаар зөвлөлдөж, Монгол нутагтаа цэрэг захиран суусан Есөнтөмөрт элч илгээн, "Хэрэг бүтвэл чамайг хаан өргөмжилнө" хэмээн мэдүүлжээ. Улмаар Гэгээн хаан үрэгдэж, Есөнтөмөр Монгол нутагт хаан суугаад, оны цолоо 'Дайдин' хэмээв. Есөнтөмөр хаан эхэндээ Тэгшийг өргөмжлөн төрд хэрэглэсэн боловч удалгүй 'Гэгээн хааныг алсан' хэмээн ял тулгаж, Аюурбарбад хааны үед цөлөгдсөн ван нарыг чөлөөлсөн байна. Энэ бүхэнд Монголын ихэс дээдэс талархалтай хандсан бөгөөд түүний хаанчлалын үед нийгэм харьцангуй тогтвортой байв.

Арахибаг (1328он)

Есөнтөмөр хааны хөвгүүн. 1324 оны 3-р сард хунтайжаар өргөмжлөгдсөн. Есөнтөмөр хааны итгэмжит хүн, уйгар Даолад Шаг, Тогтох ван нар Арахибагийг Шандуд хаан ор суулгажээ. Харин сарын дараа Дайдуд Элтөмөр, Арднашир ван нар Төвтөмөрийг хаан болгосон тул Дайду, Шанду хоёр нийслэлийн хооронд дайн үүсч, хоёр сар гаруй тэмцэлдээд Дайдугийн тал ялалт байгуулжээ. Арахибаг хаан тухайн үед алуулсан, амьд үлдсэн эсэх нь тодорхойгүй.

Хутагт хаан Хүслэн /1300-1329/

1329 онд хаан суув.

Хайсан Хүлэг хааны ахмад хөвгүүн. Тэр бээр 1300 онд Чечу арал дээр Хайсангийн Ки Ван Ку нэрт солонгос хатнаас төржээ. 1316 онд Аюурбарбад хаан өөрийн хүүгээ хааны залгамжлагч болгохоор шийдээд, Хүслэнг Жөү ван өргөмжлөөд Үннамд явуулжээ. Хүслэн замдаа эргэн хөдөлж боссон боловч дийлдэж, Алтай уул руу зугатан очиж, Уйгарын Арслан хааныг түшин, түүний хүргэн болжээ. Удалгүй баруун хойтын ван нар дагалдан ирсэн тул Хүслэнгийн хүч их болж, Алтай орчим суух болов. 1328 онд Есөнтөмөр хааныг нас нөгчсөний дараа Хүслэнгийн дүү Төвтөмөр Дайдуд төр захиран суужээ. Төвтөмөр элч томилон Хүслэнг ирүүлж, 1329 онд Хархорумд хаан суулгажээ. Элтөмөрт хорлогдсон.

Заяат хаан Төвтөмөр. /1304-1332/

1329-1332 онд хаан суув.

Хайсан Хүлэг хааны дэд хөвгүүн. Шадбал хааны үед Хайнань газрыг сахин сууж, Есөнтөмөр хаан үед зарлигаар эргэн ирж, Хуайван өргөмжлөгджээ. 1325 оны 8-р сард Есөнтөмөр хааны хүүг Арахибат Шандуд хаанд өргөмжлөгдөхөд, сарын дараа Төвтөмөр Дайдуд мөн л хаанд залагджээ. Төвтөмөр хаан Элтөмөр болон Хайсан хааны бүлгийнхэний дэмжлэгтэйгээр Шандуг эзлэн, Сычуань, Үннам зүг цэрэг хөдөлгөж, эсрэг этгээдээ төвшитгөсөн байна. Элтөмөрийн эрх мэдэл үлэмж болсон бөгөөд улсын санхүүгийн байдал доройтож, дотоодын тэмцэл ширүүсч байв. 1332 оны 8-р сард Төвтөмөр хаан өвчнөөр насан эцэслэсэн.

Ринчилбал хаан /1326-1332/

1332 онд хаан суув.

Хүслэн хааны дэд хөвгүүн. Эх нь Бабоша хатан. Элтөмөр Хүслэн хааныг хорлосныхоо дараа Бабоша хатныг ч мөн хорложээ. Өнчин хоцорсон насан бага Ринчинбал 1330 онд Фү ван өргөмжлөгджээ. 1332 онд Төвтөмөр хаан өвчнөөр насан эцэслэхдээ Ринчинбалыг хаан болгохоор гэрээслэжээ. Тэр үед Ринчинбал 7 настай байсан бөгөөд 43 өдөр их ор суугаад өвчнөөр нас баржээ.

Ухаант хаан Тогоонтөмөр /1320-1370/

1333-1370 онд хаан суув.

Юан гүрний сүүлчийн их хаан. Хайсан хааны солонгос хатнаас төрсөн Хүслэн хааны ууган хөвүүн. 1333 онд Шандуд их хаан суужээ. 1337 онд Монгол нутагт тариа тарин сууж байсан хятад цэргийг эргүүлэн татаж, 1346-1351 онд Хархорумын зарим орд харшийг сэргээн засварлуулжээ. Их хаан Хятадын өмнөд хэсэгт сууж байсан монголчуудыг Монгол нутагт нь буцаав. Уран барилга, соёлын цогцолбор ихээр байгуулж байсан тул хятадууд Тогоонтөмөрийг "барилгачин хаан" гэж хэлцдэг байв. 1368 онд тэр бээр Хятадын тариачдын бослогод цохигдон, эзэнт гүрнээ алдаад, Бээжин хотоос зургаан түмэн Монгол үндэстнээ дагуулан авч, Хэрлэн мөрний хөвөөнөө ирж, Барс хотыг байгуулан суурьшжээ.

Аюуширдар хаан. /1338-1378/

1370-1378 онд хаан суув.

Монгол улсын хаан. Тогоонтөмөр хааны хоёрдугаар хөвүүн. 1370 онд эцгийнхээ тэнгэрт хальсаны дараа Билэгт хаан цолтойгоор хаан ширээнд суужээ. Аюуширдарыг хаан ширээнд суумагц Хятадын

Мин улс түүнийг төрийн тамгынх нь хамт олзлон авахыг санаархсан боловч чадаагүй. 1370 онд Монголын эртний нийслэл Хархорумд ирж суурьшсанаас нь хойш Хятадын түрэмгийлэл улам ширүүсч, цэргийн хүчээр довтлон, бууж өгөхийг шаардаж байсан боловч Аюушридар хаан Монголын төрийн тусгаар тогтнолыг хамгаалсаар байжээ.

Төгстөмөр Хаан /1342-1388/

1378-1388 онд хаан суув.

Монгол улсын хаан. Тогоонтөмөр хааны хүү.1378 онд хаан ширээнд суугаад, Хархорум хотын орчим цэрэг хуралдуулж, Хятадын хил хязгаарыг зай завсаргүй уулгалан довтолж байв. 1380 онд Хятадын Мин улс үлэмж олон цэргийн хүчээр Монголын нутаг руу довтолж, Хархорум хотыг эзлэн түймэрдээд, маш олон монгол хүнийг олзлон буцжээ. Төгстөмөр хаан орд өргөөгөө Инчан хотод шилжүүлэн, цэргийн хүчээ эмхэлж хуралдуулан, Хятадын 130 мянган цэрэгтэй байлдсан боловч ялагдаад, ууган хүү, бараа бологсдынхоо хамт зугтан гарсан боловч замдаа алагджээ.

Зоригт Хаан Есүдэр /1358-1391/

1391 онд хаан суув.

Монгол улсын хаан. Хубилайн дүү, Аригбөхийн хойчис.1388 онд Есүдэр ойрадуудыг удирдан Төгстөмөрийг хөнөөн, "төрийн тамгыг булааж",хаан суужээ. Төгстөмөр хорлогдсоноос үүдэн Хубилай болон Аригбөхийн угсааныханы хооронд шинэ өс буй болов. Есүдэр их ор сууснаас хойш Монголын төрийн улс төрийн төв баруун зүг шилжин, Аригбөрийн хойчисын хүчний хүрээнд шилжжээ.Есүдэрийн үед Монголын нэгдмэл байдал харьцангуй тогтвортой байв. Тэр бээр 4 жил хаан сууж, 1391 онд нас нөгчив.

Энх хаан /1359-1392/

1392/94 онд хаан суув.

Монгол улсын хаан. Төгстөмөр хааны ууган хөвүүн. Зарим түүхчид Есүдэрийн хөвүүн гэдэг. Түүх сурвалжид түүний тухай тэмдэглэн үлдээсэн нь ховор. Түүний үед монголжсон киргиз язгууртан Үгэчи Хасаха, Найманы хойчис Чорос овогт Хуухай Тайюу нарын ихэс ноёд сөргөлдөн тэмцэлдэж байжээ. 1394 онд ойрадууд өвөр зуураа эврэлцэх үед Энх хаан хорлогджээ.

Элбэг нигүүлсэгч хаан Майдарбал./1362-1399/

1394-1399 онд хаан суув.

Монгол улсын хаан. Аюушридар хааны ганц хөвүүн. 1370 онд Хятадын Мин улсын цэрэг Барс хотыг эвдэхэд Майдарбал олзлогджээ. 1374 онд Мингийн ихэс ноёд Аюушридартай ойртохын тулд Майдарбалыг нутагт нь хүргэжээ. Майдарбал Чорос овогт Хуухай Тайюүг дотночлон үзэж, түүнтэй худ ураг барилцав. Түүний хүү Махамугаар ойрадуудыг захируулжээ. Энэ явдалд дургүйцсэн Үгэчи Хасаха 1399 онд цэрэг босгож, Майдарбалыг хөнөөжээ.

Тогоон хаан Гүнтөмөр./1377-1402/

1400-1402 онд хаан суув.

Монгол улсын хаан. Элбэг нигүүлсэгч хааны хөвүүн. Гүнтөмөр хааны үед Ойрадын Гэргүүд (монголжсон киргиз язгууртан) болон Чорос овгийнхоны дунд эрх мэдлийн төлөөх тэмцэл хурцадсан юм. 1402 онд Махаму их ноён Үгэчи Хасахыг хөнөөж, Гүнтөмөрийг алжээ.

Үрэгтөмөр хаан Гүйличи /1408он/

1402-1408 онд хаан суув.

Өгөөдэйн үр хойчис. 1402 онд ойрадууд өвөр зуураа эвдрэлцэж, Гүнтөмөр хаан хорлогдсоноор Төгстөмөрийн хуучин харьяат Аругтай нар Үрэгтөмөрийг хаан ор суулгажээ. Үүнээс болж Монгол улс Аригбөхийн удмын харьяат ардаар гол болгосон Баруун Монголын Ойрад, Хубилайн удмынханы харьяат Зүүн Монгол гэсэн хоёр хэсэг болон салжээ. 1408 онд Майдарбалын хөвүүн Буяншир Дундад Азиас Монголд эргэн ирэхэд Аругтай нар Үрэгтөмөрийг хороож, Буянширийг хаан суулгасан байна. Энэ бүх зүйлс Монголын хүчийг багагүй доройтуулав.

Өлзийтөмөр хаан Буяншир /1384-1410/.

1408-1410 онд хаан суув.

Элбэг нигүүлсэгч хааны хөвгүүн. 1399 онд монголчуудын өвөр зуурын үймээнээс болж, Дундад ази дахь /Доголон/Төмөрийн хаант улсад зугатан очоод "Юан улсын хойчис" хэмээн онц ихээр хүндлэгдэн суужээ. 1408 онд Аругтай Буянширыг хаан суулгав. 1409 онд Мин улсын жанжин Чю Вө 10 түмэн цэрэгтэйгээр Монголыг довтлов. Өлзийтөмөр хаан нарийн ухаан сийлж, Чю Вөгийн цэргийг нутгийн гүнд оруулж, бут цохижээ. 1410 онд Мин улсын Чэнжү хаан өөрийн биеэр 50 түмэн их цэрэг авч Монголыг дайлах үед Өлзийтөмөр алс одон Дундад азид зугатан гарчээ.

Адай хаан /1390-1438/

1438 онд хаан суув.

1410 онд Аругтай Адайг Монголын хаанаар өргөжилж, дараа жил нь Махаму Аригбөхийн хойчис Дэлбэгийг хаан болгосноор Монголын түүхэнд хоёр хаан зэрэг гарав. Тэр үеэс хойш Зүүн, Баруун Монголд алтан ургийн бус ноёдын эрх мэдэл ихсэж, тэмцэлдэх болжээ. 1415 онд Ойрадын Дэлбэг, Махаму нар цэрэглэн хөдөлж, Зүүн Монгол руу довтлоод Адай, Аругтай нарт ялагджээ. 1422, 1423 онд Мин Улсын Чэнзү хаан Монголд довтлов. Ойрадуудад дийлдсэн Адай хаан ард олноо дагуулан Өвөр Монголын баруун хэсэгт оржээ. 1438 онд Ойрад ба Мингийн цэргийн цохилтыг даалгүй ялагдаж, өөрөө хөнөөгджээ.

Дэлбэг хаан /1395-1415/

1415 онд хаан суув.

Аригбөхийн хойчис, Өлзийттөмөр хааны хөвүүн. 1411 онд Ойрадын ноёдын дэмжлэгтэйгээр хаан суужээ. 1410 онд Мингийн цэрэг Зүүн Монголыг хүчийг доройтуулахад Ойрадын хүчин ихэсчээ. Хоёр Монголыг нэгдүүзэй гэсэндээ Мингийн хаан довтолсон боловч Дэлбэг хааны цэрэгт цохигдон ухарчээ. 1415 онд Дэлбэг хаан, Махаму нар ойрадуудыг удирдан Зүүн Монголд цэрэглэжээ. Тэгэхэд Адай, Аругтай нар тосон байлдсанаар Зүүн Монгол ялж, Дэлбэг хаан алагджээ. Энэ удаагийн дайнаар ойрадууд хүчин доройтож, Зүүн Монголтой тэмцэх давуу байдлаа алдсан юм.

Ойрадай хаан /1425 он/

1415-1425 онд хаан суув.

Дэлбэг хааны дараа Үгэчи Хасахын хөвүүн Тайбин Ойрадыг нэг хэсэг захирав. 1514 онд Тайбин Аригбөхийн хойчис Ойрадайг дэмжин хаан болгоод, Зүүн Монголтой байлджээ. 1418 онд Махамугийн хүү Тогоон Зүүн Монголоос буцаж, 1924 онд Тайбиныг хороон, Ойрадын эрхийг авчээ. Дараа жил нь Ойрадай хаан нас нөгчив.

Тайсун хаан Тогтохбух /1416-1452/

1439-1452 онд хаан суув.

Хубилайн хойчис, Хархурцаг тайжийн хүү Ажай хааны ууган хөвгүүн. 1434 онд Тогтохбух цэрэглэн хөдөлж, Аругтайг алж, 1438 онд Адай хааныг хороожээ. Ингэснээр Зүүн Монголын Ойрадын эрхэн дор түр нэгдсэн юм. 1439 онд хаан сууж, Ойрадын Эсэн тайштай хүч хавсран усны эхний гурван түмнийг эрхэндээ оруулсан бөгөөд

1449 онд Мин улсад довтолж, газар нутгаа өргөтгөж байв. 1452 онд Эсэнтэй Халхын төв нутагт байлдаж ялагдсан. Тайсун хаан Хэрлэн рүү одоод, хадам эцэг Горлосын Цэвээнд алагджээ.

Эсэн хаан /1407-1455/

1454-1455 онд хаан суув.

Чингис хааны гавьяат өрлөг Урианхадын Зэлэмийн есдүгээр үеийн ач, Ойрадын Тогоон тайшийн хөвүүн бөгөөд Ойрадын Зах мянганы Чорос овогтон. Эсэн 1439 онд эцгийнхээ тайш цолыг залгамжлан, Ойрадыг нэгтгэжээ. Эсэн хятадуудаас чөлөөтэй худалдаа хийхийг шаардахад эс зөвшөөрсөн тул 1449 онд хоёр түм орчим цэрэгтэй довтолж, Хятадын Мин улсын цэргийг бүслэн цохижээ. Эсэн 1452 онд Зүүн Монголыг довтолж, Тайсун хаан Тогтохбухаг ялж, 1454 онд Монгол улсын хаанд өргөмжлөгджээ. Эсэн хаан бие даан орших гэсэн ноёдыг дарангуйлан, нэгэн хааны засаглал бүхий хүчирхэг Монгол улсыг бэхжүүлэхийн төлөө тэмцэж яваад амь эрсэджээ.

Үхэгт хаан Махагүргис. /1448-1465/

1454-1465 онд хаан суув.

Тайсун хааны хоёрдугаар хөвгүүн. "Эсэнгийн дараа Тогтобухын хатан Самур 7 настай хүү Махагүргисийгээ хаан болгож, Үхэгт тэргэнд суулган, Ойрадыг дайлсан тул Махагүргисийг 'Үхэгт хаан' хэмээжээ" гэж түүх шастирт тэмдэглэсэн буй. Махагүргис Чингисийн дүү Бэлгүтэйн хойчис Мулихай ван, Харчины Болай нарын дэмжлэгээр хаан суужээ. Тэд 1454, 1455 онд Ойрадыг цэрэглэн ялсан боловч, өвөр зуураа эрх мэдэл булаалдаж, эцэстээ Болай ялжээ. Махагүргис Мулихайг дэмжиж, Болайтай тэмцэж байв. 1465 онд Болай Махагүргисийг хороосон бол, удаад нь Муулихай цэрэглэн хөдөлж Болайг хөнөөжээ.

Молон хаан /1466он/

1465-1466 онд хаан суув.

Тогтобухын хүү, Махагүргис хааны дүү. Уг нэр нь Төгсмөнх. Тогтохбуха хөнөөгдөх үед хөвгүүн Молон нь амь хэлтэрсэн байдаг. Түүний хойно их сайд нар зөвлөлдөөд, Махагүргисийн дараа Мулихайг хаан болгох гэсэн боловч Мулихай эс зөвшөөрсөн Молонг хаан болгожээ. Хаан суусныхаа дараа Молон Мулихайг эсэргүүцэх болж, түүнтэй тэмцэлдээд хороогдов. Молон хааны дараа Монголын хаан ор 10 жил эзгүй байж, Зүүн Монголд үймээнт цаг үе нүүрлэсэн билээ.

Мандуул хаан /1426-1467/

1463-1467 онд хаан суув.

Монгол улсын хаан. Тогтохбуха хааны нөгөө эхээс төрсөн дүү, эх нь ойрад хүн. Мандуул хаан болсноосоо хойш алтан ургийнханы болон бус удмынханы харьяат ардыг өөртөө нэгтгэн хүчээ зузаатгажээ. Хархурцаг тайжийн хөвүүн Баянмөнхөд "Болох жонон" цол өргөн, Баруун түмний жонон болгожээ. Хожим хаан, жонон хоёр эвдрэлцсэн бөгөөд хаан удалгүй тэнгэрт хальжээ.

Мандухай сэцэн хатан

Монголын ихэс дээдсийн ноёрхлыг намжаан дарж, улс орны нэгдмэл байдлыг сэргээхэд гавьяа байгуулсан хатан. Энгүд отгийн Цоросбай чинсангийн охин. Мандуул хаан нас барж, хааны угсаа залгамжлал тасрахад хүрээд байсан үед Мандухай хатан Чингисийн 15-р үеийн ач, 7 настай Батмөнхийг 1470 онд "Даян хаан" цолтойгоор хаанд өргөмжилж, өөрөө хатан нь болоод, салан тусгаарлах бодлого баримталж байсан ноёдын тэмцлийг дарж, төрийн нэгдмэл байдлыг сэргээжээ.

Батмөнх даян хаан /1460-1504/

1466-1504 онд хаан суув.

7 настайдаа хаан ширээнд суусан, Монгол улсын хаан. Чингисийн 15-р үеийн ач. Олон жилийн турш үргэлжилсэн Монголын ихэс дээдсийн хямрал тэмцэл Батмөнх даян хааны үед намжиж, монголчууд нэгэн хаанд захирагдах болсноор улсын тусгаар тогтнол бэхжиж, төрийн нэгдмэл байдал сэргэсэн нь үйлдвэрлэх хүчин хөгжихөд нааштай нөлөөлсөн. Их хаан эхэндээ Хангай уулсаар нутаглаж байгаад, тэндээсээ одоогийн Өвөр Монголын Цахарын нутагт суужээ. 1500 онд тэндээсээ нүүж, Ордост ирж суурьшсан байна. Хятадын Мин улстай найрсаг харилцаа тогтоож, худалдаа хөгжүүлэв. Их хаан 48 жил төр барьжээ.

Барсболд Сайн Алаг хаан

1516-1519 онд хаан суув.

Даян хааны гуравдугаар хөвгүүн. Даян хаан Улсболдыг Ордос түмэнд, Барсболдыг Монгол түмэнд томилжээ. Улсболд хорлогдсон даруй Барсболд Даян хааны дэргэд дутаан хүрчээ. Баруун гурван түмэний урвалгааныг дарсныхаа дараа Даян хаан Барсболдыг Ордос түмэнрүү явуулж, эрх мэдүүлэв. Даян хааны дараа Боди Алагийг нас бага хэмээн Барсболд хаан орыг авчээ. 1519 онд Боди Алаг, Даян хааны 4-р хөвгүүн Арцболдтой холбоолон Барсболдод

цэрэглэж ял асуусанд Барсболд аргагүйн эрхэнд хаан ороо тавьж өгчээ. Барсболд мөн ондоо нас барав.

Боди Алаг хаан /1504-1547/

1519-1547 онд хаан суув.

Батмөнх даян хааны ач хүү. Батмөнх хааны ууган хүү Төрболд тэр үед нас барсан тул хаан өвгийнхөө орыг багадаа залгажээ. Боди Алаг хаан Даян хааны удмынхан ба Чингисийн дүү нарын удмынханы эзэмшилд ба Чингисийн дүү нарын удмынханы эзэмшилд байсан түмэн, отгуудтай нийлж, Хэнтий уулын орчим байсан Чингис хийгээд Монголын их хаадын онгоныг сахин суусан Урианхай түмэнд аялж, түүнийг хуваан тэлж, зургаан түмнээс гаргав.

Гүдэн хаан Дарайсун 1520-1557

1548-1557 онд хаан суув.

Боди алаг хааны ахмад хөвгүүн. Өөрийн харьяаны Цахарын нэг хэсгийг удирдан Монголын хаадын нутаг болох Хэрлэн гол, Хөлөнбуйр орчмоос Их хянганы давааг даван, Шармөрөн орж, Чингисийн бага дүү Отчигины удмынханы харьяа Үлгэгийн түмэний нэг хэсгийг мэдэлдээ авчээ. Тэр үед Түмэдийн Алтан хаан ихэд хүчирхэгжээд байсан тул Гүдэн хааны байр суурь хөндөгдөж, зөрчил тэмцэл их байв.

Түмэн засагт хаан /1539-1592/

1558-1592 онд хаан суусан.

Дарайсун хааны ахмад хөвгүүн. Түүний үед Монголын хааны эрх мэдэл ихсэж, Хятадын сүр хүчийг үзүүлж байв. Түмэн хаан Монгол улсын дотоод, гадаад харилцааны нэгдмэл байдлыг хангахын төлөө тууштай тэмцжээ. Түмэн харь улс үндэстнүүдийг эрхшээж, тэднээс алба татвар авч байв.

Буян цэцэн хаан /1555-1603/

1593-1603 онд хаан суув.

Түмэн засагт хааны хүү. Буян хаан шашныг бадруулахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн тул "Даян сэцэн" цол өргөмжлөгджээ. Түүний ноёллын үед их хааны сүр хүчин доройтох хандлагатай болов. Нийт түмэн задрах аюул нүүрлэж, Мин Улстай байлдах хүчин мөхөстсөн юм. Энэ бүхнийг эерүүлэхийг чармайж явсан боловч нэгэнт бий болсон нөхцөл байдлыг зүгшрүүлэх боломж тэр үед хомс байжээ.

Лигдэн хаан /1592-1634/

1604-1634 онд хаан суув.

1604 онд хаан ширээнд суусан Чингисийн угсааны сүүлчийн хаан. Буян Сэцэн хааны хөвгүүн Мангус тайжийн хүү. Лигдэн хаан Монголын ихэс дээдсийн бутралыг намжааж, монголчуудыг нэгтгэн захирахын төлөө тууштай тэмцэж байв. Лигдэн төр, соёлын талаар шинэтгэл хийж, найман отог Цахар түмэнийг гурван түмэн болгон хувааж, нийслэл "Цагаан хот"-ыг байгуулжээ. Лигдэн хаан шарын шашныг дэлгэрүүлэхэд ихэд анхаарч, сүм хийд бариулан, Гунгаа-Одсэр тэргүүтэй эрдэмтдийн хүчээр "Ганжуур"-ыг бүрэн монголчлуулжээ. Тухайн үед хүчирхэгжсэн манж нар Лигдэнг талдаа татахыг оролдож байсан ч тэр бээр Манжийн эсрэг шургуу тэмцэж байжээ.

ХАЛХЫН САЙН НОЁДУУДЫН ЗАЛГАМЖ ВАН ГҮНГҮҮД

ХАЛХЫН САЙН НОЁН 1.

Засаг хошой чин ван бөлгөө.Эдүгээ Сайн ноён хавсарч залгамжилбай.

Язгуурын өргөмжилсөн нь Шамба. Юань улсын Тайзу хааны үр. Халхын Гэрсэнз жалайр хун тайжийн гучинцар. Энх амгалангийн гучдугаар он засаг төрийн жүн ван өргөмжилбэй. Гучин тавдугаар он дэвшүүлж, хошой чин ван өргөмжилбэй. Дөчин зургадугаар онд үгүй болой.

Анхдугаар удаа: залгамжилсан нь Дашдондов. Шамбын ахмад хөвгүүн. Энх амгалангийн дөчин зургадугаар он засаг хошой чин ван залгамжилбай. Найралт төвийн дөрөвдүгээр он насжсаны учирт байлгавай.

Хоёрдугаар удаа: залгамжилсан нь Ламжав Дашдондовын ахмад хөвгүүн. Найралт төвийн дөрөвдүгээр он засаг хошой чин ван залгамжилбай. Аравдугаар он ялтайн учирт хэргэмийг эвдвэй.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Дэнчинжав Дашдондовын хоёрдугаар хөвүүн. Найралт төвийн арван нэгдүгээр он засаг хошой чин ван залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний хорьдугаар онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Норовжав.Дэчинжавын ахмад хөвгүүн. Угтаа гүнгийн зэргээс хошууны бэйс өргөмжилбэй. Өөр илтгэл буй амуй.Тэнгэрийн тэтгэсний хорин долдугаар он засаг хошой чин ван залгамжилбай. Гучин нэгдүгээр он зарлигаар

түүний зургадугаар үеийн овог Түмэнхиний Сайн ноёны цол залгамжлуулбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай. Тавин нэгдүгээр он өвчтэй болсны учир байлгавай.

Тавдугаар удаа залгамжилсан нь Цэдэнжав. Норовжавын ахмад хөвгүүн. Угтаа улсын түшээ гүн залгамжилбай. Өөр илтгэл буй амуй. Тэнгэрийн тэтгэсний тавин нэгдүгээр он дэвшүүлж, засаг хошой чин ван залгамжлаад, Сайн ноён хавсаргавай. Тавин долдугаар онд үгүй болбой.

Зургаадугаар удаа залгамжилсан нь Ренчиндорж Цэдэнжавын хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин наймдугаар он засаг хошой чин ван залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 2.

Хамааргасан хошууны бэйс бөлгөө. Эдүгээ улсын түшээ гүн залгамжилбай.

Язгуурын өргөмжилсөн нь Норовжав. Тэнгэрийн тэтгэсний арван долдугаар он гүнгийн зэрэг шагнавай. Хорьдугаар он хошууны бээр өргөмжилбэй. Хойно засаг хошой чин ван залгамжлаад, Сайн ноён хавсаргавай. Үүнийг чин вангийн илтгэлд гаргажухуй.

Анхан удаа залгамжилсан нь Цэдэнжав. Норовжавын ахмад хөвгүүн Тэнгэрийн тэтгэсний хорин долдугаар он улсын түшээ гүн залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай. Тавин нэгдүгээр он засаг хошой чин ван залгамжлаад Сайн нохой хавсаргавай. Үүнийг чин вангийн илтгэлд гаргажухуй.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Ренчиндорж. Цэдэнжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин нэгдүгээр он улсын түшээ залгамжилбай. Тавин наймдугаар он засаг хошой чин вангийн орой залгамжилбай.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Пунцагдаш. Ренчиндоржийн дүү. Тэнгэрийн тэтгэсний тавин наймдугаар он улс түшээ гүн залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 3.

Хамааргасан гүнгийн зэрэг тэргүүн тайж:

Язгуурын талбисан нь Сампилдорж. Чин ван Дэчинжавын гуравдугаар хөвгүүн. Угтаа тэргүүн зэрэг тайж болговой. Тэнгэрийн тэтгэсний хорин хоёрдугаар он гүнгийн зэрэг шагнавай. Дөчин есдүгээр онд үгүй болой. Анхан удаа залгамжилсан нь Дамиран. Сампилдоржийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавьдугаар он

гүнгийн зэрэг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тавин долдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Минжүүр. Дамираны тэнгэрийн тэтгэсний тавин долдугаар он гүнгийн зэрэг тэргүүн залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 4.

Засаг хошой чин ван

Язгуурын өргөмжилсөн нь Цэрэн. Чин ван Шамбын хаял дүү. Энх амгалангийн гучин нэгдүгээр он гуравдугаар зэрэг дашлагч түшмэл талбивай. Дөчин тавдугаар он бэйсийн зэрэг шагнавай. Жардугаар засаг талбавай. Найралт төвийн тэргүүн он тусгайлан зарлигаар төрийн жүн ван өргөмжилбэй. Есдүгээр он дэвшүүлж, хошой чин ван өргөмжлөөд, Халхын их засаг талбивай. Аравдугаар он шалгарсан баатар цол шагнавай. Тэнгэрийн тэтгэсний арван тавдугаар онд үгүй болсны хойно нэхэж зүтгэлт нэр соёрхож Таймяо/хят tai miao motayimiyuu/-д давшуулж тайлгасан бөгөөд мэргэн сайн сайдын тахил гэрт оруулж тайлгавай.

Анхан удаа залгамжилсан нь Цэнгүнжав. Цэрэнгийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тэргүүн он хошууны бэйс өргөмжилбэй. Дөрөвдүгээр он Шизы хятад. 5Ы 21, мон 51 21/өргөмжилбэй. Арван тавдугаар он засаг хошой чин ван залгамжилбай. Гучин зургадугаар он үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Лавандорж. Цэнгүнжавын долдугаар хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин есдүгээр он Ши өргөмжилбэй. Гучин зургадугаар он засаг хошой чин ван залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 5.

Хамааргасан төрийн бэйл бөлгөө. Эдүгээ хошууны бэйс залгамжилбай.

Язгуурын өргөмжилсөн нь Гүнгэравдан. Шалгарсан баатар зүтгэлт чин ван Цэрэнгийн дүү. Найралт төвийн тэргүүн он төрийн бэйл өргөмжилбэй. Удалгүйеэ үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Повоо\хят. Fo bao, мон, foboo, манж. Foboo/. Гүнгэравданы дөрөвдүгээр хөвгүүн. Найралт төвийн тэргүүн он зэрэг бууруулж, хошууны бэйс залгамжлуулбай. Аравдугаар он Зүүн гарт аваачигдвай. Хойно Илиэс эгээр өөр улсад туслагч гүн өргөмжилбэй. Үүнийг улсад туслагч гүнгийн илтгэлд гаргажухуй.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Шагдаржав Гүнгэравданы ахмад хөвгүүн. Найралт төвийн аравдугаар он хошууны бэйс залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний хорьдугаар он дэвшүүлж, төрийн бэйл өргөмжилбэй, хорин долдугаар онд үгүй болбой. Гуравдугаар удаа залгамжилсан нь Дондовдорж \Dondovdorj\ Шагдаржавын хоёрдугаар хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин долдугаар он зэрэг бууруулж, хошууны бэйс залгамжилбай. Дөчин зургаадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 6

Хамааргасан улсад туслагч гүн

Язгуурын өргөмжилсөн нь Эрхшар. Чин ван Цэнгүнжавын ахмад хөвгүүн тэнгэрийн тэтгэсний хорин хоёрдугаар он улсад туслагч гүн өргөмжилбэй. Хорин гурамдугаар он бэйсийн зэрэг шагнавай. Гучин нэгдүгээр онд үгүй болсоны хойно бэйсийн зэрэг залгамжлуулахыг байлгавай.

Анхан удаа залгамжилсан нь Ишжамц \isijamcu\ . Эрхшарын дүү, тэнгэрийн тэтгэсний гучин нэгдүгээр он улсад туслагч гүн залгамжилбай. Дөчинзургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай. Тавин тавдугаар онд үгүй болбой. Хоёрдугаар удаа залгамжилсан нь Дашдорж, /dashdorj/ Ишжамцын үеэлд ач Тэнгэрийн тэтгэсний тавин зургаадугаар он улсад туслагч гүн залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 7.

Хамааргасан улсад туслагч гүн

Язгуурын өргөмжилсөн нь Повоо. Угтаа түүний эцэс бэйс Гүнгэравданы хэргэм залгамжилсан бөлгөө. Үүнийг бэйсийн илтгэлд гаргажухуй. Тэнгэрийн тэтгэсний хорин хоёрдугаар он Илиэс эгээд гүнгийн зэрэг шагнавай. Хорин наймдугаар онд үгүй болбой. Анхан удаа залгамжилсан нь Сампилдондог \samfildondog\ Повоогийн ахмад хөвгүүн. тэнгэрийн тэтгэсний гучин зургадугаар он улсад туслагч гүн залгамжилбай. Дөчинзургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 8.

Хамааргасан гүнгийн зэрэг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь Ренчиндорж. Шалгарсан баатар зүтгэлт чин ван Цэрэнгийн тавдугаар хөвгүүн. Угтаа тэргүүн зэрэг тайж болгосон бөлгөө. Тэнгэрийн тэтгэсний хорин нэгдүгээр онд үгүй болсны хойно нэхэж гүнгийн зэрэг өргөмжилбэй.

Анхан удаа залгамжилсан нь Насандорж /nasandorj/ Ренчиндоржийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин нэгдүгээр он гүнгийн зэрэг тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 9

Засаг төрийн жүн ван.

Язгуурын өргөмжилсөн нь Цэвдэнжав. Шалгарсан баатар зүтгэлт чин ван Цэрэнгийн хоёрдугаар хөвгүүн. Найралт төвийн аравдугаар он улсад туслагч гүн өргөмжилбэй. Тэнгэрийн тэтгэсний арван зургадугаар он засаг болговой. Арван ёсдүгээр он бэйсийн зэрэг шагнавай. Хорьдугаар он төрийн бэйл өргөмжилбэй. Хорин нэгдүгээр он дэвшүүлж төрийн жүн ван өргөмжилбэй. Хорин гуравдугаар он зарлигаар түүний эцгийн шалгарсан баатар цол залгамжлуулаад, чин вангийн зэрэг шагнавай. Дөчинтавдугаар он хэтрэмхийлж захыг өргөтгөхүйг гуйсны учирт чин вангийн зэргийг эвдвэй. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй жүн ван залгамжлуулбай. Дөчин долдугаар онд үгүй болбой. Анхан удаа залгамжилсан нь Санпилдорж /sampildorj/. Цэвдэнжавын ахмад хөвгүүн. тэнгэрийн тэтгэсний дөчин долдугаар он засаг төрийн жүн ван залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 10.

Засаг төрийн жүн ван бөлгөө. Эдүгээ төрийн бэйл залгамжилбай.

Язгуурын өргөмжилсөн нь Гүмбү Чин ван Шамбын авга өвөг. Энх амгалангийн гучдугаар он засаг төрийн жүн ван өргөмжилбэй. Дөчин долдугаар онд үгүй болбой. Анхан удаа залгамжилсан нь Ренчин /eginchin/. Гүмбүгийн ахмад хөвгүүн. Энх амгалангийн дөчин долдугаар он зэрэг бууруулж засаг төрийн бэйл залгамжлуулбай. Дөчин есдүгээр он дэвшүүлж, төрийн жүн ван өргөмжилбэй. Удалгүйеэ үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Чойжамсан /soyijamsan/. Ренчингийн ахмад хөвгүүн. Энх амгалангийн тавьдугаар он засаг төрийн бэйл залгамжилбай. найралт төвийн тэргүүн онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Намжилчисүрүн /namjalcisurung/. Чойжамсаны ахмад хөвгүүн. Найралт төвийн хоёрдугаар он засаг төрийн бэйл залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний хорин тавдугаар онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Чимэддорж /cimeddorji/ Намжилчисүрүнгийн гуравдугаар хөвгүүн тэнгэрийн тэтгэсний

хорин тавдугаар он засаг төрийн бэйл залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай тавин тавдугаар онд үгүй болбой.

Тавдугаар удаа залгамжилсан нь Дэлэгпунцаг /delegfungcuу/ Чимэддоржийн ахмад хөвгүүн. тэнгэрийн тэтгэсний тавин тавдугаар он засаг төрийн бэйл залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 11.

Засаг улсын түшээ гүн бөлгөө. Эдүгээ төрийн жүн ван залгамжилбай.

Язгуурын өргөмжилсөн нь Тодэрдэнэ /tode erdeni/. Чин ван Шамбын хаяал дүү. Энх амгалангийн гучдугаар он засаг улсын түшээ гүн өргөмжилбэй. Гучин нэгдүгээр онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Убада /ubada/ Тодэрдэнийн ах. Энх амгалангийн гучин хоёрдугаар он засаг улсын түшээ гүн залгамжилбай. Дөчин есдүгээр онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Баму /bamu/. Убада-гийн ахмад хөвгүүн. Энх амгалангийн тавьдугаар он засаг улсын түшээ гүн залгамжилбай. Тавин нэгдүгээр онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Цэвээнноров /chewangnorbu/ Тодэрдэнийн үр болгосон хөвгүүн. Энх амгалангийн тавин нэгдүгээр он засаг улсын түшээ гүн залгамжилбай. Найралт төвийн хоёрдугаар он дэвшүүлж хошууны бэйс өргөмжилбэй. Аравдугаар он насжсаны учирт байлгавай.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Чэмчүгжав /chemcugjav/. Цэвээнноровын ахмад хөвгүүн. Найралт төвийн аравдугаар он засаг улсын түшээ гүн залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний гуравдугаар он дэвшүүлж хошууны бэйс өргөмжилбэй. Арван есдүгээр он бэйлийн зэрэг шагнавай. Хорин нэгдүгээр он төрийн бэйл өргөмжлөөд дагалдаагаар дэвшүүлж төрийн жүн ван өргөмжилбэй. Дөчин гуравдугаар онд үгүй болбой.

Тавдугаар удаа залгамжилсан нь Гүнчогжав /gungcovjav/. Чэмчүгжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний дөчин дөрөвдүгээр он засаг төрийн жүн ван залгамжилбай. Дөчин зурагдугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Тавин гуравдугаар он өвчтэй болсны учирт байлгавай.

Зургадугаар удаа залгамжилсан нь Дэмчигжав /demcuvjav/. Гүнчогжавын дүү. Тэнгэрийн тэтгэсний тавин гуравдугаар он засаг төрийн жүн ван залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 12.

Засаг улсын түшээ гүн бөлгөө. Эдүгээ төрийн бэйл залгамжилбай.

Язгуурын өргөмжилсөн нь Сутай илдэн /sutai ilden/. Чин ван Шамбын төрлийн дүү. Энх амгалангийн гучдугаар он засаг улсын түшээ гүн өргөмжилбэй. Дөчин хоёрдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Хонгор /допдуог/. Сутай илдэний ахмад хөвгүүн. Энх амгалангийн дөчин хоёрдугаар он зэрэг бууруулж, засаг тэргүүн зэрэг тайж залгамжлуулбай. Дөчин тавдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Анури /anuri/. Хонгорын ахмад хөвгүүн. Энх амгалангийн дөчин тавдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тавдугаар он улсад туслагч гүн өргөмжилбэй. Найралт төвийн есдүгээр он дэвшүүлж, хүшууны бэйс өргөмжилбэй. Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Доржванчуг /dorjiwangcuv/. Анурийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар он засаг хошууны бэйс залгамжилбай. Арван тавдугаар онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Лувсанцэрэн /luzangcerin/. Доржванчугийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван тавдугаар он засаг хошууны бэйс залгамжилбай. Хорьдугаар он Илийн урвасан хулгайг дарахуйд үгүй болсны учирт зарлигаар дэвшүүлж, бэйлийн хэргэм өргөмжилбэй.

Тавдугаар удаа залгамжилсан нь Дэмчигжав /demcuvjab/. Лувсанцэрэнгийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин нэгдүгээр онзасаг төрийн бэйл залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Тавин тавдугаар онд үгүй болбой.

Зургадугаар удаа залгамжилсан нь Гүмбүцэрэн /gumbucerin/. Дэмчигжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин тавдугаар он засаг төрийн бэйл залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 13.

Засаг улсад туслагч гүн

Язгуурын өргөмжилсөн нь Ваншуг. Чин ван Шамбын үелд хөвгүүн. Энх амгалангийн гучин нэгдүгээр он засаг улсад туслагч гүн өргөмжилбэй. Найралт төвийн аравдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Жалцан /Jalcan/. Ваншугийн ахмад хөвгүүн. Найралт төвийн тэргүүн он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний тавдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Батмөнх /batumongke/.

Жалцаны ахмад хөвгүүн тэнгэрийн тэтгэсний аравдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Хорьдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Дамбажинжүн /dambajingjun/. Батмөнхийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин нэгдүгээр он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжилбай. Тавин тавдугаар онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Лувсандорж /luzangdorji/. Дамбажинжүний ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин тавдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 14.

Засаг улсад туслагч гүн

Язгуурын өргөмжилсөн нь Аюуш. Чин ван Шамбын хаяалд дүү. Энх амгалангийн гучдугаар он засаг тэргүүн зэрэг тайж болговой. Гучин тавдугаар он улсад туслагч гүн өргөмжилбэй. Гучин есдүгээр онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Ванжил /wangjil/. Аюушийн ач. Энх амгалангийн гучин есдүгээр он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний арван хоёрдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Сандагцэмбэл /sanduvsembel/. Ванжилын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван хоёрдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Хорин тавдугаар он өвчтэй болсны учирт байлгавай.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Цэдэнжав /cedenjab/. Сандагцэмбэлийн ахмад хөвгүүн: Тэнгэрийн тэтгэснээр хорин тавдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Хорин есдүгээр онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Сандагцэмбэл, Тэнгэрийн тэтгэснээр хорин есдүгээр он дахиж засаг улсад туслагч гүн залгамжилбай. Гучин тавдугаар онд үгүй болбой.

Тавдугаар удаа залгамжилсан нь Гарма \kharm-a\). Цэдэнжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний гучин тавдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 15.

Засаг улсад туслагч гүн

Язгуурын өргөмжилсөн нь Цэрэндаш. Чин ван Шамбын хоёрдугаар хөвгүүн. Энх амгалангийн дөчин зургадугаар он засаг

тэргүүн зэрэг тайж болговой. Дагалдаагаар улсад туслагч гүн өргөмжилбэй. Найралт төвийн хоёрдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Дондовэринчин /dondob erincin/. Цэрэндашийн ахмад хөвгүүн. Найралт төвийн хоёрдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Наймдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Сэнэй /senei/. Дондовэринчиний ахмад хөвгүүн. Найралт төвийн наймдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний наймдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Гүнгэ. Цэрэндашийн хоёрдугаар хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний наймдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Арван дөрөвдүгээр онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь. Сандагжав /sanduyjab/. Цэрэндашийн гуравдугаар хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван дөрөвдугаар он зэрэг бууруулж, засаг тэргүүн зэрэг тайж залгамжлуулбай. Хорин дөрөвдүгээр он дахиж улсад туслагч гүнгийн язгуурын хэргэм залгамжилбай. Хорин зургадугаар онд үгүй болбой.

Тавдугаар удаа залгамжилсан нь Минжүүрдорж /minjurdorji/. Сандагжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин зургадугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Дөчин гуравдугаар он өвчтэй болсны учир байлгавай.

Зургадугаар удаа залгамжилсан нь Цэдэнжав /cedenjab/. Минжүүрдоржийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний дөчин гуравдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Тавьдугаар онд үгүй болбой.

Долдугаар удаа залгамжилсан нь Дэлэгдорж /deligdorji/. Цэдэнжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавьдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 16.

Засаг улсад туслагч гүн

Язгуурын өргөмжилсөн нь Норовжав. Улсын түшээ гүн Бамугийн ахмад хөвгүүн Энх амгалангийн тавин нэгдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж болговой. Тэнгэрийн тэтгэсний тэргүүн он улсад туслагч гүн өргөмжилбэй. Тавдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Дамбадорж /dambadorj/. Норовжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Есдүгээр онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь /Гүнчог /guncoy/.

Дамбадоржийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний есдүгээр он засаг улсад туслагч гүн залгамжилбай.

Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Тавин нэгдүгээр онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Сономбалжирдорж /sonombaljurdorji/. Гүнчогийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин нэгдүгээр он засаг улсад туслагч гүн залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 17.

Засаг тэргүүн зэрэг тайж бөлгөө. Эдүгээ гүнгийн зэрэг залгамжилбай.

Язгуурын талбисан нь Чинвандорж. Чин Ван Дэчинжавын хоёрдугаар хөвгүүн. Угтаа тэргүүн зэрэг тайж болгосон бөлгөө. Тэнгэрийн тэтгэсний арван есдүгээр он гүнгийн зэрэг шагнавай. Хорин хоёрдугаар он дэвшүүлж, бэйсийн зэрэг өргөмжилбэй. Хорин дөрөвдүгээр он засаг болговой. Гучин наймдугаар он ялтайн учирт хэргэмийг эвдвэй.

Анхан удаа залгамжилсан нь Сандавдорж /sandubdorji/. Чивандоржийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний гучин наймдугаар он гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тавин хоёрдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Ванчинжав /wangcinjab/. Сандавдоржийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин гуравдугаар он гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 18.

Засаг тэргүүн зэрэг тайж бөлгөө. Эдүгээ улсын түшээ гүн залгамжилбай.

Язгуурын талбисан нь Арьяа. Чин Ван Шамбын төрлийн үеэлд хөвгүүн Энх амгалангийн гучин нэгдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж болговой. Тавин дөрөвдүгээр онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Гэмпил /gemfil/. Арьяагийн ахмад хөвгүүн Энх амгалангийн тавин дөрөвдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Найралт төвийн аравдугаар он улсад туслагч гүн өргөмжилбэй. Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар он дэвшүүлж, улсын түшээ гүн өргөмжилбэй. Арван дөрөвдүгээр онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Гүнгэдондан /gunggedondan/.

Гэмпилийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван дөрөвдүгээр он засаг улсын түшээ гүн залгамжилбай. Гучин тавдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Дансүрүн /dangsurung/.

Гүнгэдонданы ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний гучин тавдугаар он засаг улсын түшээ гүн залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Дөчин долдугаар онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Чинвандаш /ciwangdasi/. Дамдинсүрэнгийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний дөчин долоодугаар он засаг улсын түшээ гүн залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 19.

Хамаарагсан улсад туслагч гүн

Язгуурын талбисан нь Дорж Улсын түшээ гүн Гүнгэдодоны төрлийн хүмүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин нэгдүгээр он улсад туслагч гүн өргөмжилбэй. Хорин долдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Шагдаржав. Доржийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин долдугаар он улсад туслагч гүн залгамжилбэй. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Тавин есдүгээр онд үгүй болбой.

ХАЛХЫН САЙН НОЁН 20.

Засаг тэргүүн зэрэг тайж бөлгөө. Эдүгээ улсад туслагч гүн залгамжилбай.

Язгуурын талбисан нь Туба Улсын түшээ гүн Тодэрдэнийн үеэл хөвгүүн. Энх амгалангийн гучдугаар он засаг тэргүүн зэрэг тайж болговой. Гучин зургадугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Сиди /sidi/. Туба-гийн ахмад хөвгүүн. Энх амгалангийн гучин зургадугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тавин наймдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Чиван /ciwang/. Сидийн ахмад хөвгүүн. Энх амгалангийн тавин наймдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Найралт төвийн аравдугаар он улсад туслагч гүн өргөмжилбэй. Тэнгэрийн тэтгэсний хорин хоёрдугаар он өвчтэй болсны учирт байлгавай.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Даш /dasi/. Чиван-ы ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин хоёрдугаар он улсад туслагч гүн залгамжилбай. Гучин нэгдүгээр он дэвшүүлж улсын түшээ гүн өргөмжилбэй. Дөчин тавдугаар онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Ламжав /lamajab/. Дашийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний дөчин тавдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай

ХАЛХЫН САЙН НОЁН 21.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь Данзанэрдэнэ. Чин ван Шамбын хаяал дүү. Энх амгалангийн гучдугаар он засаг тэргүүн зэрэг тайж болговой Тавин нэгдүгээр он үгүй болбой..

Анхан удаа залгамжилсан нь Шаржав /sirajab/ Данзанэрдэнийн ахмад хөвгүүн. Энх амгалангийн тавин нэгдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Найралт төвийн зургадугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Манзушир /manjusiri/. Шаржавын ахмад хөвгүүн. Найралт төвийн зургадугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Есдүгээр онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Чоймпил /coyimfil, cuyimpil/. Манзуширын ахмад хөвгүүн. Найралт төвийн есдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний хорьдугаар онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Дондовнамжид: /dondobnamjal/. Чоймпилын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорьдугаар он засаг гэргүүн зэрэг тайж залгамжилбай. Гучдугаар онд үгүй болбой.

Тавдугаар удаа залгамжилсан нь Доржчибаг /dorjicibay/. Чоймпилын хоёрдугаар хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний гучдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчдүгээр онд үгүй бодбой.

Зургадугаар удаа залгамжилсан нь Сономгүмбү /sonomgumbu/. Доржчибагийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний дөчдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай. Тавин гуравдугаар онд үгүй болбой.

Долдугаар удаа залгамжилсан нь Лувсандаш /luvsangdasi/. Сономгүмбүгийн хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин дөрөвдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 22.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь Самжид. Засаг тайж Арьяагийн авга өвөг. Энх амгалангийн гучин нэгдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж болговой. Тавин нэгдүгээр онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Гэндэн /gendun/. Самжидын ахмад хөвгүүн. Энх амгалангийн тавин нэгдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Найралт төвийн арван гуравдугаар он өвчтэй болсны учир байлгавай.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Буджав /budajab/. Гэндэний ахмад хөвгүүн. Найралт төвийн арван гуравдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний арван долдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Цэдэнжав /cedenjab/. Буджавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван долдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай. Дөчин долдугаар он өвчтэй болсны учирт байлгавай.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Доржжав /dorjijab/. Цэдэнжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний дөчин долдугаар он засас.тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 23.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талвисан нь Ядам ван Шамбын хаяал дүү. Энх амгалангийн гучин тавдугаар он эасаг тэргүүн зэрэг тайж болговой. Дөчин наймдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Даржав /darjiv-a/ Ядамын ахмад хөвгүүн энх амгалангийн дөчин наймдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Найралт төвийн зургадугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан Чиванжав /ciwanajab/. Даржаагийн ахмад хөвгүүн. Найралт төвийн зургадугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Арван хоёрдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Эринчин /erincin/. Чиванжавын ахмад хөвгүүн. Найралт төвийн арван хоёрдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний хорин есдүгээр онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Балсанминжүүр /balsangminjur/. Эринчиний ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин есдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Тавин долдугаар онд үгүй болбой.

Тавдугаар удаа залгамжилсан нь Базар /bajar/. Балсанминжүүрийн хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин есдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 24.

Хамааргасан улсад туслагч гүн

Яэгуурын өргөмжилсөн нь Гүмбүцэрэн. Засаг тайж Ядамын үеэл хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тэргүүн он улсад туслагч гүн өргөмжилбэй.

Есдүгээр онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Данжун /danung/. Гүмбүцэрэнгийн ахмад хөвгүүн. Тэнгэр тэтгэсний есдүгээр он улсад туслагч гүн залгамжилбай. Хорьдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Дашпунцаг /dasifungcuу/. Данжунгийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорьдугаар он улсад туслагч гүн залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралгүй залгамжлуулбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 25.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь Намжил. Засаг тайж Ядамын үеэлд дүү. Энх амгалангийн гучин тавдугаар он засаг тэргүүн зэрэг тайж болговой. Тавин тавдугаар онд үгүй болбой.

Анхан удаа эалгамжилсан нь Баран /barang/. Намжилын ахмад хөвгүүн. Энх амгалангийн тавин тавдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний арван гуравдугаар он өвчтэй болсны учирт байлгавай.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Аравтан /arabtan/. Барангийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван гуравдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Хорин дөрөвдүгээр онд үгүй болбой.

Гуравдугаар удаа эалгамжилсан Дондов /dondov/. Аравтны ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин дөрөвдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Гучин нэгдүгээр он өвчтэй болсны учирт байлгавай.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Ванжилсампил /wangjilsamfil/. Дондовын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний гучин нэгдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчин зургадугаар он үе улиран тасралгүй залгамжлуулбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 26.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь Шарилдэч Чин Ван Шамбын хаяал дүү. Энх амгалангийн гучин тавдугаар он засаг тэргүүн зэрэг тайж

болговой. Найралт төвийн хоёрдугаар он өвчтэй болсны учирт байлгавай.

Анх удаа залгамжилсан нь /Яндбоди /yandabodi/. Шарилдэчийн ахмад хөвгүүн. Найралт төвийн хоёрдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Лувсандондов /Luvzangdondob/. Яндбодийн ахмад хөвгүүд. Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Гучин хоёрдугаар он эмгэглэсний учирт байлгавай.

Гуравдугаар удаа залгамжилсан нь /Гүмбүдорж /gumbudorji/ Лувсандондовын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчин зургаа дугаар он зарилгаар үе улиран тасралгүй залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 27.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь Судани. Чин Ван Шамбын үеэл дүү. Энх амгалангийн гучин зургаа дугаар он засаг тэргүүн зэрэг тайж болговой. Гучин есдүгээр онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь /Цэвдэн /Cebden/. Сарванжилын ахмад хөвгүүн. Энх амгалангийн гучин есдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Найралт төвийн тэргүүн онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Цэвдэн /cebden/. Сарванжилийн ахмад хөвгүүн. Найралт төвийн тэргүүн он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Арван нэгдүгээр он ялтайн учирт хэргэмийг эвдвэй.

Гуравдугаар удаа залгамжилсан нь /Лайчунжав /layicungjab/. Цэвдэний ахмад хөвгүүн. Найралт төвийн арван нэгдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний хорин дөрөвдүгээр онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь /Наваанцэрэн /navangsering/. Цэвдэний хоёрдугаар хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин дөрөвдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Дөчин есдүгээр он өвчтэй болсны учирт байлгавай.

Тавдугаар удаа залгамжилсан нь /Гүнгэрэш /gunggerasi/. Наваанцэрэнгийн дөрөвдүгээр хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний дөчин есдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 28.

Хамааргасан гүнгийн зэрэг гутгаар зэрэг тайж

Язгуурын талбисан нь /Гаваа. Засаг тайж Лайчунжавын төрлийн хүмүүн. Угтаа гутгаар зэрэг тайж болгосон бөлгөө. Тэнгэрийн тэтгэсний хорин нэгдүгээр он гүнгийн зэрэг шагнавай. Гучин дөрөвдүгээр онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь /Санж /sangji/. Гаваагийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний гучин дөрөвдүгээр он гүнгийн зэрэг гутгаар зэрэг тайж залгамжилбай. Дөчин долдугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 29.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь /Зинамида. Чин Ван Шамбын хаяал дүү. Энх амгалангийн дөчин наймдугаар он засаг тэргүүн зэрэг тайж болговой.

Найралт төвийн хоёрдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Тэгш /tegsi/. Зинамида-гийн ахмад хөвгүүн. Найралт төвийн хоёрдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний арван тавдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Убаши /ubasi/. Тэгшийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван тавдугаар он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчин зургадугаар он зарилгаар үе улиран тасралтгүй залгамжилж байв. Тавин зургаа дугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Будачисүрүн /Budacisurung/. Убашийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин дөрөвдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 30.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь Дорж Чин Ван Шамбын үеэл дүү. Энх амгалангийн тавин нэгдүгээр он засаг тэргүүн зэрэг тайж болговой. Найралт төвийн гуравдугаар он өвчтэй болсны учирт байлгавай.

Анхан удаа залгамжилсан нь Ням /nim-a/. Доржийн ахмад хөвгүүн. Найралт төвийн гуравдугаар он засаг тэргүүн зэрэгтайж залгамжилбай. Аравдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Абуу /abuу/. Нямын ахмад хөвгүүн. Найралт төвийн аравдугаар он засаг тэргүүн зэрэг тайж

залгамжилбай. Тэнгэрийн тэтгэсний арван наймдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь /Цэримбал /cerimbal/. Доржийн хоёрдугаар хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван наймдугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Хорин тавдугаар онд үгүй болбой.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь /Цэнгүнжав /cenggunjab/. Цэрэнбалын ахмад хөвгүүн Тэнгэрийн тэтгэсний хорин тавдугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Хорин тавдугаар онд үгүй болбой.

Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжилуулбай. Тавьдугаар онд үгүй болбой.

Тавдугаар удаа залгамжилсан нь Дэмчиг /demciy/ Цэнгүнжавын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавьдугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 31.

Засаг тэргүүн зэрэг тайж

Язгуурын талбисан нь Эмгэн. Жүн ван Гүмбү-ийн жич. Тэнгэрийн тэтгэсний гуравдугаар он тэргүүн зэрэг тайж болговой. Дөрөвдүгээр онд засаг болговой. Хорин хоёрдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Даш /dasi/. Эмгэний ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин хоёрдугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Хорин гуравдугаар онд гүнгийн зэрэг шагнавай. Хорин тавдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Банди /bandi/. Дашийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин тавдугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Тавин тавдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Дамиран /damarin/. Бандийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин тавдугаар онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 32.

Өөлдийн засаг төрийн жүн ван бөлгөө. Эдүгээ хошууны бэйс залгамжилбай.

Язгуурын өргөмжилсөн нь Аравтан. Зүүнгарын тайж Эсмэд дархан ноёны есдүгээр үеийн ач. Энх амгалангийн дөчин нэгдүгээр он дагаар ирсний учир засаг төрийн жүн ван өргөмжилбэй. Дөчин хоёрдугаар онд үгүй болбой.

Анх удаа залгамжилсан нь Цэрэнванбу /ceringwangbu/. Аравтаны ахмад хөвгүүн. Энх амгалангийн дөчин хоёрдугаар он засаг төрийн жүн ван залгамжилбай. Найралт төвийн зургадугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Сэвтэнванбу /sebtenwangbu/. Аравтаны хоёрдугаар хөвүүн. Найралт төвийн тэргүүн онд төрийн бэйл өргөмжилбэй. Дөрөвдүгээр он засаг болговой. Долдугаар он төрийн жүн ван залгамжлуулаад, хоёр засгийг нэгэн засаг болговой. Тэнгэрийн тэтгэсний арван гуравдугаар онд үгүй болбой.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Пунсаг /funsuy/. Сэвтэнванбугийн үр болгосон хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний арван гуравдугаар он зэрэг бууруулж, засаг хошууны бэйс залгамжилбай. Хорин зургадугаар он зарлигаар Халхын Сайн ноён аймагт оруулбай. Дөчин гуравдугаар он ялтайн учирт засгийг байлгаж, бэйсийн хэргэмийг агуулбай.

Дөрөвдүгээр удаа залгамжилсан нь Намжил /namjal/. Пунсагийн ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний дөчин гуравдугаар он засаг хошууны бэйс залгамжилбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай. Тавин гуравдугаар онд үгүй болбой.

Тавдугаар удаа залгамжилсан нь Цэрэндорж /cerindorji/. Намжилын ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний тавин гуравдугаар он засаг хошууны бэйс залгамжилбай. Тавин зургадугаар онд үгүй болбой.

Зургадугаар удаа залгамжилсан нь Пунсаг. Цэрэндоржийн өвөг. Тэнгэрийн тэтгэсний тавин зургадугаар он мөнхүү засаг хошууны бэйс залгамжилбай.

ХАЛХЫН САЙН НОЁН 33.

Өөлдийн засаг улсад туслагч гүн бөлгөө. Эдүгээ хошууны бэйс залгамжилбай.

Язгуурын өргөмжилсөн нь Данжила. Зүүнгарын тайж Эсмэд дархан ноёны есдүгээр үеийн ач. Энх амгалангийн гучин зургадугаар он дагаар ирсний учир дотоод сайд талбивай. Дөчин дөрөвдүгээр он засаг улсад туслагч гүн өргөмжилбэй. Дөчин долдугаар онд үгүй болбой.

Анхан удаа залгамжилсан нь Доржсэвтэн /dorjisebten/. Данжилагийн ахмад хөвгүүн. Энх амгалангийн дөчин долдугаар он засаг улсад туслагч гүн залгамжилбай. Найралт төвийн тэргүүн он дэвшүүлж, хошууны бэйс өргөмжилбэй. Наймдугаар он дэвшүүлж, төрийн бэйл өргөмжилбэй. Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар онд үгүй болбой.

Хоёрдугаар удаа залгамжилсан нь Сандав /sandub/. Доржсэвтэний ахмад хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хоёрдугаар он засаг хошууны бэйс залгамжилбай. Хорин тавдугаар онд үгүй болбой. Үе улиран тасралгүй залгамжлуулбай.

Гуравдугаар удаа залгамжилсан нь Гүнчогбан /gungsoybang/. Сандавын үр болгосон хөвгүүн. Тэнгэрийн тэтгэсний хорин зургадугаар он засаг хошууны бэйс залгамжлуулаад, зарлигаар Халхын Сайн ноёны аймагт оруулбай. Дөчин зургадугаар он зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулбай.

АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ГУРВАНТАА СУУРЬШСАН ИХ ХҮРЭЭНИЙ НҮҮДЭЛ

Өргөө-их хүрээний нүүдэл

Хутагтын өргөө буюу Их хүрээ 1639-1855 он хүртэл 28 удаа нутаг сэлгэн нүүсэн гэдгийг эрдэмтэн Л.Дүгэрсүрэн, С.Пүрэвжав, С.Ичинноров, О.Пүрэв нар бичсэн бөгөөд энд бид шинжлэх ухааны доктор, түүхч Отгоны Пүрэвийн "Монголын улс төрийн төв" (Улаанбаатар 1994 он) гэдэг номонд Хутагтын өргөө суурьшиж байсан гэж дурьдсан газар нутгийн газарзүйн товч тодорхойлолт гаргалаа. Өргөө, Их хүрээ нүүдэллэн бууж байсан газруудыг олж тогтоох ажлыг Улаанбаатар хотын соёлын газар санаачилга гаргасныг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дэмжиж 1999 оноос эхэлсэн юм. Ингээд уг газруудыг олж тогтоох, тэр бүгдэд дурсгалын гэрэлт хөшөө босгох ажлыг 1999-2003 онд гүйцэтгэхэд үе үед нь Улаанбаатар хотын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Болдсайхан Улаанбаатар хотын соёлын газрын дарга Г.Нямсамбуу, Ц.Энхбат, эрдэмтэн О.Пүрэв, С.Ичинноров, С.Идшинноров, Ш.Шагдар, О.Сүхбаатар, Ж.Саруулбуян, Ардын багш Г.Миеэгомбо, ажилтан Г.Сүхбаатар С.Жимээхүү, Д.Энхчимэг, С.Оюунчимэг, сэтгүүлч, сурвалжлагч Д.Цогбадрах, Н.Ариунтуяа, Ш.Ундармаа, С.Жаргалсайхан, Б.Солонго, С.Насанбат, Б.Болдболор нар оролцон ажилласан юм. 1999-2002 онд уг газруудаа олж тэмдэг тамга тавьсан бөгөөд 2003 онд уг тамгаа гантиган гэрэлт хөшөө болгосон билээ. Хутагтын өргөө ингэж олон нүүсэн нь Монголчуудын нүүдлийн уламжлал, байгаль хамгааллын бодлого, улс төр нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас болж байсан бөгөөд энэ тухай эрдэмтэн О.Пүрэв номондоо тодорхой бичжээ. Гэрэлт хөшөө босгосон газруудаа дурдъя.

- 1. Ширээт Цагаан нуур.** Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутагт сумын төвөөс хойш 27 км-т манхат Монгол элсэнд Их Монгол уулын зүүн урд хормойд оршдог. Энэ нуурын эрэг дээр 1639 онд Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазарыг 5 настай байхад нь Гэгээн цол өргөмжилж анхдугаар Богд гэж алдаршуулан түүнд Шар бүст өргөө барьж өгснөөр өнөөгийн Улаанбаатарын суурь тавигджээ. Ширээт цагаан нуурын оршдог монгол элс нь хээрийн бүсийн хүрээлэнд оршдог. Монгол улс нь бургас, улиасан шугуй ойтой. Нуурын эрэгт

нь шинэсэн төгөлтэй, ойд нь хөхөө донгоддог, халиун буга сүргээрээ амьдардаг, Их монгол ууланд нь өндөр уулын арц ургадаг ийм сонин нутаг. Өөрөөр хэлбэл Монголын говь, хээр, ойт хээр, ой тайга, өндөр уулын тагийн бүс гээд монгол орны байгалийн үндсэн бүсийн төрх байдлыг хадгалсан энэ онцлог нутгийг сонгож монголын нийслэлийн шав тавьсан эрдэмт, их ухаант хүмүүс дээдсийн санаа бодлыг үнэхээр биширнэ. Шар бүст өргөөний анхны суурь тавьсан газрыг Ширээт цагаан нуурын эргээс баруун тийш холгүй, Их Монгол уулаас зүүн урагш 2 км орчимд хойд өргөргийн 47° 09' зүүн уртрагийн 103°55'-ын солбилцолд далайн төвшнөөс дээш 1500 орчим м өндөр газарт сонгож тэндээ гэрэлт хөшөө босгов. Ширээт цагаан нуур нь манай улсын өнөөгийн нутгийн газарзүйн төв цэг Хүйс Өвөрхөшөөтөөс хойш тийм их холгүй (40 орчим км) байгаа нь бас санамсаргүй хэрэг бишээ. Ширээт цагаан нуур нь бас Хүннүгээс хойш бараг бүх Монгол улсын нийслэл хаадын орд оршиж байсан Орхоны хөндийн хавьд (90 орчим км) байгаа нь ч бас жирийн тохиолдол биш биз.

2. **Улаан худаг. Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт Өгийнуураас урагш шуудаараа 12 км-т Хөгшин Орхон голоос зүүн тийш 10 км-т толгодорхог хээр тал нутагт далайн төвшнөөс дээш 1300 орчим м өндөрт хойд өргөргийн 47°40', зүүн уртрагийн 102°47'-ын солбилцолд гэрэлт хөшөө босгов. Хутагтын Өргөө энд 1640-1654 онд суурьшиж байжээ. Орхоны хөндийд оршдог.**
3. Хэнтий ханы өвөрт Хутагтын өргөө 1654-1688 онд суурьшиж байсан аж. Хагийн Хар нуураас зүүн хойш орших 2666 м өндөр Сарьдагийн өвөрт байсан бөгөөд сарьдгийг нь Хийдийн сарьдаг, Хийдийг нь Сарьдагийн хийд гэж нэрлэж байсан. Өргөө энд хийдийн голын хөвөөнд хойд өргөргийн 47°28', зүүн уртрагийн 108°02'-ын солбицол орчимд байрлаж байсан бололтой. Энд энэ удаа гэрэлт хөшөө босгож амжаагүй. Хэнтий хан нь Монголын их тайгатай уул билээ. Энэ хийдийг Галданбошготын цэрэг 1688 онд эзлэн сүйтгэсэн гэдэг.
4. **Өгөөмөр.** Төв аймгийн Баян сумын нутаг Ихбаян ба Өгөөмөрийн дунд намхан ширээд Өгөөмөрийн нуурын хонхороос баруун хойш Хүүш, Дарцагт, Сэрвэн толгодоос урагш далайн төвшнөөс дээш 1400 орчим м өндөрт хойд өргөргийн 46°59', зүүн уртрагийн 107°58'-ын солбицол орчимд гэрэлт хөшөө босгов. Энд Хутагтын өргөө 1688-1689

- он, 1743-1747 онд 2 удаа суурьшиж байжээ. Энэ хавь нутаг нь Монголын жинхэнэ хээр тал нутгийн нэг хэсэг нь юм.
5. **Хутагтын өргөө.** 1690-1700 онд Өвөрмонголын нутагт суурьшиж байжээ. Энд энэ удаа гэрэлт хөшөө босгож амжаагүй.
 6. **Эрдэнэтолгой.** Архангай аймгийн Төвшрүүлэх сумын нутагт сумын төвөөс урагш 16 км-т Хөх сүмийн голын хөндийн хойд захад хуучин Хөх сүмийн туурийн дэргэд далайн төвшнөөс дээш 1700 орчим метр өндөрт хойд өргөргийн 47°15', зүүн уртрагийн 101°59'-ын солбицол орчимд гэрэлт хөшөө босгов. Энд хутагтын өргөө 1700-1719 онд (19 жил) суурьшиж байж. 1706 онд Цогчин дугантай болсон аж. О.Пүрэв номондоо усаа өгдөг Цэцэрлэг голын хөндийд орших Эрдэнэтолгойд Хутагтын өргөө суурьшиж байсан гэж бичсэн. Хөх сүмийн голын Эрдэнэтолгойд гэрэлт хөшөө босгосонд О.Пүрэв жаахан эргэлзэж байсан. Өргөө Эрдэнэтолгойд байхдаа Их хүрээ нэртэй болсон юм байна.
 7. **Дааган дэл.** Сэлэнгэ аймгийн Ерөө сумын төвөөс бауун хойш 9 км-т Дааган дэл уулын зүүн урд бэлд далайн төвшнөөс дээш 700 м өндөрт хойд өргөргийн 49°48', зүүн уртрагийн 106°37'-ын солбицолд гэрэлт хөшөө босгов. Их хүрээ энд 1719 онд суурьшиж байжээ. Ерөө голоос хойш 4 орчим км зайтай байна. Жинхэнэ ойт хээрийн нутаг.
 8. **Усан сээр.** Сэлэнгэ аймгийн Сант, Хушаат сумын нутаг Сондуулт, Хушаат, Хонгилт, Хожуул голууд нийлж Усансээр гол болж Орхонд цутгадаг юм. Энэ голын зүүн гарт Галсангийн гозгор уулын урд бэлээс урагш Орхон Усансээр голын бэлчирээс дээш 4 орчим км зайтай хойд өргөргийн 49°28', зүүн уртрагийн 105°36'-ын солбицол орчимд гэрэлт хөшөө босгов. Энд Их хүрээ 1720-1722 онд суурьшиж байжээ.
 9. **Тамир.** Их хүрээ энд 1722-1723 онд суурьшиж байжээ. Архангай аймгийн Батцэнгэл, Ихтамир сумын нутгийн хооронд чухам хаана суурьшиж байсныг тодруулах шаардлагатай тул энэ удаа хөшөө босгосонгүй.
 10. **Жаргалант.** Төв аймгийн Жаргалант сумын нутагт сумын төвөөс урагш 6 км-т Буурал уулын өвөрт Жаргалант голын баруун гарт далайн төвшнөөс дээш 900 орчим м өндөрт хойд өргөргийн 48°27', зүүн уртрагийн 105°55'-ын солбицол орчимд гэрэлт хөшөө босгов. Их хүрээ 1723 онд өвөлжжээ.

11. **Угтаал жаргалант.** Төв Угтаалцайдам сумын хуучин II багийн нутаг, Угтаалын голын баруун гарт, Дэлгэр булгийн хойд дэнжид хоёр голын бэлчирээс зүүн тийш Угтаалцайдам сумын төвөөс зүүн тийш Угтаалцайдам сумын төвөөс зүүн тийш 45 км-т Жаргалант сумын төвөөс баруун урагш 18 км-т Тахилгат Шархад уулаас зүүн тийш далайн төвшнөөс дээш 1000 орчим метр өндөрт хойд өргөргийн $48^{\circ}23'$, зүүн уртрагийн $105^{\circ}47'$ -ын солбицолд гэрэлт хөшөө босгов. Их хүрээ энд 1724 онд суурьшиж байжээ.
12. **Орхон-Ээвэн голын бэлчир.** Сэлэнгэ аймгийн Сант сумын төв. Сумын Засаг даргын Тамгын газрын үүдэнд далайн төвшнөөс дээш 900 орчим м өндөрт хойд өргөргийн $49^{\circ}15'$, зүүн уртрагийн $105^{\circ}23'$ -ын солбицолд гэрэлт хөшөө босгов. Хоёр голын бэлчирээс хойш 4 орчим км зайтай. Энд Их хүрээ 1725-1729 онд суурьшиж байжээ.
13. **Ээвэн гол.** Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутагт Амарбаясгалант хийдийн баруун талд ойрхон далайн төвшнөөс дээш 1000 метрт, хойд өргөргийн $49^{\circ}28'$, зүүн уртрагийн $105^{\circ}05'$ -ын солбицолд гэрэлт хөшөө босгов. Энд Их хүрээ 1724 оны зун суурьшиж байв.
14. **Хужирбулангийн Жаргалант.** Улаанбаатараас зүүн тийш Хужирбулангаас зүүн урагш ойрхон Их хүрээ 1730-1732 онд суурьшиж байж, энд хөшөө босгоогүй.
15. **Бургалтайн гол.** Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг сумын төвөөс баруун тийш 30 орчим км-т Бургалтайн голын хөндийд Хөх овоо (Хүүхдийн овоо)-ноос зүүн урагш голын зүүн гарт далайн төвшнөөс дээш 1200 орчим м өндөрт хойд өргөргийн $48^{\circ}20'$, зүүн уртрагийн $106^{\circ}34'$ солбицолд гэрэлт хөшөө босгов. Энд Их хүрээ 1732 онд суурьшиж байжээ.
16. **Сөгнөгөр.** Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг сумын төвөөс зүүн хойш 7 орчим км-т Сөгнөгөр голын баруун гарт Алтанбүс уулын өвөрт Их нарстайн амны адагт далайн төвшнөөс 1000 орчим м өндөрт хойд өргөргийн $48^{\circ}23'$, зүүн уртрагийн $106^{\circ}53'$ -ын солбицолд гэрэлт хөшөө босгов. Энд Их хүрээ 1730-1732 онд суурьшиж байж. Энд гэрэлт хөшөө босгох газраа сонгож явах замд Тахилгат Мандал тоглой дээр УИХ-ын дарга С.Төмөр-Очир, Ерөнхий сайд Н.Энхбаяр, МАХН-ын Д.Идэвхитэн, Төв аймгийн Засаг дарга Мэндбилэг нартай уулзаж ажил явдлаа танилцуулж явав. Тэд бидэнд зөв зүйтэй ажил хийж яваа юм байна гэж урам хайрлав.

17. Тэрэлж Туулын бэлчир. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг. Тэрэлжийн амралтаас доош 10 км-т Тэрэлж голын зүүн гарт, Баянбулгийн Зоо уулын өвөрт, Туул-Тэрэлжийн бэлчирт далайн төвшнөөс дээш 1500 орчим м өндөрт хойд өргөргийн 47о57', зүүн уртрагийн 107о35'-ын солбицолд гэрэлт хөшөө босгов. Энд Их хүрээ 1733 онд өвөлжжээ.
18. **Хүйн гол (Хүйн нуур)**. Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг, сумын төвөөс урагш 8 км-т төмөр замын 24 дүгээр зөрлөгийн дэргэд далайн төвшнөөс дээш 1100 орчим м өндөрт хойд өргөргийн 48о17', зүүн уртрагийн 106о44'-ын солбицолд гэрэлт хөшөө босгов. Энд Их хүрээ 1736-1740 онд суурьшиж байжээ.
19. **Хунцлын голын эх**. Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт, сумын төвөөс баруун тийш Нарстайн давааны өвөрт Хунцлын голын эх орчимд голын зүүн гарт далайн төвшнөөс дээш 1100 орчим метр өндөрт хойд өргөргийн 48о25', зүүн уртрагийн 106о26'-ын солбицолд гэрэлт хөшөө босгов. Энд Их хүрээ 1740-1742 онд суурьшиж байв.
20. **Үдлэг**. Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг сумын төвөөс урагш 12 км-т Жаргалант уулын баруун аманд Үдлэг суурингийн хойд захад уулын баруун аманд хуучин усан сангийн хаалт далангаас хойш далайн төвшнөөс дээш 1200 орчим м өндөрт, хойд өргөргийн 48о17', зүүн уртрагийн 106о48'-ын солбицолд гэрэлт хөшөө босгов.

Их хүрээ өнөөгийн Улаанбаатарын дэвсгэр нутагт хэд хэдэн газарт суурьшиж байсан бөгөөд тэр бүгдэд гэрэлт хөшөө босгоогүй.

Тайлбар: Далайн төвшнөөс дээш их өндөр, газарзүйн солбилцлүүдыг 1:500 000 масштабтай зургаас тодорхойлов.

САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ҮЕ ЗАЛГАМЖЛАХ ВАН ГҮНГҮҮДИЙН БАС НЭГЭН БАРИМТ СЭЛТИЙГ ЖАГСААН БИЧВЭЭС ҮҮ

Цэвээндорж. Цэсхив дайчин баатрын хөвгүүн

Цэвээнноров. Цэвээндоржийн хүү. Засаг түшээ гүн Тод -Эрдэнийн үрчилсэн хөвгүүн. Манжийн дотоод сайд, дээд адууны явдлын яамны эрхэлсэн түшмэл, Шулуун шарын монгол хошууны сумын зангийн тушаалд хавсран ажиллаж байжээ. 1712 онд эцэг Тод эрдэнийн засаг улсын түшээ гүнгийн хэргэм залгамжилсан. 1716 онд Хөхнуурын ноёдын үймээнийг эвлэрүүлэхэд хиа Бударийн хамт хүчин зүтгэв. 1720 онд Манжийн тэрсэлснийг түвшитгэгч жанжин Яншиний цэргийн хэргийн туслан шийтгэх албанд томилогдож, Түвдийн 6-р Далай лам Лувсангалсанжамцын ширээнд залж, Баруун зууд хүргэжээ. Үүний дараа түүнд Баруун дахиныг тогтоогч жанжины тамга олгожээ. 1723 онд Хөхнуурын Лувсанданзаны байдлыг мэдээлсэн бөгөөд Баруун зууд орсон учир гавьяаг ялгаж, хошууны ноёнд өргөмжилж, 3 нүдний тогосын отго шагнуулав. 1726 оноос дэд чуулганы даргаар ажиллаж байгаад 1732 онд насжсан учир байлгав/Илтгэл шастир. 71-р дэвтэр/. Тэрбээр сайн ноён аймгийн Эрдэнэ засгийн хошууны ноёдын өвөг юм. Тус хошуу нь Манжийн эрхшээлийн үед Халхын хойт замын дундадын баруун этгээдийн хошуу нэртэй байжээ. Энэ нь одоогийн Баянхонгор аймгийн Гурванбулаг, Бууцагаан, Заг, Жаргалант сум бүтнээр, Шинэжинст сумын зарим хэсгийг хамарч байв.

Чамчугжав. Цэвээнноровын ахмад хөвгүүн. 1732 онд засаг улсын түшээ гүн залгамжилсан. Мөн онд Хэрсэн чулуу, Эрдэнэ зууд Зүүнгарын цэрэгтэй сайн тулалдсан учир Цянь чин минд явуулжээ. 1738 онд Тэнгэрийн тэтгэсэн хааны буулгасан зарлигт "Эдүгээ үзвээс Чамчугжав цэргийн хүрээд ахуд бас ч ихэд хичээн зүтгэсэн тулд дэвшүүлж, бэйс залгамжлуулагтун" гэжээ. /Илтгэл шастир. 71-р дэвтэр/. 1753 онд Зүүнгарын Мамудыг барьсан учир бэйлийн зэрэг, 3 нүдний тогосын отго хадуулжээ. 1756 онд Чингүнжавын бослогын үеэр тасарсан өртөөг залгуулсан учир Чамчугжавыг төрийн бэйл, удалгүй жүн вангийн зэрэг өргөмжлөгджээ. 1757 онд Урианхайг дагуулахад хүчин зүтгэсэн учир төрийн жүн вангийн хэргэм шагнуулав. Үүнээс хойш тэрээр аймгийн туслах жанжин чуулган даргаар ажиллаж байгаад 1778 онд нас баржээ.

Гончигжав. Чамчугжавын ахмад хөвгүүн. 1761 онд Мураны авд явсан учир тогосын отог шагнуулж, 1772 онд Цянь чин минд

явжээ. 1779 онд засаг төрийн жүн ван залгамжлаад Мураны авд явсан учир 3 нүдний тогосын отго, шар олбог шагнуулав. 1781 онд Тэнгэрийг тэтгэсэн хааны буулгасан зарлагт Тончигжавын язгуурын тулгар өвөг Тод эрдэнэ язгуураас гүнгийн хэргэм өргөмжилсөн бөглөө. Дараагаар Гончигжавын эцэг Чамчугжав цэргийн газарт шаламгайлан явж, гавьяа зүтгэлгэ хэтийдэж гарсаны учирт улсын түшээ гүнгээс жүн ванд хүргүүлж өргөмжлөв. Үүнд хишиг хүртээж тасралтгүй залгамжлуулагтун" гэжээ. /Илтгэл шастир. 71-р дэвтэр /. Тэрбээр 1788 онд өвчин олсон учир түүний дүү Дэмчигжавт засаг хэргэмийг залгамжлуулав.

Улсын түшээ гүнгээс жүн ванд хүргүүлж өргөмжлөв. Үүнд хишиг хүртээж тасралтгүй залгамжлуулагтун" гэжээ. Илтгэл шастир. 71-р дэвтэр/. Тэрбээр 1788 онд өвчин олсон учир түүний дүү Дэмчигжавт засаг хэргэмийг залгамжлуулав.

ДАМЧУГЖАВ. Гончигжавын дүү. 1788 онд засаг төрийн жүн вангийн хэргэм залгамжилсан. Улмаар Цянь чин минд явж, 3 нүдний тогосын отго хадуулж, дараа жил нь Урамдалын авд явж, шар хүрэм, харавтар улаан жолоо шагнуулав. 1791 онд туслагч жанжны Хэбэй, 1793 онд аймгийн туслагч жанжин, 1801 он хүртэл Эрдэнэ засгийн хошууны ноён байв. /Илтгэл шастир. 71-р дэвтэр/.

ТҮГЖЖАВ. Дамчугжавын гутгаар хөвгүүн. 1831 онд засаг төрийн жүн ван залгамжилсан. 1835 онд Цянь чин минд явж, 3 нүдний тогосын отго хадуулав. 1837 оноос Сайн ноён аймгийн туслагч жанжнаар ажиллаж байв. Тэрбээр 1849 он хүртэл Эрдэнэ засгийн хошууны ноён байв.

ДҮЙНХЭРЖАВ. Түгжжавын ганц хөвгүүн. 1849 онд засаг төрийн жүн ван залгамжилсан. Тэрбээр 1856 он хүртэл Эрдэнэ засгийн хошууны ноён байв.

ГЭЛЭГЖАМЦ. Дамчугжавын тавдугаар хөвгүүн. 1857 онд засаг төрийн жүн ван залгамжилсан. 1865, 1866, 1867 онд цэргийн хэрэглэлд морь тусалсан учир удаа дараа 6 нэмсэн, 9 тэмдэглэсэн зэрэг олгуулж, 1767 онд аймгийн туслагч жанжин болжээ. Үүнээс хойш Булантахойн газар хот байгуулах ба цэргийн хэрэглэлд мөнгө, тэмээ тусалсан учир харавтар улаан жолоо, улбар шар жолоо шагнуулж, 1872 онд цэргийн өртөөг шийтгэхэд зүтгэсэн учир ноён байв. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал160/.

ЧОЙСҮРЭНЖАВ. Гэлэгжамцын ахмад хөвгүүн. 1878 онд засаг төрийн жүн ван залгамжилсан. 1883 онд Сайн ноён аймгийн дэд чуулган дарга, /130-р хуудас /

1885 онд аймгийн туслагч жанжны тушаалд томилогдов. Тэрбээр оргодол Очирбат, Далантай, Пүрэв нарыг барьсан учир

удаа дараа нэмсэн, тэмдэглэсэн зэрэг шагнуулж, мөн Цэрэн, Лхасүрэн, Гарьд нарын оргодлуудыг хугацаанд эс бариулсан учир 1 нэмсэн, 2 тэмдэглэсэн зэргээ хасуулж байв. 1895 онд Жавзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэх ажилд мөнгө тусласан учир 3 нүдний тогосын отго шагнуулж, Сайн ноён аймгийн чуулган дарга болов. Тэрбээр 1906 он хүртэл Эрдэнэ засгийн хошууны ноён байв. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 161/.

СОНОМ СЭЦЭН ДАЙЧИН ХОШУУЧ. Зодов сэцэн ноёны гутгаар хөвгүүн. " Шар века. Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шасстиной. М тууж "-д түүнийг " Зодов тайжийн Игэ хатнаас төрсөн Соном " /Шара туджи. Монгольская летопись XVII -Л., 1957. Стр.120./гэсэн бол " Асрагч нэртийн түүх "-нд " Зодов сэцэн ноён долдугаар хөвгүүн Соном сэцэн дайчин хошууч " /Асрагч нэртийн түүх. Галиглаж, үгийн хэлхээг үйлдсэн Ц. Шагдарсүрэн, И Сен Гю. УБ., 2002. Тал 80 /хэмээн бичжээ. Тэрбээр Хүрэн бэлчирийн орчим нутаглаж байжээ.

УБАДА. Соном сэцэн дайчин хошуучийн хөвгүүн. Тэрбээр 1692 онд дүү Тод - Эрдэнийн үрчилсэн хөвгүүн Цэвээнноровыг Бээжинд суулгаж, Дотоод сайд тавьсан учир засаг улсын түшээ гүн залгамжилж байжээ.

ТОД-ЭРДЭНЭ. Соном сэцэн дайчин хошуучийн хөвгүүн. 1688 онд Манжид дагаж, Өвөр Монголын Урд нутагт суужээ. 1690 онд өөрийн төрлийн тайж Сутай илдэнгийн хамт 3000 цэрэг авч, манж байд Ундаг дагалдаж, Туул голын орчимд Зүүнгарын цэргийн буцах замыг хаажээ. 1691 оны Долоннуурын чуулганаар засаг улсын түшээ гүн өргөмлөгджээ. Тэрбээр 1711 он хүртэл засаг байв.

БАМУ.Тод-Эрдэнийн ах Убадагийн ахмад хөвгүүн. Тэрбээр 1711 онд авга ах Тод-Эрдэнийн засаг улсын түшээ гүнгийн хэргэм залгамжилаад удалгүй нас баржээ. Баму нас барсны дараа Тод-Эрдэнийн хөвгүүн Норовжавыг тусгай засаг болгов.

Норовжав. Бамугийн ахмад хөвгүүн. Тэрбээр 1712 онд засаг тэргүүн зэрэг тайж өргөмжлөгджээ. 1731, 1732 онд Сүх алдах, Хэрсэн чулуу, Эрдэнэ зууд Зүүнгарын цэрэгтэй байлдсан учир 1736 онд гавъяаг нь хэлэлцэж, улсад туслагч гүнд өргөмжилж, тогосын отго шагнав. Тэрбээр Сайн ноён аймгийн Хошууч мэргэн засгийн хошууны өвөг юм. 1740 он хүртэл уг хошууны ноён байв. Тус хошуу нь Манжийн үед Халхын умар замын дундад дахь умард хошуу нэртэй байсан бөгөөд одоогийн Завхан аймгийн Отгон, Улиастай, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Алдархаан, Яруу сумын нутгийг хамарч байжээ. Үүнд Цагаанчулуут сумын нутагт Нарванчин хутагтын шавийн нутгаас оролцсон байна.

ДАМБАДОРЖ. Норовжавын ахмад хөвгүүн. 1740 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1741 онд Манжийн хуулийн сайд, мэйрний занги Гиндэй намрын сэргийлэх цэргийг байцаахад Дамбадоржийн хошууны цэргийн өнгө тэгш сайн хэмээн хөхүүлэн шагнажээ. Тэрбээр 1744 он хүртэл Хошууч мэргэн засгийн хошууны ноён байв.

ГОНЧИГ. Дамбадоржийн ахмад хөвгүүн. 1744 онд засаг улсад туслагч гүн залгамжлаад Урамдалын авд явсанд тогосын отго шагнуулсан. 1781 онд Тэнгэрийн тэтгэсэн хааны буулгасан зарлигт "Гончигийн залгамжилсан улсад туслагч гүн хэмээгч түүний өвөг Норовжавын цэргийн хүрээнд хүчин барьж шаламгайлан зүтгэсний учирт засаг тайжаас дэвшүүлж өргөмжилсний тулд хишиг хүртээж үе улиран тасралгүй залгамжлуулагтун" гэжээ. Тэрбээр 1786 он хүртэл Хошууч мэргэн засгийн хошууны ноён байв \Илтгэл шастир. 73-р дэвтэр\.

СОНОМБАЛЖИРДОРЖ. Гончигийн ахмад хөвгүүн. Тэрбээр 1786 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1812 онд Урамдалын авд явж, тогосын отго хадуулсан. Тэрбээр 1824 он хүртэл Хошууч мэргэн засгийн хошууны ноён байв.

ГҮРСЭД. Сономбалжирдоржийн ахмад хөвгүүн. 1824 онд засаг улсад туслагч гүн залгамжилж, тогосын отго хадуулжээ. Тэрбээр 1856 онд бие барах хүртлээ Хошууч мэргэн засгийн хошууны ноён байв.

ЭРХЭМЖАРГАЛ. Гүрсэдийн ахмад хөвгүүн. 1856 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. Тэрбээр 1864 онд тогосын отго хадуулж, цэргийн хэрэглэлд тэмээ, морь, үхэр, гэр, Улиастай хотыг засахад дөрвөн түмэн жин гурил тусалсан учир бэйсийн зэргээр шагнуулжээ. 1876 онд түүний бэйсийн зэргийг үе улиран тасралгүй залгамжлуулахаар болгож, хоёр нүдний тогосын отго хадуулжээ. Тэрбээр 1885 он хүртэл Хошууч мэргэн засгийн хошууны ноён байв. \Монгол улсын шастир. Тэргүүн боть. Уб., 1997. Тал 175\

ТӨМӨР-ОЧИР. Эрхэмжаргалын ахмад хөвгүүн. 1886 онд бэйсийн зэрэг засаг улсад туслагч гүн залгамжилж, Цянь чин минд явжээ. 1889 онд Манжийн хааны хишиг тараахад хоёр нэмсэн зэрэг, 1890 онд оргосон хулгай Батыг хугацааны дотор хүчлэн бариулсан учир нэг нэмсэн зэрэг шагнуулав. Тэрбээр 1893 он хүртэл Хошууч мэргэн засгийн хошууны ноён байв.

ДУГАРЖАВ. Төмөр-Очирын ахмад хөвгүүн. 1894 онд бэйсийн зэрэг засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1895 онд Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэн засахад мөнгө тусалсан учир хоёр тэмдэглэсэн зэрэг олгуулж, 1898 онд Цянь чин минд явжээ.

1907 онд аймгийн туслагч жанжны хэбэй, 1910 онд аймгийн туслагч жанжнаар томилогджээ. 1911 онд Очирдара Богд гэгээнтнийг хаан өргөмжилж, эрдэнийн сууринаа залсан учир зарлигаар бэйлийн зэрэг, хоёр нүдний тогосын отго, үе улиран хошууч мэргэн цол шагнан хүртээжээ. Дугаржав Монгол улсын Шүүх таслах яамны дэд сайдаар томилогдсон боловч тушаалын газар явсангүй учирт байлгажээ. 1914 онд Богд хаан тусгайлан зарлиг буулгаж, бэйсийн зэрэг шагнан хүртээж байв. \Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 175\

ДАНЗАН ЛАМ. Түмэнхэн сайн ноёны хоёрдугаар хөвгүүн. Түүнийг зарим Монгол сурвалжид "номын эзэн", "эрдэнэ үйзэн ноён" гэх зэргээр тэмдэглэжээ. Тэрбээр тойн болсноор Данжин лам хэмээн нэрлэгдэж, Далай ламаас "Номун хан" цол хүртжээ. Энэ тухай сурвалжид "Түмэнхэн үгүй болсон хойно түүний хоёрдугаар хөвгүүн Данжин ламыг Далай лам бас Номун хаан хэмээн цол соёрхвой" гэжээ. \Илтгэл шастир. 69-р дэвтэр\ Тийнхүү Данжин лам эцэг Түмэнхэний адил халхад шашныг дэлгэрүүлэх үйлсэд хүчин зүтгэж, Халхын зүүн гарын дотор нөлөө бүхий ноён болжээ. Данзан ламын угсаа гарал, шашны ажиллагаа нь Халхын ноёдын дотор нэр хүндийг нь өсгөж, Халх Манжийн харилцаанд ч голлох үүрэгтэй оролцож байв. Халх, Манжийн захидал харилцааны бичгүүдээс үзэхэд, Манжийн Эеэр засагч хааны Халхын ноёдод илгээсэн бичигт, Засагт хан, Түшээт хан, Сэцэн хааны дараагаар Данжин ламыг бичсэн байдаг. /Э. Жигмиддорж. Халх Манжийн улс төрийн харилцаа. УБ., 2008. Тал 68/. 1655 онд Данжин ламыг Халхын найман засгийн нэгээр томилж, жил бүр Халхын гурван ханы адил 9 цагаан алба бариулахаар болгов. 1661 онд түүнд "Утгыг дээдлэх журмыг дагагч" цол шагнаж, тамга олгожээ. Данжин лам Онги голын Хужирхай хэмээх газар нутаглаж байв.

Дашхив Илдэн Дүүргэч. Данзан ламын хөвгүүн бөгөөд 1660-аад оны эхээр эцэг Данзан ламын угсаа залгамжилсан боловч удалгүй нас баржээ.

Шамба. Данзан ламын ач бөгөөд Дашхивын илдэн дүүрэгчийн хөвгүүн. Тэрбээр Манжийн Энх амгалан хаанаас 1666 онд "Итгэмжит зэтэй эрх дайчин" цол шагнуулж, Сайн ноёны угсаа залгамжилжээ. Тэрбээр Сайн ноёны угсааны төрлийг тэргүүлж, Данжин ламын тамгыг барьж байв. 1686 онд Хүрэн бэлчирийн чуулганд Түшээт хан Чахундорж, Засагт хан Цэнгүн нарыг эвлэрүүлэхэд зуучлан оролцож байсан. Галдан бошготын довтолгооны үеэр харьяат ардыг авч, 1688 онд Манжид дагаж, Өвөрмонголын Урад аймгийн нутаг сууж байв. Энэ үед Шамбын Манжийн Энх амгалан хаанд айлтгасан

бичигт өгүүлснээр "Манзушир дээд их хааны гэгээнээ итгэлт найрт Эрх дайчин ноёны айлтгал.Эзний өршөөж эмхлэн сумлаж засаг цаазаар явахын захиа болсноос хойш хэд хэдэн хүн алсан билээ. Өөр зуурын самуу хулгай маань үгүй болжээ.Улсын сэтгэл нь тогтож аж төрөхийг хичээх болов. Сумлахад тус минь өөрийн хувьд сум 19 билээ. 860 эр, 2670 ам, хүнстэй. 1960 эр 5880 ам хоосон" гэж мэдүүлжээ /Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс.1X Боть.УБ.,2010.Тал 82/. 1691 оны Дол нуурын чуулганаар засаг төрийн жүн ван буюу "ван тайж" өргөмжлөгдөж,Түшээт хан аймагт захирагдаж байв.1696 онд Манжийн баруун замын их цэргийн бүрэлдэхүүнд Галдан бошготын цэргийг Зуумодонд цохиж,559 хүнийг дагуулсан учир зарлигаар хошой чин ван өргөмжлөгджээ.1701 онд Энх амгалан хааны зарлигаар харьяат цэргээ авч,Алтайд Зүүнгарын Цэвээнравданг сэргийлэн суужээ. Шамба Сайн ноён аймгийн Сайн ноёны хошууны өвөг бөгөөд 1707 он хүртэл засаг байжээ.Тэрбээр Дашдондов,Цэрэндаш гэсэн 2 хөвгүүнтэй байв/.Илтгэл шастир.69-р дэвтэр/.Сайн ноёны хошуу нь одоогийн Өвархангай аймгийн Бат-Өлзий,Баруунбаян-Улаан,Гучин-Ус,Хайрхандулаан,Нарийн тээл,Уянга,Богд,Баянхонгор аймгийн Богд сумын нутгийг хамарч байжээ.

Дашдондов.Шамбын ахмад хөвгүүн.1707 онд эцэг Шамбын засаг хошой чин вангийн хэргэм залгамжилж,дараа нь чуулган дарга болжээ.1725 онд Найралт төв хаан "харьяат аймгийн үржил Сайн ноёноос гарсан нь 3 ханы үрээс маш олон" хэмээгээд Дашдондов,бэйл Намжил,бэйс Цэвээнноров нарын зэрэг Сайн ноён аймгийн 19 засгийг Түшээт хан аймгаас салгаж "Халхын дундад зам" буюу "Сайн ноён аймаг" хэмээн нэрийджээ.1726 онд чин ван Дашдондов насжсан учир засгаас байлгахыг гуйсан ёсоор болгожээ./Илтгэл шастир.69-р дэвтэр/.

Ламжав. Дашдондовын ахмад хөвгүүн.1726 онд засаг хошой чин вангийн хэргэм залгамжилжээ. 1731 онд Зүүн гарын Галданцэрэн хаан "олон халх"-ыг аргадсугай хэмээн Ламжавт бичиг хүргүүлж, Манжийн хаанд айлтгасанд "олон халх нарт ухуулагтун. Бүү түүнд мунхрагтун" гэж зарлиг буулгаж байв. 1732 онд Хэрсэн чулуунд Манжийн их цэрэг Зүүнгарын Цэрэндондовын цэрэгтэй тулалдахад Ламжав цааргалан, цэргийн газрыг орхиж, нутагт буцсан учир эхлээд алах ял заагдсан боловч эцэст нь хэргэмийг эвдэж, үүрд хорионд оруулжээ. Мөн Ламжавын хошуунаас нэгэн сум татаж, эфү Цэрэнд өгчээ. /Илтгэл шастир 69-рдэвтэр/.

Дэчинжав.Дашдондовын хоёрдугаар хөвгүүн.1733 онд засаг хошой чингийн хэргэм залгамжилжээ. 1751 онд Сайн ноён аймгийн

туслагч жанжин, дэд чуулган даргаар тавигджээ. 1752 онд Түшээт хан аймгийн ван Чавагаримпилын хамт Шар усанд, 1754 онд Улиастайн харуулд Зүүнгараас сэргийлэн суужээ. Мөн онд Хойдын Амарсанаагийн дагуулан ирсэн ардыг Тамирт нүүлгэн харгалзан суужээ. 1756 онд хуулийн сайд болсны дараа Чингүнжавын бослогын үед Халхын ноёдод бичиг илгээж, харуулын хуудас 134-135 нэмсэн зэрэг цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир улбар шар жолоо шагнуулжээ. Тэрбээр 1883 он хүртэл Сайн ноёны хошууны засаг ноён байв. /Монгол улсын шастир. Тэргүүн боть УБ.1997. тал145\ Цэргийг татсан хэмээн, Чингүнжавтай сүлбээлсэн хэмээн сэжиглэгдэж, хуулийн сайдаас огцорчээ. 1757 онд "цэргийн хэрэгт боловсон хийгээд урсгал номхон" хэмээн дахин хуулийн сайдаар тавигдаж, Бархөлд цэргийн хэрэгт зүтгүүлжээ. Тэрбээр 1762 он хүртэл Сайн ноёны хошууны засаг байжээ. Дэчинжав нь Норовжав, Цэвээндорж, Сампилдорж гэсэн 3 хүүтэй байв. /Илтгэл шастир. 69-р дэвтэр/

НОРОВЖАВ. Дэчинжавын ахмад хөвгүүн. Угтаа тэргүүн зэрэг тайжаас дэвшүүлж, хошууны бэйс өргөмжилжээ. 1762 онд засаг хошой чин вангийн хэргэм залгамжлав. Улмаар дэд чуулган даргаар тавигдаж, Цянь чин минд яван 3 нүдэт отго шагнуулав. 1725 онд Сайн ноён аймгийг түшээт хан аймгаас салган байгуулах үед Сайн ноён аймаг хэмээн нэрлэсэн боловч Сайн ноён цолыг тус аймгийн ноёдын аль нэгэнд залгамжлуулаагүй байжээ. Тиймээс 1776 онд Улиастайн жанжин Цэнгүнжавын айлтгасан ёсоор Сайн ноён аймгийн ноёдын дээд өвөг Түмхэний Сайн ноён цолыг түүний шууд угсааны чин ван Норовжавт залгамжлуулж, аймгийн туслагч жанжин болгожээ/Илтгэл шастир. 69-р дэвтэр/. Мөн Сайн ноён цолыг тэдний угсааны ноёдод Түшээт хан, Сэцэн хан, Засагт ханы нэгэн адил үе улиран тасралтгүй залгамжлуулхаар болгов. Норовжав 1786 онд өвчтэй болсон засгаас байлгажээ.

ЦЭДЭНЖАВ. Норовжавын ахмад хөвгүүн. 1786 онд Сайн ноён засаг хошой чин вангийн хэргэм залгамжилжээ. 1792 он хүртэл Сайн ноёны хошууны засаг байжээ.

РИНЧИНДОРЖ. Цэдэнжавын хөвгүүн. 1793 онд Сайн ноён засаг хошой чин залгамжилж, Сайн ноён аймгийн дэд чуулган даргаар томилогдон ажиллажээ. 1800 онд лам Сандувдоржийн заалдсан ялын учирт дэд чуулган дарга, Сайн ноён засаг хошой чин вангаас огцруулж, сул гүнгийн зэрэгтэй болжээ.

ПУНЦАГДАШ. Цэдэнжавын гутгаар хөвгүүн. 1802 онд Сайн ноён засаг хошой чингийн хэргэм залгамжилсан. 1810 онд Умардалын авд одсонд Цянь чин минд явуулж, 3 нүдний тогосын отго, шар

хүрэм шагнажээ. Улмаар аймгийн дэд чуулган дарга, хэбэйн тушаалд томилогдон ажиллаж байгаад нас барсан. Тэрбээр 1817 он хүртэл Сайн ноёны хошууны засаг ноён байв.

ЦЭРЭНДОРЖ. Пунцагдашийн ахмад хөвгүүн. 1817 онд Сайн ноён засаг хошой чин вангийн хэргэм залгамжилж, аймгийн дэд чуулган даргаар тавигджээ. 1823 онд Цянь чин минд, 3 нүдний тогосын отго хадуулж, харавтар улаан жолоо шагнуулжээ. 1827 онд Улиастайн хуулийн сайдаар томилогдож, 1829 онд шадарт явав. Энэ хугацаанд 1839-1840 онд хязгаарыг давсан хасаг цэргийг 2 удаа хөөж гаргасан учир бор үнэгэн хүрэм, бор ирвэсний хормогч, хас үсгийн гуурс, эрхэвч, их, бага хавтага, мөнгө 4000 лангаар шагнуулжээ. Мөн Улиастайн үржүүлэх тэмээ адууны хэргийг сайн захирч, түм илүү болгон үржүүлсэн учир 32 тэмдэглэсэн зэрэг, 1 нэмсэн зэрэг шагнуулсан. Ингээд 1845 онд аймгийн чуулган даргаар томилогдсон ч Улиастайн хэбэй амбаны тушаалд хавсрахад хэрэгт тусгүй хэмээн болиулжээ. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 144/. Цэрэндорж 1853 он хүртэл Сайн ноёны хошууны засаг ноён байв.

ДАМЧОЙ. Цэрэндоржийн үрчилсэн үеэл хөвгүүн. 1853 онд Сайн ноён засаг хошой чин вангийн хэргэм залгамжилсан. 1857 онд өмнөд мужийн цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир 5 нэмсэн зэрэг, 1858 онд мөн цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир 3 нүдний тогосын отго хадуулжээ. 1863 онд Цянь чин минд явж, дараа жил нь Сайн ноён аймгийн туслагч жанжин болов. 1868 онд Булан тохойн хотын хэрэглэл, цэргийн хэрэгт мөнгө, мал тусалсан учир харавтар улаан жолоо, улбар шар жолоо шагнуулж байв. Мөн Улиастайн үржүүлэх тэмээний хэргийг сайн захирч, 2 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. Тэрбээр 1869 онд Сайн ноёны хошууны засаг ноён байв/Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 144/.

ЦЭРЭНДОНДОВ. Пунцагдашийн хөвгүүн улсын түшээ гүн Занажавын гагц хөвгүүн. 1871 онд Сайн ноён засаг хошой чингийн хэргэм залгамжилсан. 1772 онд Улиастай хотыг засахад мөнгө тусалсан учир 3 нүдний тогосын отго хадуулж, аймгийн туслагч жанжин болжээ. 1874 онд Улиастай, Ховд, Хүрээнд дайчилсан Чин улсын цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учир 2 нэмсэн, 2 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1876, 1879 онд оргодол Сэнгэ, Билгүүн нарыг хүчлэн бариулжээ.

ТӨГС-ОЧИР: Цэрэндондовын хоёрдугаар хөвүүн. 1883 онд Сайн ноён засаг хошой чин вангийн хэргэм залгамжилж, 3 нүдний тогосын отго хадуулжээ. 1884 онд аймгийн туслагч жанжины хэбэй болж, 1888 онд аймгийн чуулган даргаар томилогджээ. Мөн оргодол

Сэнгэ, Буянцогт, Жанчив, Осорхүү, Хорогдой нарыг бариулсан учир нэжгээд нэмсэн зэрэг олгуулав. 1894 онд цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир харавтар улаан жолоо шагнуулсан. Тэрбээр 1896 он хүртэл Сайн ноёны хошууны засаг ноён байв. \Монгол улсын шастир. Тэргүүн боть УБ.1997. тал 144\

НАМНАНСҮРЭН. Төгс-Очирын хоёрдугаар хөвүүн. XX зууны эхэн үеийн Монголын төрийн зүтгэлтэн. Бадаргуулт төрийн 22-р он буюу 1896 онд Сайн ноён засаг хошой чин ван залгамжилсан. Монгол улсын олноо өргөгдсөний тэргүүн он, өвөл цаг Очирдара Богд гэгээнтнийг хаан өргөмжилж, эрдэнийн сууринаа залсан учир зарлигаар хишиг тархаахад үе улиран хан, ногоон жууз, шар хүрэм, улбар шар жолоо, Итгэмжит зетэй дайчин цол шагнасан хүртээж, шадар сайд тавьжээ. 1912 онд тусгайлан зарлиг буулгаж, эрт цагт баруун Богд нараас шагнасан Түмэнхэн Номун эзэн хэмээх цолыг тамгын үсэгт оруулан гүйцэтгүүлэгтүн хэмээснийг хичээнгүйлэн дагаж шийтгүүлжээ. Мөн ондоо Монгол Улсын ерөнхий сайдаар томилогдсон. 1913 онд Хаант Орос улсад Монголын төлөөлөгчдийг тэргүүлэн Петербург хотод айлчилж байсан. 1915 онд Богд хааны зарлигаар Цэргийн яамны тэргүүн сайд, Ерөнхийлэн шийтгэх сайдад хавсарган тавьжээ. 1919 онд нас барсан. Түүний учир битүүлэг байдлаар батлах нэгэн баримт Буриад зоны нэгэн бичигт "Богд Чингис хааны язгуур үндэсний өр маш ариун тунгалаг оюунт ерөнхий сайд сайн ноён ханыг хорлосон нь даанч өнгөргүй, муу хоронд хамаг бие нь шарлаж, хилсээр өөд болсон" \Тусгаар тогтнол сонин. УБ., 1991, 6-р сарын 4-ний дугаар\ гэжээ. Д.Бодоо, Д.Догсом нараас 1920 онд Коминтерний Алс Дорнодын нарийн бичгийн дарга нарын газарт өргөсөн бичигт "... Бээжин засгийн газрын ховдог харгис эзэлт эрх баригчид сайн ноён хан мэтийн үнэнхүү сайдуудыг хороор алж арилгав" \Үнэн сонин, УБ., 1989. 7 сарын 11-ний дугаар. Хуудас 3 \ гэж бичсэн байна.

ЗАНАЖАВ. Сайн ноён Пунцагдашийн хөвгүүн. Түшээ гүнгийн зэрэг залгамжилсан.

ЦЭРЭНДОНДОВ. Занажавын хөвгүүн. Түшээ гүнгийн зэрэг залгамжилсан.

ЭРЭГЗЭНДАШ. Цэрэндондовын дүү. Түшээ гүнгийн зэрэг залгамжилсан.

ЦЭВЭЭНДОРЖ. Сайн ноён Дэчинжавын хоёрдугаар хөвгүүн. Угтаа тэргүүн зэрэг тайж байгаад 1754 онд манжийн их цэрэг Даваачийг дайлахаар одоход зүтгэсэн учир гүнгийн зэрэг шагнуулжээ. 1755 онд Илийг эзэлсний дараа түүнийг Цянь чин минд явуулж, шар хүрэм шагнаж, 1756 онд бэйсийн зэрэг хүртээв. 1759

онд Цэвээндоржийг засаг өргөмжилж, тусгай хошуу зохиосноор Сайн ноён хан аймгийн Эрх засгийн хошуу байгуулагдав. 1760 онд Урамдалын авд явж, 2 нүдний тогосын отго хадуулав. Гэвч 1763 онд Хязгаар дахиныг тогтоох зүүн этгээдийн туслах жанжин Цэвдэнжавтай заалдсан учир засгаас байлгажээ. Монгол улсын шастир. Тэргүүн боть УБ.1997.тал 181. Эрх засгийн хошуу нь Манжийн үед Халхын умар замын зүүн гарын дундадын хошуу хэмээгдэж байсан бөгөөд энэ нь одоогийн Булган аймгийн Баян-Агт сумын нутаг юм.

САНДАВДОРЖ: Цэвээндоржийн ахмад хөвгүүн. 1773 онд гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1787 он хүртэл Эрх засгийн хошууны ноён байв.

ВАНЧИНЖАВ: Сандавдоржийн ахмад хөвгүүн. 1788 онд гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1811 он хүртэл Эрх засгийн хошууны ноён байв.

ОЙДОВДОРЖ: Ванчинжавын ахмад хөвгүүн. 1812 онд гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1826 онд цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учир 6 тэмдэглэсэн зэрэг, Орос зүгийн гэр харуулыг сайн захирсан учир 3 тэмдэглэсэн зэрэг шагнуулав. 1834 он хүртэл Эрх засгийн хошууны ноён байв

Сайн ноён аймгийн Үйзэн вангийн хошууны тайж нарын гэрийн үеийн бичмэл. УТНС.ГБС/.

ДАМДИНЖАВ. Ойдовдоржийн ахмад хөвгүүн. 1843 онд гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Цэргийн хэрэглэлд 3 жилийн пүнлүүний мөнгөөр тусалсан учир 1 нэмсэн, 2 тэмдэглэсэн зэрэг, Орос зүгийн гэр харуулыг эндэгдэлгүй захирсан учир 1 нэмсэн, 2 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. Тэрбээр 1859 он хүртэл Эрх засгийн хошууны ноён байв.

САМАНДБАДАР. Дамдинжавын ахмад хөвгүүн. 1860 онд гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1863 онд тогосын отго хадуулж, цэргийн хэрэглэл ба Булантохойн хот байгуулахад тусалсан учир 1 нэмсэн, 4 тэмдэглэсэн зэрэг шагнуулав. Тэрбээр 1870 он хүртэл Эрх засгийн хошууны ноён байв.

ҮРЖИНЖАВ. Самандбадарын ганц хөвгүүн. 1870 онд гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилж, Эрх засгийн хошууны ноён болжээ. 1891 онд хишиг тараахад 2 нэмсэн зэрэг, 1895 онд

Жибзундамбаа хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэхэд мөнгө тусалсан учир 2 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. 1911 онд Очирдараа Богд гэгээнтнийг Монгол улсын хаан ширээнд өргөмжилж эрдэнийн сууринаа залсан учир зарлигаар хишиг тархахад түшээ гүнгийн зэрэг бөгөөд үе улиран Эрх цол шагнан хүртээжээ. 1918 онд улсын

санд мөнгө өргөсөн учир үе улиран бэйсийн зэрэг, 2 нүдний тогосын отго, харавтар улаан жолоо, 3 нэмсэн, 2 тэмдэглэсэн зэрэг хүртжээ. \Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ.,1997. Тал 182\

САМПИЛДОРЖ. Сайн ноён Дэчинжавын гутгаар хөвгүүн. Угтаа гутгаар зэрэг тайж байв. 1757 онд түүний эцэг Дэчинжав цэргийн хэрэглэлд морь барьж тусалсан учир түүний хөвгүүн Сампилдоржийг гүнгийн зэрэг тэргүүн зэрэг тайж болгожээ.

ДАМИРАН. Сампилдоржийн ахмад хөвгүүн.1785 онд гүнгийн зэрэг тайж залгамжилжээ.

МИНЖҮҮР. Сампилдоржийн хоёрдугаар хөвгүүн. 1792 онд гүнгийн зэрэг тайж залгамжилжээ.

ГАНЖУУРЖАВ. Минжүүрийн жич хөвгүүн. Тэргүүн зэрэг тайж.

ЦЭРЭНДАШ. Сайн ноён Шамбын хоёрдугаар хөвгүүн. 1707 онд засаг чин ван Дашдондовын хошуунаас салгаж, тусгай нэгэн хошуу байгуулж, Цэрэндашид захируулж, засаг тэргүүн тайж өргөмжилжээ.үүний дараа Энх амгалан хааны буулгасан зарлигт" их цэрэг цэрэглэсэнээс нааш засагт тайж Цэрэндаш тэмээ, морь, хонь нийлүүлж ихэд шаламгайлан зүтгэж хүчин баривай. Ихэд сайшаалтай. Урьд Сэцэн хан Өмхэйн авга тайж Санжжав цэргийн хэрэглэхүүн туслан шийтгэсний учирт хэтэрхий гүнгийн хэргэм өргөмжилвэй. Цэрэндашийн хэрэг адил мөний тул хишиг хүртээж улсад туслагч гүн өргөмжлөгтүн. Мөнхүү засаг хавсаргагтун" гэжээ.\ Илтгэл шастир. 73-р дэвтэр\чингэж засаг Цэрэндаш Халхын Сайн ноён аймгийн Үйзэн засгийн хошууны ноёдын өвөг болжээ. Үйзэн засгийн хошуунд одоогийн Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан, Арвайхээр, Баянгол, Тарагт, Төгрөг сумын нутгийг хамарч байжээ. Төгрөг сум байгуулахад Сайн ноёны хошуунаас оролцсон байна. Манжийн үед Халхын умар замын баруун гарын дундад зүүн гарын хошуу нэртэй байжээ. Тэрбээр 1724 онд нас барсан бөгөөд Дондовринчен, Гүнгэ, Шагдаржав гэсэн гурван хүүтэй байжээ.

ДОВДОНРИНЧЕН. Цэрэндашийн хөвгүүн. 1724 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1730 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв.

САНАЙ. Цэрэндашийн хөвгүүн. 1730 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан.\Илтгэл шастир \-т түүний нэрийг Санай хэмээн тэмдэглэсэн зарим сурвалжид Сандив гэсэн буй. 1743 хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв.\Илтгэл шастир 73-р дэвтэр \

ГҮЛГЭЭ. Цэрэндашийн хоёрдугаар хөвгүүн 1743 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан.м 1749 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв. Түүнийг нас барах үед төрсөн хөвгүүн Цэдэнжав нас бага байсан учир түүний дүү Самданжав улсад туслагч гүн залгамжлуулжээ.

Шагдаржав. Цэрэндашийн гутгаар хөвгүүн. 1749 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1759 онд тэнгэрийн тэтгэсэн хааны буулгасан зарлигт "Цэрэндашийн улсад туслагч гүн хэмээгч язгуураасхишигхүртээжөргөмжилсөньбуюу. Дөрвөнүезалгамжилж Цэдэнжавд хүрч ирээд нас багын тул залгамжлуулахыг байлгав. Эдүгээ Цэдэнжав үгүй болжухуй. Сандагжав Цэрэндашийн хөвгүүн. засаг болсноос аливаа хэрэгт зүтгэж явбай. Цэргийн хэрэглэгдэхүүнд тусалсан учирт хэд хэдэн тэмдэглэсэн зэрэг олгуулав. "Хишиг хүртээж мөнхүү улсад туслагч гүн залгамжлуултугай" хэмээн өртөөний хэргийг хавсарган шийтгүүлжээ. /Илтгэл шастир. 73-р дэвтэр/ 1761 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв.

Минжүүрдорж. Сандагжавын хөвгүүн. 1761 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1778 онд өвчтэй болсны учирт засгаас байлгаж, түүний хөвгүүн Цэдэнжавд залгамжлуулжээ. Тус хошууны ноёдын гэрийн үеийн бичмэлээс үзэхэд Минжүүрдорж нь Цэрэндорж, Довжав, Цэрэнжав, Чивагравдан, Ванчиг, Ванжил нарын 6 хүүтэй байжээ. 1768 онд Баруун зууд аялан явж, буян ном үйлджээ. Банчин Богдоос Минжүүрдоржийг хувилгаан хэмээн тодруулан "Эрдэнэ бишрэлт мэргэн бандид" цол хүртээснээр Үйзэн гүний хошууны бандид ламтны анхны ширээнд суужээ. Тэр үеэс бандид ламтны шавь сан буй болж, бандид ламтны дүр нийт 5 удаа тодрон залагдсан ажээ. /С. Ичинноров. Арвайхээрийн хошууны хураангуй түүх. УБ., 1997. Тал 31/1778 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв.

Цэдэнжав. Минжүүрдоржийн ахмад хөвгүүн. 1778 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1781 онд зарлигаар засаг хэргэмийн үе улиран тасралтгүй залгамжлуулахаар болгожээ. 1785 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв. Тэрбээр Шагдар, Вамбуу, Жан чивдорж, Сампилдорж, Дондов, Ванжил, Дамиран Балган гэсэн 8 хөвгүүнтэй байжээ.

Дэлэгдорж. Цэдэнжавын ахмад хөвгүүн. 1785 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1806 онд урамдалын авд явж, тогосын отго хадуулж, мөн үржүүлэх тэмээний хэрэг сайн захирсан учир 2 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. 1823 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв. Тус хошууны ноёдын гэрийн үеийн бичмэлд тэмдэглэснээр Бавуудай, Жигдэн, Бүнчин, Буян, Лигдэнжав, Баяр, Б адамжав, Гомбо гэсэн 6 хүүтэй байв. /Халхын Сайн ноён аймгийн Үйзэн вангийн хошууны тайж нарын гэрийн үеийн бичмэл. УТНС.

ГБС/.

Дашравдан Дэлэгдоржийн хөвгүүн. 1824 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1826, 1830 онд цэргийн хэрэглэлд

тэмээ тусалсан учир 10 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. Мөн оргодол Цэвэг, Гэндэн, Цагаанай нарыг хугацааны дотор бариулж чадаагүй ба харъяат дөтгөөр зэрэг тайж Азар хулгай болж явсан учир 7 тэмдэглэсэн зэрэг хасуулжээ. 1834 онд оргодол Өлзийтийг хугацаанд нь бариулсан учир 1 нэмсэн зэрэг олгуулжээ. 1835 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв. Тэрбээр Жүрмэдванжил, Раднаасэд, Дашравдан, Уртнаст, Лувсан, Сэнгэж а в, Жамсран, Дондовдорж, Дашдондог гэсэн хөвгүүдтэй байжээ. / Халхын Сайн ноён аймгийн Үйзэн вангийн хошууны тайж нарын гэрийн үеийн бичмэл. УТНС.ГБС/.

Жүрмэдванжил Дашравдангийн ахмад хөвгүүн. 1836 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1845 онд үржүүлэх тэмээний хэргийг захирах болж, удаа дараа 6 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1846 онд Харчин өртөө ба цагдаа цэргийг хавсран захирах болов. 1854 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв. Түдэв, Шаравдорж, Дамдин, Доржжав, Очир, Ягнин, Сонимпил гэсэн хөвгүүдтэй байжээ. / Халхын Сайн ноён аймгийн Үйзэн вангийн хошууны тайж нарын гэрийн үеийн бичмэл. УТНС.ГБС/.

Дармаабазар Жүрмэдванжилын ахмад хөвгүүн. 1855 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1863 онд тогосын отго хадуулж, 1868 онд цэргийн хэрэглэлд тусалсан учир Цянь чин минд явуулан 2 нүдний тогосын отго хадуулав. Мөн Булан тохойн хот байгуулахад мөнгө тусалсан ба оргодлуудыг хугацаанд нь бариулсан учир 7 нэмсэн, 8 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. 1879 онд Сайн ноён аймгийн туслагч жанжны хэбэй болж, дараа жил нь цэргийн хэрэглэлд мал, мөнгө тусалсан учир харавтар улаан жолоо шагнуулжээ. 1884 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв. / Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 169/. Тэрбээр Ламцагдорж, Цэрэнбалжир, Цэрэнсодном гэсэн хөвгүүдтэй байв/.

ДЭЛЭГДОРЖ. Дармабазарын хоёрдугаар хөвгүүн. 1884 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1887 онд Харчин өртөөний хэргийг захирах болж, 1890 онд Цянь чин минд явжээ. 1889 онд хишиг тархаахад 2 нэмсэн зэрэг, 1891-1892 онд оргодлуудыг барьсан учир нэжгээд нэмсэн зэрэг шагнуулж, 1892 онд Сайн ноён аймгийн туслагч жанжны хэбэй болов. 1894 онд Бадаргуулт төр хааны 60 насны баяраар тогосын отго хадуулж, цэргийн хэрэглээнд мөнгө тусалж шадарт явав. 1895 онд Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэхэд мөнгө тусалж, 3 тэмдэглэсэн зэрэг шагнуулав. 1897 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв. Тэрбээр Дэчинравдан, Агваандондов гэсэн 2 хөвгүүнтэй.

ДЭЧИНРАВДАН. Дармабазарын гуравдугаар хөвгүүн. 1897 онд

засаг улсад туслагч гүн залгамжилж, тогосын отго хадуулжээ. 1902 онд оргодол Хондовыг хугацааны дотор барьж, 1 нэмсэн зэрэг, мөн пүнлүүний мөнгө тусалсан учир 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг. 1909 онд оргодол Жалбааг барьсан учир 1 тэмдэглэсэн зэрэг шагнуулав. 1910 он хүртэл Үйзэн засгийн хошууны ноён байв. Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 170/

СЭРЖИМЭ. Данжин дамын хоёрдугаар хөвгүүн.

ДЭГДЭХЭЙ МЭРГЭН АХАЙ. Сэржимэгийн хөвгүүн. Тэрбээр 1960-аад оны үед Сайн ноёны угсааны ноёдтой зөрчилдөж, Засагт хан Шарыг дагалдан Галданг угтан дэмжсэн учир Түшээт хан Чахундоржид алагджээ.

ВАНЧИГ. Дэгдэхэй мэргэн ахайн хөвгүүн. 1692 онд Долоннуурын газарт Энх амгалан хаанд бараалхахаар ирсэнд " Ванчигийн урьдын хүмүүн үе улиран алба барьсаар явбай. Халхын хоёр хан харилцан муудаад түүний эцэг Дэгдээхэй учиргүй алагдаж харъяат ард сарниад зовох туйлд хүрч түших газар үгүйг би ихэд өршөөмүй. Нэгэнт түүний харъяат ардыг байцааж, мөнхүү өгөөд түүний хуучин хөрөнгийг дахиулсани тулд хишиг хүртээж засаг улсад туслагч гүн өргөмжлөгтүн" гэжээ. /Илтгэл шастир. 73-р дэвтэр/. 1696 онд Манжийн баруун замын жанжин Виянгуг дагалдаж, Галдан бошготыг Зуумодны газарт дарахад оролцжээ. 1697 онд төрлийн тайж Дуба, Данжин-Эрдэнэ нарын Галдангийн холбоотон Ялгуусан хутагтыг сэргийлэн суужээ. Тэрбээр Сайн ноён аймгийн Жонон засгийн хошууны өвөг юм. Тус хошуу нь Манжийн үед Халхын умар замын зүүн гарын зүүн этгээдийн хошуу нэртэй байв. Энэ нь одоогийн Баянхонгор аймгийн Баянбулаг, Хүрээмарал сумын нутаг болно.

ЖАМЦ. Ванчингийн ахмад хөвгүүн. 1723 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1732 онд 2 нүдний тогосын отго шагнуулав. Тэрбээр 1745 он хүртэл Жонон засгийн хошууны ноён байв.

БАТМӨНХ. Жамцын ахмад хөвгүүн. 1745 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1753 онд нэгэн аймгийн түшээ гүн Гүнгэдондогийн хамт 1000 цэрэг авч Улиастайд сэргийлэн суув. 1755 онд Манжийн их цэрэг Даваачийг дайлахад тэрбээр Сэцэн хан аймгийн жүн ван Базарсадын хамт 3000 цэрэг авч тулалдаанд оролцжээ. Мөн 200 цэрэг авч, Мухулай Дэчиний 70 өрхийг дагуулсан учир торго, зүү, хавтага шагнуулжээ. 1755 он хүртэл Жонон засгийн хошууны ноён байв. /Илтгэл шастир.: 74-р дэвтэр/.

ДАМБАЖИГЖИД. Батмөнхийн ахмад хөвгүүн. 1756 онд засаг улсад туслагч гүн залгамжилж, Цянь чин минд явжээ. 1781 оны үе улиран тасралгүй залгамжээлсан. Тэрбээр 1790 он хүртэл Жонон засгийн хошууны хоён байв.

ЛУВСАНДОРЖ. Дамбажигжидийн ахмад хөвгүүн. 1790 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1797 он хүртэл Жонон засгийн хошууны ноён байв.

ЦЭДЭНЖАВ. Лувсандоржийн гагц хөвгүүн. 1798 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. Тэрбээр 1807 он хүртэл Жонон засгийн хошууны ноён байв.

ЖАМЪЯН. Цэдэнжавын хөвгүүн.

ЖАМСРАНЖАВ. Цэвээнжавын төрлийн хөвгүүн. 1808 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1826 онд цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учир тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1857 онд цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учир 2 нүдний тогосын отго хадуулсан. 1858 он хүртэл Жонон засгийн хошууны ноён байв. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 179 /.

РАВДАНДОРЖ. Жамсранжавын ач хөвгүүн. 1858 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1866, 1867, 1868, 1871 онд цэргийн хэрэглэл ба Булантохойн хот байгуулах зэрэг зүйлд мөнгө, мал, гэр зэргээр тусалсан учир 2 нүдний тогосын отго, харавтар улаан жолоо, 2 нэмсэн, 5 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1882 он хүртэл Жонон загийн хошууны ноён байв /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 180 /.

СОНОМДАШ. Равдандоржийн хоёрдугаар хөвгүүн. 1882 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1892 онд хишиг тархаахад 2 нэмсэн зэрэг олгуулжээ. Тэрбээр 1897 он хүртэл Жонон засгийн хошууны ноён байв.

ПҮРЭВЖАВ. Сономдашийн ахмад хөвгүүн. 1897 онд засаг улсад туслагч гүн залгамжилж, Жонон засгийн хошууны ноён болжээ. 1903 онд хязгаарыг сэргийлсэн хэрэгт сайнаар зүтгэсэн учир тогосын отго хадуулж, 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. 1911 онд Очирдара Богд гэгээнтнийг хаан өргөмжилж, эрдэнийн сууринаа залсан учир зарлигаар түшээ гүнгийн зэрэг, үе улиран жонон цол шагнал хүртээжээ. 1918 онд улсын санд мөнгө өргөсөн учир үе улиран бэйлийн зэрэг, харавтар улаан жолоо, 2 нүдний тогосын отго, 4 нэмсэн, 4 тэмдэглэсэн зэрэг шагнуулав / Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 180/.

ЭРДЭНЭ ЯЛГУУЛСАН ТОЙН ЛУВСАН. Данзан ламын гутгаар хөвгүүн. Эцэг Данзан ламын адил шашны сахил хүртэн тойн хэмээгдэж, Эрдэнэ ялгуулсан хэмээх цолтой байв. XVII зууны дундуур амьдарч, Сайн ноёны захиргаанд байв. Лувсан тойноос Энх амгалан хаанд өргөсөн бичигт "эцэг маань итгэлт Данжин лам Халх долоон хошуун дээр төр шашныг барьж явахдаа дэлхий дахины хааны гэгээнээ дээд хүнд хайранд хүртэж ихэсээс дээр явж билээ.

Түүний үрээс үлдсэн Лувсан тойн, Чөөхүр хоёр бүгдийн ах авга Жибзундамба хутагт, хаан эхлэн ноёд элчийг минь улаан шүүстэй болгосон билээ" хэмээн өгүүлсэн буй /Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. IX боть. УБ., 2010 Тал 29/.

СУДАНИ. Эрдэнэ ялгуусан тойны хөвгүүн. Угтаа Сайн ноён Шамбын хошууны туслагч тайж байжээ. 1696 онд Манжийн их цэрэг Галдан бошготыг дайлахад Галдангийн хоршоо Гүен бичээчийг дарж, харъяатыг нь дагуулжээ. 1697 онд Сайн ноён чин ван Шамба "Суданий эцэг Лувсан. Цол Эрдэнэ ялгуусан тойн хэмээмүй. Данзан ламын гуравдугаар хөвгүүн мөн. Язгуураас харьяат аймгийн засгийн хэргийг захирсан бөгөөд Судани бас дагалдаж дайлахад гавъяа байгуулав. Олдвоос түүний харьяат ардыг өөр нэгэн хошуу зохиогоод түүнд захиргах ажааму " хэмээн Энх амгалан хаанд айлтгажээ. /Итгэл шастир. 76-р дэвтэр /. Үүнийг ёсоор болгож, Суданийг засаг тэргүүн зэрэг тайж өргөмжилж, тусгай хошуу байгуулсан нь хожмын Сайн ноён аймгийн Ахай засгийн хошууны үүсэл болжээ. Судани 1700 он хүртэл тус хошууны засаг ноён байв. Ахай засгийн хошуу буюу Халхын умар замын баруун гарын зүүн этгээдийн адгийн хошуугаар одоогийн Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын өмнөд ихэнхи хэсгийг байгуулжээ.

СЭРВАНЖИЛ. Суданийн ахмад хөвгүүн. 1700 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1723 он хүртэл Ахай засгийн хошууны ноён байв.

ЦЭВДЭН. Сэрванчингийн ахмад хөвгүүн. 1723 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1733 онд Манжийн их цэрэг Зүүнгарын цэрэгтэй тулалдахад цааргалж, дураар байлдааны талбарыг орхиж, нутагт буцсанд ял хэлэлцэж, хэргэмийг эвдээд, түүний хүү Лайчинжавт залгамжлуулжээ.

ЛАЙЧИНЖАВ. Цэвдэнгийн ахмад хөвгүүн. 1733 онд тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1755 онд Манжийн их цэрэг Зүүнгарын Даваачийг дайлахад агт морьд гаргаж тусалсан учир зарлигаар Ховдод адууны хэргийг захируулахаар явуулжээ. 1756 онд Чингүнжавын бослогын үеэр Лайчинжав Сайн ноён аймгийн засаг тайж Ринчин, туслагч тайж Ванчигдорж нарын хамт адууны хэргийг захирч сайн адгуулсан тул сайшааж, тогосын отго, торго шагнуулжээ. Мөн Манжийн хааны зарлигаар "адууч эр"-д хүнсний амуу өгч хөхиүлэн шагнав. Тэрбээр 1759 он хүртэл Ахай засгийн хошууны ноён байв. /Илтгэл шастир. 76-р дэвтэр/

НАВААНЦЭРЭН. Цэвдэнгийн хоёрдугаар хөвгүүн. 1759 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1781 онд зарлигаар үе

улиран тасралтгүй залгамжлуулахаар болгожээ. 1784 онд засаг Наваанцэрэн өвчтэй болсны учир Ахай засгийн хошууны ноёноос байлгаж, хүү Гүнгэраашт залгамжлуулав.

ГҮНГЭРААШ. Наваанцэрэнгийн хоёрдугаар хөвгүүн. 1784 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1801 он хүртэл Ахай засгийн хошууны ноён байв.

ГОНЧИГЖАВ. Гүнгэраашийн хөвгүүн. 1801 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1847 он хүртэл Ахай засгийн хошууны ноён байв.

ЦЭДЭНБАЛЖАА. Гончигжавын үрчилсэн хөвгүүн. 1847 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1872 онд Манжийн цэргийн хүнсний амууг харгалзан өнгөрүүлэхэд сайн зүтгэсэн учир гүнгийн зэрэг шагнуулжээ. Дараа нь цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир улсын түшээ гүнгийн зэрэг олгуулсан ба 1876 онд цэргийн хэрэглэлд гурил тусалсан учир гүнгийн зэргийг үе улиран тасралтгүй залгамжлуулжээ. 1883 онд түүний бие өвдсөн учир Ахай засгийн ноёноос байлгаж, хүү Юндэндоржид залгамжлуулжээ. /Монгол улсын шастир. Тэргүүн боть.УБ., 1997. Тал 178/

ЮНДЭНДОРЖ. Цэдэнбалжаагийн хөвгүүн. 1883 онд улсын түшээ гүнгийн зэрэг засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1887 он хүртэл Ахай засгийн хошууны ноён байв.

БИНЬЯА. Засаг Суданигийн хөвгүүн.

ГАВАА. Биньяагийн хөвгүүн. Угтаа гутгаар зэрэг тайж бөгөөд Ахай засаг Лайчинжавын хошууны хэргийг туслан шийтгэж байжээ. 1756 онд Чингүнжавын бослогын үеэр өртөөний зам хаагдахад Биньяа өртөөний адуу, морины хэргийг захирч залгуулжээ. Үүнд тэнгэрийн тэтгэсэн хаан " өртөөний зам тасрахад өнгөрөн явах түшмэд бачим түүний хувьсгалыг учраад Гаваагийн морь мал нийлүүлэн итгэж харгалзаж хүргэвэй. Тийм бөгөөд түүний өртөөг залгуулахын тул туслан барьсан морь маш олон. Албаны хэрэгт хичээн зүтгэсэн явдлыг би машид сайшаамуй. Гүнгийн зэрэг шагнагтун" хэмээн зарлиг буулгажээ. /Итгэл шастир.

76-р дэвтэр/1769 онд түүнийг бас барахад Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамнаас Гаваагийн гүнгийн зэргийг залгамжлуулах эсэхийг хэлэлцээд хүү Санжид нь залгамжлуулахаар болжээ.

САНЖ. Гаваагийн ахмад хөвгүүн. 1769 онд гүнгийн зэрэг гутгаар зэрэг тайж залгамжилжээ. 1746 онд гүнгийн зэргийг залгамжлуулахгүй болсон боловч дараа жил нь түүний эцэг Гаваагийн гавьяаг санаж, түүний үр хойчид нь үе улиран тасралтгүй залгамжлуулахаар болжээ. /Илтгэл шастир. 76-р дэвтэр/

ВАМПИЛ. Санжийн хөвгүүн. 1817 онд гүнгийн зэрэг залгамжилжээ.

ЦЭРЭНСАНДАВ. Вампилын хөвгүүн. 1823 онд гүнгийн зэрэг залгамжилжээ.

ОЙДОВСАМБУУ. Цэрэнсандавын хөвгүүн. 1864 онд гүнгийн зэрэг залгамжилжээ.

МАНДАУ. Данзан ламын дөтгөөр хөвгүүн. 17-р зууны эхэн үед амьдарч байсан язгууртан юм.

ДОРЖ. Мандаугийн ахмад хөвгүүн. Үйзэн ахай хэмээх цолтой байжээ. 1680-аад оны сүүлчээр Галдан бошготын довтолгооны үеэр Хөхнуурт зугтаж очоод байжээ. 1696онд Галданг ялагдсаны дараа Хөхнуурын ван Сагнандорж Дорж үйзэн ахайг Халхад буцаан нүүлгэхийг Энх-Амгалан хаанд айлтгажээ. Үүнийг ёсоор болгож, Дорж ноён харьяатын хамт уг нутагтаа ирээд Ван Шамбын хошуунд сул тайж болон захирагджээ. 1712 онд Доржийг засаг тэргүүн зэрэг тайж болгож, харьяат ардыг тусгай хошуу болгосон нь Сайн ноён аймгийн Дархан засгийн хошууны үүсэл болов. Тэрбээр 1725 он хүртэл тус хошууны ноён байв. /Илтгэл шастир. 76-р дэвтэр/. Дархан засгийн хошуу буюу Халхын умар замын баруун гарын дундад адгийн хошуугаар Баянхонгор аймгийн Баацагаан сум байгуулагджээ.

НЯМ. Доржийн ахмад хөвгүүн. 1725онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1732 он хүртэл Дархан засгийн хошууны ноён байжээ.

АБУУ. Нямын ахмад хөвгүүн. 1732 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1753 онд Ням нас барахад үр үгүй учир түүний бага авга Цэрэнпилд засаг хэргэмийг залгамжлуулжээ.

ЦЭРЭНПИЛ. Доржийн хоёрдугаар хөвгүүн. 1753 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1760 онд нас барах хүртлээ Дархан засгийн хошууны ноён байжээ.

ЦЭНГҮНЖАВ. Цэрэнпилийн ахмад хөвгүүн. 1760 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэнгэрийн тэтгэсэн хааныг дагаж Мураны авд дагасан учир тогосын отго хадуулав. 1781 онд зарлигаар засаг хэргэмийг үе улиран тасралгүй залгамжлуулахаар болжээ. Тэрбээр 1785 он хүртэл Дархан засгийн хошууны ноён байжээ.

ДАМЧИГ. Цэнгүнжавын ахмад хөвгүүн. 1785 онд засаг тэргүүний зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1800 он хүртэл Дархан засгийн хошууны ноён байжээ.

ЦЭДЭНДАШ. Дэмчигийн хоёрдугаар хөвгүүн. 1801 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1820 он хүртэл Дархан засгийн хошууны ноён байжээ.

САНЖЖАВ. Цэдэндашийн төрсөн дүү. 1820 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1831 онд бие өвдсөн учир Дархан засгийн хошууны ноёноос байлгажээ.

ЦЭРЭН. Санжжавын ахмад хөвгүүн. 1831 онд засаг тэргүүн зэрэг тайж болоод удалгүй 1832 онд нас баржээ.

БУЯНЖАРГАЛ. Цэрэнгийн төрсөн дүү. 1832 онд засаг тэргүүний зэрэг тайж залгамжилсан. 1860 онд тогосын отго хадгалсан. 1869 онд бие өвдсөн учир Дархан засгийн хошууны ноёноос байлгажээ.

МАНИБАЛ. Буянжаргалын ахмад хөвгүүн. 1850 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Урьд тайж байхдаа цэргийн хэрэглэлд мал тусалсан учир тогосын отго хадгалж, хоёр нэмсэн зэрэг шагнуулж байжээ. Тэрбээр 1892 он хүртэл Дархан засгийн хошууны ноён байв.

ЧИМИДБАЛЖИН. Буянжаргалын хоёрдугаар хөвгүүн. 1894 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1895 онд Живзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэхэд мөнгө тусалсан учир 1 тэмдэглэсэн зэрэг, 1903 онд нэг жилийн пүнлүүний мөнгө тусалсан учир 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг, хязгаарыг сэргийлэхэд зүтгэсэн учир тогосын отго шагнуулав. 1911 онд Очир дара Богд гэгээнтнийгхаан ширээнд өргөмжилж, эрдэнийн сууринаа залсан учир зарлигаар хишиг тархаахад үе улиран улсад туслагч гүн Дархан цол шагнаан хүртжээ. Тэрбээр 1912 он хүртэл Дархан засгийн хошууны ноён байв. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ, 1997. Тал 184-185/.

ЖИЯГ ҮЙЗЭН ЦӨХҮР. Түмэнхэн хөндлөн ноёны гуравдугаар хөвгүүн. "Асрагч нэртийн түүх"-нд "Түмэнхэн хөндлөн цөхүрийн хөвгүүн Жэв эрдэнэ үйзэн ноён" /Асрагч нэртийн түүх. Галиглаж, үгийн хэлхээг үйлдсэн. Ц.Шагдарсүрэн, И.Сөн Гю УБ.,2002.Тал79\ гэсэн бол " Шар тууж"-д "Хандусхив эрдэнэ үйзэн ноён" Шара туджи. Монгольская летопись 17 века. Свопный текст,перевод,введение и премичания Н.П.Шастиной. М-Л.,1957.стр.117\ гэж бичжээ.

АЮУШ. Жияг үйзэн цөхүрийн хөвгүүн.1688 онд Манжид дагаж,1691 онд Долнуурын чуулганаар засаг тэргүүн зэрэг тайж өргөмжлөгджээ. 1695 онд Түшээт хан аймгийн засаг Чамчугнамжилын хамт Сүйх хонгорын газарт Галдан бошготын цэргийг мэдээчлэхээр явав.1696 онд Манжийн их цэрэг Галдан бошготыг дайлахад өөрийн хошууны Цэвээн чухалыг газарчаар явуулав.Галданг дарсны дараа Энх-Амгалан хаан Аюушийг улсад туслагч гүн болгожээ. Мөн оны намар мухулигт жүн ван Маладыг дагалдаж, өөлдийн дагасан ардыг харгалзан Чуулалт хаалганд хүргэв. Тэрбээр Сайн ноён хан аймгийн Саруул засгийн хошууны

өвөг юм. \Илтгэл шастир.75-р дэвтэр\ Саруул засгийн хошуу буюу Халхын умар замын зүүн гарын зүүн этгээдийн адгийн хошуугаар одоогийн Архангай аймгийн Хайрхан сум байгуулагджээ.

ПАГВАЖАВ. Аюушийн хөвгүүн. Тэрбээр эцэг Аюушаас өмнө нас барсан тул түүний хүү Ванжилд засаг хэргэмийг залгамжлуулжээ.

ВАНЖИЛ. Аюушийн ач хөвгүүн. 1700 онд засаг улсад туслагч гүн залгамжлав. Тэрбээр 1747 он хүртэл Саруул засгийн хошууны ноён байв.

САНДАГЦЭМБЭЛ. 1747 онд засаг улсад туслагч гүн залгамжилжээ. 1760 онд өвчтэй болсон учир байлгажээ. Тэрбээр Саруул засгийн хошууны гуравдахь ноён бөгөөд түүнийг залгасан Цэдэнжав нас барсан учир хэргэмийг дахиулжээ. 1781 он хүртэл Саруул засгийн хошууны ноён байв.

ЦЭДЭНЖАВ. Сандагцэмбэлийн ахмад хөвгүүн. 1760 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан 1764 он хүртэл Саруул засгийн хошууны ноён байв.

ГАРМАА. Цэдэнжавын ахмад хөвгүүн. 1770 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1781 онд Тэнгэрийн тэтгэсэн хааны буулгасан зарлигт "Гартаагийн залгамжилсан засаг улсад туслагч гүн хэмээгч түүний язгуурын тулгар өвөг Аюушийн цэргийн хүрээнд зүтгэн явсны учирт дэвшүүлж өргөмжилсний тулд хишиг хүртээж үе улиран тасралгүй залгамжлуулагтун" гэжээ. \Илтгэл шастир.75-р дэвтэр \ 1788 онд тогосын отго шар олбог шагнуулав. Тэрбээр 1803 он хүртэл Саруул засгийн хошууны ноён байв.

ГЭМПИЛДОНДОВ. Гармагийн ахмад хөвгүүн. 1804 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1811 онд урамдалын авд явж, тогосын отго, шар хүрэм шагнуулжээ. Тэрбээр 1815 он хүртэл Саруул засгийн хошууны ноён байв.

ДАШДЭЛЭГ. Гэнпилдондовын төрсөн дүү. 1815 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. Тэрбээр 1828 он хүртэл Саруул засгийн хошууны ноён байв.

ВАНДАНЖАВ. Дашдэлэгийн ахмад хөвгүүн. 1828 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1844 онд тогосын отго хадуулжээ. 1846 он хүртэл Саруул засгийн ноён байв.

ЖИГЖИДДОРЖ. Ванданжавын 3-р хөвгүүн. 1847 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. 1848 онд тогосын отго хадуулж, 1866-1871 онд цэргийн хэрэглэл ба Булантохойн хот байгуулах зэрэг ажилд мөнгө, мал тусалсан учир 6 нэмсэн, 5 тэмдэглэсэн зэрэг шагнуулав. Мөн Сайн соён хан харуулыг сайн захирсан учир 1 нэмсэн, 6 тэмдэглэсэн зэрэг 1876, 1880, 1884 онд оргодол Цэрэнсоном, Цэвэгдорж, Цэрэнсоном нарыг хугацааны

дотор бариулсан учир нэжгээд нэмсэн зэрэг шагнуулав. 1878 онд Сайн ноён хан аймгийн дэд чуулганы дарга, 1880 онд жинхэнэ чуулганы даргаар томилогдон ажиллаж байгаад 1887 онд нас барав. \Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 187\.

МАХАСАМДАН. Жижигддоржийн төрсөн дүү. 1892 онд засаг улсад туслагч гүн залгамжилсан. Үүнээс хойш 2 жилийн дараа нас барав. 1894 он хүртэл Саруул засгийн хошууны ноён байв.

РАШХИВ ХӨНДЛӨН. Түмэнхэн сайн ноёны дөрөвдүгээр хөвгүүн "Илтгэл шастир"-т түүнийг Түмэнхэн сайн ноёны долдугаар хөвгүүн гэжээ. Тэрбээр 17-р зууны дундуур амьдарч байсан бөгөөд Жамьян хунтайж Дорж, Дов гэсэн гурван хөвгүүнтэй байжээ. Тэдгээрийн хойчис нь Сайн ноён аймгийн Ачит засаг, Эрх түшээт засаг, Дархан засгийн хошүүны ноёд тайж нар болжээ.

ЖАМЬЯН ХУН ТАЙЖ. Рашхив хөндлөнгийн хөвгүүн "Шар тууж"-д "Хөндлөн Убашийн хөвгүүн Жамьян дайчин хошууч" гэж бичжээ. /Шара туджи. Монголская летопись 17-р века. Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шастиной. М-Л, 1957. Стр.90. "Илтгэл шастир"-т түүнийг Халхын хуучин засаг хэмээн бичсэн буй.

ЯДАМ. Жамьян хунтайжийн хөвгүүн мэргэн тайж хэмээх цолтой. "Шар тууж"-д " Эрх дайчин хошуучын хөвгүүн засгийн тайж Ядам мэргэн ахай" гэж бичжээ. Шара Туджи. Монголская летопись 17-р века. Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шастиной. М-Л, 1957. Стр.90. 1688 онд Манжид дагаж, Сайн ноён Шамбын хошуунд захируулжээ. 1696 онд Манжын баруун замын их жанжин Вянуг дагалдаж Галдан Бошгитын цэргийг Зуун модонд цохиход оролцжээ. Сурвалжит өгүүлсэнээр Энх-Амгалан хаан "түүний эцэг Жамьян хуучин засаг бөгөөд Ядам бас дагалдаж цэрэглэсэн гавьяа буй тул зарлигаар засаг тэргүүн зэрэг тайж болгоод Шамбад захиргахгүй болговой" гэжээ. /Илтгэл шастир. 75-р/ Чингэж сайн ноён аймгийн Ачит засгийн хошуу одоогийн Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг юм. Манжийн эрхшээлийн үед Халхын умар замын дундад баруун гарын адгийн хошуу нэртэй байв.

ДАРЖАА. Ядамын хөвгүүн. 1719 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1728 он хүртэл Ачит засгийн хошууны ноён байв.

ЦЭВЭЭНЖАВ. Даржаагийн хөвгүүн. 1728 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1734 он хүртэл Ачит засгийн хошууны ноён байв.

РИНЧИН. Цэвээнжавын хөвгүүн. 1734 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1755 онд Манжийн их цэрэг Зүүнгарын

Даваачийг дайлахад цэргийн хүрээнд тэмээ, морийг адгуулан суужээ. 1756 онд Хотгойдын Чингүнжавын бослогын үеэр Халхын ноёд харуулыг орхиж нутагтаа буцахад Ринчин Сайн ноён аймгийн засаг Дайчунжавын хамт цэргийн адууны хэргийг хэвээр захирсаар байжээ. Тиймээс Тэнгэрийн тэтгэсэн хаан түүнийг сайшаан хөхүүлж, тогосын отго шагнаад торго соёрхжээ. Мөн хууль ёсоор "адуучин эрс"-т хүнсний амуу өгдөггүй байсныг тэр үеэс өгч эхэлжээ/Илтгэл шастир. 75-р дэвтэр/. Ринчин 1764 он хүртэл Ачит засгийн хошууны ноён байв.

БАЛСАНМИНЖҮҮР. Ринчингийн хөвгүүн. 1764 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1781 онд засаг хэргэмийг үе улиран тасралгүй залгамжлуулхаар болжээ. Тэрбээр 1792 он хүртэл Ачит засгийн хошууны ноён байв.

БАЗАР. Балсанминжүүрийн хөвгүүн. 1794 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1827, 1828, 1830 онд цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учир удаа дараа 4 тэмдэглэсэн зэрэг шагнажээ. 1841 онд тогосын отго хадуулжээ. Тэрбээр 1851 он хүртэл Ачит засгийн хошууны ноён байв.

ДОГМИД. Базарын хөвгүүн. 1851 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1887 он хүртэл Ачит засгийн хошууны ноён байв.

СЭД-ОЧИР. Догмидын хөвгүүн. 1887 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1889 онд Манжийн хааны хишиг тараахад 2 нэмсэн зэрэг, 1895 онд Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэх ажилд мөнгө тусалсан учир 1 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. Мөн оргодлыг хугацаанд нь бариулж чадаагүй учир 2 тэмдэглэсэн зэрэг хасуулсан. 1901 онд пүнлүүний мөнгө тусалсан учир 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг шагнуулж

ДОРЖ ИЛДЭН. Рашхив хөндлөнгийн хөвгүүн.

ГОМБОЦЭРЭН. Дорж илдэнгийн хөвгүүн. Угтаа туслагч тайж байжээ. 1732 онд эфү Цэрэнг дагалдаж, Зүүнгарын Цэрэндондовын цэргийг Хэрсэн чулуу, Эрдэнэзууд дарахад зүтгэжээ. Чингээд 1736 онд улсад туслагч гүн өргөмжлөгдсөн. 1744 онд нас барав.

ДАНЖИН. Гомбоцэрэнгийн хөвгүүн. 1744 онд улсад туслагч гүн залгамжилсан.

ДАШПУНЦАГ. Данзангийн хөвгүүн. 1755 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1781 онд Тэнгэрийн тэтгэсэн хааны буулгасан зарлигт " Дашпунцагийн өвөг Гомбоцэрэн цэргийн газарт хүчин барьж зүтгэн явсны учирт хэтэрхий улсад туслагч гүн өргөмжлөөд эдүгээ болтол гурван үе залгамжилсаны тулд хишиг хүртээж үе улиран тасралгүй залгамжлуулагтун" гэжээ \ Илтгэл шастир. 75-р дэвтэр \

ЦЭВЭЭНДАШ. Дашпунцагийн хөвгүүн. 1800 онд улсад туслагч гүн залгамжилсан.

ДЭЛЭГДАШ. Цэвээндашийн хөвгүүн. 1814 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1827, 1828, 1832 онд цэргийн хэрэглэлд тэмээ, мөнгө тусалсан учир 6 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. 1832 онд хошуу засгийн хэргийг эрхэлж байх үедээ оргодлыг хугацааны дотор бариулаагүй учир 1 тэмдэглэсэн зэрэг хасуулжээ.

СОНОМДОРЖ. Дэлэгдашийн хөвгүүн. 1867 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1888 онд тогосын отго хадуулсан. 1900 онд пүнлүүний мөнгө тусалсан учир 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ.

ДОВ. Рашхив хөндлөнгийн гутгаар хөвгүүн.

НАМЖИЛ. Довын хөвгүүн. 1696 онд Манжийн их цэргийн бүрэлдэхүүнд Галданг дайлахаар одож, Өвөр хоолой адагийн газар сайн байлдсан учир засаг тэргүүн зэрэг тайж өргөмжлөгджээ. Тэрбээр Сайн ноён аймгийн Эрх түшээт засгийн хошууны өвөг юм. 1716 он хүртэл тус хошууны ноён байв. Эрх түшээт засгийн хошуу буюу Халхын умар замын зүүн гарын зүүн этгээдийн адгийн хошуу нь одоогийн Архангай аймгийн Батцэнгэлийн сумын нутаг юм.

БАРАН. Намжилын ахмад хөвгүүн. 1716 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1732 онд эфү Цэрэнг дагалдаж, Хэрсэн чулууны газарт Зүүнгарын цэрэгтэй байлдахад шархдсан учир сайшааж, 4 өрх шагнажээ. 1748 онд өвчний учир засгаас байлгажээ.

РАВДАН. Барангийн ахмад хөвгүүн. 1748 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1755 онд Манжийн их цэрэг Даваачийг дайлахад Тамирын цэргийн хүрээнд сэргийлэн суужээ. 1756 онд Чингүнжавын бослогын үеэр тэрбээр Тамирын хүрээнд цэргийн хүнс, санг хамгаалсны тулд тогосын отго шагнажээ. Тэрбээр 1759 он хүртэл Эрх түшээт засгийн хошууны ноён байв.

ДОНДОВ. Равдангийн ахмад хөвгүүн. 1759 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1766 он хүртэл Эрх түшээт засгийн хошууны ноён байгаад өвчний учир байлгажээ.

ВАНЖИЛСАМПИЛ. Дондовын хөвгүүн. 1766 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1781 онд зарлигаар засаг тэргүүн зэрэг тайжийн хэргэмийг үе улиран тасралгүй залгамжлуулсан. 1821 он хүртэл Эрх түшээт засгийн хошууны ноён байв.

ГЭЖЭЭПИЛ. Ванжилсампилын гуравдугаар хөвгүүн. 1822 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1838 онд хилд нэвтэрсэн хасгуудыг хөөн зайлуулахад хүчин зүтгэсэн учир тогосын отго хадуулж, цэргийн гавьяанд 2 зэрэг нэмжээ. 1839 онд Цянь чин минд явав. Тэрбээр 1862 он хүртэл Эрх түшээт засгийн хошууны ноён байв.

ЖАМСРАНЖАВ. Гэжээпилийн хоёрдугаар хөвгүүн. 1862 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1865 он хүртэл Эрх түшээт засгийн хошууны ноён байв.

ЦЭРЭНГОМБО. Жамсранжавын ганц хөвгүүн. 1865 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1866-1868, 1871-1872 онд цэргийн хэрэглэл ба Булан тохойн хот байгуулахад мал, мөнгө тусалсан учир тогосын отго хадуулж, 6 нэмсэн, 10 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. 1879 онд цэргийн хэрэглэлд тусалсан учир улсын түшээ гүнгийн зэрэг өргөмжлөгджээ. Мөн Орос зүгийн харуулыг сайн захирсан учир 1 нэмсэн, 6 тэмдэглэсэн зэрэг шагнагдав. 1888 онд бие өвдсөн учир засгаас байлгажээ.

ЛУВСАНХАЙДАВ. Цэрэнгомбын ахмад хөвгүүн. 1883 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилж, Эрх түшээт засгийн ноён болжээ. 1886 онд хишиг тархаахад 2 нэмсэн зэрэг, 1889 онд цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир тогосын отго хадуулав. 1895 онд Жибузундамба хутагтын шатсан сүмийг шинэтгэхэд мөнгө тусалсан учир 1 тэмдэглэсэн зэрэг, 1899 онд Бат тэмдэгт бичгийн зүйлд мөнгө тусалсан учир 1 нэмсэн зэрэг шагнуулав. Мөн харуулыг захирч, зах хязгаарыг сэргийлсэн учир улсад туслагч гүнгийн зэрэг 2 нэмсэн, 4 тэмдэглэсэн зэрэг, пүнлүүний мөнгө тусалсан учир 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1911 онд Очирдара Богд гэгээнтнийг хаан ширээнд өргөмжилж, эрдэнийн сууринаа залсан учир хишиг тараахад түшээ гүнгийн зэрэг бөгөөд үе улиран улсад туслагч гүн, Түшээт цол шагнан хүртээжээ. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 183 /.

ДАНЖИНБАНЖУР. Түмэнхэн хөндлөн ноёны тавдугаар хөвгүүн.

НАМЖИЛ ЁСТ ҮЙЗЭН АХАЙ. Данжинбанжурын хөвгүүн. Цэрэн, Гүнгэравдан гэсэн 2 хөвгүүнтэй байжээ. Намжил ёст үйзэн ахай 1680-аад онд Халх, Ойрадын тэмцлийн үед нас баржээ.

ЭФҮ ЦЭРЭН. Намжил ёст үйзэн ахайн ахмад хөвгүүн. 1692 онд эмэг эх Гэцэлийн /Данжин ламын хатан/ хамт Тамирын газраас Манжид дагаж орсон. Манжийн хааны ордонд хүмүүжсэн. Энх амгалан хаан Цэрэнг гутгаар зэрэг дэсэлсэн түшмэл болгоод хааны ордонд хүмүүжүүлж, харьяат ардыг нь сум зохиож, Цахарын хөвөөт шар хошуунд хавсарган нутаглуулжээ. 1706 онд Энх амгалан хааны Хошой шулуун чин үнэмлэт гүнжтэй ураг барилдаж, эфү өргөмжлөгдсөн. 1715 онд Энх амгалан хааны зарлигаар Цэрэн Түйн голд одож, Манжийн умард их цэргийн бүрэлдэхүүнд орж, Зүүн гараас сэргийлэн суужээ. 1721 онд Зүүн гартай сайн байлдсан учир түүнийг хошууны бэйс өргөмжилж, тусгай хошуу захиргасан. Энэ нь Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн

хошууны үүсэл болсон бөгөөд Манжийн үед Халхын умар замын дундад дахь зүүн этгээдийн хошуу нэртэй байв. Энэ нь одоогийн Архангай аймгийн Булган, Их Тамир, Өндөр-Улаан, Чулуут сумын нутаг юм. 1725 онд Халхын туслагч жанжнаар томилж, түүний ойр төрлийн 19 хошуугаар Сайн ноён хан аймгийг байгуулж, Түшээт хан аймгаас салгажээ. Эфү Цэрэн 1727 оны 8-р сарын 25-нд Буурын гэрээнд Манжийн талыг төлөөлөн оролцож, Манж, Оросын хилийг тогтоожээ. 1731 онд Сүх алдахын газарт Халхын цэргийг удирдан Зүүн гарын цэрэгт цохилт өгчээ. Энэ тухай сурвалжид "эфү жүн ван Цэрэн түшмэл цэргийг захирч яваад шаламгайлан баатархан тэмцэлдэн байлдаж, Зүүн гарын хулгайг ихэд дарсан нь ихэд сайшаалтай. Үүнийг дэвшүүлж, хошой чин ван өргөмжлөөд нэгэн түмэн лан мөнгө шагнаж, хөхүүлэхийг үзүүлтүгэй" /Илтгэл шастир. 70-р дэвтэр/гэжээ. 1732 онд мөн Зүүн гарын цэрэгт дахин цохилт өгч зугтаалгасан учир түүнд Шалгарсан баатар цол шагнаж, Тамир нутагт нь шинэ орд хот байгуулж өгч, Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжнаар томилж байв. Эфү Цэрэн 1737 оны Халх, Зүүн гарын хилийг тогтооход гол үүрэгтэй оролцож байв. 1750 онд Цэрэнг нас барсны дараа гашуудлын хэрэгт нь улсын сангаас түмэн лан мөнгө гаргаж, шарилыг нь Бээжинд хүргүүлэн, Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хаан оршуулгын хэрэгт нь биеэр оролцож байжээ. Эфү Цэрэн бол багаас Манжийн хааны ордонд өсч хүмүүжиж, бичиг цэргийн боловсрол эзэмшиж, улмаар хааны хүргэн болсон учир Манжийн төрийн хамгийн итгэлт ноён байж, тэдний ашиг сонирхлыг бат найдвартай илэрхийлж байсан юм. Эфү Цэрэн 8 хөвгүүнтэй байснаас гэрийн үеийн бичмэлд жагсаасан нь ахмад хөвгүүн Цэнгүнжав, дэд хөвгүүн Цэвдэнжав, гутгаар хөвгүүн гүн Субшир, дөтгөөр хөвгүүн Жанцандорж, тавдугаар хөвгүүн Ринчиндорж, зургадугаар хөвгүүн Ширээт хутагт гэж тэмдэглэжээ /МУУТА. ФМ-168, Д-2, ХН-831/.

ЦЭНГҮНЖАВ. Эфү Цэрэнгийн ахмад хөвгүүн. Тэрбээр 1720 оноос эфү Цэрэнг дагалдан цэрэг дайны хэрэгт хүчин зүтгэж эхэлсэн. 1732 онд Зүүнгарын цэрэгтэй сайн байлдсан учир тэргүүн зэрэг тайж, улмаар 1736 онд хошууны бэйс өргөмжилж. Сайн ноён аймгийн туслагч жанжнаар томилогджээ. 1739 онд "Цэнгүнжав эр сайн, цэргийн хэрэгт үнэхээр зүтгэж явбай" гээд, Манж угсааны хошой чин ванг залгамжлагчид олгодог шизи цол хэргэм хүртээжээ. 1750 онд эцэг Цэрэнгийн хошой чин вангийн хэргэмийг залгамжилж, Сайн ноён аймгийн чуулган даргын тушаалд ажиллах болов. Улмаар Хязгаар дахиныг тогтоох зүүн этгээдийн туслагч жанжнаар томилогджээ. Гэвч 1753 онд Манжид дагасан дөрвөдүүдийг нэхэж,

харуулд довтолсон Зүүнгарын Захчин аймгийн тэргүүн Мамудыг алдсан ба Урианхайд дайлахад цэрэг авч мордоогүй Халхын ноёдыг өмөөрсөн учир туслагч жанжнаас байлгажээ. 1756-1757 онд Халхад Чингүнжаваар удирдуулсан Манжийн эсрэг тэмцэл гарсаны дараа Манжийн хааны Цэнгүнжавын цэрэг удирдах чадвар, Халхын ноёдын доторх дэмжлэг зэргийг харгалзан түүнийг өөртөө татахаар шийдэж, дахин Хязгаар дахиныг тогтоох туслагч жанжин болгож, зэвсэгт бослогыг дарах гол үүргийг ногдуулж, Чингүнжавын эсрэг сэргүүлэн тавьжээ. Цэнгүнжав Чингүнжавын бослогыг дарахад хүчин зүтгэсэн бөгөөд Манжийн хаан түүнд улбар шар өнгөт бүс шагнаж, дөтгөөр хөвгүүн Жанчивдоржийг шизи өргөмжилжээ. 1757 онд Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хаан "жанжин талбихад тун хүмүүн олохгүй. Цэнгүнжав монгол хэргийг ихэд ухамуй" гээд түүнийг хязгаар дахиныг тогтоох жанжнаар тавьж, 5000 лан мөнгө шагнаж байжээ. Цэнгүнжав 1771 онд нас барах хүртлээ Улиастайн жанжны тушаалд ажилласан бөгөөд түүний удирдлага, оролцоотойгоор тэр үеийн Халхын олон чухал асуудлууд шийдвэрлэгдэж байв. Тус хошууны ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэлд тэмдэглэсэнээр, Цэнгүнжав Эрх шар, Ишжамц, Минжүүрдорж, Жанчивдорж, Намхайдорж, Дэлэгдорж, Лавандорж гэсэн 7 хөвгүүнтэй байжээ/ МУУТА. ФМ-168, Д-2, ХН-831/.

ЭРХ ШАР. Цэнгүнжавын ахмад хөвгүүн. 1757 онд Зүүнгарын үлдэгдэл Баярыг сөнөөсөн учир улсад туслагч гүн өргөмжлөгджээ. 1758 онд Мураны авд явж, шар хүрэм, харавтар улаан жолоо шагнуулж, Цянь чин минд явжээ. Үүний дараа бэйсийн зэрэг шагнуулжээ.

ИШЖАМЦ. Цэнгүнжавын хоёрдугаар хөвгүүн. 1766 онд ах Эрхшарын улсад туслагч гүнг залгамжилсан. 1781 онд гүнгийн зэргийг нь үе улиран тасралгүй залгамжлуулсан. 1790 онд нас баржээ.

АМУРБАЙ. Эрх шарын хөвгүүн. Тэргүүн зэрэг тайж залгамжилсан.

ДАШДОРЖ. Амурбайн хөвгүүн. 1791 онд улсад туслагч гүн залгамжилж, Цянь чин минд явжээ. 1796 онд нас барсан.

НЯМ. Дашдоржийн ганц хөвгүүн. 1797 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1803 онд тогосын отго хадуулсан. 1830 онд нас барсан.

БУНИДАРЬ. Нямын ахмад хөвгүүн. 1831 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1844 онд нас барсан.

МИЖИДДОРЖ. Бунидарийн хөвгүүн. 1845 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1864 онд тогосын отго хадуулж, 1866 онд цэргийн

хэрэглэлд морь тусалсан учир 1 тэмдэглэсэн зэрэг шагнуулав. 1872 онд нас барсан.

ЧОЙМБОЛ. Мижиддоржийн хөвгүүн. Мижиддоржийн ойр төрлийн гутгаар зэрэг тайж Мөнхжавын хөвгүүн. 1904онд улсад туслагч гүн залгамжилсан. 1907 онд тогосын отог хадуулсан. 1911 онд нас барсан.

ЛАВАНДОРЖ. Цэнгүнжавын долдугаар хөвгүүн. Тэрбээр Бээжинд Манжийн хааны ордонд өсч хүмүүжиж, эфү өргөмжлөгдсөн. Энэ тухай сурвалжид "Тэнгэрийн тэтгэсний 22 он /1757/арван сарын шинийн 7-нд жанжин Цэнгүнжавын хатан түүний хөвгүүн Лавандорж түүний дүү Вобууг авч надад бараалхан эдүгээ Бээжинд хүрч ирэв. Би түүний хөвгүүнийг оруулж үзвээс буянтай төржээ. Хишиг хүртээлж, түүний хөвгүүн Лавандоржид 2 нүдэт отго шагнаж, энд агуулж, цэцэг тариулмуй"

/Галдан. Эрдэнийн эрих. Эрхлэн нийтлүүлсэн Ж.Гэрэлбадрах. УБ., 2007 Тал 771 - 773/гэжээ.Улмаар Лаваандоржийг нас биед хүрэхэд Манжийн найртай Амирлангуй улсын гүнжтэй гэрлүүлж, улсын эфү өргөмжлөөд, 1771 онд засгийн хошой чинвангийн хэргэм залгамжлуулжээ.Тэгэхдээ тэрбээр ихэвчлэн Бээжинд аж төрөх болсон бөгөөд Шулуун нарын монгол хошууны хошуу захирах сайд, Жүн Жан Тяны хэргийг захирах сайд. Жү Мин Юны 8 хошууны гэрийн 3 хошууны хэрэг, улмаар чуулган дарга, Шилсэн хурц хүрээний хэрэг, Галын зэвсгийн хүрээ, Хөвөөт шарын монгол хошууны сумын занги, Хиа захирах дотоод сайд зэрэг Чин улсын дотоод захиргааны албанд зүтгэж байв. Харин Лавандоржийн уугуул хошууны хэргийг түүний ах Ишжамц нь орлон эрхэлдэг байжээ. Эфү Лавандорж, Түшээт хан Цэдэндорж зэрэг Халхын том ноёдтой зөрчилдөж байсан байсан баримт бий. Тухайлбал, 1780 онд Түшээт хан Цэдэндорж нар Дөрвөд, Урианхайн сульдсан аймгийн нутгийг эзэрхлээ хэмээн Лавандоржийг буруутгаж, Монгол жургаанаас ял хэлэлцэж, түүнийг Хиа захирах дотоод сайдаас огцруулж, шадраас гарган вангийн пүнлүүг нь зогсоожээ. Гэвч 3 жилийн дараа Лавандорж "Түшээт хан Цэдэндорж санааны дураар тэргүүлж, зоргоор хүмүүнд шар торгоны улаа унах тэмдэг бичиг олгов" хэмээн айлтгаж, түүнийг Хүрээний хэрэг шийтгэх сайдын тушаалаас зайлуулж байв. Үүний дараа Лавандоржийн зогсоосон пүнлүүг уучилж, дахин Чин улсын дотоод сайдаар тавьжээ. Ван эфү Лавандорж Бээжингээс үе үе уугуул нутагтаа морилон ирдэг байсан бөгөөд хамгийн сүүлд 1815 онд нутагтаа буцаах үедээ нас баржээ. Манжийн хааны зарлигаар түүний гашуудлын хэргийг Хүрээ сайд Юндэндоржоор эрхлүүлж, улсын сангаас номун хөнжил 2000 лан

мөнгө гаргаж байв. /Илтгэл шастир. 69 - р дэвтэр/

Баянжаргал. Лавандоржийн асарсан хөвгүүн. 1815 онд эцэг Лавандоржийн засаг хошой чин вангийн хэргэм залгамжлаад 1816 онд нас баржээ.

Цэдэнбазар. Баянжаргалын хөвгүүн. 1816 онд засаг хошой чин вангийн хэргэм залгамжилжээ. Тэрбээр Бээжинд амьдарч байсан. 1823 онд гурван нүдний тогосын отго хадуулж, 1828 онд шадарт явжээ. Мөн цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учирт 3 тэмдэглэсэн зэрэг олгуулж, дараа нь уг барьсан тэмээдийг нь буцаан шагнажээ. Улмаар бослого гаргасан Жанкарыг амьд барьж хүргүүлсэн учир дөрвөн тэмдэглэсэн зэрэг олгуулав.

1831 онд харавтар улаан жолоо шагнаж, хагас жилийн пүнлүү олгуулжээ. 1836 онд Жүва Мин Юаны дотор гал гарсныг цаг тухайд нь тэнхрүүлсэн учир 1 нэмсэн зэрэг, 1839 онд Төр гэрэлт хааныг дагаж, Зүүн усанд бараа болсонд хоёр нэмсэн зэрэг олгов. 1842 онд Шулуун улааны монгол хошууны хошуу захирагч сайд, 1844 онд улбар шар жолоо шагнаж, Бөх хошуут суман хорооны хэргийг захируулжээ. 1845 онд Шулуун цагааны хиаг захирагч дотоод сайд болгож, гөрөөчин газрын хэргийг захиргажээ. 1848 онд чуулганы даргаар томилогдон ажиллаж байгаад 1852 онд нас баржээ. /Монгол Улсын шастир. Тэргүүн боть.УБ.,1997.Тал 150/.

Дарам.Цэдэнбазарын хоёрдугаар хөвгүүн. 1852 онд засаг хошой чин вангийн хэргэм залгамжилж, 3 нүдний тогосын отго шагнуулжээ. 1862 онд шадарт явж, нэг жилийн пүнлүүний мөнгө шагнуулж, цэргийн хэрэглэлд тусалсан учир таван нэмсэн зэрэг, 1864 онд цэргийн хэрэглэлд морь тусалсан учир нэг тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1865 онд харавтар улаан жолоо, 1867 онд цэрэгт шар үхэр, хонь тусалсан учир 4 нэмсэн, 3 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1872 онд шар жолоо шагнуулав. Дарам ван Бээжинд амьдарч байгаад 1874 онд нас баржээ. Монгол Улсын шастир. Тэргүүн боть.УБ.,1997.Тал 151/.

Наянт. Дарамын хоёрдугаар хөвгүүн. Тэрбээр багаас эцгээ дагаж Бээжинд сууж байгаад 1874 онд Сэцэн засаг хошой чин вангийн хэргэм залгамжилсан.Түүнийг 1883 онд шадарт авч, 3 нүдэт отгоор шагнаж, удирдагч сайд болгов. Дараа жил нь Манжийн төрийн бэйлийн охинтой гэрлүүлж, төрийн эфү өргөмжилжээ. Үүнээс хойш тэрбээр Чин улсын төрийн албанд идэвхийлэн зүтгэж, дагалдагч сайд, шадар сайд, Хөвөөт цагаан монгол хошууны сайд, Шинэ, хуучин албан гэр хороог захирах сайд, Жүн Тэн Тяны хэргийг захирах тэргүүн сайдын албыг хаших болжээ. Наянт вангийн өвөг дээдэс нь үе улиран Манжийн хаадтай ургийн холбоотой ба ойр

дотно харилцаж, хүчин зүтгэж ирсэн учир тэрбээр Манжийн хааны ордонд ихээхэн эрх нөлөөтэй байв. Наянт 1895 онд Дотоод сайд, чуулганы даргаар томилогдож, Шулуун улааны манж хошууны сайд, Аялан явах бүгд хэргийг захирах сайд, Хиа захирах сайд, Жагсаалыг бүртгэх сайд зэрэг Чин улсын чухал албанд ажиллаж байв. XX зууны эхэн үед Чин улсын эрх баригчидын Монгол шинэ засгийн бодлого хэрэгжүүлэх ажилд Наянт ван хүчин зүтгэж байв. 1908 онд уг шинэ

Засгийн бодлогыг дэмжих зорилгоор тэрбээр Хорчины ван Амарлингуй, Харчин ван Гүнсэнноров зэрэг Өвөр Монголын ноёдтой хамтран өөрсдийн хөрөнгөд түшиглэж, "Монголын үйлдвэр, худалдааны компани"-ийг Бээжинд байгуулжээ. Гэвч тун удалгүй тэдний үйл ажиллагаагаа явуулж эхлэх үед 1911 оны цагагчин гахай жилийн хувьсгал гарч, Чин гүрэн унаснаар эл байгууллага 1914 он гэхэд оршин тогтнохоо больжээ. Дундад иргэн улсын ерөнхийлөгч Юань Ши Каы Наянт ванг Ар Монголын тохинуулан тогтоох Улиастайн жанжны тушаалд томилж, Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн хэргийг эрхлүүлэх шийдвэр гаргаж байжээ. Гэвч үүнийг Монгол улс эсэргүүцэж байсан тул Наянт ван Халхад ирсэнгүй. Наянт ван Бээжинд удаан хугацаагаар сууж, хувийн тансаг орд харш, олон зуун зарц үйлчлэгчтэй байсан аж. Наянт ван 1926 онд жонон ван Ширнэндамдин, гүн Жамъян тэргүүтэй Монголын төлөөлөгчдэд өөртөө байсан Монгол Данжуурын бүрэн ботийг тусгай гэрээ байгуулж хүлээлгэн өгсөн нь Монголын шинжлэх ухаан, соёлын өв санд үнэтэй хувь нэмэр болсон юм. Наянт ван Монголын төлөөлөгч Ширнэндамдинд "Хэрэв хятадын улс төрийн байдал тогтворгүй болж, энд суухад бэрх болбол би Монголд очиж амьдрах хүсэлтэй. Энэ хүслийг минь Монголын эрх баригчдад уламжилж өгөөрэй" (С.Ишинноров. Буруугүй буруутнууд. Зуунмод 1993. Тал 70) гэж хэлж байжээ. Наянт ван 1939 онд Бээжинд өвчнөөр нас барсан бөгөөд гэрийн үеийн бичмэлд жагсааснаар Хэчингү, Чигдан, Чинга, Доронго, Цэнд-Аюуш гэсэн 5 хүүтэй байжээ. (МУҮТА. ФМ-168, Д-2, ХН-831).

ЦЭВДЭНЖАВ. Эфү Цэрэнгийн хоёрдугаа хөвгүүн. 1731 онд Сүх алдах, 1732 онд Хэрсэн чулуу, Эрдэнэ зууд Зүүнгарын эсрэг сайн байлдсан учир улсад туслагч гүн өргөмжлөгдөж, 2 нүдэт отго шагнуулжээ. 1742 онд шадарт явж, 1751 онд Цэнгүнжавын гуйсан ёсоор Цэвдэнжавын харьяатыг салгаж, засаг болгож, тусгай хошуу байгуулжээ. Чингэж тэрбээр Сайнноён аймгийн Дайчин засгийн хошууны ноёдын өвөг болов. Дайчин засгийн хошуу буюу Халхын умар замын дундадын баруун этгээдиний хошуу нь одоогийн

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Баян-Овоо, Баянхонгор (хот) сумын нутаг юм. 1754 онд Урианхайн зайсан Цадаг, Өөлдийн тайж Цэгэн, Зүүнгарын зайсан Хөгшин, Мамуд нарыг дарсан учир төрийн бэйл өргөмжлөгдөв. 1755 онд Манжийн их цэргийн бүрэлдэхүүнд өөрийн 300 морьт цэргийг авч дагуулан хүчин зүтгэсэн учир төрийн жүн вангийн хэргэм хүртээж, урианхай нарыг захиргав. 1756 онд урианхай нартай сүлбээлсэн зайсан Гурван Хожог дарж сөнөөсөн учир төрийн жүн ван болов. Чингүнжавын бослогыг дарсаны дараа Цэвдэнжавт Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжны тамгын хэргийг түр хамааруулж, Улиастайд суулгажээ. Мөн онд Тэнгэрийн тэтгэсэн хаан буулгасан зарлигт "Цэвдэнжав цэргийн хэрэг шийтгэхэд цөм тухайн ёсонд нийлэлцмүй. Урьдаас ихэд хүмүүжчүхүй. Хойд жил цэрэг ороход Жаухуйг Цэнгүнжавын оронд Хязгаар дахиныг тогтоогч жанжин талбиад Цэвдэнжавыг туслагч жанжин болгогтун" гэжээ. Үүнээс хойш тэрбээр Зүүнгарыг нутгийг түвшитгэн тогтоох хэрэгт идэвхтэй зүтгэж гавьяа байгуулсан тул түүний эцэг эфү Цэрэнгийн "Шалгарсан баатар" цол, чин вангийн зэрэг хүртээж, аймгийн туслагч жанжин болгов. Тийнхүү Цэвдэнжавыг Манжийн хаанаас ихээхэн үнэлж байсны нэг гэрч нь 1759 онд түүний хөргийг Туяа гэрэлт зуруулж, Тэнгэрийн тэтгэсэн хаан өөрөө магталгын шүлэг бичиж байжээ. 1771 онд Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин, аймгийн чуулганы дарга болсон ч 2 жилийн дараа "ашгийг хичээж явсан" хэмээн бэйс Цэвээндоржийн заалдсанд Зүүн этгээдийн туслагч жанжнаас байлгав. 1774 онд Цэвдэнжавын 70 насны ойгоор Тэнгэрийн тэтгэсэн хаан Хязгаалашгүй өлзийт бурхан, шүр эрх, 4 дүгрэг луутай бүс хүрэм шагнажээ. 1779 онд түүний хуучин гавьяаг нэхэн санаж, хуулийн сайд тавиад, зарлигаар зургийг зуруулаад шагнажээ. Гэвч 1780 онд "хэдэrmэгийлэн нутгийн захыг бадруулсугай" хэмээн айлтгасан учирт чин вангийн зэргийг эвдэв. 1781 оны хааны зарлигт "Цэвдэнжав цэрэгт зүтгэн байлдсан гавьяа ихэд илрэв. Тайжаас жүн ванд хүрүүлж өргөмжлөөд бас засаг талбисны тулд хишиг хүртээж үе улиран тасралгүй загамжлуулагтун" (Илтгэл шастир. 71-р дэвтэр) гэжээ. 1782 онд нас барав.

Сампилдорж. Цэвдэнжавын ахмад хөвгүүн. 1782 онд засаг төрийн жүн ван залгамжлаад, шадарт явж, 3 нүдний тогосын отго хадуулжээ. 1784 онд Сайнноён аймгийн чуулган даргаар тавьж, хааны үржүүлэх сүргийг захирав. 1787 онд Улиастайн хэбэй амбан тавьж, Халхын өртөөг захиргаж, хар үнэгэн дах шагнажээ. Мөн оноос 1807 он хүртэл үржүүлэх сүргийг сайн захирав хэмээн 14 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1807 онд Сампилдоржийг нас барахад

улсын сангаас 500 лан мөнгө олгуулж, гашуудлын хэргийг үйлдүүлж байв. Тэрбээр Сайн ноён аймгийн Дайчин засгийн хошууны ноён хоёрдахь ноён юм. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 164/.

ДАМИРАНЖАВ. Сампилдоржийн ахмад хөвгүүн. 1788 онд урамдалын авд явж, шар хүрэм шагнуулж байжээ. 1807 онд эцэг Сампилдоржийн засаг төрийн жүн ван-залгамжилжээ. Мөн онд Цянь чин минд явуулан 3 нүдний тогосын отго хадуулжээ. Тэрбээр 1815 он хүртэл Дайчин засгийн хошууны ноён байв.

ЧОГСОМЖАВ. Дамиранжавын ахмад хөвгүүн. 1815 онд засаг төрийн жүн ван залгамжилж, 3 нүдний тогосын отго, шар хүрэм шагнуулжээ. 1817 онд Сайн ноён аймгийн туслагч жанжнаар томилогдов. 1826 онд Цянь чин минд явжээ. 1826 ба 1830 онд цэргийн хэрэглэлийг зөөх тэмээ тусалсан учир 16 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. Тэрбээр 1831 он хүртэл Дайчин засгийн хошууны ноён байв.

ЦЭРЭНГОМБО. Дамиранжавын гуравдугаар хөвгүүн. 1831 онд засаг төрийн жүн ван залгамжлаад Цянь чин минд явж, 3 нүдний тогосын отго хадуулав. 1834 онд үржүүлэх тэмээг захиргаж, 1835 онд аймгийн туслагч жанжнаар тавьжээ. 1836 онд үржүүлэх тэмээг сайнаар захирч үржүүлсэн учир 2 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. Тэрбээр 1853 он хүртэл Дайчин засгийн хошууны ноён байв.

ДАРАМЖАВ. Цэрэнгомбын гуравдугаар хөвгүүн. 1836 онд засаг төрийн жүн ван залгамжилсан. 1846 онд Сайн ноён аймгийн туслагч жанжнаар томилогдон ажиллах болжээ. Тэрбээр 1853 он хүртэл Дайчин засгийн хошууны ноён байв.

СЭНГЭШИР. Дарамбазарын төрсөн дүү. 1853 онд засаг төрийн жүн ван залгамжилсан. 1856 онд цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир 2 нүдний тогосын отго, 1857 онд 3 нэмсэн зэрэг олгуулжээ. Мөн онд аймгийн туслагч жанжий болжээ. 1865-1867 онд цэргийн хэрэглэлд мал тусалсан учир 3 нэмсэн, 5 тэмдэглэсэн зэрэг шагнуулав. 1868 онд Булантохойн хот байгуулахад мөнгө тусалсан учир харавтар улаан жолоо шагнаж, 1870 оноос үржүүлэх тэмээг захиргажээ. 1771 онд цэргийн хэрэглэлд мал тусалсан учир улбар шар жолоо, 1771-1779 онд 4 нэмсэн, 4 тэмдэглэсэн зэрэг, үржүүлэх тэмээ сайн захирсан учир 6 тэмдэглэсэн зэрэг олгуулав. Тэрбээр 1883 он хүртэл Дайчин засгийн хошууны-ноён байв. /Монгол улсын шастир. Тэргүүн боть.УБ., 1997. Тал 165/.

ЦЭРЭНДОРЖ. Сэнгэширийн ахмад хөвгүүн. 1883 онд засаг төрийн жүн ван залгамжилсан. 1889 онд Сайн ноён аймгийн туслагч жанжны хэбэйн тусаалд томилогджээ. Мөн онд хишиг тараахад 2

нэмсэн зэрэг шагнуулжээ. Тэрбээр 1889 он хүртэл Дайчин засгийн хошууны ноён байв.

ГҮРГЭМЖАВ. Цэрэндоржийн үеэл дүү. 1893 онд засаг төрийн жүн ван залгамжлаад 1896 онд аймгийн чуулганы дэд дарга болжээ. 1895 онд Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэн засах ажилд мөнгө туслан барьсан учир 3 тэмдэглэсэн зэрэг олгуулав. 1901 онд пүнлүүний мөнгө тусалсан учир 3 нэмсэн, 3 тэмдэглэсэн зэрэг олгожээ. 1909 онд Улиастайн хэбэй амбаны тушаалд томилогдов. 1911 онд Олноо өргөгдсөний тэргүүн он Очирдара Богд гэгээнтнийг хаан өргөмжилж, эрдэнийн сууринаа залсан учир зарлигаар чин вангийн зэрэг бөгөөд 3 нүдний тогосын отго, үе улиран Дайчин цол шагнан хүртээжээ. 1912 онд Улиастайн манж, хятад сайд, жанждыг үлдэн хөөж буцаахад хүчин зүтгэсэн учир харавтар улаан жолоо шагнуулжээ. Тэрбээр 1918 он хүртэл Дайчин засгийн хошууны ноён байв. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 166/.

ЭРИНЧИНДОРЖ. Эфү Цэрэнгийн тавдугаар хөвгүүн. Гүнгийн зэрэг тайж.

НАСАНДОРЖ. Эринчиндоржийн хөвгүүн. Гүнгийн зэрэг тайж.

ЭРИН-ОЧИР. Насандоржийн хөвгүүн. гүн зэрэг тайж.

ГҮНГЭРАВДАН. Намжил ёст үйзэн ахайн хоёрдугаар хөвгүүн. Эфү Цэрэнгийн төрсөн дүү. 1723 онд хошууны бэйс өргөмжлөгджээ.

ШАГДАРЖАВ. Гүнгэравданы дүү. 1733 онд хошууны бэйс залгамжилж, 1763 онд төрийн бэйлийн хэргэм шагнуулжээ. 1772 онд нас баржээ.

СОДОВДОРЖ. Шагдаржавын хоёрдугаар хөвгүүн. 1772 онд хууль ёсоор зэрэг бууруулж, 1795 он хүртэл хошууны бэйс залгамжилжээ. 1779 онд Сайн ноён хан аймгийн дэд чуулганы даргаар тавигдан ажилжээ.

БАЛЖУРСОНДОВ. Содовдоржийн хөвгүүн. 1946 онд хооронд хошууны бэйс залгамжилжээ. 1818 онд нас барав.

БАЛДОРЖ. Балжурсондовын хөвгүүн. 1818 онд хошууны бэйс залгамжилсан. 1826 онд цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учир 2 тэмдэглэсэн зэрэг олгуулж, уг тэмээдийг буцаан шагнажээ. 1828 онд туслагч жанжны хэбэй болж, 2 нүдний тогосын отго хадуулав. 1830 онд цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учир 2 тэмдэглэсэн зэрэг шагнуулав. 1831 онд дэд чуулган даргаар томилогдон ажиллаж байгаад 1849 онд нас барав. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 167/.

ЖАМБАЛИНГИД. Балдоржийн хөвгүүн. 1849 онд хошууны бэйс залгамжилсан. 1850 онд харьяат засаг хошой чин ван Дарамын тамгын хэргийг шийтгүүлжээ. 1857 онд пүнлүүний мөнгө тусалсан

учир 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1863 онд нас барав.

ТУНГАЛАГ-ОЧИР. Жамбалингийн дүү. 1864 онд хошууны бэйс залгамжилсан. 1866, 1868 онд цэргийн хэрэглэлд мал тусалсан учир 2 нэмсэн, 4 тэмдэглэсэн зэрэг олгуулж, 2 нүдний тогосын отго хадуулав. 1874 онд нас баржээ.

ВАНЧИГЧАГДАР. Тунгалаг-Очирын хоёрдугаар хөвгүүн. 1875 онд хошууны бэйс залгамжилж, 2 нүдний тогосын отго хадуулсан. 1884-1885 онд харьяат засаг Наянтын тамгын хэргийг шийтгэж байв. 1885 онд Цянь чин минд, 1887 онд шадарт явжээ. 1895 онд Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэхэд мөнгө тусалсан учир 1 тэмдэглэсэн зэрэг олгуулав. 1896 онд нас баржээ. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 167/.

ЖАМСРАН. Ванчигчагдарын ахмад хөвгүүн. 1896 онд хошууны бэйс залгамжилсан. 1912 онд бэйлийн зэрэг шагнаан хүртээжээ. 1918 онд улсын санд мөнгө өргөсөн учир 3 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ.

ВОБУУ. Гүнгэравданы хөвгүүн. 1764 онд Зүүнгат олзонд байгаад буцаж ирсэн учир улсад туслагч гүн өргөмжлөгджээ. 1772 онд нас баржээ.

САМПИЛДОНДОВ. Вобуугийн ахмад хөвгүүн. 1772-1801 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1871 онд үе улиран тасралгүй залгамжлуулахаар болжээ.

ГЭЛЭГДОНДОВ. Сампилдондовын гуравдугаар хөвгүүн. 1802-1818 онд улсад туслагч гүн залгамжилсан.

САНДУВДОРЖ. Гэлэгдондовын ахмад хөвгүүн. 1818-1860 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1826, 1830 онд цэргийн хэрэглэлд тэмээ тусалсан учир 4 тэмдэглэсэн зэрэг олгуулав. 1835 онд тогосын отго хадуулжээ.

ЖИГЖИДДОРЖ. Сандувдоржийн хөвгүүн. 1860-1876 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1857 онд пүнлүүний мөнгө тусалсан учир 2 тэмдэглэсэн зэрэг олгуулсан. 1866, 1868 онд цэргийн хэрэглэлд мал тусалсан учир 3 тэмдэглэсэн зэрэг олгуулав. /Монгол улсын шастир. Тэргүүн боть. УБ., 1997. Тал 168/.

БИМИГИРЭДЭЙ. Түмэнхэн сайн ноёны есдүгээр хөвгүүн. Баатар эрдэнэ ноён хэмээх цолтой байв. "Шар тууж", "Асрагч нэрийн түүх"-нд түүнийг "Баатар эрдэнэ номч. Убаши болсоны хойно Бималигирди" гэж бичсэн буй. 1679 онд Зүүнгарын Галдан бошгот хаан хүчирхэгжиж, нутгийн зах нь Халхад тулж ирэхэд тэрбээр "түүний Халхад халдсугай" гэхийг сонсоод Манжид элч зарж илгээсэнд Энх-Амгалан хаан ихэд сайшаан шагнаж байжээ. 1680 онд Галдан бошготын харьяат Эрдэнэ хошууч Өвөр Монголын Урад аймгийг уулгалсны дараа Бимигирэдэй түүний Эзнээ голд

очиж суусныг Энх амгалан хаанд айлтгасанд харуул байгуулж, сэргийлэн тостугай хэмээн зарлиг буулгаж байжээ/Илтгэл шастир, 75-р дэвтэр /. 1685 онд нас барав.

БАЧИНДАЙ ЭРХ ДАЙЧИН. Бимигирэдэйн ахмад хөвгүүн. 1685 онд эцэг Бимигирэдэйн угсаа залгамжлаад удалгүй 1688 онд нас баржээ.

ДАНЖИН-ЭРДЭНЭ. Бачиндайн хөвгүүн. Тэрбээр 1688 онд ах Шамбыг дагаж Манжид дагаж ирсэнд Харууна ууланд нутаглуулан суулгажээ. 1689 онд Шүрхий хаалганы сангийн амууг Данжин эрдэнийн харьяат ардад олгожээ. 1691 онд тэрбээр Долоннуурын чуулганаар засаг тэргүүн зэрэг тайж өргөмжлөгджээ. Мөн Алшаагийн Баатарх эрх жонон Хоролийн хүн, малыг хурааж, Данжин-Эрдэнэд өгөөд, түүнийг Сайн ноён Шамбын хамт Хоролийг сэргийлэн тостугай хэмээн суулгажээ. 1697 онд Галдан бошготын холбоотон Ялгуусан хутагтыг Хатан голын орчимд байхад нь Данжин-Эрдэнийг бусад ноёдын хамт бариулахаар илгээж байв. Тэрбээр Сайн ноён аймгийн Ёст засгийн хошууны ноёдын өвөг бөгөөд 1712 он хүртэл засаг ноён байв/Илтгэл шастир, 75-р дэвтэр /. Ёст засгийн хошуу буюу Халхын умар замын зүүн гарын баруун этгээдийн хошуугаар хожим Өмнөговь аймгийн Ноён, Сэрвэй, Гурвантэс, Хүрмэн, Баяндалай сумдыг байгуулсан байна.

ШИРЖАВ. Данжин-Эрдэнийн ахмад хөвгүүн. 1711 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1728 он хүртэл Сайн ноён аймгийн Ёст засгийн хошууны ноён байв.

МАНЗУШИР. Ширжавын ахмад хөвгүүн. 1728 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1731 он хүртэл Ёст засгийн хошууны ноён байв.

ЧОЙМБОЛ. Манзуширийн ахмад хөвгүүн. 1731 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1755 он хүртэл Ёст засгийн хошууны ноён байв.

ТҮВДЭННАМЖИЛ. 1755 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1756 он хүртэл Ёст засгийн хошууны ноён байв.

ДОРЖЧАВАГ. Чоймболын хоёрдугаар хөвгүүн. 1765 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1775 он хүртэл Ёст засгийн хошууны ноён байв.

СОНОМГОМБО. Доржчавагийн ахмад хөвгүүн. 1775 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1776 онд зарлигаар засаг хэргэмийг үе улиран тасралгүй залгамжлуулсан. Тэрбээр 1788 он хүртэл Ёст засгийн хошууны ноён байв.

ЛУВСАНДАШ. Сономгомбын дүү. 1789 онд засаг тэргүүн зэрэг

тайж залгамжилсан. Тэрбээр 1816 он хүртэл Ёст засгийн хошууны ноён байв.

ДАМИРАНЖАВ. Лувсандашийн ахмад хөвгүүн. 1816 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1833 онд хэргийн учир засгаас байлгаж, түүний дүү Сандагдоржид залгамжлуулжээ.

САНДАГДОРЖ. Дамиранжавын дүү. Тайжийн зэрэгтэй.

ШИНАРАГСАД ХУНТАЙЖ. Түмэнхэн сайн ноёны аравдугаар хөвгүүн. Түүний нэрийг Сайн ноён аймгийн Мэргэн засгийн хошууны ноёд тайж нарын гэрийн үеийн бичмэлд Шарз даян хунтайж, "Илтгэл шастир"-т Шинарагсад хунтайж хэмээжээ. Шинарагсад хунтайж эцэг Түмэнхэн сайн ноёны шарын шашныг дэлгэрүүлэх ажлыг үргэлжлүүлж, өөрийн хошуу нутаг Зая бандид, Дарба бандид зэрэг Халхын томоохон хутагтуудыг урин залж, ном сургаал айлдуулж, сүм дуган байгуулж байжээ. Сурвалж Бичгийн мэдээнээс үзэхэд, тэрбээр 1680-аад он хүртэл амьдарч байсан бололтой. Чабагдар сэцэн, Сэмжид гэсэн 2 хүүтэй байжээ.

ЧАВАГДАР СЭЦЭН НОЁН. Шинарагсадын ахмад хөвгүүн. 1686-1687 онд Галданд нийлэхээр одсон учир Хотгойдын бэйл Гэндэнд баригджээ. Тэрбээр Буни гэсэн хөвгүүнтэй байв.

БУНИ. Чавагдар сэцэн ноёны хөвгүүн. Эцгээс урьд нас баржээ.

АРЪЯА. Бунийн хөвгүүн. Тэрбээр нас бага учир авга ах Сэмжидийн хараанд байжээ. Гэвч түүнийг харгалзаж байсан Чабагдар ноёны харьяат Арслан үй зайсан гэгч Арьяагийн харьяатыг авч Сэмжидээс тусгаарлан сууж байжээ. 1692 онд Арьяа,

Арслан үй зайсан нар харьяат ардаа авч Манжид дагаар ирсэнд Арьяаг засаг тэргүүн зэрэг тайж өргөмжилж, тусгай хошуу болгож, Арслан үй зайсанг хошууны туслан хэрэг шийтгэгчээр томилов. 1693 онд Арьяагийн харьяат нь Хэрлэнгээс Орхон, Туулын захад нүүн суув. 1696 онд Манжийн их цэрэг Галданг дайлахад Арьяа, Арслан үй зайсан нар явж хүчин зүтгэжээ. 1715 онд Халхын Засагт хан аймгийн жанжин Бүүвэй Урианхайг дайлахад "засаг Арьяагийн хошууны цэрэг байлдахад мэргэн" хэмээн томилон явуулах үед нас баржээ. Тэрбээр Сайн ноён аймгийн Итгэмжит засгийн хошууны ноёдын өвөг юм. Тус хошуу нь одоогийн Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутгийг хамарч байжээ.

ГЭМПИЛ. Арьяагийн ахмад хөвгүүн. 1715 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1731 онд Сүх алдах, 1732 онд Хэрсэн чулуунд Зүүнгартай байлдахад хүчин зүтгэж шарх олсон боловч дахин 3000 цэрэг авч Хар азарга хэмээн газарт сайн байлдаж, олон хүн, мал олзолжээ. Үүнийг Манжийн Интэй чин ван Шибүү Манжийн тэтгэсэн хаан айлтгасанд "Гэмпил өнгөрсөн жил гавъяа

зүтгэлгэ ихэд илэрхийлэв. Эдүгээ бас баатархан хулгайг дайлахад шарх олсон бөгөөд нэн шаламгайгаар явсан нь маш сайшаалтай. Үүнийг улсад туслагч гүн өргөмжлөөд хөхүүлэхийг үзүүлэгтүн" гэжээ /Илтгэл шастир. 74-р дэвтэр/. 1737 онд түүнийг дэвшүүлж, улсын түшээ өргөмжлөв. 1738 онд өөрийн хошууны малын бэлчээр хорогдож, аж төрөхөд хүндэрсэн учир нутаг өргөтгөхийг гуйн айлтгасанд Зүүнгартай хил тогтоогүй учир Манжийн хаан хүлээн аваагүй аж. Тэрбээр 1749 он хүртэл Итгэмжит засгийн хошууны ноён байв.

ГҮНГЭДОНДОГ. Гэмпилийн ахмад хөвгүүн. 1749 онд засаг улсын түшээ гүн залгамжилсан. 1753 онд Сэцэн хан аймгийн туслагч жанжин Гэлэгямпилын хамт Улиастайд сууж, Дөрвөдийн дагасан ардыг харгалзан суужээ. 1754 онд Манжийн харуулд нэвтэрсэн Урианхайн Дэмч хутаг, Жамц нарыг барьсан учир тогосын отог харуулав. Мөн оны зун Цагаан зэл, Өлгий нуурт сэргийлж суусан ба өвөл нь Урианхайн зайсан Цэгэний харьяат ардыг хураажээ. Тэнгэрийн тэтгэсэн хаан түүнийг сайшаан дуудуулсан боловч тэрбээр Манжийн жанжин Бандийн тушаалаар Цэцэг нуурт сэргийлэн сууж, Зүүнгарын буучины зайсан Агзул нарыг дагуулжээ. Улмаар 1755 онд Манжийн их цэрэг Даваачийг дайлахад хүчин зүтгэснээс гадна Зүүнгарын Гурван Хожо нарыг дарсан учир 2 нүдний отго шагнуулжээ. Тэрбээр 1770 онд Итгэмжит засгийн хошууны ноён байв /Илтгэл шастир. 74-р дэвтэр/.

ДАНСРАН. Гүнгэдондогийн ахмад хөвгүүн. 1770 онд засаг улсын түшээ гүн залгамжлав. 1781 онд Тэнгэрийн тэтгэсэн хааны буулгасан зарлигт "Дансрангийн язгуурын тулгар өвөг Арьяа засаг тайж өргөмжилсөн бөлгөө. Хойно түүний хөвгүүн Гэмпил цэргийн хүрээнд хүчин барьж зүтгэн гавъяа зүтгэлгэ илэрсний учир дэвшүүлж улсын түшээ гүн өргөмжлөв. Дансранд хүрч ирээд бас хоёр үе залгамжилсны тулд хишиг хүртээж үе улиран тасралтгүй залгамжлуулагтун" гэжээ. Тэрбээр 1782 он хүртэл Итгэмжит засгийн хошууны ноён байв /Илтгэл шастир. 74-р дэвтэр/.

ЦЭВЭЭНДАШ. Дансрангийн ахмад хөвгүүн. 1782 онд засаг улсын түшээ гүн залгамжилсан. Тэрбээр 1813 он хүртэл Итгэмжит засгийн хошууны ноён байв.

БАЛЖИН. Цэвээндашийн ахмад хөвгүүн. 1813 онд засаг улсын түшээ гүн залгамжилсан. Тэрбээр 1825 он хүртэл Итгэмжит засгийн хошууны ноён байв.

ЖАМСРАН. Балжингийн дүү

ЦЭДЭНЖАВ. Жамсрангийн хөвгүүн. Засаг улсын түшээ гүн Балжингийн үеэл хөвгүүн. 1825 онд засаг улсын түшээ гүн

залгамжилсан.Тэрбээр 1866 он хүртэл Итгэмжит засгийн хошууны ноён байв.

ГАНЖУУРЖАВ. Цэдэнжавын долдугаар хөвгүүн. 1867 онд засаг улсын түшээ гүн залгамжилсан. Тэрбээр 1910 он хүртэл Итгэмжит засгийн хошууны ноён байв.

ДОРЖ. Засаг Гүнгэдондогийн ойр төрлийн дүү.1655 онд Манжийн их цэрэг Зүүнгарын Даваачийг дайлахад оролцож яваад Хойдын Амарсанаагийн холбоотон Кэсим нарт олзлогджээ.Тэрбээр Зүүнгарын дайсан Тугт Болдын гэрт байгаад Зүүнгарын бослогыг дарсаны дараа эргэж ирэхэд нь улсад туслагч гүн өргөмжилж нутаг нь буцаажээ./Илтгэл шастир.74-р дэвтэр/

ШАГДАРЖАВ. Доржийн ахмад хөвгүүн.1762 онд улсад туслагч гүн залгамжилсан. 1771 онд Тэнгэрийн тэтгэсэн хааны буулгасан зарлигт "Шагдаржавын эцэг Дорж цэргийн хүрээнд язгуураас адагт хүртэл хүчин барьж зүтгэн явсан бөгөөд бас цэргийн хүрээнд одоход замын зуур өвчнөөр үгүй болов. Ихэд асран өршөөмүй. Тийнхүү Шагдаржавыг мөнхүү гүнгийн хэргэм залгамжлуулбай. Үүнд хишиг хүртээж үе улиран тасралгүй залгамжлуулагтун"гэжээ./ Илтгэл шастир.74-р дэвтэр/

ДОВЧИН.Шагдаржавын ахмад хөвгүүн.Улсад туслагч гүнгийн хэргэм залгамжилжээ.

ЦЭДЭНЖАВ. Довчингийн ахмад хөвгүүн.Улсад туслагч гүнгийн хэргэм залгамжилжээ.

ГҮНГЭ. Цэдэнжавын ахмад хөвгүүн.Улсад туслагч гүн залгамжилжээ.

СЭМЖИД. Шинарагсад хунтайжийн тавдугаар хөвгүүн. Сайн ноён аймгийн Мэргэн засгийн хошууны ноёдын өвөг."Илтгэл шастир"-т "Сэмжид. Халх аймгийн хүмүүн. Боржигид овогтой. Үүний эцэг Шинарагсад.Цол хунтайж хэмээмүй.Язгуураас харьяат аймгийн засаг болсон бөлгөө.Сэмжид залгамжлаад цол Хөндлөн дайчин мэргэн хэмээмүй" гэжээ./Илтгэл шастир.73-р дэвтэр/. Сэмжид хөндлөн мэргэн бол Мэргэн засгийн хошууны анхны засаг ноён агаад 1692 онд Манжийн Энх амгалан хааны зарлигаар засаг тэргүүн зэрэг тайж өргөмжлөгдсөн ажээ. Энэ тухай манж сурвалжид өгүүлсэн нь "Засгийн тайж Сэмжидийг хойд замын баруун гарын хойд хошууны хэргийг захируулъя"/Биеэр дайлж өрнө умрын газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг.ӨМСХХ.1992.Тал 184/ гэжээ. Тус хошуу нь Манжийн хуулиар батлагдсан албан ёсны нэр нь Халхын умард замын баруун гарын умард этгээдийн хошуу гэх боловч ХҮЛИ-XX зууны эхэн үед аман яриа болон бичиг зохиолд анхны засаг Сэмжидийн цолоор Хөндлөн мэргэн засгийн хошуу

гэх буюу товчоор Мэргэн засгийн хошуу гэдэг байжээ. Тус хошуу нь Манжийн эрхшээлийн үед Халхын умар замын баруун гарын умард хошуу нэртэй байгаад хожим одоогийн Архангай аймгийн Цэцэрлэг, Хөвсгөл сумдыг байгуулахад оролцжээ.

ГЭНДЭН. Сэмжидийн ахмад хөвгүүн. 1712-1735 онд Мэргэн засгийн хошууны ноён байв. 1712 онд Энх амгалан хааны зарлигаар засаг тэргүүн зэрэг тайж залгамжилжээ.

БУДЖАВ. Гэндэнгийн ахмад хөвгүүн. 1735-1752 онд Мэргэн засгийн хошууны ноён байв. Гэндэн засаг нас өтөлсөн учир Манжийн Найралт төв хааны зарлигаар 1735 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан.

ЦЭДЭНЖАВ. Буджавын ахмад хөвгүүн. 1752 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилжээ. 1781 онд Манжийн Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигаар засгийн хэргэмийг үе улиран тасралтгүй залгамжлуулахаар болжээ. Тэрбээр 1782 он хүртэл Мэргэн засгийн хошууны ноён байв.

ДОРЖЖАВ. Цэдэнжавын ахмад хөвгүүн. 1782-1846 онд Мэргэн засгийн хошууны ноён байв. 1782 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан

1812 онд Мураны авд бараалхсан учирт Манжийн Сайшаалт ерөөлт хаанаас тогосын отго шагнан хадуулжээ. Доржжав нас өтөлж бие өвдсөн учир 1846 онд засгаас байлгав.

ЛУВСАНЦЭРЭН. Доржжавын хоёрдугаар хөвгүүн. 1846-1852 онд Мэргэн засгийн хошууны ноён байв. 1846 онд Манжийн Төр гэрэлт хааны зарлигаар засаг тэргүүн зэрэг тайж залгамжилжээ. Мөн онд тогосын отго хадуулжээ.

ӨЛЗИЙБАДРАХЛЯНХУА. Лувсанцэрэнгийн ахмад хөвгүүн. 1852-1898 онд Мэргэн засгийн хошууны ноён байв. 1852 онд Түгээмэл элбэгт хааны зарлигаар засаг тэргүүн зэрэг тайж залгамжилжээ. 1856 онд цэргийн хэрэгт мөнгө 300 лан барьсан учир 1 нэмсэн, 2 тэмдэглэсэн зэрэг, 1864 онд цэргийн хэрэглэлд морь 16-г барьсан учир 2 тэмдэглэсэн зэрэг, 1866 онд Илийн цэргийн хэрэглэлд морь 10-ыг барьсан учир 2 тэмдэглэсэн зэрэг, 1868 онд Булан тохойд хот байгуулахад мөнгө 50 лан барьсан учир 1 тэмдэглэсэн зэрэг, цэргийн хэрэгт туслан барьсан учир үхэр, хонины үнэ 431 лан, 7 цэнд тогосын отго, 2 нэмсэн, 3 тэмдэглэсэн зэрэг, бас Сайн ноён аймгийн харуулыг 5 жил эндэгдэлгүй захирсан учир 1 нэмсэн, 2 тэмдэглэсэн зэрэг, 1901 онд хишиг тараах зарлигаар 3 нэмсэн зэрэг, Чуулалт хаалганы газар гачигдсан иргэдийг тэнхрүүлэх ба Жибзундамба хутагтын сүм шинэтгэхэд мөнгө 20 лан барьсан учир 1 тэмдэглэсэн зэрэг олгож байжээ. /Сайн ноён аймгийн улсад

туслагч гүн Мөнх-Очирын уг эх, УТНС, ГБС /

МӨНХ-ОЧИР. Өлзийбадрахлянхуагийн ахмад хөвгүүн. 1898 онд Манжийн Бадаргуулт төр хааны зарлигаар засаг тэргүүн зэрэг тайж залгамжилж, Мэргэн засгийн хошууны ноён болжээ. Тэрбээр 1871 онд их цэргийн хэрэглэлд 39 морь туслан барьсан учир тогосын отго, 1911 онд Манжийн хааны санд 100 мөнгө туслан барьсан учир 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг бас Сайн ноён аймгийн харуулыг 3 жил эндэгдэлгүй захирсан учир 2 тэмдэглэсэн зэргийг олгуулж байжээ. 1911 онд Богд Жибзундамба хутагтын хаан ширээнд өргөмжилж, эрдэнийн ширээнд залсан учирт хишиг тархаах зарлигаар нэгэн үед улсад туслагч гүнгийн зэрэг бөгөөд үе улиран Мэргэн цол шагнан хүртээжээ. /МУУТА. М-168, Д-3, ХН-37, Сайн ноён аймгийн улсад туслагч гүн Мөнх-Очирын уг эх. УТНС. ГБС./

САНГАРЖАЙ ИЛДЭН ХОШУУЧ. Түмэнхэн сайн ноёны наймдугаар хөвгүүн. "Шар тууж" ба "Асралт нэртийн түүх"-д Түмэнхэн сайд ноёны хөвгүүдийг жагсаан бичихдээ Сангаржай илдэн хошууч хэмээн арван нэгдүгээрт бичсэн байна. /Шара туджи. Монгольская летопись XVII века. Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шастиной. М-Л., 1957. Стр.88, Асрагч нэртийн түүх. Галиглаж, үгсийн хэлхээ үйлдсэн Ц.Шагдарсүрэн. И Сөн Гю. УБ., 2002. Тал 79/.

ДУГАР. Сангаржай илдэн хошуучийн хөвгүүн. Түүний үеэс Сайн ноён Шамбын хошуунд захирагдаж байв.

ШИРҮ ИЛДЭЧ. Дугарын хөвгүүн. 1696 онд Манжийн баруун замын их цэргийг дагалдаж, Галдан бошготыг дайлахад байлдаж яваад Туул хасагийн газарт шархджээ. Энх амгалан хаан түүнийг засаг тэргүүн зэрэг тайж өргөмжилж, тусгай хошуу байгуулснаар Сайн ноён аймгийн Зоригт засгийн хошууны үүсэл тавигджээ. 1724 он хүртэл Зоригт засгийн хошууны ноён байв. /Илтгэл шастир. 75-р дэвтэр/.

ЗАГДАБОДИ. Шир илдэчийн ахмад хөвгүүн. 1724 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1737 он хүртэл Сайн ноён аймгийн Зоригт засгийн хошууны ноён байв.

ЛУВСАНДОНДОВ. Загдабодийн ахмад хөвгүүн. 1737 онд тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1767 он хүртэл Зоригт засгийн хошууны ноён байсан бөгөөд өвчтэй болсон учир засгаас болиулжээ.

ГҮМБҮДОРЖ. Лувсандондовын ахмад хөвгүүн. 1767 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1769 онд Манжийн хааны Урамдалын авд явсан учир тогосын отго хадуулав. 1781 онд засаг хэргэмийг үе улиран тасралтгүй залгамжлуулахаар болгожээ. Тэрбээр 1802 он хүртэл Зоригт засгийн хошууны ноён байв.

Сампилдорж. Гүмбүдоржийн ахмад хөвгүүн, 1802 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрвээр 1844 он хүртэл зоригт засгийн хошууны ноён байв.

Бадар. Сампилдоржийн үеэл ач. 1844 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1844 он хүртэл зоригт засгийн хошууны ноён байв.

Гончигчойнжун. Бадарын 3-р хөвгүүн. 1897 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилж, зоригт засгийн хошууны ноён болжээ. 1911 онд Очирдара Богд гэгээнтнийг хаан ширээнд өргөмжилж, эрдэнийн сууринд залсан учир зарлигаар хишиг тараахад улсад туслагч гүнгийн зэрэг, үе улиран Зоригт цол шагнаан хүртээжээ. 1918 онд улсын санд мөнгө өргөсөн учир түшээ гүнгийн зэрэг, Тогосын отго, нэг нэмсэн зэрэг шагнаан хүртээжээ./Монгол улсын шаштир. УБ:1997. Тэргүүн боть. Тал 190/.

Хүүхэн Базар. Түмэнхэн сайн ноёны 9-р хөвгүүн. XVII зууны дундуур амьдарч байжээ. Базар буюу очир хэмээх цолтой. "Илтгэл шаштир"-т түүнийг Сайн ноён Түмэнхэний 12-р хөвгүүн гэжээ. "Асрагч нэртийн түүх" ба "Шар тууж" -д түүнийг Түмэнхэн хөндлөн цөхүрийн хөвгүүдийн 12-рт "Багаржа хүүхэн" гэж бичсэн байна. /Асрагч нэртийн түүх. Галиглаж, үсгийн хэлхээ үйлдсэн Ц.Шагдарсүрэн. И Сөн Гю. УБ., 2002. Тал 79, Шара Туджи. Монгольская летопись

XVII века. Сводный текст, перевод, введение и примечания Н.П. Шастиной. М-Л., 1957.стр.88/

Цэдэнцогт. Хүүхэн Базарын хөвгүүн. XVII зууны сүүл XVIII зууны эхэн үед амьдарч байжээ. Цогт хэмээх цолтой байжээ.

Зинамид. Цэдэнцогтын хөвгүүн Сайн ноён Шамбын хошуунд захирагдаж байжээ. 1709 онд засаг тэргүүн зэрэг тайж өргөмжлөгдөж, тусгай хошуу болжээ. 1715 онд Засагт Хан аймгийн Хотгойдын Бүүвэй бэйл Урианхайг дайлахаар одоход "Занимидын хошууны цэргийг дайтахад сайн" хэмээн явуулж байжээ. Тэрбээр Сайн Ноён аймгийн Эетэй засгийн хошууны ноёдын өвөг бөгөөд 1724 онд нас баржээ. /Итгэлт шастир. 76-р дэвтэр/. Эетэй засгийн хошуу буюу Халхын умар замын дундад умар этгээдийн хошуугаар хожим Архангай аймгийн Жаргалант сумыг байгуулжээ.

Тэгш. Зинамидын ахмад хөвгүүн. 1724 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1750 он хүртэл Эетэй засгийн хошууны ноён байв.

Убаш. Тэгшийн ахмад хөвгүүн. 1750 онд засгийн тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1781 онд зарлигаар үе улиран тасралтгүй залгамжлуулахаар болжээ. Тэрбээр 1788 он хүртэл Эетэй засгийн хошууны ноён байв.

Будцэсүрэн. Убашийн ахмад хөвгүүн. 1789 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1804 он хүртэл Эетэй засгийн хошууны ноён байв.

Омбодорж. Будцэсүрэнгийн төрсөн дүү. 1805 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1826 онд цэргийн хэрэглэлд тэмээ, морь тусалсан учир 4 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. Тэрбээр 1843 он хүртэл Эетэй засгийн ноён байв.

Галсандорж. Омбодоржийн гутгаар хөвгүүн. 1843 онд засгийн тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1850 он хүртэл Эетэй засгийн ноён байв.

Жанчивдорж. Омбодоржийн ахмад хөвгүүн 1851 онд засгийн тэргүүн тайж залгамжлаад мөн жилдээ нас баржээ.

Эриндорж. Галсандоржийн ач. 1852 онд засгийн тэргүүн тайж залгамжилсан. 1868 оноос хойш Булан Тохой хот байгуулах, цэргийн хэрэглэлд мөнгө, мал тусалсан учир 6 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. 1871 онд цэргийн хэрэглэлд мал тусалсан учир Тогосын отог хадуулав. Мөн оргодол Төгсийг хугацааны дотор бариулаагүй учир 2 тэмдэглэсэн зэрэг хасуулж, оргодол Очирыг барьсан учир 1 тэмдэг шагнуулж байв. 1889 онд Манжийн хааны хишиг тараахад 2 нэмсэн зэрэг олгуулжээ. Тэрбээр 1895 он хүртэл Эетэй засгийн хошуунд ноён байв./Монгол улсын шаштир. Тэргүүн боть. УБ:1997. тал 194/.

396.1 ДАЯНЖАЛБУУ. Элбэгдоржийн гуравдугаар хөвгүүн. 1895 онд Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэхэд мөнгө тусалсан учир 1 тэмдэглэсэн шагнуулж байсан. 1897 онд засаг тэргүүн тайж залгамжилж, Эетэй засгийн хошууны ноён болов. 1903 онд пүнлүүний мөнгө тусалсан учир 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг олгуулсан. 1911 онд Очирдара Богд гэгээнтнийг хаан ширээнд өргөмжилж, эрдэнийн сууринаа залсан учир зарлигаар тараахад тогосын отго, улсад туслагч гүн, үе улиран Эетэй цол шагнан хүртээжээ. 1916 он хүртэл хошуу ноён байв.

ХӨНДЛӨН БОШГОТ ГОМБО. Түмэнхэн сайн ноёны арван гуравдугаар хөвгүүн. Тус хошууны шаштирт тэмдэглэснээр "Энх амгалангийн тэргүүн онд /1662/Халхын баруун гарын Засагт хан Ванчигийг мөн аймгийн нэгэн засаг Лувсанринчин шоглож алсан учир зүүн аймгийг цэргийг авч байлдан тэднийг буруулав. Түшээт ханаас Гомбод цэргийн хэрэгт зүтгэсний учир Хурцбаатар алдар, Хөндлөн бошгот цол шагнав" гэжээ. /Илтгэл шаштир. 71-р дэвтэр/. Мөн энэ тухай Хөндлөн бошготоос Энх амгалан хаанд өргөсөн бичигт "энэ Сайн ноёны отгон хөвгүүн Далай чөөхүр төр шажинд тусалсаны тулд хүндлэн шагнан хичээнгүй хэмээн Бошгот хүндлэн

ноён цол өгөв. Элчийг хүндлэн өртөөний зэрэг юмыг зохихыг үзэн өгч, басхүү хүндэлбээс зохимуу хэмээн ухуулах бичиг харагчин тахиа жилийн есдүгээр сарын сайн өдөр Очирай сайн ханы Их сүмээс бичив" гэжээ/Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс. Боть III. Уб., 2010. Тал 147/. Дараа нь Гомбо хөндлөн бошгот 1686 онд Хүрэнбэлчирийн чуулганаар засаг өргөмжлөгджээ. 1688 онд Зүүнгарын Галдан бошгот Халхад довтолсон учир харъяат ардыг авч, 1690 онд Галдангийн цэрэгт гүйцэгдэн тулалдсан боловч ялагдаад Арнайн удирдсан Манжийн цэргийн өмгөөлөлд оржээ. 1691 онд Гомбо хөндлөн Долоннуурын чуулганаар засаг төрийн жүн ван өргөмжлөгдөв. Тэрбээр Сайн ноён аймгийн Далай чойнхор вангийн хошууны ноёдын өвөг бөгөөд 1708 онд нас баржээ. Далай чойнхор вангийн хошуу буюу Халхын умар замын дундад дахь зүүн этгээдийн хошуу нь одоогийн Архангай аймгийн Хангай, Тариат, Цахир, Завхан аймгийн Их-Уул, Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр, Жаргалант, Галт сумын нутаг болно.

РИНЧИН. Гомбын ахмад хөвгүүн. 1708-1711 онд Сайн ноён аймгийн Далай Чойнхор засгийн хошууны ноён байв. Энх амгалан хааны буулгасан зарлигт "Бэйл Ринчин Халхын дотор үе дээд бөгөөд хүмүн маш хүндтэй, үнэнч шударгуу" /Илтгэл шастир. 61-р дэвтэр/ гэж тэмдэглэжээ. Ринчин өөрийн эцэг Гомбын хамт 1696 онд Галдан бошготын эсрэг Зуунмодны тулалдаанд оролцож явжээ.

Ринчин 9 хөвгүүн, 1 охинтой. "Түүний ахмад хөвгүүн Чойжамц, гуравдугаар хөвгүүн, Лхамжав, Ламжавын хөвгүүн Товжав, түүний хөвгүүн Ядам тайж, түүний хөвгүүн Дорж тайж, түүний хөвгүүн Түмэн тайж, түүний хөвгүүн Ёндон тайж, түүний хөвгүүн Луузан тайж, түүний хөвгүүн Галсан тайж, түүний хөвгүүн Цэрэнпил тайж, түүний хөвгүүн Шагдаржав тайж" гэх мэтээр Богд хаант Монгол улсын үе хүртэл тус хошууны ноёдын угийн бичигт тодорхой тэмдэглэсэн буй/ МУТНС.ГБС. Далай чойнхор вангийн хошууны тайж нарын гэрийн үеийн бичмэл/. Ринчин өөрийн залгамжлагч хөвгүүн Чойжамцыг дэргэдээ авч үлдээд бусад 8 хөвгүүддээ өмч хөрөнгө, хамжлагаа хувааж өгөөд Идэр, Чулуутын бэлчирт нутаг олгож суулгаснаас тус хошууны Зүүн сумын олон тайж нар бүхий 4 баг үүссэн ажээ.

ЧОЙМСАЛ. Ринчингийн ахмад хөвгүүн. 1711-1724 онд Далай чойнхор засгийн хошууны ноён байв. Чойжамц хошууны цэргийг авч Энх амгалангийн 56-р онд буюу 1717 онд Зүүнгарын цэрэгтэй Алтай уулын чанадад байлдаж явжээ /Илтгэл шастир 71-дэвтэр/

НАМЖИЛЦЭСРЭН. Чоймсалын ахмад хөвгүүн. 1724-1760 онд Далай чойнхор засгийн хошууг 35 жил захирсан ноён байв. Тэрбээр 1731, 1732, 1753 онд хошууны цэргийг авч Хэрсэн чулуу, Аж богд, Ил

Тарвагатай зэрэг газарт Зүүнгарын эсрэг байлдаж, Завхан цагаан толгой, Галбын говь зэрэг газруудад сэргийлэн хамгаалах цэргийг захирч явжээ. Намжилцэсрэн нь ахмад хөвгүүн Ванжилдорж, гутгаар хөвгүүн Чимиддорж зэрэг хэдэн хөвгүүнтэй байснаас Чимиддоржийг засаг бэйлийн хэргэмээ залгамжлуулахаар Манжийн хаанд мэдүүлж, Жургааны яаманд тэмдэглүүлжээ. /Илтгэл шастир. 71-р дэвтэр./

ЧИМИДДОРЖ. Намжилцэсрэнгийн гуравдугаар хөвгүүн. 1760-1790 онд Далай чойнхор засгийн хошууны ноён байв. Тэрбээр 1762 онд Манжийн хааныг дагалдаж, Урамдлын авд оролцож, хоёр нүдтэй тогосын отго шагнуулж, Сайн ноён аймгийн цэргийн туслагч жанжины тушаал хүлээж явав. Бэйл Чимиддорж хошуунаасаа хөрөнгө гаргаж, 1762 онд II Зая бандид хутагт Лувсаншиндэлэгнамжилд 1962 онд том хэмжээний дуганыг бариулж өгчээ. 1781 онд Манжийн хааны буулгасан зарлигт, "Чимиддоржийн өвөг Гомбо халхын хуучин засаг. Анх жүн вангийн хэргэм шагнажээ. Эдүгээ дөрвөн үе болсон тулд түүнд хишиг хүртээж үе улиран тасралтгүй залгамжлуул " /Илтгэл шастир, 71-р дэвтэр/гэжээ.

ДЭЛЭГПУНЦАГ. Чимиддоржийн хөвгүүн. 1790-1817 онд Далай чойнхор засгийн хошууны ноён байв. Тус хошууны тамгын газраас 1793 оны өвлийн сүүл сарын 17-ны өдөр дээш өргөсөн бичигт, "Манай хошууны засаг бэйл Чимиддорж өвчнөөр үгүй болов. Түүнээс амид ахуйдаа зэрэг хэргэмээ залгуулахаар батлан мэдүүлсэн ахмад хөвгүүн. Дэлэгпунцагийг жүн вангийн зэрэг засаг төрийн бэйл залгамжлуулъя " хэмээжээ /МУУТА. ФМ-1, Д-1, ХН-1528/. Дэлэгпунцаг 1793 онд аймгийн туслагч жанжны хэбэй, 1801 онд аймгийн дэд чуулган дарга, 1816 онд аймгийн туслагч жанжны тушаалд хавсран ажиллаж байжээ.

ГОНЧИГЖАВ. Дэлэгпунцагийн ахмад хөвгүүн. 1785 онд төрсөн. 1794 онд эцэг Дэлэгпунцагийн хэргэм зэргийг залгамжлахаар батлан тэмдэглүүлж, тэргүүн зэрэг тайж болсон. 1817 онд Бэйжинд Манжийн хаанд бараалхаж, засаг жүн вангийн хэргэм залгамжилж, урамдлын авд оролцжээ. 1817-1845 онд Далай чойнхор засгийн хошууны ноён байв. Тэрбээр 1818 оноос аймгийн туслагч жанжны хэбэй, 1828 оноос аймгийн чуулганы дэд дарга, 1831 оноос чуулганы жинхэнэ дарга байгаад 1846 онд нас баржээ.

ГЭМПИЛДОРЖ. Гончигжавын ахмад хөвгүүн. 1821 онд төрсөн. 1827 онд эцгийн хэргэмийг залгамжлах агь ноён, тэргүүн зэрэг тайж болсон. 1845-1875 онд Далай чойнхор засгийн хошууны ноён байв. Гэмпилдорж 1849 онд сайн ноён аймгийн чуулганы дэд дарга, 1852 онд жинхэнэ чуулганы дарга, 1866 онд Улиастайн хэбэй амбан

болжээ. Гэмпилдорж 1864-1867 онд Манжийн цэргийн хэрэгцээнд бие мөнгө 7800, агт морь 2144, шар үхэр 100, эр хонь 1000-ыг туслан барьж, шадарт явах, 3 нүдтэй тогосын отго, жүн вангийн зэргийг үе улиран тасралтгүй залгамжлахаар шагнуулж байсан баримт буй. Улмаар 1867-1870 онд шар үхэр 275, эр хонь 780, цай 100 хунз, будаа 3600 жин, 6105 лан мөнгө тусалж, жүн вангийн хэргэм шагнуулж явжээ /МУҮТА. М-62, Д-1, ХН-11/. 1873 онд VIII Богд Жибзундамба хутагтыг залж ирэх албанд томлигдсон боловч нас өтөлж, бие сульдсан хэмээх шалтаглаж яваагүй учир Манжийн хаан түүний жүн вангийн хэргэмийг эвдэж, засаг төрийн бэйл болгожээ. Тэрбээр 1881 оноос чуулганы дэд дарга, 1883 оноос аймгийн туслагч жанжны тушаалд томилогдож, уг албыг сайн хаасан болон 1882-1894 онд Улиастайн цайз хэрмийг сэлбэн засахад 23042 лан мөнгө тусласан учир чин вангийн хэргэм шагнуулжээ. 1894 онд нас баржээ.

ЦЭДЭНСОНОМ. Гэмпилдоржийн төрлийн хөвгүүн. Гэмпилдорж төрсөн хүүгүй учир өөрийн ойр төрлийн Очир жонон тайжийнхаас үеэл хөвгүүн Цэдэнсономыг үрчлэн авч зэрэг хэргэмээ залгамжлуулжээ. Цэдэнсоном 1894 онд Далай чойнхор засгийн хошууны ноён болжээ. Тэрбээр 1902 онд Улиастайн манж сайдын хувийн сайдад тохоогдож, 1905 онд цэргийн хэрэглэлд 5000 лан мөнгө тусалсан учир жүн вангийн хэргэм шагнагджээ. 1911 онд

Монгол улсын тусгаар тогтнолыг сэргээж, VIII Богд Жибзундамба хутагтыг хаанд өргөмжлөх их ёслолд Цэдэнсоном биеэр оролцож, үе улирах чин вангийн зэрэг, засаг төрийн жүн ван, Далай чойнхор цол, хүрэн жолоо шагнагджээ. 1916 онд Богдын ордон барихад 1000 лан мөнгө, улсын цэргийн хэрэглэлд 50410 лан мөнгө тусалсан учир чин вангийн хэргэм, улбар шар жолоо шагнаж, Гадаад явдлын яамны дэд сайдын тушаалд томилогджээ. Ардын хувьсгалын дараа 1921-1924 онд Цэцэрлэг мандал уулын аймгийн Чандмана өлзийт уулын хошууны засаг даргын тушаал хүлээж явав. 1923 оны тус хошууны ардын төлөөлөгчдийн 3-р их хурлаас гарсан тогтоолд "Эдүгээгийн засаг Далай чойнхор чин ван болвоос бичиг үсэг төсөөлөх тул хошууны засаг даргаар баталсугай" /МУҮТА. АФ-164,

Д-1, ХН-24/гэжээ.

ДУГАРЖАВ. Хөндлөн бошгот засаг Гомбын хөвгүүн. Дайчин ахай хэмээх цолтой. XVII зууны сүүлч XVIII зууны эхээр амьдарч байсан язгууртан бөгөөд засаг жүн ван Гомбын хошуунд захирагдаж байжээ. 184-р тал

РАВДАН. Дугаржав дайчин ахайн хөвгүүн. Бинт тайж хэмээх цолтой. X[^]Ш зууны хээр амьдарч байсан. Мөн засаг Жүн ван Гомбын

хошуунд тусгай тайж нарын багийг ахалж байжээ.

АМСАЛ. Равдан Бинт тайжмйн хөвгүүн. Түүний нэрийг "Илтгэл шастир"-т Эмгэн хэмээн бичжээ. Тус хошууны ноёд, тайж нарын гэрийн үеийн бичмэлүүдэд, түүнийг Амсал хэмээн бичжээ. Амсал угтаа бэйл хошууны Чойжамцын хошууны хэргийг туслан шийтгэгч сайд байжээ. 1720 онд Манжийн их цэргийг дагалдаж, Булганы орчмоос Зүүнгарыг дайлахад оролцжээ. 1731 онд Сүх алдах, 1732 онд Хэрсэн чулууны газарт эфү Цэрэнг дагалдаж, Зүүнгарын цэрэгтэй сайн байлдаж, шархдсан учир мөнгө, торго, тогосын отгоор шагнуулжээ. 1737 онд тэрбээр Манжийн хааны зарлигаар Зүүнгарын хаан Галданцэрэнг хилийн хэлэлцээр хийхийг ухуулахаар хэдэнтээ элчээр явж байжээ. Тиймээс 1738 онд эфү Цэрэнг дагаж, Тэнгэрийн тэтгэсэн хаанд бараалхсаны дараа засаг тэргүүн зэрэг тайж өргөмжилж, Цянь чин минд явуулав. Чингэж Сайн ноён аймгийн Баатар засгийн хошууны үүсэл тавигджээ. Амсал 1757 онд нас барав. \Илтгэл шастир, 76-р дэвтэр\.

Баатар засгийн хошуу буюу Халхын умар замын баруун этгээдийн адгийн хошуу нь одоогийн Завхан аймгийн Булнай (Тосонцэнгэл) сумын нутаг юм.

ДАШ. Амсалын ахмад хөвгүүн. Угтаа туслагч тайж байсан бөгөөд Урамдалын авд явж, тогосын отго, шар олбог шагнуулж, Цянь чин минд явжээ. 1753 онд Дөрвөдийн тайж Цэрэнг нэхсэн цэргийг угтаж байлдсан ба дараа жил нь бэйс Чамчугжавын хамт

Урианхайн зайсан цэдэг, Зүүнгарын зайсан хөгшин Мамуд нарыг барьжээ. 1755 онд Манжийн их цэрэг Даваачийг дайлахад өөрийн хошууны цэргүүдийг захирч хүчин зүтгэжээ. 1756-1757 онд тэрбээр ван Цэвдэнжавыг дагалдаж, Урианхай, Зүүнгарын босогчдыг дарахад идэвхтэй байлдаж, хүчин зүтгэсэн учир засаг тэргүүн зэрэг тайж, улмаар гүнгийн зэрэг шагнуулжээ. Тэрбээр 1760 он хүртэл Баатар засгийн хошууны ноён байв. \Илтгэл шастир. 76-р дэвтэр\

БАНДИ. Дашийн ахмад хөвгүн. 1760 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. 1781 онд түүний засаг хэргэмийг үе улиран тасралтгүй 185-р тал залгамжлуулахаар болжээ. Тэрбээр 1790 он хүртэл Баатар засгийн хошууны ноён байв.

ДАМИРАН. Бандийн ахмад хөвгүүн. 1790 онд засаг тэргүүн тайж залгамжилсан. Тэрбээр 1819 он хүртэл Баатар засгийн хошууны ноён байв.

ХАСБАЗАР. Дамирангийн ахмад хөвгүүн. 1819 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1828 он хүртэл Баатар засгийн хошууны ноён байв.

БҮНТЭР. Хасбазарын ахмад хөвгүүн. 1840 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Тэрбээр 1865 он хүртэл Баатар засгийн

хошууны ноён байв.

ЧИМИДДОРЖ. Бүнтэрийн ахмад хөвгүүн. 1865 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан. Баатар засгийн хошууны ноён болоод 2 жилийн дараа нас баржээ.

ЖАМСРАНЖАВ. Бүнтэрийн гуравдугаар хөвгүүн. 1867 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилжээ. Булантахойн хот байгуулахад мөнгө тусалсан учир 1 нэмсэн зэрэг, 1871,1872 онд цэргийн хэрэглэлд мал тусалсан учир тогосын отго, 3 тэмдэглэсэн зэрэг олгуулжээ. 1778 онд хэргийн учир 2 тэмдэглэсэн зэрэг хасуулж 1793 онд хишиг тараахад 2 нэмсэн зэрэг шагнуулжээ. 1895-1899 онд Жибзундамба хутагтын түлэгдсэн сүмийг шинэтгэх ба Улиастай хотыг засахад мөнгө тусалсан учир улсын түшээ гүнгийн зэрэг, 1 нэмсэн, 4 тэмдэглэсэн зэрэг хүртжээ. 1903 онд пүнлүүний мөнгө ба цэргийн хэрэглэлд мөнгө тусалсан учир харавтар улаан жолоо, 1 нэмсэн, 1 тэмдэглэсэн зэрэг шагнажээ. 1905 он хүртэл Баатат засгийн хошууны ноён байв. \Монгол улсын шастир. УБ.,1997. Тэргүүн боть, Тал 189\

БАХАРАЙ ХОШУУЧ. Онохуй үйзэн ноёны дөтгөөр хөвгүүн. Халхын Цогт хунтайжийн эцэг, "Шар тууж" -д түүнийг " Онохуй үйзэн ноёны хатан гавьяанд 2 зэрэг нэмжээ. 1839 онд Цянь чин минд явав. Тэрбээр 1862 он хүртэл Эрх түшээт засгийн хошууны ноён байв.

Нь Хилуетийн Эцэнхэн зоригт хатнаас төрсөн...Бахарай хошууч ноён модон үхэртэй" гэж бичжээ.Шара туджи.Монгольская летопись XVII века. Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шастиной, М-Л, 1957.стр.111/ Эндээс үзвэл, тэрбээр 1565 онд төрсөн ажээ.

ТҮМЭНХЭН ЦОГТ ХУНТАЙЖ. Барай хошуучийн хөвгүүн. XVII зууны эхэн үеийн Халхын улс төр, шашин,соёлын зүтгэлтэн. Тэрбээр 1581 онд Халхын Гэрсэнз жалайр хунтайжийн хөвгүүн Бахарай хошуучийн гэрт төржээ. "Асрагч нэртийн түүх"-нд "Ноонох үйзэн ноёны 5-р хөвгүүн Бахарай хошуучийн хөвгүүн Түмэнхэн Цогт хунтайж" /Асрагч нэртийн түүх, Галиглаж, үгийн хэлхээг үйлдсэн Ц.Шагдарсүрэн, И.Сон Гю.УБ, 2002.Тал.85/"Шар тууж"-д "Бахарай хошууч баатарын хатан нь Онниудын Бэрхийн охин Тайху хатнаас төрсөн Цуругул Цогт төмөр могойтой" / Шара туджи.Монгольская летопись XVII века. Сводный текст, перевод, введение и примечания Н.П.Шастиной, М-Л, 1957.стр.117/ гэж бичжээ.Тэрбээр Түшээт ханы дотор өөрийн хувь албат,эзэмшил бүхий Халхын зүүнгарт нэлээн нэр нөлөө бүхий баян байжээ.^И зууны эхэн үед өөрийн эх Мадай Тайгал хатны хамт сүм хийд байгуулах, судар шастир орчуулах зэргээр бурхны шашны улааны урсгалыг

дэлгэрүүлэхэд хүчин зүтгэж байв.Цогт тайж өөрийн улс төр, шашны үзэл баримтлалаас шалтгаалж, 1634 онд Халхаас өөрийн албатыг авч Хөхнуурт очсон бөгөөд тэндэхийн түмэн Холочийн ноёныг эрхшээлдээ оруулж Түвдийн улааны шашныхантай холбоо тогтоож, "Хөхнуурын Цогт хаан" хэмээн алдаршсан байна.Гэвч 1637 онд Түвдийн шарын шашны холбоотон Гүүш хаан тэргүүтэй Зүүнгарын цэргийн хамтарсан хүчинд цохигдож, Цогт өөрөө амь үрэгджээ.

ГАРМА ЗҮГИЙН ЗААН.Цогт хунтайжийн хөвгүүн. "Асрагч нэртийн түүх" -нд түүнийг "Цогт хунтайжийн үйлдсэн Ц.Шагдарсүрэн, И Сөн Гю,УБ.,2002.Тал 80/.

СУТАЙ ИЛДЭН.Цогт тайжийн ач хөвгүүн.Угтаа Түшээт ханы харьяат бөгөөд Бурхантайн газарт нутаглаж байв. 1688 онд Манжид дагахад Өвөр Монголын Дөрвөнхүүхэд аймгийн нутагт нутаглуулжээ.1691 онд Долоннуурын чуулганаар засаг улсын түшээ гүн өргөмжлөгдөж,Халхын Сайн ноён аймгийн бүрэлдэхүүнд орж захирагджээ.1696 онд өөрийн хошууны тайж Цэмбэлийг зарж, Галдан бошготын мөшгүүлж, Манжийн сайд Виянгуд мэдээлжээ. Тэрбээр Сайн ноён аймгийн Илдэн засгийн хошууны ноёдын өвөг юм./Итгэл шастир. 72-р дэвтэр /.1703 он хүртэл Илдэн засгийн хошууны ноён байв.Тус хошуу нь Манжийн үед Халхын умард замын дундад дахь өмнөд хошуу нэртэй байгаад хожим засаг захиргааны өөрчлөлтөөр Архангай аймгийн Хотонт сумын өмнөд хэсэг, Өвөрхангай аймгийн Хужирт сумын баруун хойт, Өвөрхангай аймгийн Зүйл сумын нутгийг бүрдүүлжээ.

ХОНГОР.Сутай илдэний ахмад хөвгүүн.1703 онд зэрэг бууруулж, засаг тэргүүн зэрэг тайж залгамжилжээ.1706 он хүртэл Сайн ноён аймгийн Илдэн засгийн хошууны ноён байв.

АНУРИ.Хонгорын ахмад хөвгүүн.1706 онд засаг тэргүүн зэрэг тайж залгамжилсан.1710 онд Манжийн Энх-Амгалан хаан Ануриг жил бүр бараалхан ирж, үнэн санааг үзүүлэв хэмээн улсад туслагч гүн өргөмжилжээ.1731 онд Зүүнгарын цэрэг Халхад уулгалахад Анури бие өвчтэй хэдий ч цэрэг илгээж, өртөөнд амуу түгээж зүтгэсэн учир хошууны бэйс өргөмжилжээ.1733 онд Сайн ноён аймгийн туслагч жанжны хэргийг хамааруулав.1735 онд цэргийн хэрэгт зүтгэж байгаад өвчин нь хүндэрсэн учир нутагтаа буцаад 1737 онд нас барав. /Илтгэл шастир. 72-р дэвтэр /.

ДОРЖВАНЧИГ. Анурийн ахмад хөвгүүн.1737 онд засаг хошууны бэйс залгамжилсан.Тэрбээр 1750 он хүртэл Илдэн засгийн хошууны ноён байв.

ЛУВСАНЦЭРЭН. Доржванчигийг ахмад хөвгүүн.1750 онд засаг хошууны бэйс залгамжилсан.1755 онд Манжийн их цэрэг Зүүнгарыг

Даваачийг дайлахад тэрбээр туслагч тайж Гүмүжав, Дэмчи, Дашжав нарын хамт улаан ус, Үрүмчийн өртөөний хэргийг захиран шийтгэж байв. Тэр үед Хойдын Амарсанаа бослого гаргаж, өртөөг уулгалахад Лувсанцэрэн уг байлдаанд нас баржээ. Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигт "бэйс Лувсанцэрэн улсын тул байлдаж үхсэн нь хөөрхий бөгөөд түүний хөвгүүн тайж Дэмчигжав эдүгээ бас цэргийн өртөө залгалдуулах хэргийг шийтгэжүхүй. Үүнд бас хишиг хүртээж бэйсийн язгуурын хэргэмээс дэвшүүлж бэйл өргөмжлөөд Дэмчигжавт залгамжилуулагтун" гэжээ/Илтгэл шастир. 72-р дэвтэр/

ДЭМЧИГЖАВ. Лувсанцэрэнгийн ахмад хөвгүүн. 1756 онд засаг төрийн бэйл залгамжилсан. Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигт "Дэмчигжавын эцэг Лувсанцэрэнгийн улсын хэрэгт үгүй болсон бөгөөд Дэмчигжав бас өртөө залгалдуулж гавъяа буй агсаны тулд хишиг хүртээж, бэйсээс дэвшүүлж бэйл залгамжлуулав. үүнийг басхүү хишиг хүртээж үе улиран тасралтгүй залгамжлуулагтун " гэжээ/Илтгэл шастир. 72-р дэвтэр/. Мөн онд Урамдалын авд явж, 2 нүдний тогосын отго хадуулжээ. Тэрбээр 1790 он хүртэл Илдэн засгийн хошууны ноён байв.

ГОМБОЦЭРЭН. Дэмчигжавын ахмад хөвгүүн. 1790 онд засаг төрийн бэйл залгамжилсан. 1801 онд Сайн ноён аймгийн туслагч жанжнаар томилогдон ажиллаж байв. Тэрбээр 1816 он хүртэл Илдэн засгийн хошууны ноён байв.

ПУНЦАГДОРЖ. Гомбоцэрэнгийн ахмад хөвгүүн. Урьд Урамдалын авд явж, тогосын отго хадуулжээ. 1816 онд засаг төрийн бэйлийн хэргэм залгамжилсан. Тэрбээр цэргийн хэрэглэлд тэмээ тусалдаг учир 12 тэмдэглэсэн зэрэг, үржүүлэх тэмээний хэргийг сайн захирсан учир хоёр тэмдэглэсэн зэрэг шагнуулжээ. 1831 онд туслагч жанжны хэбэй, улмаар туслагч жанжнаар томилогдон ажиллажээ. 1835 олон хүртэл Илдэн засгийн хошууны ноён байв. / Илтгэл шастир. 72-р дэвтэр/

НАМЖИЛДОРЖ. Пунцагдоржийн ахмад хөвгүүн. 1835 онд засаг төрийн бэйл залгамжилсан. Тэрбээр үржүүлэх тэмээний хэргийг захирч байсан бөгөөд удаа дараа 4 тэмдэглэсэн зэргээр шагнуулжээ. 1842 оноос аймгийн туслагч жанжны хэбэйн тушаалд ажиллаж байжээ. Тэрбээр 1845 он хүртэл Илдэн засгийн хошууны ноён байв.

ШИРБАЗАРЖАВ. Намжилдоржын ахмад хөвгүүн. 1845 онд засаг төрийн бэйлийн хэргэм залгамжилсан. 1857, 1859 онд 1865, 1866 онд цэргийн хэрэглэлт мөнгө, морь тусалсан учир хоёр нэмсэн, дөрөв тэмдэглэсэн зэрэг олгуулж, тогосын отго хадуулжээ. 1868 онд Сайн ноён аймгийн туслагч жанжны хэбэй болов. Мөн

Булантохойн хот байгуулахад мөнгө тусалсан учир харавтар улаан жолоо, цэргийн хэрэгт мал тусалсан учир хоёр нүдний тогосын отго, хоёр нэмсэн, хоёр тэмдэглэсэн зэрэг шагнал хүртээжээ. 1869 онд аймгийн дэд чуулганы даргаар тавигдаж, Цянь чин мэнд явжээ. 1871 онд аймгийн жинхэнэ чуулганы даргын тушаалд томилогдов. 1876 онд Манжийн их цэргийг хязгаарт сайн өнгөрүүлсэн хэмээн жүн вангийн зэрэг хүртжээ. \Илтгэл шастир. 72-р дэвтэр \

САЙН НОЁН ХАН АЙМГИЙН ХОШУУДЫН ЗАСАГ НОЁДЫГ ХҮСНЭГТЛЭН ҮЗҮҮЛБЭЭС

Судани	Тэргүүн зэрэг тайж	1697-1700	36	Лувсан-Эрдэнийн хүү
Сэрванчин	-----“”-----	1700-1723	39	Суданийн хүү
Цэвдэн	-----“”-----	1723-1732	1	Сэрванчиний хүү
Лайчунжав	-----“”-----	1733-1759	11	Цэвдэнгийн хүү
Наваанцэрэн	-----“”-----	1759-1783	24	Лайчунжавын хүү
Гунгаарааш	-----“”-----	1784-1801	49	Наваанцэрэнгийн хүү
Гончигжав	-----“”-----	1801-1847	6	Гунгаараашийн хүү
Цэдэнбалжаа	-----“”-----	1847-1887	27	Гончигжавийн өргөсөн хүү
Ёндондорж	Түшээ гүн	1883-1887		Цэдэнбалжаагийн хүү
Цэрэндорж	-----“”-----	1887-1923	13	Ёндондоржийн хүү
Ядам	Тэргүүн зэрэг тайж	1686-1709	35	Түмэнхэний үеэл ач
Даржаа	-----“”-----	1709-1727	48	
Цэвээнжав	-----“”-----	1728-1734	6	Даржаагийн хүү
Ринчин	-----“”-----	1734-1763	12	Цэвээнжавын хүү
Балсанминжүүр	-----“”-----	1764-1794	29	Ринчингийн хүү
Базар	-----“”-----	1794-1850	59	Балсанминжүүрийн хүү
Тогмид	-----“”-----	1851-1889	1	Базарын хүү
Сэд-Очир	-----“”-----	1889-1907	15	Тогмидын хүү
Довчинжамц	-----“”-----	1907-1923	33	Сэд-Очирын хүү
Эмгэн	Засаг тайж	1738-1756	3	
Даш	-----“”-----	1757-1760	22	Эмгэний ахмад хүү
Банди	-----“”-----	1760-1789	25	Дашийн ахмад хүү
Дамиран	-----“”-----	1790-1818	55	Бандийн ахмад хүү
Хасбазар	-----“”-----	1819-1840	24	Дамирангийн хүү
Бумдарь	-----“”-----	1840-1865	20	Хасбазарын хүү
Чимэддорж	-----“”-----	1865-1867	4	Бумдарийн ахмад хүү
Жамсранжав	-----“”-----	1867-1906	6	Бумдарийн 3-р хүү
Бирваарагчаа	-----“”-----	1906-1923	32	Жамсранжавын ахмад хүү

Равдан	Тэргүүн зэрэг тайж			
Цэрэнванбуу	-----“”-----	1708-1728	42	Равданы ахмад хүү
Сэвдэнванбуу	-----“”-----	1730-1748	8	Равданы дэд хүү
Пунцаг	Тэргүүн зэрэг бэйс	1748-1778	12	Сэвдэнванбуугийн хүү
Намжил	-----“”-----	1778-1788	43	Пунцагийн ахмад хүү
Цэрэндорж	-----“”-----	1788-1791	53	Намжилын ахмад хүү
Пунцаг	-----“”-----	1791-1815	56	Цэрэндоржийн өвөг
Доржбал	-----“”-----	1815-1816	20	Пунцагын хүү
Чагдаржил	-----“”-----	1817-1878	22	Пунцагын үеэл ач
Дагдандорж	-----“”-----	1899-1903	25	
Сандагдорж	-----“”-----	1907-1918	33	Дагдандоржийн хүү
Бадамгарав	-----“”-----	1918-1923	8	Сандагдоржийн хүү
Гүмбү	Засаг тайж	1686-1708	30	Түмэнхэний отгон хүү
Ринчен	Бэйл	1708-1741	47	Гүмбийн ахмад хүү
Чойжамц	-----“”-----	1711-1724	50	Ринчений ахмад хүү
Намжил-чисүрэн	-----“”-----	1724-1760	2	Чойжамцын ахмад хүү
Чимэддорж	-----“”-----	1760-1790	25	Намжилсүрэнгийн хүү
Дэлэгдунцаг	-----“”-----	1790-1817	55	Чимэддоржийн хүү
Гончигжав	-----“”-----	1817-1845	22	Дэлэгпунцагын хүү
Гэмпилдорж	-----“”-----	1845-1894	25	Гончигжавын хүү
Цэдэнсоном	-----“”-----	1894-1922	20	Гэмпилдоржийн үрчилж авсан хүү
Цэвдэнжав	Жүн ван	1752-1781	17	Цэрэнгийн ахмад хүү
Сампилдорж	-----“”-----	1782-1806	47	Цэвдэнжавын хүү
Дамиранжав	-----“”-----	1807-1815	12	Сампилдоржийн хүү
Чогсомжав	-----“”-----	1815-1830	20	Дамранжавын хүү

Цэрэнгомбо	-----“”-----	1831-1836	11	Дамиранжавын 3-р хүү
Дармаабазар	-----“”-----	1837-1852	17	Цэрэнгомбын 3-р хүү
Сангашир	-----“”-----	1854-1883	4	Дарамбазарын дүү
Цэрэндорж	-----“”-----	1883-1892	8	Сангаширын хүү
Гүргүмжав	-----“”-----	1893-1917	19	Цэрэндоржийн дүү
Соронзон-гомбо	-----“”-----	1918-1922		Гүргүмжавын 2-р хүү
Дорж	Тэргүүн зэрэг тайж	1712-1725	51	Засаг Жамбын үеэл дүү
Ням	Түшээ гүн	1725-1731	3	Доржийн ахмад хүү
Абуу	-----“”-----	1732-1753	10	Нямын ахмад хүү
Цэрэнпил	-----“”-----	1753-1760	18	Доржийн 2-р хүү
Цэнгүнжав	Тэргүүн зэрэг тайж	1760-1784	25	Цэрэнпилийн ахмад хүү
Дэмчиг	-----“”-----	1785-1801	50	Цэнгүнжавын хүү
Цэдэндаш	-----“”-----	1801-1820	6	Дэмчигийн 2-р хүү
Санжжав	-----“”-----	1820-1831	25	Цэдэндашийн дүү
Цэрэн	-----“”-----	1831-1832	11	Санжжавын ахмад хүү
Буянжаргал	-----“”-----	1832-1871	12	Цэрэнгийн төрсөн дүү
Манибал	-----“”-----	1872-1894	11	Буянжаргалын хүү
Чимэдбалжин	-----“”-----	1894-1912	20	Буянжаргалын 2-р хүү
Балибуу	-----“”-----	1913-1923	3	Чимэдбалжингийн хүү
Данзан-Эрдэнэ	Тэргүүн зэрэг тайж	1691	30	
Ширжав	-----“”-----	1712	51	Данжин-Эрдэнийн хүү
Манзушир	-----“”-----	1723	6	Ширжавын ахмад хүү
Чоймбол	-----“”-----	1731	9	Манзуширын хүү
Довдоннамжил	-----“”-----	1755	20	Чоймболын ахмад хүү
Доржчаваг	-----“”-----	1765	30	Чоймболын дэд хүү
Сономгомбо	-----“”-----	1775	40	Доржчавагийн хүү

Лувсандаш	-----“”-----	1789	54	Сономгомбын дүү
Дамиранжав	-----“”-----	1816	21	Лувсандашийн хүү
Авирмэд	Тэргүүн гүнг зэрэг	1833	13	Дамиранжавын үеэл хүү
Балдан	-----“”-----	1885	11	Авирмэдийн хүү
Цүлтэм	-----“”-----	1912	2	Балдангийн 3-р хүү
Ширбазар	Тэргүүн гүнгийн зэрэг тайж	1920		Цүлтэм бэйсийг цагаантанд алагдсаны дараа засаг ноён.
Ваанчиг	Туслагч гүн	1691-1723	30	Шамбын үеэл
Жамц	-----“”-----	1723-1745	1	Ваанчигын ахмад хүү
Батмөнх	-----“”-----	1745-1755	10	Жамцын ахмад хүү
Дамбажанцан	-----“”-----	1756-1790	21	Батмөнхийн хүү
Лувсандорж	-----“”-----	1790-1797	55	Дамбажанцангийн хүү
Цэвээнжав	-----“”-----	1798-1807	3	Лувсандоржийн хүү
Жамсранжав	-----“”-----	1807-1858	12	Цэвээнжавын төрөл
Равдандорж	-----“”-----	1858-1881	8	Жамсранжавын ач хүү
Сономдаш	-----“”-----	1881-1897	7	Равдандоржийн хүү
Пүрэвжав	-----“”-----	1897-1923	25	Содномдашийн хүү
Шүр илдүчи	Тэргүүн зэрэг тайж	1696-1724	35	Шамбын хаяал хүү
Загдбоди	-----“”-----	1724-1736	2	Шүр илдүчийн хүү
Лувсандондов	-----“”-----	1737-1766	2	Загдбогдын ахмад хүү
Гүмбүдорж	-----“”-----	1767-1801	32	Лувсандондовын хүү
Сампилдорж	-----“”-----	1802-1844	7	Гомбодоржийн хүү
Бадар	-----“”-----	1844-1897	24	Сампилдоржийн ач
Гонцгигчойнжон	-----“”-----	1897-1923	23	Бадаын 3-р хүү

Содай илдэн	Түшээ гүн	1691-1703	30	Шамбын төрлийн дүү
Гонгор	Тэргүүн зэрэг тайж	1703-1706	42	Содай илдэнгийн хүү
Анури	Туслагч гүн	1706-1737	45	Гонгорын хүү
Доржваанчиг	Бэйс	1737-1750	2	Анурын хүү
Лувсанцэрэн	-----“”-----	1750-1756	15	Доржваанчигын хүү
Дэмчигжав	-----“”-----	1756-1790	21	Лувсанцэрэнгийн хүү
Гүмбүцэрэн	-----“”-----	1790-1816	55	Дэмчигжавын хүү
Пунцагдорж	-----“”-----	1816-1835	21	
Намжилдорж	-----“”-----	1835-1845	15	
Шаравжиржав	-----“”-----	1845-1877	25	
Ринченжунай	-----“”-----	1877-1886	3	
Дондовжанцан	-----“”-----	1887-1915	13	
Норовжанцан	Бэйл, жүн жав	1915-1923	5	
Арьяа	Тэргүүн тайж	1692-1715	31	Буниагмийн ахмад хүү
Гимпил	-----“”-----	1715-1748	54	Аьяагийн ахмад хүү
Гунгаадондон	Тэргүүн түшээ гүн	1749-1770	14	Гимпилийн ахмад хүү
Дансран	-----“”-----	1770-1782	35	Гунгаадондонгийн хүү
Цэвээндаш	-----“”-----	1782-1812	47	Дансрангийн хүү
Балжин	-----“”-----	1813-1825	18	Цэвээндашийн хүү
Цэрэнжав	-----“”-----	1825-1866	5	Цэвээндашийн ахмад хүү Жамсрангийн хүү
Ганжууржав	-----“”-----	1867-1910	6	Цэвээнжавын 6-р хүү
Магсаржав	-----“”-----	1912-1914	2	Цэдэнжавын төрөл
Цогт-Очир	-----“”-----	1914-1921	4	Магсаржавын ойрын төрөл. 1917 онд бэйс болжээ.
Магсаржав	Хошууны ван	1922-1923		
Сэмжид	Мэргэн тайж	1692-1712	31	Санарганшидийн 2-р хүү

Гэндэн	Тэргүүн зэрэг тайж	1712-1735	51	Сэмжидийн ахмад хүү
Буджав	-----“”-----	1735-1752	13	Гэндэнгийн ахмад хүү
Цэдэнжав	Туслагч гүн	1752-1782	17	Буджавын ахмад хүү
Доржжав	-----“”-----	1782-1845	47	Цэдэнжавын хүү
Лувсанцэрэн	-----“”-----	1846-1852	26	Доржжавын дэд дүү
Өлзийбадрах-лянхуа	-----“”-----	1852-1898	2	Лувсанцэрэн-гийн ахмад хүү
Мөнх-Очир	-----“”-----	1898-1921	24	Өлзийбадрах-лянхуан ахмад хүү
Гомбожав	Тэргүүн зэрэг тайж	1921-1922	11	Мөнх-Очирын ахмад хүү
Түмэнхэн сайн ноён	Далай ламаас түмэнхэн сайн ноёны цол	1588-1640		Онохуй Үйзэний 4-р хүү
Данзан	-----“”-----	1640		Түмэнхэний 2-р хүү
Шамба	Жүн ван	1689	28	Данзан ламын ач хүү
Дашдэндэв	Чин ван	1707	46	Шамбын ахмад хүү
Ланжав	-----“”-----	1726	4	Дашдэндэвийн хүү
Дэчинжав	-----“”-----	1733	11	Ламжавын 2-р хүү
Норовжав	-----“”-----	1772	27	Дэчинжавын хүү
Цэдэнжав	-----“”-----	1786	51	Норовжавын хүү
Ринчендорж	-----“”-----	1793	58	Цэдэнжавын хүү
Пунцагдаш	-----“”-----	1802	7	Ринчендорж-ийн хүү
Цэрэндорж	-----“”-----	1817	22	
Дамчой	-----“”-----	1853	3	
Цэрэндондов	-----“”-----	1871	10	
Төгс-Очир	-----“”-----	1883	22	
Намнансүрэн	-----“”-----	1896	22	
Батсүх	Эрх дайчин	1919	9	

Аюуш	Тэргүүн зэрэг тайж	1691-1700	30	1696 онд Засаг улсад туслагч гүн болсон
Ванжил	Туслагч гүн	1700-1747	39	Аюушийн ач хүү
Сандавцэмбэл	-----“”-----	1747-1760	12	Ванжилын ахмад хүү
Цэдэнжав	-----“”-----	1760-1781	25	Сандавцэмбэлийн ач
Гармаа	-----“”-----	1781-1804	46	Цэдэнжавын хүү
Гимпилдондов	-----“”-----	1804-1815	9	Гармаагийн ахмад хүү
Дашдэлэг	-----“”-----	1815-1827	20	Гимпилдондовын дүү
Бандижав	-----“”-----	1828-1847	8	Дашдэлэгийн хүү
Жигжиддорж	-----“”-----	1847-1891	27	Бандижавын 3-р хүү
Махсамдан	-----“”-----	1892-1912	18	Жигжиддоржийн дүү
Гэлэн	Туслагч саруул гүн	1912-1923	2	Махсамдангийн ойр төрлийн хүн
Данжила	Засаг төрийн гүн	1697-1708		Галданбошигт хааны дүүгийн хүү
Доржцэвцэн	Бэйл	1708	47	Данжилагийн хүү
Сандав	Бэйс	1737	2	Доржцэвдэнгийн хүү
Гончигба	-----“”-----	1761	26	Сандибыб өргөсөн хүү
Жигмэдгүнсэн	-----“”-----	1804	9	Гончигбагийн хүү
Цэвэнжил	-----“”-----	1807	12	Жигмэдгүнгээгийн хүү
Жамьяндорж	-----“”-----	1814	19	Жигмэдгүнсэнгийн хүү
Гунгаадорж	-----“”-----	1818	23	Гончигбагийн ач хүү
Цэдэвдорж	-----“”-----	1842	22	Гунгаадоржийн хүү
Чимэддэлэг	-----“”-----	1886	12	Цэдэвдоржийн төрөл
Сандаг-Очир	Сүжигт гүн	1918	8	Чимэддэлэгийн дүү

Цэрэн	Хошой чин ван, эфү	1721-1750	60	Улиастайн сайд байсан
Цэнгүнжав	Хошой чин ван	1750-1771	15	Цэрэнгийн хүү
Лаваандорж	-----“”-----	1771-1816	36	Манж хааны шадар сайд байсан
Баянжаргал	-----“”-----	1816-1817	21	
Цэдэнбазар	-----“”-----	1817-1852	22	Баянжаргалын хүү
Дармаа	Чин ван	1852-1874	2	Цэндбазарын хүү
Наянт	-----“”-----	1874-1921	13	Дармаагийн хүү
Намжил	Тэргүүн зэрэг тайж	1696	35	Засаг тайж Ядамын үеэл дүү
Бааран	-----“”-----	1716	55	Намжилын ахмад хүү
Равдан	-----“”-----	1748	13	Баарангийн ахамд хүү
Дондов	-----“”-----	1759	24	Равдангийн ахмад хүү
Ванжилсампил	-----“”-----	1766	31	Дондовын ахмад хүү
Гэжээбал	-----“”-----	1822	2	Ванжилсампилын хүү
Жамсранжав	-----“”-----	1862	1	Гэжээбалын 2-р хүү
Цэрэнгомбо	-----“”-----	1865	4	Жамсранжавын хүү
Лувсанхайдав	-----“”-----	1888	14	Цэрэнгомбын хүү
Ширзагд	-----“”-----			
Цэрэндаш	Засаг тайж	1707-1724	46	Шамбын 2-р хөвгүүн
Дондовринчен	Улсад туслагч гүн	1724-1730	2	Цэрэндашийн хүү
Сани	-----“”-----	1730-1743	8	Цэрэндашийн 2-р хүү
Гунгаа	-----“”-----	1743-1749	8	Цэрэндашийн 3-р хүү
Сандуйжав	-----“”-----	1749-1760	14	Цэрэндашийн 4-р хүү
Минжүүрдорж	-----“”-----	1761-1778	26	Сундуйжавын хүү
Цэдэнжав	-----“”-----	1778-1785	43	Минжүүрдоржийн хүү

Дэлэгдорж	-----“”-----	1785-1824	50	Цэдэнжавын хүү
Дашравдан	-----“”-----	1824-1835	4	Дэлэгдоржийн хүү
Жүрмэдванжил	-----“”-----	1836-1855	16	Дашравдангийн хүү
Дармаабазар	-----“”-----	1855-1884	5	Жүрмэдванжилын хүү
Дэлэгдорж	-----“”-----	1884-1897	10	Дарамбазарын хүү
Дэчинравдан	-----“”-----	1897-1911	23	Дарамбазарын хүү
Бат-Очир	-----“”-----	1911-1923	3	Дэчинравдангийн хүү
Түмэнхэн сайн ноён	-----“”-----			
Санарганшад	-----“”-----			Түмэнхэний 10-р хүү Шарза даян хун тайж
Шатар	-----“”-----			Санарганшадын хүү
Обуу	-----“”-----			Шатарын хүү
Гэдэхэн тайж	-----“”-----			Обуугын хүү
Дорж мэргэн	Туслагч гүн	1756	21	Гэдэхэний хүү
Шагдаржав	-----“”-----			Дорж мэргэний хүү
Довчин	-----“”-----	1797	2	Шагдаржавын 2-р хүү
Жачин	-----“”-----	1825	5	Шагдаржавын хүү
Цэдэнжав	-----“”-----	1853	3	Жачингийн ахмад хүү
Сандагдорж	-----“”-----	1893	19	Цэдэнжавын хүү
Магсаржав	Чин ван бэйс	1918	8	Сандагдоржийн хүү
Норовжав	Тэргүүн зэрэг тайж	1712-1739	51	Бамуугийн ахмад хүү
Дамбадорж	Тэргүүн туслагч гүн	1740-1743	5	Норовжавын хүү
Гончиг	-----“”-----	1744-1785	9	Дамбадоржийн хүү
Сономбалжирдорж	-----“”-----	1786-1823	51	Гончигийн ахмад хүү
Гүрсэд	-----“”-----	1824-1855	4	Сономбалжирдоржийн хүү
Эрхэмжаргалан	Тэргүүн зэрэг бэйс	1856-1885	6	Гүрсэдийн ахмад хүү

Өлзийтөмөр	-----“”-----	1886-1823	12	Эрхэмжар- галангийн хүү
Дугаржав	Түшээ гүн	1894-1912	20	Өлзийтөмөрийн хүү
Ядамжав	-----“”-----	1913-1917	3	Дугаржавын ахмад хүү
Дашзэвэг	-----“”-----	1918-1923	8	Ядамжавын ойр төрөл
Бумдарь	Тэргүүн зэрэг тайж	1689-1691	28	Чойкур цолтой
Тов	-----“”-----	1691-1697	30	Бумдарийн хүү
Сэд	-----“”-----	1697-1719	36	Товын хүү
Цэвээн	Туслагч гүн	1719-1765	58	Сэдийн хүү
Даш	-----“”-----	1757-1788	22	Цэвээний хүү
Ламжав	-----“”-----	1789-1789	54	Дашийн хүү
Цэвдэндорж	-----“”-----	1789-1814		Ламжавын хүү
Далхжав	-----“”-----	1815-1831	20	Цэвдэндоржийн хүү
Лаваандорж	-----“”-----	1831-1873	11	Далхжавын хүү
Дашдорж	-----“”-----	1874-1917	13	Лхаваандоржийн хүү
Гомбосүрэн	Цогтой гүн	1917-1923	7	Дашдоржийн хүү
Зинамид	Тэргүүн зэрэг тайж	1709-1724	48	Шамбын хаяал дүү
Даш	-----“”-----	1727-1750	2	Зинамидийн ахмад хүү
Убаши	-----“”-----	1750-1788	15	Дашийн ахмад хүү
Бодичисүрэн	-----“”-----	1789-1804	54	Убашийн ахмад хүү
Гомбодорж	-----“”-----	1805-1843	10	Бодисүрэнгийн дүү
Галсандорж	-----“”-----	1850-1850	30	Гомбодоржийн 3-р хүү
Жанчивдорж	-----“”-----	1851	1	Гомбодоржийн хүү
Эриндорж	-----“”-----	1852-1895	2	Жанчивдоржийн хүү
Данзанжалбуу	Туслагч гүн	1897-1916	23	Эриндоржийн 3-р хүү
Ванчиннамжил	Туслагч зетэй гүн	1916-1918	6	Даянжалбуугийн хүү
Намсайжав	-----“”-----	1918-1923	8	

Тод-Эрдэнэ	Төрийн түшээ гүн	1691-1692	30	Түмэнхэний ахмад хүү Зодов, түүний хүү Сономын хүү
Убала	Улсад туслагч гүн	1693-1710	32	Тод-Эрдэнэ хүүгүй тул Сономын хүү Убала болов
Баму	-----“”-----	1710-1712	49	Убадайн ахмад хүү
Цэвээнноров	-----“”-----	1712-1731	51	Тод-Эрдэнийн үрчилсэн хүү
Чамчугжав	Жүн ван	1732-1778	10	Цэвээнноровын хүү
Гончигжав	-----“”-----	1779-1787	44	Чамчугжавын хүү
Дэмчигжав	-----“”-----	1788-1830	53	Гончигжавын дүү
Түгжжав	-----“”-----	1831-1848	11	Дэмчигжавын 3-р хүү
Дуйнхоржав	-----“”-----	1849-1856	29	Түгжжавын ганц хүү
Гэлэгжамц	-----“”-----	1857-1877	7	Дэмчигжавын 5-р хүү
Чойсүрэнжав	-----“”-----	1878-1906	4	Гэлэгжамцын хүү
Жамьяндорж	-----“”-----	1907-1922	33	Чойсүрэнжавын хүү
Цэвээндорж	Бэйс	1759-1773	24	Сайн ноён Дэчинжавын 2-р хүү
Сандавдорж	Тэргүүн зэрэг тайж	1773-1787	38	Цэвээндоржийн хүү
Ванчинжав	-----“”-----	1788-1811	53	Сандивдоржийн хүү
Ойдовдорж	-----“”-----	1812-1843	17	Ванчигжавын хүү
Дамдинжав	-----“”-----	1843-1859	23	Ойдовдоржийн хүү
Самандбадраа	-----“”-----	1860-1870	10	Дамдинжавын хүү
Үржинжав	-----“”-----	1870-1923	9	Дамдинжавын хүү
Содномбагмиддорж	-----“”-----	1911	1	
Лувсанпэрэнлэй	1-р дүр	1692-1716		Сайн ноён Хөндлөн Убашийн хүү

Лувсаншиндэлэг- намжил	2-р дүр	1717-1765	Түшээт хан аймгийн ван Чаваг-Яринпилийн хошууны мэйрэн Банжуурын хүү
Лувсанжигмэддорж	3-р дүр	1766-1803	Сайн ноён хан аймгийн ван цэнгүнжавын хүү
Лувсанжигмэд-намжил	4-р дүр	1804-1866	Сайн ноён хан аймгийн ван Сампилдоржийн хошууны тайж Дамиангийн хүү
Лувсанчойживанчиг	5-р дүр	1866-1904	Сайн ноён хан аймгийн гүн Ганжууржавын хошууны тайж Ванчинбазарын хүү
Лувсандондов- чойжиням	6-р дүр	1905-1913	Тус шавийн зайсан Сономдоржийн хүү
Жамбацэрэн	7-р дүр	1914	
Бадамдорж	Анхдугаар дүр	1699-1737	
Агваанчойдогданзанжанцан	2-р дүр	1738-1817	
Түгжжав	3-р дүр	1818-1860	
Бирваа	4-р дүр	1862-1883	
Пүрэвжав	5-р дүр	1884-1903	
Жүгдэрнамжил	6-р дүр	1901	
Санж-Агваандамба	Анхдугаар дүр		
Дэчин-Осор	2-р дүр	-1909	
Бадамжав	3-р дүр	1912-1913	
Магсаржав	4-р дүр	1914-	
Наваангончиг	Анхдугаар дүр, цорж	1757-1824	
Цэрэндорж	2-р дүр	1826-1883	
Дарамсэд	3-р дүр, номч цорж		
Лувсанноровшарав	Анхдугаар дүр	1701-1768	
Лувсандарваанчиг	2-р дүр	1772-1827	
Бадамдорж	3-р дүр	1830-1882	
Лувсанданзан	4-р дүр	1880-1893	
Цэдэнбалжир	5-р дүр	1896-1921	
Галсан-Ёндон	6-р дүр	1922-1967	
Ханжав тойн	Анхдугаар дүр		

Лувсангаваа	2-р дүр	-1743	
Намхайдорж	3-р дүр	1744-1799	
Банди	4-р дүр	1800-1830	
Ванданчоймбол	5-р дүр	1831-1875	
Наваанлэгдэн-дамбийжанцан	6-р дүр	1876-	
Лувсанданзанжанцан	Анхдугаар дүр	1639-1703	Зурхайч
Лувсанбалчинбалбар	2-р дүр	1703-1788	
Лувсанцэвээнжав	3-р дүр	1793-1846	
Ширбазар	4-р дүр	1851-1861	
Чулуун	5-р дүр	1862-1907	
Жамьяндорж	6-р дүр	1908-1912	
Цэрэндорж	7-р дүр	1913-1930	
Жамьян	Анхдугаар дүр	-1672	
Жанцан	2-р дүр	1673-1747	
Галсан	3-р дүр	1750-1778	
Лувсандамчойжанцан	4-р дүр	1781-1810	
Цэрэнваанчиг	5-р дүр	1811-1866	
Аюушир	6-р дүр	1875-1882	
Сономцэрэн	7-р дүр	1883-	1918 онд Бишрэлт цолоор шагнажээ.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ХУВААРЬ

Сумын нэр	Тайлбар
Эрдэнэ-Булган	1931 онд байгуулагдсан. Аймгийн төв нь Цэцэрлэг хот
Батцэнгэл	1931 онд байгуулагдсан.
Булган	1931 онд байгуулагдсан. 1952 онд Цэцэрлэг хот болон бусад суманд тасарч шилжсэн. Дараа дахин байгуулжээ.
Жаргалант	1931 онд байгуулагдсан.
Их-Тамир	1931 онд байгуулагдсан.
Өгийнуур	1952 онд Хотонт сумын 3,4,5-р баг, Батцэнгэл сумын 1,12-р баг, Өлзийт сумын 5,6,7-р багуудаар байгуулсан.
Өлзийт	1931 онд байгуулагдсан.
Өндөр-Улаан	1931 онд байгуулагдсан.
Тариат	1931 онд байгуулагдсан. 1961 он дМөрөн, 1966 онд Цахир сумын хагасыг нийлүүлсэн.
Төвшрүүлэх	1938 онд Хотонт, Цэнхэр сумаас тасалж байгуулсан. 1954 онд татан буугдаж Баян-Улаан, Булган суманд нийлүүлсэн. Дааа нь дахин байгуулжээ.
Хайрхан	1931 онд байгуулагдсан.
Хангай	1931 онд байгуулагдсан.
Хашаат	1931 онд байгуулагдсан.
Хотонт	1931 онд байгуулагдсан.
Цахир	1931 онд байгуулагдсан.
Цэнхэр	1931 онд байгуулагдсан.
Чулуут	1931 онд байгуулагдсан.
Цэцэрлэг	1931 онд байгуулагдсан.
Эрдэнэ-Мандал	1931 онд байгуулагдсан.

Татан буугдсан сум

Баян-Уул	1931 онд байгуулсан. 1968 онд татан буугдаж Батцэнгэл суманд нэгтгэжээ.
Бугат	1931 онд байгуулагдсан. 1960 онд Тайхар сумын хамт Их-Тамирт нийлүүлсэн.
Мөрөн	1931 онд байгуулагдсан. 1961 онд татан буугдаж Тариат суманд нийлүүлсэн.
Лүн	1931 онд байгуулсан. 1956 онд буулгаж, 1,2,3-р багийг Өгийнуурт, 7,8-р багийг Хотонт, 4,6-р багийг Хашаатад нийлүүлсэн. 1959 онд Лүн сумыг дахин байгуулаад 1960 онд Хашаат сумтай нийлүүлсэн.

Мөрөн	1931 онд байгуулсан. 1961 онд татан буугдаж Тариат суманд нийлүүлсэн.
Өндөрсант	1931 онд байгуулсан. 1961 онд татан буугдаж Хотонт суманд нийлүүлсэн.
Тайхар	1959 онд Их-Тамир сумаас тасалж байгуулаад 1961 онд Их-Тамирт нийлүүлсэн.
Туулант	1959 онд Цэцэрлэг, Жаргалант сумаас тасалж байгуулаад 1961 онд мөн сумдад буцаан нийлүүлсэн.
УрьдТамир	1959 онд Булган, Баян-Уул сумаас тасалж байгуулаад 1961 онд Цэнхэр, Баян-Уул сумдад нийлүүлсэн.
Хан-Орд	1931 онд байгуулсан. 1956 онд буулгахдаа 1-р багийн хагасыг Бугатад, 1,2,3-р багийг Хайрханд, 4,7-р багийг Эрдэнэмандалд нийлүүлэв. 1959 онд дахин байгуулаад 1960 онд Эрдэнэмандалд нийлүүлжээ.
Хануй	1959 онд Бугат, Өндөр-Улаан сумаас тасалж байгуулаад, 1961 онд Өндөр-Улаан сумтай нийлүүлсэн.

Өөр аймагт шилжсэн сум

Авзага	1931 онд Архангай аймгийн харъяанд байгуулагдсан. 1934 онд Төв аймагт, 1938 онд Булган аймагт шилжсэн.
Баацагаан-гол	1931 онд Өвөрхангай аймгийн харъяанд Цагаан гол нэртэй байгуулагдаад 1934 онд Архангай, 1940 онд Говь-Алтай, 1942 онд Баянхонгор аймагт шилжсэн.
Бат-Өлзий	1931 онд Архангай аймагт Бат-Өлзийбүрд нэртэй байгуулагдсан. 1934 онд Өвөрхангай аймагт шилжсэн.
Баянзүрх	1931 онд Архангай аймагт байгуулагдсан. 1941 онд Хөвсгөл аймагт шилжсэн.
Бөмбөгөр	1931 онд Өвөрхангай аймагт байгуулагдаад 1934 онд Архангай, 1942 онд Баянхонгор аймагт шилжсэн.
Бууцагаан	1931 онд Өвөрхангай аймагт Буянтцагаан гол нэртэй байгуулагдаад 1934 онд Архангай, 1940 онд Говь-Алтай, 1942 онд Баянхонгор аймагт шилжсэн. 1962 онд татан буугдаж Галуут суманд нийлүүлжээ.
Бүрд	1931 онд Архангай аймагт байгуулагдсан. 1942 онд Өвөрхангай аймагт шилжсэн.
Гурванбулаг	1931 онд Архангай аймагт байгуулсан. 1942 онд Булган аймагт шилжсэн.
Гурванбулаг	1931 онд Өвөрхангай аймгийн харъяанд байгуулагдаад 1934 онд Архангай, 1940 онд Говь-Алтай, 1942 онд Баянхонгор аймагт шилжсэн. 1962 онд татан буугдаж Галуут суманд нийлүүлжээ.

Заг гол	1931 онд Өвөрхангай аймагт Заг гол нэртэй байгуулагдаад 1934 онд Архангай, 1942 онд Баянхонгор аймагт шилжсэн.
Жаргалант	1931 онд Архангай аймагт байгуулагдсан. 1941 онд Хөвсгөл аймагт шилжсэн.
Идэр	1931 онд Архангай аймгийн харъяанд байгуулагдан 1941 онд Хавсгөл аймагт шилжиж Шинэ-Чандмань нэртэй болсон.
Их-Уул	1931 онд Архангай аймагт байгуулагдсан. 1942 онд Завхан аймагт шилжсэн.
Мандал	1931 онд Өвөрхангай аймагт байгуулагдаад 1934 онд Архангай, 1942 онд Баянхонгор аймагт шилжсэн.
Могод	1931 онд Архангай аймгийн харъяанд байгуулагдсан. 1934 онд Төв аймагт, 1938 онд Булган аймагт шилжсэн.
Наран	1931 онд Архангай аймагт байгуулагдсан. 1942 онд Завхан аймагт шилжсэн.
Тосонцэнгэл	1931 онд Архангай аймагт байгуулагдсан. 1942 онд Завхан аймагт шилжсэн.
Хүрээмарал	1931 онд Өвөрхангай аймагт байгуулагдаад 1934 онд Архангай, 1940 онд Говь-Алтай, 1942 онд Баянхонгорт шилжсэн.
Чандмань	1931 онд Архангай аймагт байгуулагдсан. 1941 онд Хөвсгөл аймагт шилжсэн.
Шанх	1931 онд Архангай аймагт байгуулагдсан. 1941 онд Өвөрхангай аймагт шилжсэн.

Архангай аймагт хамаарах аймаг, хошуу

Сум	Ардын засгийн үе (1924-1931 он)		Олноо өргөгдсөн монгол улс (1911-1924 он)	
	Аймаг	Хошуу	Аймаг	Хошуу
Батцэнгэл	Цэцэрлэг мандал уул	Батцэнгэл уулын хошуу	Сайн ноён хан	Түшээт гүний хошуу
		Эрдэнэбулган уулын хошуу	Сайн ноён хан	
Эрдэнэбулган	Цэцэрлэг мандал уул	Эрдэнэбулган уулын хошуу	Сайн ноён хан	Зая бандид хутагтын шавь
Булган	Цэцэрлэг мандал уул	Эрдэнэбулган уулын хошуу	Сайн ноён хан	Зая бандид хутагтын шавь
Их-Тамир	Цэцэрлэг мандал уул	Эрдэнэбулган уулын хошуу	Сайн ноён хан	Зая бандид хутагтын шавь
		Хан-Өндөр уулын хошуу	Сайн ноён хан	Сэцэн чин вангийн хошуу

Өндөр-Улаан	Цэцэрлэг мандал уул	Хан-Өндөр уулын хошуу	Сайн ноён хан	Сэцэн чин вангийн хошуу
		Шива ширээт хутагтын шавь	Сайн ноён хан	Шива ширээт хутагтын шавь
Чулуут	Цэцэрлэг мандал уул	Хан-Өндөр уулын хошуу	Сайн ноён хан	Сэцэн чин вангийн хошуу
		Шива ширээт хутагтын шавь	Сайн ноён хан	Шива ширээт хутагтын шавь
Тариат	Цэцэрлэг мандал уул	Чандман-Өлзийт далайн хошуу	Сайн ноён хан	Далай Чойнхор вангийн хошуу
Хангай	Цэцэрлэг мандал уул	Чандман-Өлзийт далайн хошуу	Сайн ноён хан	Далай Чойнхор вангийн хошуу
Цахир	Цэцэрлэг мандал уул	Чандман-Өлзийт далайн хошуу	Сайн ноён хан	Далай Чойнхор вангийн хошуу
Хотонт	Цэцэрлэг мандал уул	Хотонт уулын хошуу	Сайн ноён хан	Сүжигт бэйсийн хошуу
Төвшрүүлэх	Цэцэрлэг мандал уул	Хотонт уулын хошуу	Сайн ноён хан	Сүжигт бэйсийн хошуу
Цэнхэр	Цэцэрлэг мандал уул	Цэцэрлэг голын хошуу	Сайн ноён хан	Ачит гүний хошуу
		Цэцэрлэг голын хошуу	Сайн ноён хан	Зоригт вангийн хошуу
		Цагаан сүм уулын хошуу	Сайн ноён хан	Зоригт вангийн хошуу
Хайрхан	Цэцэрлэг мандал уул	Цонхайлан уулын хошуу	Сайн ноён хан	Саруул гүний хошуу
Эрдэнэ-Мандал	Цэцэрлэг мандал уул	Цонхайлан уулын хошуу	Сайн ноён хан	Саруул гүний хошуу
Жаргалант	Цэцэрлэг мандал уул	Эрдэнэцогсолсон уулын хошуу	Сайн ноён хан	Эетэй гүний хошуу
Цэцэрлэг	Цэцэрлэг мандал уул	Рашаант уулын хошуу	Сайн ноён хан	Мэргэн гүний хошуу
Өлзийт	Цэцэрлэг мандал уул	Баянбайшир уулын хошуу	Сайн ноён хан	Бишрэлт бэйлийн хошуу
Өгий-нуур	Цэцэрлэг мандал уул	Баянбайшир уулын хошуу	Сайн ноён хан	Бишрэлт бэйлийн хошуу
	Богд хан уул	Хангай хайрхан уулын хошуу	Түшээт хан	Түшээт ханы хошуу
Хашаат	Богд хан уул	Хангай хайрхан уулын хошуу	Түшээт хан	Түшээт ханы хошуу

ЗАЯГЭГЭЭН ЛУВСАНПЭРЭНЛЭЙН 365 ЖИЛИЙН ОЙГ ТОХИОЛДУУЛАН ХИЙСЭН ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ ДЭЭР ТАВЬСАН ЛАМ Ц.ОТГОНБАЯРЫН ИЛТГЭЛ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БУРХАНЫ ШАШИНЫ УЛБАА

Одоогоос 2550 жилийн өмнө Бурхан багш лагшин мэндэлж номын хүрд өргүүлсэнийг та бүхэн бүгд мэддэг билээ. Тэгвэл бурхан багш цагийн хүрдний номлолыг өмнөд энэтхэгийн балдан брайван суварган дээр номлосон байдаг. Тэрхүү одоогийн энэтхэгийн карнатака муж амравати хэмээх газарт 14-р Далай лам данзан жамц бээр цагийн хүрдний авшиг айлдахдаа Лондол ламын зохиосон дүйнхорын түүх хэмээх номыг ишлэл болгон энэхүү газар бурхан багшаас өмнө заларсан Сэртүв бурханы үед нэгэн гэлэн бээр өлсөж буй түмэнд туслахаар лусаас хурын оронд амуу тариа хүсэж хурчилан буулгасан бөгөөд түүнийг бэлэгдэн арвайгаа бөөрөнхийлөн хумиж суврага мэт овоолон тэнгэр бурханаас хайрласан хишгийн газар үүнээс хойш бурхан тэнгэртэйгээ эндээс тахиж харьцана гэж тэмдэг тавин чодён буюу тахилын суурийг анхлан бүтээсэн гэж цохон тэмдэглэсэн байдаг.

Энэхүү он тоололоос 12000 жилийн тэртээ ВЕД ийн шаштир дэлгэрч кастийн системтэй байжээ. Вархман буюу барамсай язгуур кшастра буюу хаан язгуур вайвшика буюу худалдаачин гар урчуудын язгуур, шутра буюу боолын язгуур гэх 4 ангид харъяалагддаг ба боолын хүүхэд боол байх хувь зохиолтой дээд ангитайгаа харьцахгүй байдаг байжээ. Гэтэл энэхүү систем монголд тэгэх тусмаа хуучин сайн ноён хан аймаг далай вангийн нутагт ордог байсан Завханы Алдархааны богдын голд хадан дээр дээрх барамсай, хаан, худалдаачин цэргийн хүн, боолыг дүрсэлэн зурсан 4хүний хадны зургийг монгол телевизийн сурвалжлагч Бадамсамбуу тайлбар хийсэн байдаг энэ нь кастийн систем байсныг батлан харуулах эд өлгийн дурсгал болно.

Манай хүннү дээдэс хааныгаа шанью гэж тийм системтэй байсан ба тэр уламжлал нь урагшаа энэтхэг оронд дамжсан. Тэр бол бөгсөндөө хөх толботой аричууд байсан гэж оросын холбооны улсын академич Вангорд Левин гэдэг эрдэмтэн, мөн энэтхэгийн эрдэмтэн Радхакришна нар олон зохиол бүтээлээрээ баталсан байдаг.

Бурханы шашины өмнө ведийн шашин буюу мани шашинтай байжээ гэсэн дүгнэлтэнд хүрч болох юм. бурханы шашин бас эрт

манай нутагт дэлгэрчээ. Монгол улсад төрт улс байгуулагдсаны 2220 жил гэж бид энэ жил тэмдэглэсэн энэ нь миний төрсөн нутаг болох Эзэгийнтийн хужиртаас баруун 25км т хүннүгийн хаад түмэн шаньюгийн хөвгүүн модун шанью луут хотыг байгуулсан түүний туурь болон бичгийн дурсгалаар эрдэмтэн Гүнжийн Сүхбаатар хүннү нар монголчуудын эртний өвөг болох нь гэх цуврал бүтээлээрээ нотолсон билээ. Тэр үед Хан улс 3чи өндөр бурхан багш манай хүннү чүүдээс дээрэмдэн авч тахиж байсан тухай баримт бий. Энэ нь бас л манай нутагтай холбоотой мөн Ц Доржсүрэн.1956он Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн тухай тайлан, Г Мэнэсийн 1982онд хийсэн археологийн тайлан, С Г Кляшторный. В А Лившиц нарын Согдийская надпись из бугата хэмээх эрдэм шинжилгээний бүтээл, японы эрдэмтэн эрдэмтэн Ятака юүшида, Такяа муруша нарын зодсПап рап: тзсприОп хэмээх бүтээлүүдэд бугатын баян цагаанаас авчирсан яст мэлхий дээрхи хүүхэд хөхүүлж буй чонын дүрстэй бичигт хөшөөг тайлан уншиж 528онд босгосон бурханы шашинтай холбогдох эд өлгийн дурсгал хэмээн нотолсон нь тэр үед бурханы шашин дэлгэрч байсныг таамагаар бус бодитоор нотолсон хосгүй ховор дурсгал юм.

Батмөнх Даян хаан 11 хөвгүүнтэй байсан бөгөөд тэдгээрийн отгон нь Гэрсэнз Жалайр хунтайж бөлгөө. Гэрсэнзийн 7 хөвгүүний гутгаарыг Онохуй Үйзэн гэдэг ажгуу. Монголд бурхны шашныг дэлгэрүүлэхэд ихээхэн хүчин зүтгэсний учир Онохуй Үйзэн ноён буюу күндүлэн цохурыг Ванчин богдоос Гаслан үгүй номын хааны залгамж хойд дүр хэмээн тодруулсан энэ нь Заяын гэгээнтний урьд дүр билээ. Күндүлэн цохур ноён 13 хүүхэдтэй ба 2-р хөвгүүн нь ламын гэгээнтэний аав Лоёг цокур ноён,3-р хөвгүүн нь Данзан лам буюу гэгээнтэний номын эзэн, шива ширээтийн анхдугаар дүр бээр Чонотын хөндий хэмээх булган уулын өвөрт дуганы суурь тавьж эхэлсэн. 1725 онд манжийн Найралт Төв хаан халхын гурван аймгийг 75 хошуу бүхий 4 аймаг болгож, Данзан ламын жич хүү Хошой чин ван Дашдэндэвт "хан" цол олгож, Түшээт хан аймгаас 19 хошуу тасдаж эзэмшил болгон өгч, Сайн ноён хан аймгийг байгуулж улмаар 20 гаруй хаадууд дамжин Төгс-Очирын Намнансүрэн 19 настайдаа 1897 онд эцгийн хэргэм зэргийг залган хошой чин ван цол шагнагдаж, сайн ноёны хошууны засаг ноён, Сайн ноён хан аймгийн хан болжээ. Гэгээдүүд хийд ороноо дээш хөгжүүлсээр сири живзүнбийн эхжа буюу сургалттай, дашлүнбэ дэгтэй, Сэрхүгийн манба буюу лхантүв зүчин сүм цээжээр шүүлгэж маарамва болдог, 5 н зава цээжилж гавжийн дамжаа барьдаг, зээрэмбийн дамжаатай, жалбаан авын жаягтай их хүрээний дараа

орохоор шашины хоёр дахь том байжээ. Доод, дээд гэсэн хоёр хүрээнээс бүрддэг ба дээд хүрээндээ Жи дацан буюу шашин төрийн хэргийг эрхэлэн явуулах газар Гүшүг дацан буюу гэгээнтэний албан дацан, Жара буюу нүгнээ сахидаг жанрайсиг дацан, гүнрэг дацан, сандуйн дацан энэ дацантай тохомтой шавь нар нь одоогийн эрдэнэ мандалын урьд хэсэг хамрагдах ба толгойлж буй өглөгийн эзнээ сандуйдарга хэмээгдэг, Дэмчиг дацан шавь нар нь одоогийн цэцэрлэг сумын урьд бигээр байдаг ба гол эзнээ дэмч дарга гэдэг, Дүйнхор дацан шавь нар нь бугат баян уул сумын хан байдаг ба гол өглөгийн эзнээ дүйнхор тэргүүн гэдэг байжээ. Жи дацангийн ли нарын хуваарийн дагуу улирлын хурлыг хувиарлан цогчинд нийлж хуран цогсаг босдог байжээ. Доод хүрээндээ аюуш цэвээлэн хоёр дацантай байв Эргэн тойрондоо буи хийд ороноо боловсон хүчнээр хангаж хамтын ажиллагаан дор шашинаа хөгжүүлэж байв. Тэдгээр хийдүүдийг дурьдвал Баян уул сум Лхамын хурлын дэнж. Агьтийн хурал, бугатын хурал, бурхангийн дуган зэрэг газруудад улирлын хурал болдог байжээ. Батцэнгэл суманд Тарваачинбуулин хийд. улаан чулуутын хүрээ, Халчиний хийд зэрэгт байнгийн хуралтай 300 гаруй лам нартай байв. Баянбулаг суманд Баруун хийд, Бугатын хийд, Сангийн далай хийд, Хадатын хийд зэрэг хийдүүд байжээ, Баянхонгор суманд Гавжийн чойнхорлин хийд, Ганданцэцээлэн хийд, Бөмбөгөр суманд Галдан дуган, хишгэн жас, Бугат суманд тайжид сүм, Дарь эхийн хурал, Чойжоо хурал Майдарын хурал, Урт булагийн дарь эх, зэрэг Буянт цагаан гол суманд Буянтын хийд, Данхорын жас, Зүүн жас зэрэг. Заг гол суманд Хөгнө хийд үйзэн хурал, Шивэртийн сүм, Идэр суманд Мандахын хүрээ, Нарийний хүрээ, Дэрстийн дуган, зэрэг. Их жаргалант суманд Арын хүрээ, Агьтийн сүм Гүнжилийн сүм, Их уул суманд Зартийн хийд, Зартын бага дуган, Дарь эхийн дуган, Юмын байшин. Мандал суманд Мандалын хүрээ гэх олон лам нар салбар дугантай том хүрээ байв. Их тамир суманд Чойдэлэг хийд Майдар хурал, Шивэртийн дуган Бумбатын дуган, Их хужиртийн дуган, Урт булагийн дуган Арцатийн дуган хан өндөрийн хүрээ, Лүн суманд Эрдэнэ зуу хийд, Чойнхорын хурал, хурахуйн хурал, Хорчиний хурал Могод суманд Урт мэргэний хийд, Баргын хийд, Эрдэнийн хийд Жаргалантийн хийд, Баян өндөрийн хийд, Рашааны хийд, Баясгалантын хийд, Наран суманд Хожуулын хийд, Өлзийт суманд Будантын хийд, Лавран хийд, Өндөрсант сант суманд Цагаан сүмийн хийд, Өндөр улаан суманд Хануйн дуган, Одорхын дуган, Тахилын дээд дуган Маанийн дуган, Тариат суманд Тариатийн хүрээ, Суурийн хийд, Чоичирлэн хийд, Улаанчулуутын хийд, Хайрхан суманд Хануйн хүрээ, Журамтайн

хүрээ, Хашаат суманд Ар өвөр номгоны хийд,

Хотонт суманд Хотонтын хүрээ зэрэг хийд сүм дуганыг Заяын хүрээний Жи дацангаас удирдан дэлгэрүүлж иржээ.

Сайн ноён хан аймаг 1725-1911 оны хооронд 24 засаг хошуу, 8 тамгатай хутагтын шавь бүгд 32 засаг захиргааны нэгжтэй, халх дөрөв, дөрвөд хоёр нийт зургаан аймгаас хамгийн томд нь тооцогдож байжээ.

Хутагт хувилгаад нар нь: Богдоос гадна тамгатай 13 хутагт байснаас Сайн ноён хан аймагт Зая бандид хутагт, Эрдэнэ бандид хутагт, Чин сүжигч Номун хан, Нарбанчин хутагт, Эрдэнэ мэргэн ноён хутагт, Шиваа ширээт хутагт, Наран хутагт, Хамба хутагт, Засагт хан аймагт Жалханз хутагт, Ялгуулсан хутагт, Бигэр Номун хан гэсэн гурван хутагт Цэцэн хан аймагт Егүүзэр хутагт, Ялгуулсан хутагт гэсэн хоёр хутагт тус тус харьяалагдаж байжээ.

Заяын гэгээний хүрээ болон Сайн ноён хан аймгаас гарсан эрдэм номтой лам нар

Агваандамба. Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошууны гавж, XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть. Судар тарнийн тайлбар ба зан үйл, Илдэн бэйлийн хошуунд бартай.

Агваанпэрэнлэй. Сайн ноён хан аймгийн Хошууч бэйсийн хошууны Лашин хувилгаан. XX зууны үеийн хүн. Зохиол нь таван боть, зан үйл, намтрууд. Бичмэл.

Артасэдбазар. Сайн ноён хан аймгийн Далай чойнхор вангийн хошууны Ялгуусан тойн. XIX зууны үеийн хүн, зохиол нь таван боть, судар тарнийн тайлбар, яруу найраг, зан үйл боть үйл зэрэг. Ялгуугсаны хүрээнд бартай.

Өлзийбат. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний маарамба. XX зууны үеийн хүн, зохиол нь дөрвөн боть, эмийн дохионы тайлбар зэрэг бичмэл.

Бадрах. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны Заяын хүрээний гавж, XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судрын тайлбар, зан үйл зэрэг, бичмэл.

Балдандэчинодсэл. Сайн ноён хан аймгийн Пүрэв гүний хошууны Наран хутагтын III дүр. XX зууны үеийн хүн, зохиол нь долоон боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, зарим нь бар, зарим нь бичмэл.

Галсан. Сайн ноён хан аймгийн мөн хошууны Ловон. XIX зууны үеийн хүн, нэг боть зохиолтой. Тарнийн тайлбар номууд зэрэг, бичмэл.

Галсан. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний хамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть тарнийн тайлбар, хөтөлбөр зэрэг, бичмэл.

Галсан. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний Шүнлайв, XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн тайлбар зэрэг, бичмэл.

Галсангэмпэл. Сайн ноён хан аймгийн мөн хошууны хамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, зан үйл, залбирал, мөргөл зэрэг бичмэл.

Жамбацэвээн. Сайн ноён хан аймгийн Ламын гэгээний хүрээний ловон. XVIII зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть, судар тарнийн тайлбар, зан үйлийн зэрэг, бичмэл.

Жамъянгарав. Сайн ноён хан аймгийн Даян жалбуу засгийн хошууны хамба, гэгээн. XX зууны үеийн хүн, зохиол нь арван гурван боть, уран зохиолын онол зэрэг мөн хошуундаа бартай.

Жамсран. Сайн ноён хан аймгийн мөн хошууны цорж, XIX зууны үеийн хүн, зохиол нь таван боть, элдэв зан үйл зэрэг мөн хошуунд бартай.

Ёндон. Сайн ноён хан аймгийнсайд вангийн хошууны маарамба.

XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть. Эмийн дарван үндэсний түүвэр зэрэг, мөн хошуундаа бартай.

Дашравдан. Заяын хүрээний цорж. XIX зууны үеийн хүн, зохиол нь дөрвөн боть, дотоод ухааны тайлбар, зан үйл, магтаал зэрэг бичмэл.

Далай. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны маарамба. XX зууны үеийн хүн, нэг боть зохиолтой, эмнэлгийн тухай бичмэл.

Даваа. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны цорж.

XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Билиг барамидийн тайлбар зэрэг, Арвай хээрийн хүрээнд бартай.

Дондов - Ринчин. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний гавж, XIX зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть, судар тарнийн тайлбар, зан үйл бичмэл.

Дүвжүү. Ламын гэгээний хамба. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, элдэв зан үйл зэрэг, бичмэл.

Ринчиндагва. Сайн ноён хан аймгийн Заяын цагаан равжамба. XVIII зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, чойрын ном, бичмэл.

Рэгзэнсэвжиддорж. Сайн ноён хан аймгийн Далайчойнхор вангийн хошууны шавь. XVIII зууны үеийн хүн, зохиол нь таван боть, судар тарнийн тайлбар яруу найраг, элдэв зан үйл, мөн хошуунд бартай.

Самданлхүндэв. Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошууны даянч лам. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, элдэв зан үйл, бичмэл.

Сампил. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны гавж, жорвон. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, чойрын номууд, бичмэл.

Сономжамц. Сайн ноён хан аймгийн мөн хошууны ловон, долоон боть зохиолтой, судар тарнийн бан дуун ухааны тайлбар зэрэг, мөн хошуунд бартай.

Содов. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны гэцэл. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн олон зүйлийн тайлбар, бичмэл.

Шаравжамц. Сайн ноён хан аймгийн Арвайхээрийн хошууны зурхайч. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, зурхайн гол зэрэг, бичмэл.

Лувсан. Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны Шива ширээт. XVIII зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, тарнийн зан үйл зэрэг бичмэл.

Лувсаннамжил. Сайн ноён хан аймгийн Зая бандидагийн хоёрдугаар дүр. XVIII зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть, зан үйл зэрэг, бичмэл.

Лувсанняндаг. Сайн ноён хан аймгийн мөн хошууны хамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, тарнийн тайлбар, бичмэл.

Лувсанжамба. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний хамба. XX зууны үеийн хүн зохиол нь нэг боть. Ванайн тайлбар, зан үйл зэрэг, бичмэл.

Лувсанданзан. Сайн ноён хан аймгийн Арвайхээрийн хошууны XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Номун сахиулсан билгийн зан үйлийн тайлбар, бичмэл.

Лувсанданзанжалцан. Сайн ноён хан аймгийн Ламын гэгээний анхдугаар дүр. XVII зууны хүн, зохиол нь дөрвөн боть, судар тарни, эмнэлэг, зурхайн тайлбар мөн шууны бартай.

Лувсандорж. Сайн ноён хан аймгийн мөн хошууны хамба. XIX зууны үеийн хүн, зохиол нь дөрвөн боть, судар тарнийн тайлбар, бодь мөрийн шалгалт зэрэг. Мөн хошуунд бартай.

Лувсандамба. Сайн ноён хан аймгийн XVIII зууны үеийн хүн зохиол нь нэг боть, судрын тайлбар тэмдэглэл, бичмэл.

Лувсан-Агваанчүлтэм. Номгоны Дарь-эх лам XX зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть. Судар тарнийн тайлбар, зан үйл, намтар зэрэг, бичмэл.

Лувсанчимэддорж. Сайн ноён хан аймгийн Түшээт вангийн

хошууны Цорж. XX зууны үеийн хүн, зохиол нь хоёр боть, Авидарамгийн тайлбар зэрэг, бичмэл.

Лувсансодовжамц. Лхарамба. XVII зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн тайлбар зэрэг, бичмэл.

Лувсанпэрэнлэй. Сайн ноён хан аймгийн Зая бандидагийн анхдугаар дүр. XVII зууны үеийн хүн, зохиол нь зургаан боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, Бээжинд бартай.

Лувсанцэрэн. Сайн ноён хан аймгийн Далай вангийн хошууны гавж. XIX зууны үеийн хүн, нэг боть зохиолтой судрын тайлбар зэрэг, бичмэл.

Лувсанчүлтэм. Сайн ноён хан аймгийн Заяын таягт лам хэмээн алдаршсан. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, бичмэл.

Лодойдамба. Сайн ноён хан аймгийн мөн хошууны ловон. XIX зууны үеийн хүн, зохиол нэг боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, мөн хошууны хүрээнд бартай.

Доржбал. Сайн ноён хан аймгийн Далай вангийн хошууны цорж. XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Дохионы бичиг зэрэг, мөн хошууны хүрээнд бартай.

Ванганжав. Сайн ноён хан аймгийн Заяын хүрээний гавж. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, судар тарнийн тайлбар, зан үйл зэрэг, бичмэл.

Зундуйсодов. Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошууны даяан ламын ёнзон. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, хамба гэгээн Жамъянгарав, Нарангэгээн, Дэчин-Одсэл зэргийн намтар, бичмэл.

Цэвэлванчогдорж. Сайн ноён хан аймгийн Арвайхээрийн хошууны бандида лам. XIX зууны үеийн хүн, зохиол нь арван таван боть, судар тарни, эмнэлэг зэрэг, Арвайхээрийн хошуунд бартай.

Цэвээнлхасүрэн. Сайн ноён хан аймгийн Түшээт вангийн хошууны тойн. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Билэг барамидын тайлбар зэрэг, бичмэл.

Цэрэндорж. Сайн ноён хан аймгийн Гадан засгийн хошууны гавж. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, элдэв чухал үгс зэрэг, бичмэл.

Цэрэнжав. Сайн ноён хан аймгийн Далай гүнгийн хошууны аграмба. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, чойрын ба эмнэлэг зэргийн, бичмэл.

Цэрэндорж. Сайн ноён хан аймгийн Илдэв бэйлийн хошууны гавж. XX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, Бодь мөрийн зэрэг, Шалгадаг ухааны тайлбар зэрэг, бичмэл.

Цэвээнчавцог. Сайн ноён хан аймгийн Ламын гэгээний гуравдугаар дүр. XVIII зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, тарнийн ёсны утгыг тодруулсан зэрэг, мөн хүрээнд бартай.

Чүлтэм. Сайн ноён хан аймгийн мөн хошууны ловон. /Дондоо/ XIX зууны үеийн хүн, зохиол нь нэг боть, тарнийн ёсны ном зэрэг, бичмэл.

Гол нандин шүтээнүүд:

Көндүлэн цоохор ноёныг жинсрэг зутган чандарлахад магнайнаас нь Одбагмид бурханы дүр гарч хөлийн улнаас түвд а үсэг гарсныг би үзсэн хэмээн Зая гэгээнтэн өөрийн бичсэн намтартаа бичсэн байдаг ба түүнийг жаарийн дуганы гол шүтээн жанрайсигт жанрайсиг бурханы сүншүгт гэгээнтэн өөрийн мутраар хийсэн хосгүй шүтээн байв. Чогчин дуганы гол шүтээн майдар бурхан бээр 1905 онд 13-р Далай ламын дагуул лам нар ирж номгүй газарт хэмээн дорд үзэхэд заяын Балжиржанцан гавж ном хаяж номхруулан госо өндөр гэдгийг мэдрүүлсэн байдаг. Тэгтэл тэд мөчөөгөө өгөлгүй жаяг дүлбаа гүй хэмээхэд жалваан авын жаягтай гэхэд түүнийгээ үзүүл гэж шаардахад майдар бурханы шүншүгт бий гэж гэсгүй хэлсэнд үзнэ хэмээн тэд Майдарт ойртоход бурхан дуу гарган хөлөрсөнд тэд айж буцсан гэдэг. Баян уул багын Эзэгийнтийн хужирт хэмээх газар байх Лхамын дуганы гол шүтээн Балдан лхам бурхан урдуураа морьтой хүн гаргадаггүй догшин шүтээнтэй байв, тэр шүтээний гарал үүслийг ярьвал Түүгээр Увс аймгийн харьяат илжгэн ноён тэмээн хөсөгтэй үдлээд явах гэтэл Лхам бурхан ачиж явсан тэмээ хэвтээд босоогүй тул аргаа бараад нутгийн эзэн Зая гэгээнээс асуулгахад лхам сахиус энэ нутгийг таалжээ хэмээсэнд ноён дуган барьж залаад орхисон түүхтэй билээ, Галдан бошигт хүрээнд ирж Дамдин чойжоо бурхан д сэлмээрээ адис өргөөд гарах гэтэл хамраас нь цус гараад тогтоогүй гэдэг нандин шүтээн олон байжээ.

Орон нутгийн шүтээн уул усны талаар:

Зая гэгээнтэн үе уламжлан тахиж ирсэн тахилгатай уул ус дурьдваас Отгон тэнгэр хайрхан, Бөхөн шарын нуруу, Суварга хайрхан, Булган хайрхан зэрэг уулс, Орхоны эх, Тамирын эх Шаргалжуут зэрэг уул усыг тахидаг байжээ Эндээс би Булган хайрханыг онцлон дурдаж байна. Яагаад гэвэл 1-р богдийн хүрээ 4 н уулын дунд байдаг уншлага сэлтэд жаврэ чингэл хэмээн хойморийн хайрхан гэж хүндэлдэг бөгөөд угаас монгол хүн хоймор талаа хүндлэн эрдмийн зүйлээр бөөлжөөд байдаг эрүү цагаан

хулгана зүг гэж тооцон шүтээнээ залж гэрийн эзэн зүүн хоиноо бар зүгийг эзлэн сууж болохгүй нөхдүүдийг баруун хатавчинд нохой зүгт эзэндээ үнэнч байхийг сануулан суулгадаг байжээ. 2-рт Булган хайрхан нь өнө эртний тахилагатай бурхан уул байжээ. Арван буяны шинж бүрдэхээр аранжин маань гардаг гэдэг бол энд маань түвд үсгээр ургаад байгааг та нар бэлхнээ харж байгаа. Их хүрээ 10 хангал хурахдаа өөр өөрийн аймгийн нийтийн бус сахиусыг тахидаг түүнтэй адил заяын хүрээнд нисэр хангай хэмээх сахиус хурдаг байсныг Би аав заяын доод хүрээний лам Г.Цэрэнбатаас асууж тахилгын сударыг нь хадгалсаар ирсэн юм. Тэр бол булган хайрханы тахилгын судар болно. Уг судар гар бичмэл 18 хуудастай ба түвдийн Дашилхүнбү жүд дацангий н ловон лам нарын нэрсийг Доси Цэрэндоржийн дашлүнбийн түүх номын дагуу дугаарлавал 1-р Зонон Лувсан Дамбиижанцангаас 6-р Гэндэн дүв гэгээн 8-рт Синчин гэлэг равжаа, Зүүнгарын лам 31-р Агчин дарав бандид монгол хүн, 2 монгол хүн байсны 8-р Синчин гэлэг равжаа бээр 1861оны 11 сарын 15 нд Буян дэлгэрүүлэх хийдийн хамба хувилгаан лагшинт Галсан Гүжи Да лам, Зая гэгээний Засаг лам гэх албаны хоёр хүнээс гадна дагуул Гэлэн Лувсан Чойнжүр донир, Ча лам Иш ширав нарын хүсэлтээр зохиосон болой гэжээ. Сударт ондог буюу илт бүтээлт жандэн заллага ганс шавга сан сэржим болон тахил магтаал бүхий өвөрмөгц судар болно. бүгдийг орчуулж ондогийн дагуу уг сахиусийг хоёр нөхөр сэлттэй нь бүтээсэн, Булганы өвөр хэмээх 12 бадаг дуунд хайрханы байдлыг тодорхой харуулсан байдаг. Зээ Булганы өвөрт Зуу галдан хийдтэй, Зургаан мааний үсэг зүг бүхэндээ дэлгэсэн, Долоо найман дацантай ямар сонин ламаа бээ гэж магтсан байдаг энэ үнэхээр биелэлээ олсон нутагаа Миний номын ах Аюуш агсан бээр энэ уулын талаар 31 жилийн өмнө тайлбарлахдаа бар арслан сарлаг хайнаг гэх 4 хүчтэнтэй, арслан зохио бол нэг нь хойшид бурхан ном дэлгэрвэл энэ дөрвийг сэргээн дүрд оруулаарай мөн гэгээний рашааныг сэргээж гаргаарай, нүүрэнд байдаг зонхов бурханыг сэргээгээрэй засаг эхлээд эвлэлийн тэмдэг дараа нь улаан таван хошуу зурж арилгахаар үзээд бараагүйг хэлж тойроод долоон одны байрлалтай Намсиг бурхан, Зүгдэр бурхан, Тамжид жав бурхан, Хорвоон жиг бурхан, Сиртүв бурхан, Одсүрэн бурхан, Шагж түв бурхан зэрэг 7 бурхан байгаа ранжин маанийг олон хүнд битгий хэлээрэй бузартвал алга болно шүү гэж нэг өдөр бүтэн явган дагуулж яваад булган хайрханы дагуул уул усыг нэрлэхдээ Сангийн толгой, Сайрын овоо Цөөн цод Бүрдэнэ хоолой, бүхэг цэнхэр цөөн цод, Алтан овоо Арцат хайрхан цөөн цод, Майдар чулуу, Мааньтийн овоо, цөөн цод хэмээн үрс гаргаж

тахил өргөөд Жи дацангаас зохион баигуулж найр үүтгэн 6 насны морьд мордуулахад мэгзэм уншиж асарын өндөр, армаг түмэн эх холч хурдан, өндөр хангай зэрэг дуу эхэлдэг хайлан гадаалаж найр зохиож лам нар Лам гурван эрдэнэ Булганы өвөр, Төгс цогт их Янжимаа хилигнэсэн дүртэй боловч амирлангүй байдалтай гэж Лам едам чойжин сахиусаа магтан дуулдаг дүйцэн өдрүүдээр Булган хайрхандаа зул өргөж дацангууд ээлжээр тахидаг байсныг хэлж байсан нь өнөөдөр юм шиг санагдаж уул ус лус аргадаж Булган ууландаа бүтээн босголт хийхийг та бүхнээс хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХАРЪЯАЛАГДАХ ШАШИН СҮМ ХИЙДИЙН БАЙРШИЛ

/1990 ОНООС ХОЙШХИ БАЙДЛААР/

1. Архангай аймгийн Батцэнгэл сумын Халзангийн хүрээ.

Тус хийд нь Архангай аймгийн Батцэнгэл сумаас зүүн хойшоо 42 км-т Халзан хэмээх газарт 1832 онд Чойжав тэргүүн байгуулжээ. Энэ хийдэд их,бага дуган хоёр, Цогчин, Манба дацангууд байжээ. Хийдийн төвд хийц маягтай, тоосго шавраар барьсан, 120 гаруй ламын данстай ч ес нь шавилан сууж,хурал ном хурдаг, 110 гаруй нь улирлын байдлаас хамааран хөдөөлөн суудаг байсан. Нэг




аграмбатай байсан. Хийдийн хөрөнгө, мал сүргийн тоо нь нийтдээ 40 гаруй толгой, хашаа 48, байшин 72, эсгий гэр 42 байсан.

Гүж ламын хийд гэж нэрлэсэн нь учиртай, Түвдээс Гүж хэмээх лам ирж суун мөн хожим нь Ширээт лам болсонтой холбоотой юм.Тус хүрээг Баруун хүрээ гэж нэрлэж байсан нь Лу.гүний хүрээнээс одоогийн сумын төвөөс баруун хойш 35 км-т байрлаж байсантай уялдаатай юм.

Тус хийдэд сууж байсан Олзвой хувилгаан 1938 онд улс төрийн хилс хэрэгт холбогдон баригдаад ял эдлэх үедээ оргон гарч улмаар уг хийдээс баруун тийш зургаан км-т орших Халзан агуйтын агуйд сууж байсан. Олзвой хувилгаан 1990-ээд оны эхээр цагаатгагдаж уламжлалт хийдийнхээ туурин дээр суварга босгох санаа сэдэн Батцэнгэл сумын малчин Бавуудорж зохион байгуулж орон нутгийн сүсэгтэн олны хандив өргөлөөр 2006 онд 3м. 30 см өндөр суварга босгожээ.

Олзвой хувилгааныг нутгийн олон түмэн “Өндөр багш” хэмээн авгайлдаг бөгөөд саяхан болтол амьдарч байгаад 2005 онд таалал төгсчээ. Хамгийн сүүлчийн ширээт лам нь 1937 оны үед Норов гэлэнхай байсан бөгөөд энэ хүн одоогийн Гандантэгчилэн хийдийн Идгаа дацангийн шунлайв Доржжанцан гавжийн багш нь байсан ажээ. Уг хийдийн түүхэн тодорхой хугацаанд Түвдээс лам нар олонтаа ирж суудаг байв, Тус хүрээнд улааны урсгалын Нар Хажидын сүмтэй байжээ.

2. Архангай аймгийн Батцэнгэл сумын Тарвачэнболин хийд.



Хуучин Сайн ноён хан аймгийн Лу.Гүн Лувсанхайдавын хошууны нутаг одоогийн Архангай аймгийн Батцэнгэл сумын төвд байсан Тарвачэнболин хийд нь Хойд Тамирын голын хөвөөнд оршиж байв. Энэ хийд нь Төвдийн гүн ухаантан Сэра хийдийн Живзунба Чойжижалцангийн зохиосон Сэрийн игчааны дагуу гүн ухаан судалдаг Чойр дацантай байв.

Лу.Гүний хүрээнээс төрөн гарсан номын мэргэд их, бага хоёр Чойжилыг дурдаж болно. Чухамхүү их хүрээнд ном эрдмээрээ алдаршиж байсан Их Чойжил гавж нь Хувилгааны аймгийн Лувсанчойнзин цоржийн номын багш байв. Чойжил гавж нь төвд хэл дээр олон ном зохиол туурвисан бөгөөд түүний “Бодь мөрийн зэргийн сонссон тэмдэглэл” хэмээх ном нь Их хүрээ зэрэг олон газар барласан алдартай зохиол юм. Лу гүний хүрээ нь 1937 онд сүм хийд хаагдахад 170 гаруй лам хуварга байсан нь архивын баримтаар нотлогдож байна.


3. Архангай аймгийн Батцэнгэл сумын Улаанчулуутын хурал.



Энэхүү хурал нь Батцэнгэл сумын төвөөс зүүн хойш 42 км бөгөөд Улаанчулуутын гол гэдэг газар тал хээрийн бүсэд оршино. Хоёр дуганы туурь дээр үед байсан гэж нутгийн хүмүүс ярьдаг ч одоогоор туурийн үлдэгдэл байхгүй шахам болж, шарилж ургасан байна. Нэрийн учир:

Улаан чулуут хэмээх голын хойд эрэгт байдаг учир гол усны нэрээр нь Улаанчулуутын хурал хэмээн нэрлэжээ. Бас зүүний хүрээ гэдэг байжээ. Энэ нь уг хошуу нутгийн гол төв хүрээ хийд болох Лу.Гүний хүрээнээс зүүн хойш байрладаг учир тийнхүү нэрлэж байсан удаатай, зарим нь эл хурлыг Ганданжадайлин гэж түвдээр нэрлэдэг байжээ. Уг хурал нь 10-14 ламтай байснаа 1937 онд үйл ажиллагаагаа зогсоохоос өөр аргагүй болсон.

4.Архангай аймгийн Булган сумын Бэйсийн хүрээ.



Бэйсийн хүрээ буюу Жамсран Дашдэжээлин хийд нь Архангай аймгийн Тамирын-Дашгай хэмээх газар Төр гэрэлтийн аравдугаар 1830 онд байгуулагджээ. Уг хийд нь нэг Цогчин дуган, Чойр гэдэг дацангуудаас гадна нэг суваргатай байжээ. Эл хүрээнд 140 гаруй ламтай, тэд өвөл, хаврын цаг байнга сууж, бусад үед цаг улирлын байдлаар хурал хурдаг

байжээ. Энэ хүрээ 17 гавжтай байсан нь нутаг хошуундаа эрдэмтэй лам нараар алдартай байсны нотолгоо юм.

б.Архангай аймгийн Булган сумын Шинэ барууны дуган.



Архангай аймгийн Булган сумын нэгдүгээр багийн нутаг сумын төвөөс 38 км-т Тусгалтын булан хэмээх газар гурван сүмийн туурь өдгөө байна."Баруун дуган" гэсэн нь одоогийн Булган сумын нутаг дэвсгэрийн хамгийн баруун биед байсан учир нутгийн ардууд ийнхүү гэж нэрлэж заншжээ. Мөн жононгийн хурал гэх буюу газар усны нэрээр нь Тусгалын дуган

гэж нэрлэдэг удаа байжээ. Энэ зэрэгцээ гурван дуганын зүүнийг нь Лхамын хурлын дуган, дундахыг Оточийн дуган , барууныг Шинэ дуган хэмээн нэрлэх нь бий. Эдгээрээс баруун талынх нь Шаашгай жононгийн мэдлийн дуган байжээ.

Халхын зүүн талын Сэцэн хан аймгийн Хардал Жанжин бэйсийн хошуунаас цөллөгт явуулж, хатуу чанга хуультай, хуульд мэргэн түшмэл сайтай газар хэмээн Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуунд цөлөгдөн ирсэн Шаашгай жонон, Шамба дайчин гэгч хүнийг Сэцэн чин вангийн хошуунаас Их баруун суманд захируулан өгчээ. Их баруун сум нь одоогийн Булган сумын нутаг дэвсгэрийн баруун биед оршино.

6.Архангай аймгийн Булган сумын Жононгийн хурал.

Халхын Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, Зая бандида хутагтын шавийн нутаг, одоогийн Архангай аймгийн Булган сумын нутагт эл хурал байжээ.

7.Архангай аймгийн Булган сумын Багын хурал.


Халхын Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Булган сумын нутаг Суварга уулын ойролцоо энэхүү хурал оршиж байжээ.

8.Архангай аймгийн Жаргалант сумын Азрагын (ажрагийн) хүрээ.



Архангай аймгийн Жаргалант сумын төвөөс баруун тийш 35-км т Хүрээт уулын өвөрт орших Ажрагийн хүрээ нь 1913 онд байгуулагдсан бөгөөд Улиастайн хүрээний жасаа хурал байв. Энэ нь 1200 орчим бог, 800 орчим бодтой томоохон жасаа байжээ. Тус хурлын гурван дуганд 3-4 тахилч лам байнга сууж хаврын эхэн сарын шинийн 8-15, зуны дунд сарын эхэн, намрын дунд сарын дундуур болон өвлийн эхэн саруудад Улиастайн хүрээнээс лам нар ирж ном хурдаг байв. Ажрагийн хурлын лам хуврагуудаас Дамбийжанцан, Пүрэвдорж, Дэмчиг нарын гэлэнгүүд 1970-аад оныг хүртэл амьд сэрүүн байсан байна. Уг цагийн хурал 1979-аад оныг хүртэл амьд сэрүүн байсан байна. Уг цагийн хурал 1979 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын угсаатны зүйн атлас”-ын сүм хийдийн бүртгэлийн 156-рт Азрагын хурал нэрээр бүртгэгдсэн байна.

9.Архангай аймгийн Жаргалант сумын Асайтын хүрээ.



Тус хүрээний туурь нь одоогийн Архангай аймгийн Жаргалант сумын төвөөс баруун урагш 35 км орчимд Асайт багийн нутаг Булган уулын энгэр хүрээний дэнж хэмээх газар байдаг. Асайтын хүрээ нь тухайн цаг үедээ Сайн ноён хан аймгийн Эетэй гүн Даянжалбуу засгийн хошууны шашин номын төв байсан бөгөөд 1810-аад оны

үед байгуулагдсан хэмээн үздэг. Тус хүрээний үүсгэн байгуулагч нь тухайн үеийн засаг ноён байсан бололтой.

Асайтын хүрээ Чойр, Чогчин, Жүд, Мамба, Сахиусын зэрэг долоон сүм дугантай, 200 орчим лам байнга сууж байсан суурин амьдралын хэв шинж бүхий төвлөрсөн газар байжээ. Асайтын хүрээний анхны хувилгаан нь Түвдэн, хоёр дахь нь их номч Ханчин хамба Сүрэнхорын Жамъяангарав, гурав дахь нь буюу сүүлчийнх нь Очиржанцан байв. Хүрээнд гавжийн дамжаа барьдаг байсан ба 10 гаруй гавж мяндагтантай, зуны эхэн сард Майдар эргэдэг, намрын дунд сард хайлан хурж байжээ. Хүрээний гол шүтээн нь Балдан Лхам бурхан байсан бөгөөд энэ хүрээнд шүтэгдэж байсан бас нэг шүтээн 80см өндөр босоо Майдар цутгамал бурхан эдүгээ Жаргалант сумын Асайт багийн нэгэн өндөр настныд үе дамжин хадгалагдаж байжээ.

Асайтын хүрээ нь хөрш зэргэлдээ Мэргэн гүний хошууны одоогийн Хөвсгөл аймгийн Рашаант сум Рашаантын хүрээ, Далай Чойнхор вангийн хошууны одоогийн Архангай аймгийн Тариат сум Тариатын дээд, доод хүрээ, Заяын хүрээ зэрэг хүрээ хийд хурал номын газруудтай ном, эрдмийн өргөн харилцаатай байжээ. Тус хүрээ нь 1932 онд баруун аймгуудад гарсан лам нарын хөдөлгөөний үед их хохирол үзэж зарим сүм дуган нь устжээ.

Ханчин хамбо хэмээн алдаршсан бурханы шашны сонгодог боловсролтон, утга зохиолын онолч, яруу найрагч, соён гэгээрүүлэгч Сүрэнхорын Жамъяангарав нь Асайтын хүрээнээ 1890 онд Цанидын дацанг байгуулсан номын мэргэн багш байв. Тэрээр хуучин Сайн ноён хан аймгийн Даянжалбуу засгийн хошуу, одоогийн Архангай аймгийн Жаргалант сумын нутагт 1891 оны аравдугаар сарын 25-нд төржээ. С.Жамъяангарав бага насандаа буддын таван их ухааны

эрдэмд шамдаж, санскрит хэлийг бие даан сурч буддын шашин, гүн ухааны өндөр боловсрол эзэмшсэн бөгөөд “Очироор огтлогчийн тус эрдмийг номлосон судар” зэргийг түвдээс монгол хэл рүү хөрвүүлсэн төдийгүй “Эсура тэнгэрийн дуун эгшиг” гэдэг утга зохиолын онолын тулгуур бүтээл нь төвд, Монголын номын мэргэдэд ихэд үнэлэгдэж, XIII далай лам Түвдэнжамц энэ бүтээлийн учир түүнд Эрдэнэ мэргэн баньдид” гэдэг номын их цол хүртээжээ. С.Жамьяангарав энэ бүтээлдээ дорно дахины уран сайхны сэтгэлгээний сонгодог уламжлалд түшиглэж яруу найргийн онол, урнаар дүрслэх арга зарчмыг тайлбарлахдаа олон зуун бадаг шүлгийг зохиож энэхүү номдоо оруулжээ.

10.Архангай аймгийн Жаргалант сумын Хоолтын завдлын хийд.



Сайн ноён хан аймгийн Даянжалбуу засгийн хошуу, одоогийн Архангай аймгийн Жаргалант сумын төвөөс баруун хойш 15км-т, Сайшаалт ерөөлтийн арванесдүгээр 1814 онд эл хийдийг үүсгэн байгуулжээ. 1937 онд сүм хийд хаагдахад 220-иод ламтай, үүнээс 22 лам гавжийн мяндаг цол хамгаалсан байв. Энэхүү хийд нь Цогчин дуган,

Манба дацангаас гадна хоёр дацантай байжээ. Уг хийдийг Архангай аймгийн Жаргалант суманд Даянжалбуу, Данзанжалбуу болон засгийн зүүн отгийн хэсэг ардууд байгуулснаас хойш хийдэд дуган дөрөв, Цогчин, Манба, Чойнбрүл гэсэн дацангуудтай болжээ. Хийдийн барилгыг түвд маягаар тоосго, шавраар мод ашиглан барьсан байна.

11.Архангай аймгийн Жаргалант сумын Дашпэлжээлин хийд.

Гэндэнгончог буюу Дашпэлжээлин хийд нь Архангай аймгийн Жаргалант сумын төвийн зүүн талд өндөр уулын бүсэд оршдог. Энэхүү хийдийн нэрийн утга нь “хуврагууд арвижих дэлгэрэх” гэсэн утгатай Түвд үг юм. Жаргалант сумын төвийн орчимд ямар нэгэн хуучин хийдийн буурь туурь уламжлалт хийдийн нэрээр 1991 онд Асаатын хүрээ, Рашаантын хүрээнд сууж байсан өндөр настан лам гэлэн Пүрэвдорж шинэ сүм санаачлан байгуулж, анхны хамбаар нь ажиллаж байжээ. Одоогоор түүний хүү Нямжанцан тус хийдийн



хамбаар ажиллаж байгаа бөгөөд тус хийдэд хурлын Цогчин дуган, Дара эхийн дуган, сүсэгтэн олны бүтээсэн таван метр өндөр хоёр бодь суварга, гурван метр өндөртэй гонх бүхий том хүрд, мөн жижиг зургаан хүрдтэй болгосон байна. Дашпэлжээлин хийд нь 20 гаруй ламтай бөгөөд сардаа 4-6 удаа хурал хурдаг. Шинийн 8,15-нд цогчин, шинийн 29-нд Чойжоо

сахиус, Арван хангал хурдаг.

12.Архангай аймгийн Жаргалант сумын Улиастайн хүрээ.

Хуучин Сайн ноён хан аймгийн Эетэй гүн Даянжалбуу засгийн хошууны Зүүн багийн буддын шашин ном, соёлын төв болох Улиастайн хүрээ нь Жаргалант сумын төвөөс чанх хойш 20 орчим км-т Улиастайн голын баруун эргийн Эрдэнэ уул хэмээх овоо тахилга бүхий бэсрэг уулын өвөрт Шар хөндий хэмээх дэвсгэгт 1905 оны орчимд байгуулагдсан гэж сурвалжид тэмдэглэжээ. Улиастайн хүрээ нь Чойр,Цогчин зэрэг есөн сүм дугантай, 400 лам хуврагтайгаас 250 орчим нь шавилан суудаг тухайн үеийн дунд зэргийн хэмжээний хүрээ хийд байжээ. Улиастайн хүрээ зуны эхэн сарын адгаар Майдар хурдаг, намрын эхэн сард хайлан хурж мөн зуны эхэн сард ганжуур эргэх шашны зан үйл явуулж байсан ажээ. Тус хүрээнээс Ганжуур, Жалцов, Норов, Ванчин, Дамчаа, Цэрэн нарын гавж нар Норов, Загд нарын зурхайч байсны дотор Ванчин гавж, зурхайч Загд нар хэлмэгдүүлэлтийн үед ял эдлээд нутаг орондоо ирцгээсэн байна. Уг хүрээний лам хуврагуудаас 1980-аад оныг хүртэл Гэлэг,Дүгэр, Ёндон, Соном, Чойжанцан, Пүрэвдорж, Дамба-Осор,Жигжид, Чогсом, Сономравдан нарын номтой гэлэнгүүд ус нутагтаа энх тунх амьдарч байжээ.




13.Архангай аймгийн Их тамир сумын Норбулаг буюу Норовлин дуган.

Норовлингийн дуган нь Их тамирын Баянзүрх уулын өвөрт Тамирын голын хойд биед Хан-Өндөр багийн төвөөс баруун

хойш зургаан км-т оршино. Дуганын байсан газрыг нь Бумбат уулын баруун суга гэнэ. Архивын 1938 оны мэдээгээр энэ дуган байгуулагдсанаасаа хойш 58 жил болсон ажээ. Барилгыг тоосго, шавраар барьсан, цагийн хурал байжээ. Лам нар нь Их Тамир сумын Хан-Өндөрийн хүрээнд данстай байв.

14.Архангай аймгийн Их Тамир сумын Хан-Өндөрийн хүрээ.



Халхын Сайн ноён хан аймгийн ноёдын дээд өвөг Түмэнхэн сайн ноёны наймдугаар хөвгүүн Дэнзэнванжуур Энх-Амгалангийн арваннаймдугаар 1697 онд хүрээг үүсгэн байгуулжээ. Түүнээс хойш Сэцэн чин ван Дарам, Эфү засаг Лхавандорж, Чин ван Цэндбазар, хошой чин ван Наянт нар удаа дараалан Сэрийн игчааны Чойр, Дүйнхор, Ламрим, Жүд, Манба

дацангуудыг дараалан байгуулжээ.

Хан-өндөрийн хүрээ нь хошуу нутгийн гол дунд Тамирын голын хойд этгээдэд оршиж байв. Энэхүү хүрээ нь Сайд вангийн хүрээ гэж алдаршжээ. Сайд вангийн хүрээнээс төрөн гарсан цорж Мэндбаяр судар тарни, зан үйлийн чиглэлээр хоёр боть зохиол, Ёндон маарамба “Анагаах ухааны дөрвөн үндэсний түүвэр нэг” зэрэг зохиолуудыг түвд хэл дээр туурвижээ. Хийдийн тууриас хойно 600 орчим метрт Манбын овоо, тууриас хойш 100 орчим метр зайд 2003 онд сэргээн босгосон найман суварга байна. Эдгээр суваргыг тус сум багийн унаган иргэн өндөр настан М.Нацаг-Юм гэр бүл, үр хүүхдийн хамт босгожээ. Хан-Өндөр хэмээх домогт уулын нэрээр нэрлэгдсэн энэхүү хүрээ нь Их тамир сумын одоогийн Хан-Өндөр багийн орчимд Хойд Тамирын голын ар хөвөөнд байжээ.

15.Архангай аймгийн Их Тамир сумын Хужиртын дуган.




Энэ дуган Архангай аймгийн Их Тамир 1800-аад оны үед байгуулагдсан бөгөөд ном барладаг бархантай байжээ. Барилгыг тоосго, шавраар барьсан, цагийн хурал байв.

Энэхүү цагийн хурал Их

тамир сумын төвөөс хойш 18 км-т Хужиртын эх гэдэг газар хоёр дуганд хурал номынхоо үйлдлийг явуулдаг байжээ. Зүүн тийш 400 метр орчимд Хужиртын овоо хэмээх нутгийн тахилгат овоотой, ойт хээрийн бүсэд байрладаг энэхүү хоёр дуганын туурийн одоогийн байдал газрын хөрснөөс дээш 30см.өндөртэй шороон далан болон үлдсэн байна.

16.Архангай аймгийн Их Тамир сумын Тамирын хүрээ.



Тамирын хүрээг Халхын сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу,одоогийн Архангай аймгийн Их тамир сумын нутагт 1815 онд Гижээпэл ноён үүсгэн байгуулжээ. Сүм, дугануудыг түвд хэв загвартай, тоосго шавраар барьснаас гадна 1930-аад оны сүүлч гэхэд чанар сайтай байжээ. Тамирын хүрээнд 475 лам байснаас 370 гаруй нь

байнга хурал ном хурдаг, 100 шахам лам нь цаг улирлын байдлаар, хөдөөний гэртээ суудаг байжээ. Уг хийд мал аж ахуй эрхэлдэг байв.


17.Архангай аймгийн Их Тамир сумын Шавартын дуган.



Тамирын голын урд салааны хойд бие Хундага модны дэргэд Цагаан чулуутын хошуунд нэгэн дуган байжээ. Эл дуганын дэргэдэх Хундага мод хэмээх өвгөн хуш мод хэвтэж буй үхрийн дайтай цагаан чулууг нутгийн хүмүүс шүтдэг байна.

Архангай аймгийн Их Тамир сумын нутагт Лашан хувилгаан лам удирдан 1927 онд Шавартын дуганыг байгуулсан бөгөөд барилгыг тоосго, шавраар барьж, Их Тамирын хүрээнд данстай явдаг байжээ.

18.Архангай аймгийн Өлзийт сумын Өөлд бэйсийн хүрээ.



Хуучнаар Сайн ноён хан аймгийн Бишрэлт бэйсийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өлзийт сумын нутаг байсан Өөлд бэйсийн хүрээ 1702 онд Цогчин, Жүд, Чойр, Манба дацангууд байгуулснаас үүдэлтэй бөгөөд энэхүү хурал нь нүүдэллэн хурсаар Төр гэрэлтийн хоринтавдугаар 1845 онд Бэйс Чагдаржавын үед

Орхон голын хойд захад Байшир уулын өвөр Хашаатын дэнжид суурьшжээ. Энд зуугийн сүм, Дара эхийн сүм зэрэг сүм дуганууд байсан. Бэйсийн хүрээнд Түвдээс Ооромбо гэгээний хувилгаан Лувсандашийг залж суулгадаг байснаас улбаалж Ооромбын доод хүрээ гэж алдаршсан. Өөлд бэйсийн хүрээнд Ооромбын хувилгаан Лувсандондовпринлайжамц залагдан сууж байсан гэдэг. Галдан Бошгот ханы дайн самууны үед Халх нутгийн гүнд суурьшсан Өөлд түмний гол шүтээн Алтан зуу бурханыг тусгай сүмд тахин шүтдэг байжээ. Сайн ноён хан аймгийн Өөлд сүжигт бэйсийн хошуу нь 1923 оноос Цэцэрлэг мандал уулын аймгийн Хотонт уулын хошуу гэж нэрлэгдэж байснаа 1926 онд Эрдэнэбулган уулын хошуунд нийлэх үед Архангай аймгийн Өлзийт, Хотонт, Өгийнуур сумдын нутгийг хамрах болжээ.

19.Архангай аймгийн Өлзийт сумын Алтанзуу хийд.



Тал хээрийн бүсэд Өлзийт сумын төвд Орхон голын баруун биед эл хийд оршиж байв. Алтанзуу хийдтэй нэр холбоотой Ооромбо гэгээн нь түвдээс гэгээнээр тодорсон хүн юм. Б.Ринчин гуайн сүм хийдүүдийн тухай гаргасан жагсаалтын 165-т Ооромбын өгүүлэн буй доод хүрээний үүсэл нь 1797 онд тавигдсан бөгөөд энэ хүрээ 1843

онд өдгөөгийн газраа шилжин ирж суурьшихдаа хоёр хэсэг болж

нэг хэсэг нь Алтанзуу хийд буюу Ооромбын доод хүрээ, нөгөө нь одоогийн Өгийнуур сумын нутаг Баясгалант уулын өвөрт Ооромбын дээд хүрээ нэртэйгээр суурьшжээ.

Зуугийн жас, Чойрын жас зэрэг хоёр жастай Алтан зуугийн сүм, Дара эхийн сүм, Маналын дуган, Чойрын дуган, Жүдийн дуган зэрэг 16 сүм, дугантай байжээ. 1797 онд анх Онзод уулын өвөрт 13 жил оршин байснаа ахин нүүж Рашаант уулын баруун зүүн салааны уулзварт Өвгөн хүрээ хэмээх газар байрлаж байгаад 1843 онд Хөшөөтийн дэнж хэмээх газарт буужээ. Өөлд түмний гол шүтээн нь Алтан зуу бурхан юм. Өлзийт сумын хүн амын ихэнх нь Баруун Монголоос гаралтай Өөлд ястан бөгөөд Манж чин улсын үед Өөлдийн умард хошуу нэртэй байснаа Өөлд бэйсийн хошуу хэмээн нэрлэгдэх болжээ.

20. Архангай аймгийн Өгийнуур сумын Лавран хийд.



Сайн ноён хан аймгийн Бишрэлт бэйсийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өгийнуур сумын төвөөс зүүн хойшоо 20 км-т орших Ооромбын дээд хүрээг 1848 онд Түвдийн Ооромбо хувилгаан Лувсандандав принлайжамц үндэслэн байгуулжээ. Түвдээс дагаж ирсэн Түвд хүмүүсийн үр сад өнөө хэр энд амьдарч байдаг. Ооромбын хүрээ нь Цогчин, Чойр,

Жүд, Манба зэрэг дөрвөн хуралтай жижгэвтэр гоёмсог хийдтэй байсан гэдэг. 1904 онд XIII Далай лам Дайчин вангийн хүрээнд өвөлжөөд Заяын хүрээ орох замдаа өртөөг гуйвуулан засаж Ооромбын хүрээ дээр саатаж байжээ.


Тус хийд нь их, бага дөрвөн дуган, 70 орчим ламтай, үүнээс дооромбо нэг, аграмба 11 байсан ба хөгшчүүд нь их төлөв шавилан сууж, багачууд нь цаг улирлын байдлаар хуралд ирдэг байжээ. Хийдийн барилгыг тоосго, шавраар барьсан, 1930 оны сүүлч хүртэл чанар сайтай байв.

21.Архангай аймгийн Өгийнуур сумын Хорчингийн хийд.




Халхын Түшээт хан аймгийн Түшээт ханы хошуу, одоогийн Архангай аймгийн Өгийнуур сумын нутагт эл хийд оршиж байжээ. Энэ нь XIX зууны үед Өгийнуураас урагш байсан цагийн хурал юм. Хийдийн туурь нь Өгийнуур сумын төвөөс 30км-т, Улаан худаг гэдэг газар, Түргийн хөшөө дурсгалаас 16-км т байдаг.

22.Архангай аймгийн Өгийнуур сумын Хорчингийн сэргээгдсэн хийд.



Хорчин хийд нь Архангай аймгийн Өгийнуур сумын төвд 1994 оны 6 сард сэргээн байгуулагдсан юм. Шарын шашны гэлүгва урсгалтай энэ хурал дөрвөн ламтай, зөвхөн дүйчин өдрүүдэд хурлаа хурдаг.

23.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Бор Бургасын хийд.



Халхын сайн ноёнхан аймгийн Сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын төвөөс зүүн тийш 50 км-т Бор Бургас голын ойролцоо эл хурал байжээ. 1938 оны архивын мэдээгээр Бор бургасын хурал нь байгуулагдсанаас хойш 50 жил болсон байна. Энэ хурал, дуган нэг, 30-аад ламтай ч байнга суудаг ламгүй, цаг улирлын байдлаар

хурал хурдаг байв. Модон дугантай эл хурал нэг жастай байжээ.




24.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Бугатын туурь буюу Махагалын хурал.

Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт Бугатын гол хэмээх газарт энэхүү цагийн хурал оршиж байжээ.



25.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Дара-эхийн хурал.

Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг Хануйн голын орчим байсан цагийн хурал юм.



26.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Жанцангийн хурал.

Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт Сээрийн ат гэдэг газар эл хурал оршиж байжээ. Цагийн хурлын туурь нь сумын төвөөс 27км-т байна.



27.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Маанийн дуган.


Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг, аймгийн төвд байрлах Маанийн дуган нь байгуулснаас хойш 1938 он хүртэл 50 жил болсон байна. Тус

хийд нь нэг модон дуган, 20 гаруй ламтай, шавилан суудаг ламгүй, цаг улирлын байдлаар хурал хурдаг байв. Маанийн дуган нэг жастай байжээ.



28.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Очирвангийн хурал.

Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт сумын төвөөс 90 км-т Хануйн голд Очирвангийн хурал байжээ.



29.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Олон Турууны хурал.

Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт Цагаан-Овоо хэмээх газар энэхүү цагийн хурал байжээ.


30.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Пунцагчойнхорлин хийд.



Архангай аймгийн Өндөр-Улаан сумын төвд 1990 оны гуравдугаар сарын 8-нд Сампил гавж, лам Намбар, Жагдал нар Пунцагчойнхорлин хийдийг шинээр байгуулжээ. Тус хийд нь шарын шашны Гэлүгва урсгалтай, найман ламтай бөгөөд зөвхөн дүйчин өдрүүд болон шинийн 8-нд Чогчин хурдаг, 1993онд Бакула ринбүүчи энд морилжээ.

Одоогоор 12-16 насны таван хүүхдийг уншлагад сургаж байна.

31.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Шагжийн хурал.



Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын төвөөс зүүн урагш 65км-т Нэрсдийн ам хэмээх газар орших Хүйн Дуган буюу Шагжийн дуган 1867 онд байгуулжээ. Тус дуганыг Хуучин чин вангийн хошууны Шагжийн хамжлагын хэсэг ардын санаачлагаар байгуулжээ. Шагжийн хурал нь модон сүм,

дуган гурав, жас гурав, 50 ламтай, цагийн хурал байжээ.

32.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Тээлийн хурал ба хоёр сүмийн хурал, Доройн хурал.



Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг Тээлийн голд 1897 онд эл хурал байгуулагджээ. Тээлийн хурал гурван дугантай, 60 орчим ламтай байв.


33.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Дүйнхор тэргүүний хурал.

Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутаг Тойрох нуур гэдэг газар байсан цагийн хурал юм.

34.Архангай аймгийн Өндөр-Улаан сумын Шагжийн хурал.


Халхын сайн ноён хан аймгийн сайд вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт Хануйн голын орчим нэг дугантай цагийн хурал байжээ.

35.Архангай аймгийн Тариат сумын Баянжаргалантын хийд.



Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, Одоогийн Арханагй аймгийн Тариат сумын төвөөс зүүн тийш 68км-т Мөрөн багийн нутаг Ар давааны ам гэдэг газар 7,8 дуганы ул мөр бий. Ерөнхийдөө өндөр уулын бүсэд орших энэ дуганын туурийн хойно нь Бомбоо чулууны уул, баруун талд нь Ханат баян цагаан уул, зүүнтэй нь Гичгэний уул оршино.

Баруун урд талд нь нэг км. орчимд модот уулын оройд Баян цагааны овоо хэмээх тахилгат овоо байдаг.1892 онд байгуулагдсан гэх энэ хурал нь ойр орчмын жасаа хурлуудын дотроос харьцангуй том, 40-өөд лам байнга шавилан суудаг. 7,8 дугантай хурал номын газар байжээ.Барилга байгууламжийн хувьд хүрээний ангилалд хараахан оруулах боломжгүй ч Баянжаргалантын дуган хэмээх энэ газар зөвхөн цагийн хурлын дуган биш хийд байсан гэж үзэх бололцоотой.1937 оны хавар хаагдаж 1940-өөд оны үед устгагдсан энэ хурал номын газрын үйл ажиллагааг эдүгээ Тариат сумын өндөр настан хуврага Дашравдан гуай өөрийн санаачлага хүч хөрөнгөөр сэргээн Мөрөн багийн төвд сэргээн байгуулан үргэлжлүүлж байна. Уг хурлын газар нь БНМАУ-ын угсаатны зүйн атласын 182-рт Баянжаргалантын дуган нэртэйгээр бүртгэгдсэн байдаг.



36.Архангай аймгийн Тариат сумын Дашлин хурал.

Халхын сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Тариат сумын нутаг Их жаргалант хэмээх газарт Дашлин хурал 1848 онд байгуулагджээ.

37.Архангай аймгийн Тариат сумын Бөөрөлжүүгийн хурал.



Хуучин сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны Үйзэн тайжийн харьяа одоогийн Архангай аймгийн Тариат сумын Бөөрөлжүүт багийн нутаг, Тариат сумын төвөөс зүүн хойш 31 км-т Бөөрөлжүүтийн голын өлзий талын аманд 2-3 дуганы туурь байгаа нь энэхүү Бөөрөлжүүтийн хурлын туурь ажээ. Одоогоор дуганы чулуун сууриуд газрын

хөрсөнд зоолттой хэвээр үлдсэн ба уг дуганууд 1900-аад оны эхэн үеэр байгуулагдаж 1937 онд бүрэн хаагдсан гэж үздэг. Нутгийн хүмүүсийн ам мэдээллээр энд Цогчин дуган, Сахиусын дуган баттай байсан бололтой. Дуганууд 1980 оныг хүртэл малын тэжээлийн агуулах болон оршиж байгаад хожим нь устгажээ. Уг цагийн хуралд Тариатын хүрээнээс биш Баянжаргалантын дуганаас лам нар хавар, зун, намар хүрэлцэн ирж хурал хурдаг байсан тухай ам мэдээлэл бий.

38.Архангай аймгийн Тариат сумын Дашдаржаалин хийд.



Дашдаржаалин хийд нь Архангай аймгийн Тариат сумын Мөрөн багаас зүүн хойно Улаан толгойн уулын энгэрт оршино. Тус хийдийг 2003 оны долдугаар сарын 3-нд Дашравдан, Долгорсүрэн, Санжмятав, Даваадорж нарын санаачлагаар байгуулжээ. 2003 оны долдугаар сарын 12-нд шинэ сүмийг аравнайлсан бөгөөд билгийн улирлын цагаан сараа

энд гурван хоног ерөөл хурдаг юм.



39.Архангай аймгийн Тариат сумын Гичгэний дээд хурал.

Халхын сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Тариат сумын төвөөс зүүн урагш 38км-т орших Бүдүүн Гичгэний гол хэмээх газар 1818 онд эл хурал байгуулагджээ.

40.Архангай аймгийн Тариат сумын Нарийн ламхайн хүрээ.



Архангай аймгийн Тариат сумын Хорго багийн нутаг Тэрхийн цагаан нуурын овооны булан хэмээх газраас зүүн хойш нэг км.орчимд дуганы туурь бий. Энэ нь Тариатын хүрээний жасаа хурал байсан бөгөөд нутгийнхан Шанаат нарийны жас буюу Ламхайн хурал гэж нэрлэж байжээ. Шанаат нарийн гэдэг нь энэдэх газрын нэр бөгөөд

уг дуганын байнгын тахилч өвгөн ламыг ламхай гэж ард олон авгайлан хүндэтгэдэг байснаас Ламхайн хурал гэж нэрлэх болжээ. Энэ нь 1979 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын угсаатны зүйн атлас”-ын сүм хийдийн жагсаалтын 185-рт Ламхайн хүрээ нэрээр бүртгэгдсэн байна. Одоогийн туурийн байдал нутгийн хүмүүсийн ам мэдээлэл, бусад эх сурвалжуудаас үзэхэд хүрээ биш, Тариатын хүрээний харьяа жасаа хурал байсан бололтой.

41.Архангай аймгийн Тариат сумын Овооны булангийн хүрээ.

Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Тариат сумын төвөөс баруун тийш 58 км-т Цагаан нуур багийн нутагт, Цахир сумын төвөөс зүүн тийш 17 км-т Цагаан овоо хэмээх тахилгат овоо бүхий толгойн зүүн суга, хойд тэрхийн голын хойд эргээс 1,2 км. зайд хоёр дуган оршиж байжээ. Энэ нь Тариатын хүрээний жасаа хурал бөгөөд 1890-ээд оны үед байгуулагдаж 1932 оны сүүлээр хаагдаж, үлдсэн хоёр дуган нь 1940-



өөд оны эхээр устаж үгүй болсон хэмээн нутгийнхан ярьдаг юм.

Овооны булангийн хоёр дуганд зуны эхэн сар, намрын дунд саруудад Тариатын хүрээнээс лам нар ирж 7,14 хоногийн хугацаагаар хурал хурдаг байжээ. Мөн зуны эхэн сар, намрын эхэн саруудад ойролцоо орших Цагаан овоог тахидаг байлаа.

Дуганд хурал хураагүй үед тахилч лам өдөр бүр зул хүж асааж, бурхан тахилыг нь сэргээж байсан гэлцэнэ. Овооны булангийн хоёр дуганыг хожмын Тариат сумын Авгалдай бригадын төв дээр шилжүүлэн байрлуулж агуулах болгосон нь одоо ч тэр хав янзаар Цагаан нуур багийн төвд хувь хүний модон байшин, пэн болон ашиглагдаж байна.


42.Архангай аймгийн Тариат сумын Загастайн хүрээ „Дандарчойпунцаглин”.

Халхын сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Тариат сумын нутаг Зүүн их загаст голын орчим энэ хурал оршиж байжээ.

43.Архангай аймгийн Тариат сумын Улаанчулуутын хурал.

Халхын сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Тариат сумын нутаг Нарийн гичгэний голд байсан цагийн хурал.

44.Архангай аймгийн Тариат сумын Тариатын доод зүүн хүрээ.



Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Тариат сумын төвөөс баруун тийш 52 км орчим Цагаан нуур багийн нутаг Эрээн мод хэмээх бэсрэг уулын зүүн этгээд Ногоон ховог уулын өвөрт энэхүү хүрээ оршиж байжээ.

Анх Чин улсын Энх-Амгалангийн гучиндолдугаар

1698 онд байгуулагдаж Санчүвлин буюу сайнаар судлагч нэртэй болсон цагаас 1930-аад оны сүүлч хүртэл оршин тогтнох хугацаандаа эл хүрээ шашны Гүн ухаан, зурхай, анагаах ухаан, дуун ухаан, их,бага, ухааны салбаруудыг судалдаг Чойр, Жүд,Манба,Зурхай, Дүйнхор зэрэг 22 дацантай, 1000 гаруй лам шавилан суудаг, томоохон хурлын үед 3000 шахам лам цуглардаг олон сан жастай, Сайн ноён хан аймгийн төдийгүй Халхын шарын шашны томоохон төв болон бэхжжээ. Тариатын хүрээ нь дотроо, гол хүрээ, баруун зүүн хүрээ хэмээн хуваагдаж, дундуураа нарийн гол горхиор зааглагдсан вааран дээвэртэй төвд хэлбэрийн тоосгон дугануудтай, 30 гаруй суварга бүхий тохилог хүрээ байжээ. Хүрээ байгуулалтын хувьд дуган, дацан, сүм, хуварга, хэрэм зэрэг шашны олон арван байгууламжтай. Эдгээр байгууламжийн ерөнхий цогц тиг нь монголчуудын эртний ан ав,аян дайн, нүүдэл суудлын үед оторлон буудалладаг уламжлалт хэлбэр болох хүрээлэх, шивээлэх хэлбэрийг агуулсан бүтэцтэй байв. Эл хүрээ ХЛИ-ХИХ зууны үеийн Монголын нийгмийн хүн амын давхраажилтын бүтцэд гарсан нэг томоохон өөрчлөлт болох дан ганц нүүдлийн соёл иргэншлээс суурьшмал амьдралд шилжих үзэгдлийг өөртөө агуулсан хүн амын янз бүрийн давхрааны лам мяндагтнууд, шавь ардууд, худалдаачид, гар урчууд, борчууд, ядуучуудын төлөөлөл төвлөрсөн суурин газар болжээ.

Тариатын хүрээнд усан туулай жил 1723 онд дөрвөн аймаг байгуулсан бол 1729 онд Цогчин хурлын шинэ дуган барьжээ. 1809 онд Цанид, 1813 онд Дүйнхор, 1819 онд Манба, 1825 онд Жүд, 1842 онд Зурхайн номын сургууль дацанг тус тус үүсгэн байгуулсан байна.1849 онд гавжийн дамжаа, 1855 онд Равжамбын дамжаа, 1867 онд Маарамбын дамжааг тус тус анхлан барьсан байдаг. Тариатын хүрээнд 1886 онд бүтээсэн 44 тохой өндөр алтадсан Майдар,1889 онд босгосон 80 тохой Богд Зонхова зэрэг бурхадын дүр нь тухайн үедээ бусад хүрээ хийд төдийгүй их хүрээнд ч бий болоогүй байсан гэдэг. Тус хүрээ нь бусад хүрээ хийдийн нэгэн адил жил бүрийн намар цам гаргаж, Майдар бурхан эргэдэг байв. Үүнд эрлэг номун хааны Жахор цам, Гэсэр цам хоёрыг хоёуланг нь гаргаж байснаараа онцлог юм. Тариатын хүрээний гол сахиус нь арван догшдын дунд орших ганц бүсгүй чойжин болох Лхам бурхан байжээ.

Тариатын хүрээнээс Түвд, Монголд эрдэм чадал ном бүтээл нь алдаршсан олон арван мэргэд төрөн гарснаас да лам Данзан тойн, гэсэр лам ранжамба, Бэх-Очир, Дагва аграмба, Майдар лам, Шарав унзад, Даваацэрэн гавж,Гомбоцэрэн цорж, хувилгаан

Сэнгээ ринбүүчи, Дүлба маарамба, тойн Арвашдүвжэр , Монголын шашинтны төв Гандантэгчэнлин хийд дахин сэргээсний дараах анхны хамба Найдангийн Эрдэнэпил нарыг нэрлэж болно. Ялангуяа Лүнриг Дандар маарамба нь түвд хэл дээр анагаах ухааны олон сонирхолтой ном зохиосон бөгөөд ялангуяа гүн ухааны хэлцэн мэтгэлцэх аргаар анагаах ухаанд суралцах гарын авлага туурвисан нь түвд оронд ч үзэгдээгүй бүтээл байжээ. Лүнриг Дандар маарамбын “Анагаах ухааны дөрвөн үндсийн тайлбар намжал ар үрийн эрхэс” хэмээх зохиол нь ихэд алдартай. Тус хүрээ нь Нарийны хурал, Бөөрөлжүүтийн хурал, Улаан чулуутын хурал, Овооны булангийн хурал, Гичгэний дээд хурал, Ламхайн хурал зэрэг жасаа хурлуудтай байжээ.

Тариатын доод хүрээ 1932 оны хавар баруун дөрвөн аймагт гарсан лам нарын бослого хөдөлгөөний нэг томоохон төв болж байв. 1938 онд Тариатын доод хүрээ бусад хийдийн адил эзгүйрэн хаагдсан байна.

1990-ээд оны үед нутгийн сэхээтнүүд Монгол улсын хөдөлмөрийн баатар сум нэгдлийн дарга С.Минжүүр, “Далай ван аудит” компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн, иргэн Л.Батсүх, нарын санаачлагаар Цогчин дуганы туурин дээр дуган босгосон боловч олны хөлөөс зайдуу байнгын үйл ажиллагаа байхгүй зэргээс шалтгаалан нутгийн иргэд 1995 онд Тариат сумын төвд Санчүвлин нэртэй Цогчин дуганыг сэргээн шинээр байгуулж сүсэгтэн олондоо үйлчилж байна.

45.Архангай аймгийн Тариат сумын дээд хүрээ”Үүрд хөгжүүлэгч хийд.



Халхын сайн ноёнхан аймгийн Далай чойнхор вангийн хошууны Дээд хүрээ гэж алдаршсан энэ хийд Тариат сумын төвөөс баруун урагш 51 км-т Тариат голын орчим байв.Тариатын дээд хүрээг Үүрд хөгжүүлэгч хийд гэж нэрлэдэг байжээ. Энэ хүрээ нь Тариатын хүрээний нэг хэсэг болох Дээд хүрээ буюу Баруун хүрээ юм. Уг хүрээг байгуулахдаа сүм дуганы

уран барилга хийцийн хувьд нилээд өвөрмөц Хятадын “Утай” буюу Таван оройт гэх ариун дагшин орны хэлбэр загвараар барьсан гэх домогтой.

46.Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Их хүрээний буйр байсан газар.




Халхын сайн ноён хан аймгийн Зая бандида хутагтын шавь Сүжигт бэйсийн хошуу, одоогийн Архангай аймгийн Төвшрүүлэх сумын төвөөс зүүн урагш 21 км-т Хөх сүмийн голын цагаан чулуут хэмээх газар Их хүрээ буйр сэлгэн бууж, 1700-1719 оны хооронд суурьшиж байсан гэдэг. Энэ газарт Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын

тэргүүлэгчид, Засаг даргын тамгын газраас 2003 оны аравдугаар сарын 29-нд боржин чулуун дээр дурсгалын самбар босгосон байна. Түүний өндөр нь 1.70 см, өргөн нь 50 см болно. Төвшрүүлэх сумын Хөх сүмийн гол нь Архангай аймгийн Хотонт сумын Цагаан сүмийн голтой ойролцоо байдаг. Энэ нутаг нь хуучин Халхын Сайн ноён хан аймгийн өвөг дээдсийн голомт газар бөгөөд Сайн ноён хан аймгийг 1920-иод оны эхээр засаг захиргааны нэгж хувиарлах үед Цэцэрлэг мандал уулын аймаг болгосон юм.


Цэцэрлэг мандал уулын аймаг хэмээх нарийн Цэцэрлэг гэдэг нь энэхүү Хөх сүмийн голын ойролцоо орших Цэцэрлэгийн голын нэртэй холбоотой ажээ. Мандал уул хэмээх нь мөн Хөх сүмийн ойролцоо байгаа Мандал толгойг хэлдэг байжээ.

47.Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Жанрайсигийн дуган.



Халхын сайн ноён хан аймгийн Зая бандида хутагтын шавь, Сүжигт бэйсийн хошуу, одоогийн Архангай аймгийн Төвшрүүлэх сумын нутаг 1850 онд байгуулагджээ. Жанрайсигийн дуган нь Жаарайн цагаан лам гэж нэрлэгдсэн дуганч ламтай, цагийн хуралтай байжээ.

**48.Архангай аймгийн Төвшрүүлэх сумын
Төвшрүүлэхийн төвийн хийд.**



Төвшрүүлэх төвийн хийд нь 2006 оны зургадугаар сард шинээр байгуулагдсан бөгөөд шарын шашны гэлүгва урсгалтай, дөрвөн ламтай зөвхөн дүйчин өдрүүдэд хурал хурдаг байна.



**49.Архангай аймгийн Хайрхан сумын
Дандаршаравжунайлин хийд.**

Архангай аймгийн Хайрхан сумын төвд орших бөгөөд шарын шашны гэлүгва урсгалтай, гурван ламтай зөвхөн дүйчин өдрүүдэд хурал хурдаг хийд юм.


**50.Архангай аймгийн Хайрхан сумын
Жарантайн хийд.**



СайнноёнханаймгийнСаруул гүн Гэлэгийн хошуу, одоогийн Архангай аймгийн Хайрхан сумын нутагт 1860 онд Жарантайн хийд үүсэн байгуулагджээ. Тус хийдийн туурь сумын төвөөс урагш 22 км. Жарантай багийн нутагт байна. Хийдийн туурийн хойно Оорцог уул, зүүнтэй нь Эрээн уул, баруунтай нь Баянзүрх уул, өмнө талаар Жарантайн гол урсана.

Энэ хүрээнд Дайчин вангийн хүрээний Гачой багш гэж алдаршсан Дамба аграмбыг 1930-аад оны үед залж Ламримчимбын Гачой тавилж байжээ.


51.Архангай аймгийн Хайрхан сумын Хануйн хүрээ.



Сайн ноён хан аймгийн Саруул гүн Гэлэгийн хошуу, одоогийн Архангай аймгийн Хайрхан сумын Хайрхан сумын төвөөс зүүн хойшоо 25км-т орших нутагт Жанцан тойны санаачлагаар Хануйн хүрээ үүсэн байгуулагджээ. Жанцан тойн нутгийн уугуул хүн бөгөөд ард олны дунд “хувилгаан багш” хэмээн алдаршсан нэгэн бөлгөө.

Саруул гүн Гэлэг нь 1912- 1923 онд хошуу захирсан ноён байв. Хануйн хүрээ нь Цогчин, Манба, Жүд дацантай, 1000 гаруй лам хуврагатай шашин соёлын томоохон төв байжээ. Энэхүү хийд нь Жанцан тойны хийд, Саруул гүний хүрээ, Хануйн хүрээ зэрэг олон нэрээр алдаршжээ. Нутгийн хүмүүс газарзүйн байрлалаар нь Хануйн хүрээ, үүсгэн байгуулагчийн нэрээр Жанцан Тойн ламын хүрээ гэж нэрлэдэг. Мөн Архангай аймгийн түүхийн зарим эх сурвалжид “ Саруул гүний хүрээ” хэмээн нэрлэсэн нь бий.

52.Архангай аймгийн Хангай сумын Бүлээний “Пунцагдэжээлин” дуган.



Архангай аймгийн Хангай сумын нутаг, Бүрээн хэмээх газар байрлах Бүлээний дуган нь Олноо өргөгдсөний арваннэгдүгээр 1921 онд Тариатын хүрээний да лам, тойн, цорж Сономпунцаг нарын санаачлагаар үүсгэн байгуулжээ. Тус хийд нь нэг сүм, 20 гаруй ламтай, шавилан суудаг ламгүй, улирлын байдлаар хурал хурдаг байв. Хийдийн барилгыг хятад

мужаан мод болон тоосгоор барьсан бөгөөд 1930-аад оны сүүлч хүртэл барилгын чанар сайнд тооцогдож байсан архивын мэдээ бий. Дуганг тойрсон долоон байшинтай байжээ.

53.Архангай аймгийн Хангай сумын Гичгэний “Дашсамдандэлэгийн” хүрээ.



Архангай аймгийн Хангай сумын нутаг, сумын төвөөс 45 км-т Мөрөн гол хэмээх газар байрлах Гичгэний хүрээг Түгээмэл элбэгтийн долдугаар 1857 онд Жамсран туслагч, Хөнхөр дайчин нарын санаачлагаар таван сүм, хориод ламтайгаар үүсгэн байгуулжээ.

Энд шавилан суудаг ламгүй, цагийн хурал байсан бөгөөд барилгыг мод болон тоосгоор барьсан, дуганыг тойрсон байшин 15, нэг жастай байжээ.

54.Архангай аймгийн Хангай сумын зоогийн хүрээ.



Сайныг хамгаалагч сүм буюу Зоогийн хүрээ нь Архангай аймгийн Хангай сумын төвөөс найман км-т Урд Тэрхийн голын Зуу хэмээх газар Төр гэрэлтийн арвангуравдугаар 1833 онд гүн Даваацэрэнгийн ах да лам Магсаржавын санаачлагаар долоон сүм, 50 гаруй лам, байнга суудаг 30 гаруй ламтайгаар үүсгэн байгуулжээ.

Зоогийн хүрээ нь мод болон тоосгоор барьсан цөөн сүм, 18 хашаатай, нэг жастай байжээ. Чин улсын Бүрэнт засагчийн зургадугаар 1867 онд тус хошууны тэргүүн тайж Даваацэрэн тэргүүлж, шар хар олон сүсэгтэн өглөгийн эзэд өөрсдийн үнэнхүү сүсгээр эвсэж, Дээдийн түмэн өлзий ном уншуулахаар Цогчин хурал байгуулжээ. Үүнээс гадна энд олон отог багууд байгуулсан хурал дацангууд хэд хэд байв.

55.Архангай аймгийн Хангай сумын Мөрөнгийн хүрээ.



Халхын сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу,одоогийн Архангай аймгийн Хангай сумын төвөөс баруун хойш 30 км, Чандмань багийн нутагт Урд Тэрхийн голын хойд талд Овоот толгойн өвөр бэлд Мөрөнгийн хүрээний туурь оршино. Мөрөнгийн хүрээ нь тахилтат Овоот толгойгоос 100

орчим метр зайтай байрлаж байв.

56.Архангай аймгийн Хангай сумын Дашганданчойлин дуган.



Архангай аймгийн Хангай сумын төвөөс 15 км-т Төмөрт хэмээх газар байрласан Төмөртийн дуган нь Боржигины ахмад тайж Будын санаачлагаар нэг дуган, 10 ламтайгаар байгуулагджээ. Энэхүү дуган нь шавилан суудаг ламгүй, цагийн хурал байсан бөгөөд дуганыг модоор барьсан, орчиндоо дөрвөн байшинтай байжээ.

57.Архангай аймгийн Хашаат сумын Долооны хурал.




Түшээт хан аймгийн Хангай Хархан уулын хошуу, одоогийн Архангай аймгийн Хашаат сумын төвөөс зүүн тийш найман км-т Жанцантын ам хэмээх газар орших Долооны хурлыг Долооны голын зүүн дэнжид төвд лам Равжаагийн санаачлагаар байгуулжээ.1938 оны сурвалжид тэмдэглэсэнээр энэхүү хурал, байгуулагдсанаасаа хойш 85 жил болсон байна.

Долооны хурал нь 50 орчим ламтай, цагийн хурал хурдаг байжээ.

58.Архангай аймгийн Хашаат сумын Номгоны сүм.

Түшээт хан аймгийн Хангай хайрхан уулын хошууны Их Номгон



уулын өвөрт орших Номгоны Дара эх ламтны сүм Пунцагдаржаалин хийд нь одоогийн Архангай аймгийн Хашаат сумын төвөөс зүүн урагш 45 км-т оршиж байв.

Анхлан Их номгон уулын өвөрт Осор гэлэн суварга байгуулснаар хийдийн суурийг тавьж, 1912 оноос хоёрдугаар дүрийн хувилгаан Агваанчүлтэмжамц сүм дуган барин өргөтгөж гоёмсог сайхан

хийд болгожээ.Энэ хийд дээр Чогчингоос гадна сахиусны дуган, Чагдархорчин дацан, Ламтаны лавран зэрэг дөрөв, таван дуган буй болжээ. Дара эх ламтан өөрөө удирдан Бари лам Дамцагдоржийн айлдсан Пандэламсан судраар хурал хурж, Ламрим дацанг байгуулав. Дара Эх ламтны хийд дээр хувилгаан лам Агваанчүлтэмжамц өөрөө байнга сууж Эрдэнэзуу, Баруун хүрээнээс ирсэн гэвш, гавж лам нарт дуун ухаан,яруу найргийн онолыг хөтлөн зааж байжээ. Ламтаны лавран дуганд 70 гаруй ламын сүмбүм, ганжуур, данжуур зэрэг ховор ном судрууд залаастай байсан гэдэг. Ламтны лаврангийн хоёрдугаар давхарт ханандаа Өндөр гэгээний намтарчилсан зураг, Ламримын гурван төрөлхтний аймгийг бүдүүвчлэн зурж бүтээсэн байжээ.Дара эх ламтан түвд хэлээр намтар түүх, тарнийн гүн ухааны зэрэг таван боть зохиол туурвижээ. Номгоны сүм нь 50 гаруй лам байнга шавилан суудаг, Цогчин, Ламрим хэмээх жасуудтай байв.


59.Архангай аймгийн Хашаат сумын Мирхайн хурал.



Халхын Түшээт Хан аймгийн Түшээ гүний хошуу, одоогийн Архангай аймгийн Хашаат сумын нутагт 1880-аад онд эл хурал байгуулагджээ.Мирхай нь Амарбаясгалант хийд чиглэлийн лам байсан гэнэ. Уг цагийн хурлын дуганд Баруун хүрээ, Шанхын хийдээс лам нар ирж ном хурдаг


байжээ. Гол шүтээн нь Жамсран сахиус юм.

Мирхайн хурлын туурь нь Түрэгийн хаадын хөшөөнөөс баруун тийш найм орчим км. Хутаг уулын өвөр Орхон голын зүүн эрэгт оршино.




60.Архангай аймгийн Хашаат сумын Хорхойн хурал.

Түшээт хан аймгийн Бага бэрх уулын өвөрт Хорхойн хурал байв. Энэ хурал одоогийн Архангай аймгийн Хашаат сумын нутгийн зүүн хойд захад 1890-ээд оны үед байгуулагджээ.



61.Архангай аймгийн Хашаат сумын Цоохорын хурал.

Түшээт хан аймгийн Очирай Түшээт ханы хошуу, одоогийн Архангай аймгийн Хашаат сумын нутгийн зүүн захад Гурван-Овоо хэмээх газар 1850-иад онд Цоохорын хурал байгуулагдсан байна.



62.Архангай аймгийн Хотонт сумын

Дэчинпунцаглин хийд.

Дэчинпунцаглин хийд нь ойт хээрийн бүсэд Хотонт сумын төвөөс баруун урагш Цагаан сүмийн рашаан сувиллын дэргэд оршдог, дөрвөн ламтай, цогчин хурдаг, шинийн 8-нд Дара эрхийн мандал шива хурдаг байна.

63.Архангай аймгийн Хотонт сумын Хотонтын хүрээ.



Газарзүйн байршлын хувьд Хотонт сумын төвийн зүүн хойд хэсэгт сумын төвийн гэр хорооллуудын хойд талд Цэнгэлийн булаг хэмээх газар уг хүрээний туурь оршино. Эл туурийн зүүн талд Цэнгэлийн булаг хэмээх жижиг горхи, хойно нь хоёр том хиргисүүр, өмнө нь гэр хорооллын гудамж 40 метрт байрласан байна. Өөлдийн

Галдан бошгот хааны дүү Данжила Янбулаг хэмээх газар дөрвөн цагийн Лхам сахиусны жасаа хурлыг эхлэн байгуулж, Өөлд бэйс Жамъяандорж, хэбэй бэйс Гунгаадорж, бэйс Цэдэвдорж, бэйс Чимэддэлэг нар удаа дараалан сүм дуган байгуулж чойр, зурхай, Манба, Дүйнхор дацангуудыг байгуулжээ. 500 гаруй лам хуврагатай Хотонтын буюу Өөлд бэйсийн хүрээ Гэндэнпэлжээлин хийд нь тэр хавьдаа алдартай байв.

64.Архангай аймгийн Хотонт сумын Хөх сүм.



Халхын сайн ноён хан аймгийн Зоригт вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Хотонт сумын нутагт 1880-аад онд эл сүм байгуулагджээ. Хөх сүм хэмээх энэхүү дуган нь Зоригт гүний хүрээ буюу Цагаан сүмийн голын хүрээнээс салбарласан цагийн хурал байв. 1937 онд дуган хаагдаж хурал хурахаа больсон ч дуган 1960-аад он хүртэл урьдын

хэвээр байжээ. 1963 онд нутгийн сумнэгдлийнхэн дуганыг сүү тосны заводын байшин болгохоор зөөвөрлөн сумын төв рүү нүүлгэжээ.

65.Архангай аймгийн Хотонт сумын Цагаан сүмийн хүрээ “Сантын хүрээ”

Хуучин Сайн ноён хан аймгийн Гончогчойнзин засгийн хошуу, одоогийн Архангай аймгийн Хотонт сумын Цагаан сүмийн гол



хэмээх газар Сантын хүрээг 1804 онд засаг Сампилдоржийн үед байгуулжээ. Сантын хүрээг Зоригт засгийн хүрээ ч гэж нэрлэдэг.


Зоригт засгийн хүрээний лам нар Их хүрээнд ирж ном үзэхдээ Эрхэмийн аймагт ирж аймагладаг байв. Их хүрээнд Эрхэмийн аймгийг үндэслэгч Эрхэм тойн нь Цагаан сүмийн голд мэндэлжээ. Чин сүжигт номун хан Лувсанноровшэйрав ч Цагаан сүмийн голын ойролцоох Жарантайн халуун усны орчим мэндэлсэн байдаг. Чин сүжигт номун ханы шавь нар Их хүрээнд ирж ном үзэхдээ Эрхэмийн аймагт аймагладаг байсны учир энэ бөлгөө. Зоригт засгийн хүрээнээс ирж Их хүрээнд гүн ухааны ном судалсан олон сайн гэвш гарсны нэг нь Баруун багш гэж алдаршсан гэвш Сэр-Од юм. Тэрээр залуу насандаа Дашчойнпил дацангийн анги болж байсан эрдэмтэн лам байв. Баруун багш 1990-ээд оны эхэн үед Гандантэгчилэн хийдийн дэргэд гүн ухаан судлах Дашчойнпил дацан үүсэн байгуулахад олон шавь нарт гүн ухааны ном заасан гол багш нарын нэг байв. Цагаан сүмийн хүрээ Хотонт сумын төвөөс зүүн урагш 60 км-т Хайлаастын тал хэмээх газар оршиж байжээ.

66.Архангай аймгийн Чулуут сумын Бүрдийн хийд.



Халхын сайн ноён хан аймгийн Сэцэнчин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Чулуут сумын нутаг Бүрд хэмээх газар 1838 онд байгуулсан отгийн хурал юм. Бүрдний хийдийн туурь нь Чулуут сумын төвөөс баруун урагш 48 км-т Сант уулын өвөрт оршино.

67.Архангай аймгийн Чулуут сумын Дэчинравжаалин хийд.



Чулуут сумын төвийн хойд хэсэг Сумчийн уулын өвөр, өндөр уулын бүсэд Дэчинравжаалин хийдийг 1992 оны 6 сард Дашсүндэв, Жанрайжав, Аршсэд зэрэг лам үндэслэн байгуулж, 1994 онд Бакула ринбүүчи энд морилсон бөгөөд 2004 онд хурал уншлагын гол Цогчин дуганыг ашиглалтанд оруулсан байна. Энэхүү хийдэд 2004 онд Түвдээс


Ганжуур судар, Лхам бурхан залжээ.

68.Архангай аймгийн Чулуут сумын Цогт хайрханы хурал.



Чулуут сумын төвөөс баруун урагш 15 км-т Хүрэмийн голоос баруун тийш 500 метрт Цогт Хайрхан хурлын 4-5 дуганы байх бөгөөд өмнө талд Бумбатын нуруу, баруун хойно нь Цогтхайрхан уул, зүүн талд 500 метрт Хүрмэн гол, Хүрэмийн голын цаана Өлзийт өвөр хэмээх уул бий. Тууриас баруун хойно 1.5км орчимд нутгийн тахилгат Цогтхайрханы

овоо байна. Өндөр уулын бүсэд орших энэхүү 4-5 дуганы туурин дээр сүм дуганы чулуун суурь, шороон далан, хонхортой газрын ором тод мэдэгдэхүйц байна.




69.Архангай аймгийн Чулуут сумын Намсрай тэргүүний дуган.

Халхын сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Чулуут сумын төвөөс зүүн урагш 8км-т оршиж Мандал хэмээх газарт Монголын арванхоёрдугаар 1922 онд

Тэргүүн зэргийн тайж Намсрайн санаачлагаар дуганыг байгуулжээ. Энэхүү хурал нь ганц дуган, сахиулч лам нэгтэй, жилд нэг удаа 3-5 хоног хурал хурдаг байжээ.


70.Архангай аймгийн Чулуут сумын Улаан овооны хурал .



Сайн ноён хан аймгийн тамгатай хутагт Шива ширээтийн шавийн харьяа, одоогийн Архангай аймгийн Чулуут сумын нутагт байсан Улаан Овооны хурал нь 1800-аад онд байгуулагджээ. Энэ хурал нь сумын төвөөс зүүн зүгт 30 орчим км-т Халуун ус багийн нутагт Улаан-Овоо хэмээх тахилтат уулын энгэрт оршиж байв. Тууриас баруун тийш 100

орчим метрт 2007 оны 6-р сарын 30-нд гурван суварга босгожээ.

71.Архангай аймгийн Чулуут сумын Хангалын дуган .




Архангай аймгийн Чулуут сумын нутаг Улаан-овоо хэмээх газарбайрладаг Хангалын дуганыг Хаант Монголын есдүгээр буюу 1919 онд Бадамгарав тайжийн санаачлагаар байгуулжээ. Энд ганц модон дуган, байнга суудаг сахиулч ламтай байсны зэрэгцээ жилд нэг удаа 3-5 хоног хурал хурдаг байжээ.Эл дуган сумын төвөөс баруун урагш 25 км.

Хүрмэн багийн нутагт Хангал хэмээх газар оршиж байв. Байршлыг өгүүлвээс Хүрмэн багийн төвөөс баруун тийш 12км-т өмнө нь Хангалын уул,баруун талдаа Шивээт уул, хойно нь хангал Даваатын гол бий. Тууриас зүүн хойш найман км-т Цогтхайрханы тахилгат овоо, Цогт сүмбэрийн овоо байна.

72.Архангай аймгийн Чулуут сумын Шива ширээтийн хүрээ .

Хуучнаар Халхын сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Чулуут сумын нутагт Шива ширээт



гэгээний гуравдугаар дүрийн хувилгаан Лувсаннамхайдорж (1746-1797) эл хүрээг үүсгэн байгуулжээ. Шива ширээтийн хүрээ нь Гүн ухааны дацан, тарнийн гүн ухаан судлах Жүд дацан, Дүйнхор, Манба зэрэг дацангуудтай 500 гаруй лам хуврагатай томоохон хийд байв. Энэ хүрээнээс төрөн гарсан олон эрдэмтдийн нэг Шива ширээтийн

шавь Саюу төрөлхийн мах иддэггүй хүн Совд гавж түвд хэлээр Нарохажид бурханы чойгор тэргүүтэн хоёр боть зохиол туурвиж, 1910 онд Хүрээ барын ганжуур барлан хэвлэхэд ариутгагчийн зөвлөлд уригдан ирж байсан алдартан юм.

Халхын тамгатай томоохон хутагтуудын нэг Сайн ноён хан аймгийн Шива ширээт хутагтын “Ширээт” хэмээх цол алдраар Ширээтийн хүрээ гэж нэрлэсэн энэхүү хүрээ нь 220 гаруй жилийн түүхтэй ажээ, Эл хүрээ нь Чулуут, Өндөр-Улаан сумд буюу Сайн ноён хан аймгийн Сайд вангийн хошууны бүс нутгийн шашин номын томоохон төв болж байжээ. Гуравдахь дүрийн Ширээт хутагт Лувсаннамхайдорж 33 насандаа шороон эр нохой жил Чулуут голын хөвөөнд Гэндэнчойпэллин хэмээх сүм буюу энэхүү Ширээтийн хүрээний үндэс суурийг тавьжээ. Энэ хүрээнд Цам гарч Майдар эргэдэг, гол шүтээн нь Лхам, Жамсран байжээ. Цам гарахдаа Эрвээхэй бүжиг хэмээх хэсэгт эмэгтэй хүн оролцдог байсан нь монголын буддын шашны сүмд хийдэд ховор тохиолдол байлаа. Сүм хийд хаагдсанаас хойш удалгүй сүм дуганууд шатаж босоо шон мод үлдэлгүй устсан байна.

Ширээтийн хүрээний бурханч лам Онгоодой хэмээх хүний бүтээж урласан бурхан, түүний хэрэглэж явсан алх дөш зэрэг багажууд эдүгээ Архангай аймгийн музейд хадгалагдаж байна. Шива ширээтийн хүрээ эдүгээгийн Архангай аймгийн Чулуут сумын төвөөс зүүн тийш 45 км-т оршиж байжээ.

73. Архангай аймгийн Чулуут сумын Хажидын хурал .

1920-иод онд Шива ширээт хутагтын тавдугаар дүр Агваанлэгдэндамбийжанц ангийн айлдвараар саюу Совд гэлэн Чулуутын халуун усны ойролцоо Нарангийн энгэр хэмээх газар Нарохажид бурханы сүм бариулж, Совд гавж энд өөрөө Нарохажид бурханы чойгор номыг зохиож модон бараар хэвлүүлсэн байдаг.

Ялангуяа идэр залуу насны эмэгтэйчүүдийг хуралд суулган Хажид чойгорыг цээжлүүлж байсан гэдэг. Энэхүү Хажидын сүмээс одоо үлдсэн Гарчэнсажү гуай 90 гаруй настай сэрүүн тунгалаг Хажидын чойгор номоо уншсан хэвээр байна.

74.Архангай аймгийн Чулуут сумын “Чулуутын хурал” .

Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Чулуут сумын нутаг Чулуутын голын савд энэ хурал оршиж байв.


75.Архангай аймгийн Чулуут сумын “Зуун модонгийн хурал” .

Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Чулуут сумын нутаг Хуучин дуган хэмээх газар Зуун модонгийн хурал байжээ.

76.Архангай аймгийн Чулуут сумын “Төмөртийн хурал” .

Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Чулуут сумын нутаг Төмөртэйн гол хэмээх газар эл хурал байжээ.

77.Архангай аймгийн Цахир сумын “Байцын жанчивлин жалгын хурал” .



Байцын хурал нь Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Цахир сумын төвөөс баруун хойно 75 км-т Тэрхийн голын хойд эрэгт оршиж байжээ. Энэ нутагт Халзан Бүргэдэй буюу Очир Хайрханд Энэтхэгийн Сэра хийдийн хамба лам асан Сэнгээ ринбүүчи, мөн уулын өмнөөс Ялгасан гэгээн тус тус мэндэлсэн

байна. Өвгөн Гэсэр лам хэмээх Чүлтэмжамц ч энэ нутгаас төржээ. Үүнээс үзэхэд Цахир сумын нутгаас шарын шашин олон эрдэмтэн мэргэд төрсөн бөгөөд тэдгээрийн нэг нь Раднаасүмбэрэл юм. Раднаасүмбэрэл бага насандаа Тариатын хүрээнд буддын гүн ухаан судлаад Их хүрээний Дашчойнпил дацанд ном эрдмээрээ шалгаран гайхагдаж байжээ.

78.Архангай аймгийн Цахир сумын “Дамбаравжаалин хийд” .




Цахир сумын төлийн хойно Овоот толгой буюу Авсалтай уулын энгэрт баруун талаараа Бухтын доод үзүүр, зүүн талаараа Салтын ам хэмээх газраар Хүрээлүүлсэн Солонголын даваа өгсдөг төв замаас баруун талд хоёр км орчимд Ренчинбазар гэдэг хүний санаачлагаар 1992 оны наймдугаар сарын 25-нд байгуулжээ. 2006 онд Гомбо шүтээнийг залсан байна. Энэтхэгийн Сэра дацангийн хамба агсан Халхын Сэнгээ ринбүүчигийн дурсгалд зориулан 2005 онд суварга босгожээ.

79.Архангай аймгийн Цахир сумын “Загастайн хийд” .



Загастайн хийд нь Архангай аймгийн Цахир сумын төвөөс баруун тийш 25км-т Загастайн ам хэмээх газар байжээ. Загастайн буюу Дамбаравжаалин хийд нь байгуулагдсанаас хойш 1938 он хүртэл зуу орчим жил болсон байна. Энэхийд Их, Дэмчиг, Аюуш, Оточ,Найдан, Дара эх, Даваажин , Гүнриг дацангуудтай , нутгийн ардуудаас хоёр дацангийн дуган бариулсан байна. Хийдийн барилгыг мод болон тоосгоор барьсан , хаагдах үе хүртэл чанар сайтай байжээ. Загастайн хийдэд хаашаа тав, байшин зургаа ,эсгий гэр 37, зуу орчим ламтай байсан бөгөөд үүнээс гавж тав, аграмба нэг, маарамба нэг, 18-аас дээш насны 98 лам, 18-аас доош насны хоёр ламтай, байнга шавилан суудаг арав орчим ламтай байжээ. Жилд нэг удаа 10 хоногоор хурал хурдаг, цагийн хурал байлаа.

80.Архангай аймгийн Цахир сумын “Талын манал хурал” .



Сайн ноёнхан аймгийн Далай Чойнхор вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Цахир сумын төвөөс баруун урагш 40 км-т буй Талын Овоо тухайлбал Бодонтын гол хэмээх газар оточ Маналын уншлага үйлддэг хурал байжээ. Талын Манал хурал нь байгуулагдсанаас хойш архивын 1938 оны мэдээгээр зуу орчим жил болсон, Жамбын чога, Дара

эх, Дэмчиг зэрэг сүм дугантай байснаас нутгийн ардууд нэг дуганыг өөрсдийн хүч хөрөнгөөр барьсан бөгөөд шавилан суудаг ламгүй, Загастайн хүрээний лам нар цаг улирлын байдлаар энд хүрэлцэн ирж хурал хурдаг байв.

81.Архангай аймгийн Цэцэрлэг сумын “Агьтын хурал” .

Сайн ноён хан аймгийн Мэргэн гүн Мөнх-Очирын хошуу, одоогийн Архангай аймгийн Цэцэрлэг сумын нутаг Агьт голын Мэлхий товог хэмээх газар энэ хурлыг үүсгэн байгуулжээ. Энэ нь улирлын чанартай цагийн хурал байв.

82.Архангай аймгийн Цэцэрлэг сумын “Бухын хүрээ” .

Одоогийн Архангай аймгийн Жаргалант, Цэцэрлэг сумдын нутаг дэвсгэрийн хойд уулзвар -Идэр, Чулуут голын бэлчир , домогт Бух чулууны урд биед байрлаж байсан энэхүү бухын хүрээ нь 1870-аад оны үед байгуулагджээ. Түүхэн эх сурвалжуудаас үзвэл Бухын хүрээ нь Мэргэн гүний хошууны Рашаантын хүрээнээс салбарлан гарсан бололтой. Учир нь Манжийн үеийн болон Богд хаант Монгол улсын үеийн нутаг дэвсгэр засаг, захиргааны бүтцээр уг Идэр, Чулуутын бэлчир орчмын газар нутаг нь тухайн үедээ Мэргэн гүний хошууны нутгийн баруун хойд хил хил хязгаарт багтаж байжээ. Нөгөө талаар Бухын хүрээний хурал номын дэг жаяг ая дан, шүтээн сахиус нь Рашаантын хүрээтэй яг адил байсан бөгөөд сар жилийн онцгой дүйчэн өдрүүдэд Рашаантын хүрээнээс томоохон лам нар ирж хурал хурдаг байжээ. Бухын хүрээ нь Цогчин, Хайлан, Хүтээн ,Суварган зэрэг дөрвөн дугантай,шавилан суудаг 50 орчим ламтай, хоёр жастай байснаас үзэхэд цагийн хурал биш,багавтар хүрээ байв. Уг хүрээ нь 1932 оны лам нарын хөдөлгөөний үед хаагдаад 1936 онд дахин сэргэсэн боловч 1937 оны цагаан сарын дараа

лам нар нь тарж хар болсноос дугануудыг битүүмжилсэн байна. Хүрээний гурван дуганы үлдэгдэл 1970-аад оны дунд үеийг хүртэл саалийн фермийн сүү тосны заводын байшин, агуулах зэргээр ашиглагдаж байгаад нураагджээ. Газарзүйн байршлын хувьд Бухын хүрээ орчмын нутаг дэвсгэр нь хангайн нурууны өндөр уулсын дунд Идэр, Чулуут гэсэн хоёр томоохон голын бэлчирт оршиж байсан нь ор орчимд хүрээ хийд хурал номын газар байх боломж хязгаарлагдмал байжээ. Үүнээс үзэхэд алслагдсан бөглүү, энэ хязгаар нутгийн сүсэгтэн олонд байнгын хуралтай хүрээ хийд зайлшгүй шаардлагатай байсан байж болох юм. Уг Бухын хүрээ нь 1979 онд хэвлэгдсэн “БНМАУ-ын угсаатны зүйн атлас”-ын сүм хийдийн жагсаалтын 151-рт Бухын хүрээ гэсэн нэрээрээ бүртгэгджээ.

83.Архангай аймгийн Цэцэрлэг сумын “Дөвхөн хийд” .



Одоогийн Архангай аймгийн Цэцэрлэг сумын нутаг Мухар хужиртын рашаан нь Заяын гэгээн мэндэлсэн түүхт газар бөгөөд 1900 оны үед V Зая бандида Лувсанчойжийванчигийн тусламжтайгаар сүм барих ажлыг анх Халхын Гэргэн багш зохион байгуулж бариулснаар хийддээ Дөвхөн гэж нэрлэжээ. Дөвхөн гэдэг нь “Бурханы бүтээлийн

орон” гэсэн агуулагтай юм. Гэргэн багш анх рашаан дээр ирж сүм хийд байгуулах тухай саналыг нутгийн ард иргэдтэй зөвшилцөн дэмжүүлээд өөрөө Рашаантын хүрээ, Заяын хүрээ, Их хүрээгээр явж үлэмж хэмжээний бурхан тахил, ном судар залж авчирч хийдээ тохижуулж эхэлжээ. Улмаар анхны дуган сүмийн хажууд Суварган жас гэдэг жижигхэн барилга бариулсан байна. Уг хийд нь Дуган сүм, Дөвхөн, Суварган жас гэдэг гурван байгууламжтай бөгөөд Рашааны их ундаргын хойд энгэрт 12 цагаан суварга бүтээсэн байв. Дөвхөн хийд нь зуны эхэн болон дунд сард 49 хоногийн турш хайлан хурна. Мөн намрын дунд сарын 17-нд овооны тахилга үйлдэнэ. Хийдийн гол сахиус нь Дамдин чойжоо бурхан байжээ.


Рашаан булаг, лус савдагт зориулж уншлага уншиж, ариутгал хийдэг. Гэргэн багш Дөвхөн хийдийг өөрөө толгойлон дэд хамба ламаар Гачаа багш, хэргэмтэнгүүдэд Дамдин гавж, Бэх гавж, их

унзад Сандан, бага унзад Дамба, Сандан маарамба, Гонир гэлэг нар ажиллаж байв. Хийд нийтдээ 70-аад ламтай байжээ.

Зая гэгээний төрсөн нутаг гэгдэх энэхүү Дөвхөн хийдийн дэргэдэх Мухар хужиртын рашаан нь монголчууд эрт дээр үеэс ашиглаж ирсэн анагаахын их увидастай ариун дагшин ус бөгөөд энд эгэл жирийн рашаанчдаас гадна үе үеийн Заяын гэгээнтнүүд Даравбаньдида гэгээнтэн, Жалханз хутагт хүртэл ирж алжаалаа тайлж байсан тухай сурвалжид тэмдэглэн үлдээжээ.

1934 оноос хийд эзэнгүйрч эхэлсэн байна. Хожим нь гурван дуганыг Эрдэнэмандал сум руу зөөвөрлөжээ. Харин Халхын анхдугаар Зая гэгээний мэндэлсний 355 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд 1997 онд түүний төрсөн газар болох Мухар хужиртын рашааны дэргэд Дөвхөн хийдийн туурин дээр нэгэн жижиг мөргөлийн сүм барьжээ. Сүмийг барих ажилд нутгийн иргэн Гүнчин, Цогбадрах, Т.Намдаг, Д.Гэлэнхүү, С.Доржсүрэн зэрэг сүжигтнүүд идэвх зүтгэлтэй оролцсон байна. Ийнхүү Халхын анхдугаар Зая гэгээний хүй цөглөсөн нутаг дахь шинэ цагийн Дөвхөн хийдийн сэргэлт эхэлжээ.

84.Архангай аймгийн Цэнхэр сумын “Бүрдийн хүрээ” .



Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошуу, одоогийн Архангай аймгийн Цэнхэр сумын төвөөс 39 км-т Бүрдийн булан хэмээх газар эл хүрээ оршиж байжээ. Сурвалжид тэмдэглэснээр 1938 онд Бүрдийн хүрээ байгуулагдаад 33 жил болсон Цогчин хурдаг, Ловон Дамчойжавын санаачлагаар хоёр дацан нэмж бариулан , 160 гаруй

ламтай ,цаг улирлын байдлаар хурал хурдаг байсан аж. Хийдийн барилгыг мод болон тоосгоор барьсан байв.



85.Архангай аймгийн Цэнхэр сумын “Өлзийчойнхорлин хийд” .

Цэнхэр сумын төвд Цэнхэрийн голын зүүн эргээс 1.5 км-т Нугын төв хэмээх газар энэ хийд байршжээ. Баруун талд нь

тахилтат Алтан-Овоо бий. 1994 онд Банзрагч, Сэрдамба зэрэг лам нарын санаачлагаар эл хийдийг шинээр байгуулсан юм. Тус хийд нь есөн ламтай бөгөөд Итгэл, Цогчин,сүжигтний айлтгал уншдаг, шинийн 8-нд Дара Эхийн мандал шива хурдаг бөгөөд 2003 онд шинэ цогчин дуганыг ашиглалтанд оруулжээ.

86.Архангай аймгийн Заяын гэгээний дээд хүрээ.

Сайн ноён хан аймгийн Зая бандида Лувсанпринлай 1688 онд одоогийн Архангай аймгийн төв Булган уулын өвөрт Цогчин хурлыг үүсгэн Заяын хүрээний суурийг тавьжээ. Заяын хоёрдугаар дүрийн хувилгаан Гэлэгнамжил 1742 онд Түвдийн гүн ухаантан Сэра Живзунба Чойжижалцангийн зохиосон номлолын дагуу энэ хүрээнд Сэра-Жэ дацангийн дэгээр Чойр дацан, 1746 онд Агва дацанг Дашлхүнбэ хийдийн дэглэмээр тус тус байгуулжээ. Зая бандида Лувсанпринлай өөрөө Гүшиг, Сандуй, Гүнриг дацангуудыг байгуулсан удаатай. Зая бандида Лувсанпринлай залуу насандаа түвдийн Сэра, Дашлхүнбэ хийдэд 19 жил суралцаж судар тарнийн гүн ухаанд мэргэшиж ирээд Заяын хүрээг байгуулахдаа түвдийн Дашлхүнбэ хийдийн дэгийг баримталсан ч нүүдэлчин монголчуудын ахуй амьдрал, зан заншилд нийцүүлэн шинээр Заяын дэгийг бүтээсэн гэлцдэг. Энэхүү Заяын дэг нь монголын зарим сүм хийдүүдэд нөлөөлж Заяын дэгээр хурал номоо хурдаг байв.


Заяын хүрээ нь 1500 гаруй ламтай томоохон хийд байсан бөгөөд энд үе үеийн Зая бандида нар залран суудаг Сэмчин орд өргөө байрладаг байв. Энэхүү орд өргөөнд байсан номын сангийн зарим ховор нандин ном хожим нь Гандантэгчилэн хийдийн номын санд иржээ. Заяын хүрээнээс төрсөн эрдэмтэн хамба Галсан, шунлайв Галсан, Заяын гэгээний ёнзон Гэлэгдорж нар түвд хэлээр нилээд зохиол бүтээл туурвисан байна. Эл хүрээнд шавилан суугч олон сайн маарамбуудын дотроос Өлзийбат маарамба түвд хэлээр дөрвөн боть зохиол туурвижээ. Заяын цагаан равжамба



гэж алдаршсан Ринчиндагва Дүйра зэрэг гүн ухааны зохиолыг түвд хэл дээр туурвижээ. Заяын хүрээний сүм дуганыг XVII зууны эцэс хүртэл хугацаанд голдуу монгол дархчууд барьж, засвар хийж байсан хүмүүсээс нэрд гарсан Дандаржамъяан, Борчогба, Жигдэл дархан зэрэг алдарт урчууд нь 1696-1765 оны үед амьдарч байжээ.


X[^]Ш-X[|]X зууны үед Төгс дархан, Соном, Лувсаншарав, Буянт зэрэг урчуул хийдийн засварт оролцдог байжээ. 1887 онд тус хийдийг ихэнхэд нь засварласан байна. Цогчин дуганы баруун талд Лавран хутагтын ордон байна. Лаврангийн хэрмэн дэх давхартай сүмүүдийг шүтээний гурван сүм гэдэг байв. Энэхүү Лаврангийн баруун гүдэнд Зая бандида хутагт Лувсанпринлэй, Лувсанняндаг нарын шарилын суваргууд байжээ. Зүүн гүдэнд V хутагт Лувсанжигмэднамжилын шарилыг тус тус байршуулжээ. Эдгээр шарилуудын дотор III Зая бандида Лувсанжигмэддоржийн Гүдэнгийн суварга оршиж байдаг юм. Зүүн сүмийн дотор Ядам, Сономдоо ,голын сүмд Чожоо бурханыг тус тус тахиж, жасаа хурал хурж байжээ.

87.Архангай аймгийн Заяын гэгээний доод хүрээ.



Сайн ноён хан аймгийн Зая бандидагийн шавийн нутаг, одоогийн Архангай аймгийн Эрдэнбулган сумын Норовлин хэмээх газар Зая бандидагийн дөрөвдүгээр дүрийн хувилгаан Лувсанжигмэднамжил Төр гэрэлтийн арванхоёрдугаар буюу 1832 онд сүм байгуулж, Манжийн хаанаас нэр хайрлахыг гуйсанд “Өлзий бадруулагч сүм” хэмээх

нэр шагнасан нь Заяын доод хүрээ гэж алдаршжээ. Дөрөвдүгээр хувилгаантан 1829 онд Дүйнхор дацан, 1844 онд Манба дацан, Мянган бурханы сүм, 1852 онд Нүннайин сүм, 1853 онд Лхам сахиусны сүмийг тус тус байгуулжээ. 250 гаруй лам хуврагтай эл хийд 1938 онд үйл ажиллагаагаа зогсоосон байна.




88.Архангай аймгийн Төгс баясгалант буяныг дэлгэрүүлэгч хийд .

Халхын Сайн ноён хан аймгийн Зая бандидагийн шавийн нутаг, одоогийн Архангай аймгийн Эрдэнэбулган сумын төвд 1990 оны 6-сард сэргээн байгуулсан хийд юм.



89.Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Гүнрэгийн хурал .

Сайн ноён хан аймгийн Зая бандида хутагтын шавийн нутаг, одоогийн Архангай аймгийн Эрдэнэмандал сумын төвөөс 12км-т Гүнрэгийн Овоо хэмээх газар эл хурлын туурь оршино.



90.Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Дашчойнхорлин хийд.

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутагт 2004 оны дөрөвдүгээр сарын 16-нд Дашчойнхорлин хийдийг сэргээн байгуулжээ. Шарын шашны гэлүгва урсгалтай, гурван ламтай эл хийд зөвхөн өдөр тутмын болон сарын хурал хурдаг байна.

91.Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Дэмчиг дацан.

Зая гэгээний найман дацангийн нэг нь Дэмчиг дуган юм. Зарим түүх бичлэгт Дэмсэгийн дацан гэж нэрлэсэн нь бий. Дэмчигийн дацан нь гэр хэлбэртэй дугантай байсан бөгөөд тэр нь 400 гаруй лам хурах багтаамжтай байв. Шавийн их зурхайч Ванганжав уг газрыг шинжээд Өлзийт дэнжид баривал өдөртөө 300 хүн орох юм гэснээр уг дуганы суурийг энд тавьжээ. Жил бүрийн зуны дунд




сард Дэмчигийн дуганд Заяын хүрээнээс лам нар цугларч таван хоног ном хурдаг байв. Энэ үеэр Заяын хүрээнээс есөн цагаан морьтой хүн Шалш бурханы түгдэнг залж гэсгүй, унзад, нар дагаж ирдэг байсан гэлцдэг. Цан хэнгэрэг, сэлнэн цохиж, бүрээ бишгүүр, гандан эгшиглэнэ. Үүнээс үүдэн шавь дацанг Дэмчиг хэмээн нэрлэсэн ажээ. 1920-иод

оноос Ванганжав зурхайч, Дашзэвэг унзад, Самдан гавж нар ирж хурал номыг удирддаг болов. Хурлын үеэр жасын сүргээс хар морь, хар хонь нэжгээдийг сэтэрлэдэг байжээ.

АРХАНГАЙ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ХАРЪАЛАГДАЖ БАЙСАН ШАШИН СҮМ ХИЙДИЙН БАЙРШИЛ /1937 ОНЫ БАЙДЛААР/

1.Архангай аймгийн хүрээ хийд (1937 оны байдлаар) Батцэнгэл сумын хүрээ хийд




Батцэнгэл сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар.

1.Тамирын хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэсэн. Тус хүрээ нь сумын төвөөс хоёр км-т оршиж байсан, 400 гаруй лам хурал хурдаг байжээ.

2. Халчины хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэсэн. Тус хүрээ нь сумын төвөөс найман өртөө буюу Халчин хэмээх гэзэрт оршиж байсан, 100-150 хүртэл лам хурал хурдаг байжээ.

3. Улаанчулуутын хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь сумын төвөөс нэг өртөө зайд Улаанчулуу хэмээх газарт оршиж байсан, 100-150 хүртэл лам хурал хурдаг байжээ.

2.Баянбулаг сумын хүрээ хийд
Баянбулаг сумын зурагт тэмдэглэсэн хүрээ хийд.



1. Баруун хийд
2. Бугатын дуган
3. Сангийн Далайн хийд
4. Хадат (Хатад)-ын хийд

Баянбулаг сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар.


1. Баруун хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэсэн. Тус хийд нь аймгийн төвөөс 11, сумын төвөөс нэг өртөө газарт оршиж байсан, 100-150 хүртэл лам хурал хурдаг байжээ.

2. Бугатын дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь аймгийн төвөөс 10, сумын төвөөс нэг өртөө газарт оршиж байсан, 10-50 хүртэл лам хурал хурдаг байжээ.

3. Сангийн далай хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэсэн. Тус хийд нь аймгийн төвөөс 11, сумын төвөөс нэг өртөө зайд Сангийн далай хэмээх газарт оршиж байсан, 100-150 хүртэл лам хурал хурдаг байжээ.

4. Хадат **Хадатын** хийд: Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс 10 хагас, сумын төвөөс нэг хагас өртөө зайд Хадат хэмээх газарт оршиж байсан, 50-100 хүртэл лам хурал хурдаг байжээ.

3.Баянхонгор сумын хүрээ хийд.




Баянхонгор сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Гавжинчойнхорлин хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэсэн. Тус хийд нь сумын төвөөс 15 км зайд оршиж байсан, 100-150 хүртэл лам хурал хурдаг байжээ.

2. Ганданцэцээлин хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэсэн. Тус хийд нь сумын захиргааны ойролцоо, улсын хилээс есөн өртөө газар оршиж байсан, 350 хүртэл лам хурал хурдаг байжээ.

4.Бөмбөгөр сумын хүрээ.




Бөмбөгөт сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Галдан дуган. Зураг дээр сумын захиргаанаас баруун зүгт дүрсээр тэмдэглэсэн. Тус дуган нь сумын төвөөс 30 км зайд оршиж байсан, 10-50 хүртэл лам хурал хурдаг байжээ.

2. Хишгэн жас. Зураг дээр сумын захиргаанаас баруун хойд зүгт дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс 30 км.зайд оршиж байсан, 10 хүртэл лам хурал хурдаг байжээ.

5.Бугат сумын хүрээ хийд.



Бугат сумын зурагт тэмдэглэгдсэн хүрээ

- | | |
|-----------------------|------------------|
| 1. Тайжид | 3.Чойжоо хурал |
| 2. Дара-Эхийн хурал | 4.Майдарын хурал |
| 5.Уртбулагийн Дара-Эх | |

Бугат сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1.Тайжид дуган. Зураг дээр сумын захиргаанаас зүүн урд газарт дүрсээр тэмдэглэсэн. Тус дуган Бор бургасны голын ойролцоо оршиж байсан дуган бөгөөд 10 гаруй лам хурал хурдаг байв.

2. Дара-Эхийн хурал. Зураг дээр Бор бургасны голоос баруун тийш Бичиндунгай уулнаас урд зүгт орших цуваа 4 хурлын газрын 2 дахь нь дүрсээр тэмдэглэгдсэн, 50 гаруй лам хурал хурдаг байсан.

3. Чойжоо хурал. Зураг дээр Бичиндунгай уулнаас урд зүгт орших цувраа 4 хурлын газрын 3 дахь нь дүрсээр тэмдэглэгдсэн, 50 гаруй лам хурал хурдаг байсан.

4. Майдарын хурал. Зураг дээр Бичиндунгай уулнаас урд зүгт орших цувраа хурлын газрын 4 дахь нь дүрсээр тэмдэглэгдсэн, 50 хүртэл лам хурал хурдаг байсан.

5. Уртбулагийн Дара-Эхийн хурал. Зураг дээр сумын захиргаанаас зүүн урд дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хурал нь Бор бургасны голын хойд зүгт оршиж байсан, 50 хүртэл лам хурал хурдаг байсан.

6.Буянтцагаан гол сумын хүрээ хийд.



Буянтцагаан гол сумын зурагт тэмдэглэсэн хүрээ

1.Буянтын хийд 2.Данхорын жас 3.Зүүн жас

Буянтцагаан гол сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1.Буянтын хийд. Зураг дээр зүүн доод хэсэгт хоёр байшингаар тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс 10, сумын төвөөс хагас өртөө зайд Буянт голын ойролцоо газар оршиж байсан, 60 хүртэл лам хурал хурдаг байжээ.

2.Данхорын жас. Зураг дээр сумын захиргаанаас зүүн

хойд хэсэгт хоёр жижиг байшингийн баруун талын байшингаар тэмдэглэгдсэн. Тус жас нь Зүлэгтийн булагийн ойролцоо газар оршиж байсан, 10 хүртэл лам хурал хурдаг байжээ.

3.Зүүн жас. Зураг дээр сумын захиргаанаас зүүн хойд хэсэгт хоёр жижиг байшингийн зүүн талын байшингаар тэмдэглэгдсэн. Тус жас нь Зүлэгтийн булагийн ойролцоо газар оршиж байсан, 10 хүртэл лам хурал хурдаг байсан.


7.Заг гол сумын хүрээ хийд.



Заг гол сумын зурагт тэмдэглэсэн хүрээ

1.Байдрагийн хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэсэн. Тус хүрээ нь аймгийн төвөөс хойд зүгт Мандал голын өмнө талд оршиж байсан, 100-150 гаруй лам хурал хурж байв.

8.Зүүнгурванбулаг сумын хүрээ хийд.




Зүүнгурванбулаг сумын хүрээ хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Хөгнө хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс баруун урд зүгт Хөгнө уулын өмнө талд оршиж байсан, 10-50 хүртэл лам хурал хурдаг байжээ.

2. Үйзэнгийн хурал. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хурал нь Төв аймгийн Авзага сумын хилээс урагш зүгт Хижигийн бүрд хэмээх газрын өмнө талд оршиж байсан, таван лам хурал хурдаг байжээ.

3. Шивэртийн сүм. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус сүм нь Төв аймгийн Өндөрсант сумын залгаа Хөгнө уулын хойд хэсэгт Мойлтын ус хэмээх газрын ойролцоо оршиж байсан, 40 хүртэл лам хурал хурдаг байжээ.

9.Идэр сумын хүрээ хийд.



Идэр сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Мандахын хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь сумын төвөөс баруун тийш 15 км зайтай, Ихжаргалант сумын залгаа Идэр голын ойролцоо оршиж байсан, 50-100 хүртэл лам хурал хурдаг байжээ.


2. Нарийны хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь сумын төвөөс өмнө зүгт 8 км-т оршиж байсан, 50 хүртэл лам хурал хурдаг байсан.

3. Бумбатын дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс өмнө зүгт 7 км-т оршиж байсан, 10 хүртэл лам хурал хурдаг байжээ.

4. Дэрстийн дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвийн ойролцоо оршиж байсан, 10 хүртэл лам хурал хурдаг байжээ.

5. Улаанчулуутын дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс баруун урагш 11 км зайд оршиж байсан, 10 хүртэл лам хурал хурдаг байжээ.

10.Их Жаргалант сумын хүрээ хийд.




Их жаргалант сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Арын хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь сумын төвөөс зүүн өмнө зүгт 23 км зайд модтой ууланд оршиж байсан, 50-100 хүртэл лам хурал хурдаг байжээ.

2. Агьтын сүм. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус сүм нь сумын төвөөс баруун хойд зүгт модтой ууланд оршиж байсан, 50-100 хүртэл лам хурал хурдаг байжээ.

3. Гүнжилийн дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төв дээр Идэрийн голын ойролцоо оршиж байсан, 50 хүртэл лам хурал хурдаг байжээ.

11.Их-уул сумын хүрээ хийд.



- 1.Залтын хийд
- 2.Зартын бага дуган

- 3.Дара-Эхийн дуган
- 4.Юмын байшин

Их-уул сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:


1.Зартын хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс 10 өртөө хагас, сумын төвөөс 15 км-т Зард хэмээх газар оршиж байсан, 100 гаруй лам хурал хурдаг байжээ.

2.Зартын бага дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс 18 км зайд Зартын голын ойролцоо оршиж байсан, 30 гаруй лам хурал хурдаг байжээ.

3. Дара эхийн дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь аймгийн төвөөс 10-аад өртөө зайд Дээд цэцгийн голын ойролцоо оршиж байсан, 30 гаруй лам хурал хурдаг байжээ.

4. Юмын байшин дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс 16 км зайд оршиж байсан, 10 хүртэл лам хурал хурдаг байжээ.


12.Мандал сумын хүрээ хийд.



Мандал сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1.Мандалын хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь аймгийн төвөөс долоон өртөө зайд Цагаан доод голын хойд энгэрт оршиж байсан, 200 гаруй лам хурал хурдаг байжээ.

13.Их Тамир сумын хүрээ хийд.



Их Тамир сумын зурагт тэмдэглэгдсэн хийд дуган:

- 1.Пунцагчойндэлэг хийд
- 2.Мандалын Майдар хурал
- 3.Шивэртийн дуган

4.Бумбатын дуган Норовлин

5.Их Хужиртын дуган

6.Урт булагийн дуган Лхам

7.Арцатын дуган Лхам

**Мандал сумын хүрээ, хийдийн зургийн байршлын
тайлбар:**

1. Пунцагчойндэлэг хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь Тамирын голын Хөх даваа хэмээх газар оршдог, 800 гаруй лам хурал хурдаг байжээ.

2. Мандалын Майдар хурал. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хурал нь сумын төвөөс холгүй Тамир голын эхэн хавьд Уртын голын ойролцоо модон дотор оршдог, 40 орчим лам хурдаг байжээ.

3. Шивэрт буюу Шавартын дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс холгүй Тамир голын эхэн хавьд Уртын голын ойролцоо модон дотор Мандалын Майдар хурлын оршдог, 10 хүртэл лам хурал хурдаг байжээ.

4. Бумбатын дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь Пунцагчойндэлэг хийдийн баруун хойт зүгт модон дотор оршдог, байнга суудаг ламгүй, нэг лам сахидаг байв.

5. Их хужиртын дуган.Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төв зам дагуу Нарийн Хужирт хэмээх газрын ойролцоо оршдог, байнга суудаг ламгүй, нэг лам сахидаг байв.

6. Уртбулагийн дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь Их хужиртын дуганаас зүүн зүгт Бугат сумын хилийн ойролцоо оршдог, байнга суудаг ламгүй, нэг лам сахидаг байжээ.

7. Арцатын дуган, Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төв зам дагуу өмнө зүг Булган сумын хилийн зааг дээр оршдог, байнга суудаг ламгүй, нэг лам сахидаг байжээ.

14.Лун сумын хүрээ хийд.



Их Тамир сумын зурагт тэмдэглэгдсэн хийд

1. Эрдэнэзуу хийд.
2. Эрдэнэзуу сүм хийд
3. Чойнхорын хурал
4. Хурахуйн хурал
5. Хорчины хурал

Лун сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Эрдэнэ зуу хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс тав, сумын төвөөс нэг өртөө зайд оршиж байсан, 500 гаруй лам хурал хурдаг байжээ.


2.Эрдэнэ зуу сүм хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс тав, сумын төвөөс нэг өртөө зайд, Эрдэнэ зуу хийдийн хойд зүгт Орхон голын ойролцоо оршиж байсан, 250 орчим лам хурал хурдаг байжээ.

3.Чойнхорын хурал. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хурал нь Хөшөө цайдмаас баруун тийш оршдог, 10 хүртэл лам хурал хурдаг байжээ.

4. Хурахуйн хурал. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хурал нь аймгийн төвөөс таван өртөө, сумын төвөөс 40 км зайд Билүүт хэмээх газарт оршиж байсан, байнга суудаг ламгүй, нэг сахиулч ламтай байжээ.

5. Хорчины хурал. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хурал нь сумын төвөөс 40 км.зайд Ар гурван шанд уулын өмнө хэсэгт оршиж байсан, байнга суудаг ламгүй, нэг сахиулч ламтай байжээ.

15.Могод сумын хүрээ хийд.



Могод сумын зурагт тэмдэглэгдсэн хийд

- 1.Урт Мэргэний хийд
- 2.Баргын хийд
- 3.Эрдэнийн хийд
- 4.Бумбатын хийд
- 5.Жаргалантын хийд

6.Баян-Өндрийн хийд

7.Рашааны хийд

8.Баясгалантын хийд

Могод сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Уртын хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын зүүн урд хэсэгт Уртын гол дагуу Урт хэмээх газарт оршиж байсан, 30 орчим хурал хурдаг байжээ.

2. Баргын хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвөөс зүүн тийшээ таван өртөө, Түлээтийн нурууны өмнө үзүүр Барга хэмээх газарт оршиж байсан, 10 орчим лам хурал хурдаг байжээ.

3. Эрдэнийн хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын захиргаанаас зүүн хойд зүгт Эрдэнэ хэмээх газарт оршиж байсан, 50 орчим лам хурал хурдаг байжээ.

4. Бумбатын хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвөөс таван өртөө зайд Бумбатын голын хойт талд Бумбат хэмээх газарт оршиж байсан 60 орчим лам хурал хурдаг байжээ.


5. Жаргалантын хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвөөс таван өртөө зайд Жаргалант уулын энгэрт Жаргалант хэмээх газар оршиж байсан 100 гаруй лам хурал хурдаг байжээ.

6. Баян-Өндөрийн хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвөөс зүүн хойд зүгт таван өртөө зайд Орхон голын баруун хойд хэсэгт Баян-Өндөр хэмээх газарт оршиж байсан, 70 гаруй лам хурал хурдаг байжээ.

7. Рашааны хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн.Тус хийд нь сумын төвөөс таван өртөө зайд Хулзын баруун нурууны зүүн энгэрт оршиж байсан, 10 гаруй лам хурал хурдаг байжээ.

8. Баясгалантын хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвийн ойролцоо таван өртөө газар Баясгалант хэмээх газарт оршиж байсан, 70 гаруй лам хурал хурдаг байжээ.


16.Наран сумын хүрээ хийд.



Наран сумын зурагт тэмдэглэгдсэн хийд

1. Хожуулын хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс 13, сумын төвөөс хагас өртөө зайд Баян уулын өмнө энгэрт Хожуулын мухар хэмээх газарт оршиж байсан, 60 орчим лам хурал хурдаг байжээ.

17.Өлзийт сумын хүрээ хийд.




Өлзийт сумын зурагт тэмдэглэгдсэн хүрээ

1. Будантын хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь Будантын хүрээний голын хойд хэсэгт оршиж байсан, хэдэн лам шавилан сууж хурал хурдаг байсан нь тодорхойгүй.

2. Лаврин хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс дөрвөн өртөө зайд Бор-өндөр уулын өвөрт Өгийнuur хэмээх газар оршиж байсан ,70 орчим лам хурал хурдаг байсан мэдээ бий...


18.Өндөрсант сумын хүрээ хийд.



Өндөрсант сумын зурагт тэмдэглэгдсэн хийд

1. Цагаан сүмийн хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс гурван өртөө зайд Хөшөөтийн уулын энгэрт оршиж байсан, 160 орчим лам хурал хурдаг байжээ.

19.Өндөр-Улаан сумын хүрээ хийд.



Өндөр-Улаан сумын зурагт тэмдэглэгдсэн дуган

1. Хануйн дуган
2. Одорхын нуур дуган
3. Тахилын дээд дуган
4. Доод дуган
5. Шаргачны дуган
6. Маанийн дуган

Өндөр-Улаан сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар.

1. Хануйн дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь аймгийн төвийн ойролцоо Хуурай Хануй голын хойд талд Хуурай хануй хэмээх газар оршиж байсан, 20 орчим лам хурал хурдаг байжээ.

2. Одорхын нуур дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын захиргаанаас зүүн урд зүгт Зуун модны голын өмнө талд оршиж байсан, хэдэн лам хурал хурдаг байсан нь тодорхойгүй.


3. Тахилын дээд дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвийн ойролцоо Тахилын голын адаг хавиар Тахил хэмээх газар оршиж байсан, 20 гаруй лам хурал хурдаг байжээ.

4. Тахилын доод дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвийн ойролцоо Тахилын голын эхэн хавиар Тахил хэмээх газар оршиж байсан, 20 гаруй лам хурал хурдаг байжээ.

5. Шаргачны дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын захиргаанаас зүүн хойд зүгт Шаргачин хэмээх газар оршиж байсан, 40 орчим лам хурал хурдаг байжээ.

6. Маанийн хурал. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын захиргаанаас зүүн хойд зүгт Дашилигийн нурууны ойролцоо оршиж байсан, 20 гаруй лам хурал хурдаг байжээ.

20.Тариат сумын хүрээ хийд.



Тариат сумын зурагт тэмдэглэгдсэн хүрээ,хийд

- 1.Тариатын хүрээ
- 2.Чойчарлингийн хийд
- 3.Суурин хийд

Тариат сумын хүрээ ,хийдийн зургийн байршлын тайлбар:

Зураг дээр хүрээ, хийдүүдийн нэрийг бичээгүй байх бөгөөд харин зураг дээр тэмдэглэгдсэн тэмдэглэгээ, сумын төвөөс хэдэн км-т, ямар газар оршиж байгаагаар нь баримжаалан хүрээ,

хийдүүдийг тодорхойлов.


1. Тариатын хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс зүүн хойд зүгт 15 км. зайд оршиж байсан, 30 гаруй лам хурал хурдаг байжээ.

2. Чойчарлингийн хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвөөс зүүн хойд зүгт 20 км. зайд Бага хуурай хэмээх газрын ойролцоо оршиж байсан, 19 лам хурал хурдаг байжээ.

3. Суурийн хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвөөс зүүн урд зүгт 30 км. зайд Цагаан нуурын зүүн хэсэгт Нарийн хэмээх газрын ойролцоо оршиж байсан, 27 лам хурал хурдаг байжээ.

4. Улаанчулуутын дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс баруун урд зүгт Цагаан нуурын баруун хэсэгт Улаанчулуут хэмээх газрын ойролцоо оршиж байсан, 27 лам хурал хурдаг байжээ.

21.Хайрхан сумын хүрээ хийд.



Тариат сумын зурагт тэмдэглэгдсэн хүрээ

1.Хануйн хүрээ


2.Журамтайн хүрээ

Хайрхан сумын хүрээ ,хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Хануйн хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь сумын төвөөс хойт зүгт нэг өртөө зайд Хануй хэмээх газар оршиж байсан, 205 орчим лам хурал хурдаг байжээ.

2. Журамтайн хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь сумын төвөөс өмнө зүгт 20км. зайд Журамтайн голын зүүн хэсэгт Журамтай хэмээх газар оршиж байсан, 240 гаруй лам хурал хурдаг байжээ.


22.Хашаат сумын хүрээ хийд.



Хашаат сумын зурагт тэмдэглэгдсэн сүм

1. Номгон сүм. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус сүм нь сумын төвөөс зүүн өмнө зүгт 30 км. зайд Их номгон уулын өвөрт оршиж байсан, 50 орчим лам хурал хурдаг байжээ.


23.Хотонт сумын хүрээ хийд.



Хотонт сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1.Хорин хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь аймгийн төвөөс баруун урагш дөрвөн өртөө, сумын төвөөс зүүн өмнө хэсэгт оршиж байсан, 150 орчим лам хурал хурдаг байжээ.


24.Хүрээмарал сумын хүрээ хийд.



Хүрээмарал сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Алтангэрэлийн хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь аймгийн төвөөс 12, сумын төвөөс зүүн хойд зүгт хагас өртөө зайд Хүрээ Марал уулын зүүн энгэрт оршиж байсан, 144 лам хурал хурдаг байжээ.

25.Цахир сумын хүрээ хийд.



Цахир сумын зурагт тэмдэглэгдсэн хийд

- 1.Дамбаравжаалийн хийд
- 2.Жанчивлин дуган
- 3.Манал дацан
- 4.Тахилын дуган

Цахир сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:


1. Дамбаравжаалин хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвөөс 9 өртөө зайд Их-Уул хил залгаа Загастын голын Загастай хэмээх газар оршиж байсан, 100 орчим лам хурал хурдаг байжээ.

2. Жанчивлин дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс хоёр, аймгийн төвөөс 11 өртөө зайд Нарийн сумтай хил залгаа Байцын голын Байц хэмээх газар оршиж байсан, байнга шавилан суудаг ламгүй, Дамбаравжаалин хийдийн лам нар цаг улирлын байдлаар хурал хурдаг байжээ.

3. Манал дацан. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дацан нь сумын төвөөс 15км, аймгийн төвөөс 9 өртөө зайд Хангай сумтай хил залгаа Нарийны голын ойролцоо оршиж байсан, байнга шавилан суудаг ламгүй, Дамбаравжаалин хийдийн лам нар цаг улирлын байдлаар хурал хурдаг байжээ.

4. Тахилын дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс нэг, аймгийн төвөөс 10 өртөө зайд Нарийн сумтай хил залгаа Тахилын голын ойролцоо оршиж байсан, байнга шавилан суудаг ламгүй, Дамбаравжаалин хийдийн лам нар цаг улирлын байдлаар хурал хурдаг байжээ.

26.Цэнхэр сумын хүрээ хийд.



Цэнхэр сумын зурагт тэмдэглэгдсэн хүрээ

1. Бүрдийн хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь сумын төвөөс гурван км. зайд Бүрдийн нуурын баруун хойд хэсэгт оршиж байсан, 164 орчим лам хурал хурдаг байжээ.


27.Цэцэрлэг сумын хүрээ хийд.



Цэцэрлэг сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Бухын хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь Улаанбаатраас 22, аймгийн төвөөс 8, сумын төвөөс баруун тийш нэг өртөө зайд Чулуутын голын дагуу оршиж байсан, 80 орчим лам хурал хурдаг байжээ.
2. Агьтын дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн.

28. Чулуут сумын хүрээ хийд.



Чулуут сумын зурагт тэмдэглэгдсэн хийд дуган

1. Дэчинравжаалийн хийд
2. Цогтхайрхан дуган
3. Өндөрбаянжаргалант дуган
4. Улаан-Овоо дуган
5. Овоо дуган

Чулуут сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Дэчинравжаалин хийд. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хийд нь сумын төвөөс зүүн зүгт дөрвөн өртөө зайд машины зам дагуу нэр тодорхойгүй овооны ойролцоо Чулуут хэмээх газар оршиж байсан, 220 орчим лам хурал хурдаг байжээ.

2. Цогтхайрхан дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс баруун зүгт Галуут нуурын өмнө хэсэгт Цогтхайрхан уулын ойролцоо оршиж байсан, хэдэн лам хурал хурдаг байсан нь тодорхойгүй.


3. Өндөрбаянжаргалант дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс зүүн өмнө зүгт Өндөрбаянжаргалант уулын эр энгэрт оршиж байсан, хэдэн лам хурал хурдаг байсан нь тодорхойгүй.

4. Улаан-Овоо дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус

дуган нь сумын төвөөс зүүн өмнө зүгт Чулуут голын өмнө хэсэгт Улаан овооны баруун талд оршиж байсан, хэдэн лам хурал хурдаг байсан нь тодорхойгүй.

5. Овоо дуган. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус дуган нь сумын төвөөс хойд зүгт нэр тодорхойгүй овооны өмнө талд оршиж байсан, хэдэн лам хурал хурдаг байсан нь тодорхойгүй.

29.Шанх сумын хүрээ хийд. Чулуут сумын зурагт тэмдэглэгдсэн хүрээ



1. Баруун хүрээ
2. Баруун хүрээний сүм
3. Хангайн хурал

Шанх сумын хүрээ, хийдийн зургийн байршлын тайлбар:

1. Баруун хүрээ. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хүрээ нь сумын төвөөс өмнө зүгт 6 өртөө зайд Өлзийт голын өмнө хэсэгт оршиж байсан, 558 орчим лам хурал хурдаг байсан.

2. Баруун хүрээний сүм. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус сүм нь сумын төвөөс 6 өртөө зайд Өлзийт голын өмнө хэсэгт Баруун хүрээний баруун талд оршиж байсан, 125 орчим лам хурал хурдаг байсан.

3. Хангайн хурал. Зураг дээр дүрсээр тэмдэглэгдсэн. Тус хурал нь сумын төвөөс баруун хойд зүгт Орхон голын ар хэсэгт Хангайн нуруунд оршиж байсан, хэдэн лам хурал хурдаг байсан нь тодорхойгүй, зундаа нэг удаа хурал хурдаг байсан..



МИНИЙ БУУРАЛ АБУУ МИНУУ
Намтарчилсан баримтат найраглал

Аврорийн буудлага умартад сонсдон
Ажилчин тариачид зэвсэглэн босож
Ари үндэстэн монгол гаралт
Агуу Ленин түүнийг удирдах тэр үед
Ар халх дөрөв, шавь таван хошуу
Ачит Богд хаанаараа удирдуулан
Амар тайван аж төрж ахуйд
Арын сайхан хангай нуруу
Заяа учрал төгс бүрдсэн
Заяын шавийн нутаг
Хүнийн голын ар дэнж
Хүй далайн хошуу тохой
Хар бууц нэртээ өвөлжөөнд
Хүмүүн орчлонд хүй тасарч
Хөвүүн заяагаар мэндлэн
Хайрт аав Гунгаа тан
Хатан ээжий Должин нарт

Удам залгах үр болон,
Ураг батжих дэмбэрэлээр
Уухай хадаан дуугаа өргөсөөр
Урдын хураасан буяны үрээр
Ухаант хүний дүрээр үр заяав

Асар удалгүй дэлгэр зун болж
Ачит гэгээнийхээ өртөөг залгахаар
Аав ээж хоёр нь урагш нүүж
Арав таван малаа туусаар
Заяын хүрээнээс хоёр өртөө газар
Заяа түшэн эзгийнтийн хужиртад нутагшав
Мөдхөн дүү нар нь араас нь мэндэлж
Мунижав өвөөгийндөө аав очив.
Тоглохдоо галд орчихвий гэж
Тулгаа тойруулан бургасан хашаа барьж
Таалагдсан бүгдээ уйлж авч
Тун ч дураараа өссөн гэдэг
Дөнгөж дөрөв тавхан настай
Дөрөө дамжин морь унаж байхад
Маам гэлхай хүрээнээс хөдөөлж
Мунижав дүүгийндээ зусав.
Эрхийг сурахаар эрдэмийг сур гэх
Элдэв сургаалыг айлдсаар
Ээж аав хоёр эмэг өвөг нарыг
Эвтэйхан аргалсаар ятгасаар
Зургаа хүрэх тэр намар
Заяын доод хүрээнд анхлан аваачиж
Өлзийбадрах дацангийн горлом
Өвөг хуврага Бандихайнд сууришуулав
Түвд үсэг эхлэн заалгаж
Төдөлгүй манчү орхимж лам дээл өмсөв
Хүрээний хөл үймээнийг
Хашааны завсраар шагайж
Хүлэг морины туурайн чимээгээр
Хагас зурвас харан өнгөрөөж
Хүрээ банди нарын энд тэнд
Хөг дэгтэй ном жорлон уншихийг сонсож
Хэзээ нэг ийм болно доо гэж
Харимаар бодогдож гэрээ санах үе
Хааяа хааяа бодогддогсон сэтгэлдээ
Ууж идэх нь замбараагүй байснаа
Унтах идэх дэгэнд орж
Урт хормойтой дээл ч өмсөж байгаагүй учир
Урд хормойндоо байнга бүдэрч
Бааж шээхдээ хормойдоо хүргэж
Бандихайд жаахан зэмлүүлдэгсэн

Тэгж байтал зулын хурал болж
Томжоо Отгонжаа хоёр минь ирж
Тэрэг тэргээр түлээ авчирч
Торх гүзээгээр шар тос марчинг
Тэвэрч өргөсөөр Бандихайд барив
Нэр баруундаа мандаж сэтгэл цэлмэн
Намайг дагуулан хоёр ажаа минь
Дээд хүрээ ваюу орж үзэн
Дэлгүүр хоршоогоор оруулав.

Нанжин чавга жинг авч хормой
Навчин тамхи цай авч богц дүүрэв.
Нар баруунаа жамаараа жаргаж
Нулимс дуслуулсаар хоёр ажаагаа үдэв
Урууданхан гудамжаар алхаж явахад
Урдаас харан банди нар шоолж
Уйлдаг уйлдаг
Еээ еээ бөөвөө
Аавыгаа санаа юу
Ааруулаа санаа юу
Ээжийгээ санаа юу
Эззгийгээ санаа юу
Эчиг Эчиг Эчиг гэхэд
Түргэхэн гүйж хашаандаа ороод
Төмөр гинжээр хаалгаа цүүлэв
Цас малгайлан орж дагтаршин харлаж
Цаанаа л жавартай өвөл нэг өнгөрч
Хүрээ ном янгаа сургуулилж
Хөдөө бууз баншаа бэлдэж
Хоног тоолох өдөр ирж
Хаврын тэргүүн сар айсуй.
Хажидийн 25-нд хурж чого
Хажуугаар нь балингаа адислан

Их цогчин дугандаа лам нар цугларч
Идээ будаа бурхандаа өргөж
Эх адаггүй лам нар жигдрэн

Эхлэн унзад хурлаа эхлэв.
Бүдүүн унзадын хоолой нүргэхэд
Бүгд даган уншиж эхлэв
Суран сармай дээлтэй
Суу маажиг гуталтай
Дунжаа мөрний араар сууж
Дуу шингэлэн түргэсгэж
Олон ном цээжтэйгээ үзүүлэх гэж
Омог гаргаж чанга уншихад
Мөнөөх унзадын их дуу
Мөөрөх бухын урамдал шиг
Торж тээглэхгүй их үер шиг болж
Тодхон шингэн дуу маань
Түүнд хөвөх өвс мэт болж замхран
Төө зайтай өөрийн чихэндээ ч үл сонсдов.
Хойноос их бүрээ дуугарахад
Хүчит луу архирах мэт

Холбоожлон хэнгэрэг цан цохиход
Холоос сахиус залран ирэх мэт
Ер бусын байдалд сэтгэл автан
Ертөнц өөр газар очсон мэт
Тогшолт ихтэй цан цохиж бишгүүр янцгаахад
Толгой дахь үс маань босоод ирэх шиг
Дэлгэмэл танг догшид маань
Дэргэд минь залраад ирэх шиг
Буян ихийг хурааж
Бурханы оронд очсон мэт болж
Баяр хөөрөөр дүүрэн хурал гадаалж
Бандихайгаа дагаж гэртээ явахдаа

Баадантай барилаа барин зүтгэнэ
Буяны ачаар урам сэргэж
Битүүнд лхам сахиусаа тахив
Шөнө нойргүй хурсан ч
Шинийн нэгний өглөөний
Сэргэг сэргэлэн буйг яана
Шалавхан багштайгаа золгож
Шүтээндээ тахил мандал өргөөд
Айл гэсэх гэж яаран догдолж
Алхах биш гүйж харав
Зэгзгэрхэн биетэй жигдхэн лам хувцастай
Зиндааныхаа хэдтэй үгсэн нийлж
Айл айл хэсэж бэлэг бэлэг авч
Аруул боов самбайгаар
Ар өвөргүй дээлэндээ өвөрлөж
Баяр хөөр сэтгэл хангалуун
Баахан дэггүйтэж байдагсан
Удалгүй ерөөл эхлэж
Урьхан сайхан хавар болж
Саравчинд болжмор жиргэж
Санаа сэтгэл түвшинч
Хаврынхаа шүүлтэнд бэлдэж
Хажуу айлынхаа өрөө лам нартай
Хааяа нэг тоглон наадаж
Хүрээ маяг суун хуучирав
Томжоогийнхоо өгсөн бурмыг дуусаад
Түлээн дээр гарч алсыг харж суутал
Дээд жиндааны хоёр ламтан
Дэггүйтэх санаа өвөрлөж
Манай хүрээнд ирсэн болгон авдаг

Могдоороо олж авсан уу гэв.
Аваагүй юу байдаг юм вэ? гэж асуухад
Авахгүй бол өөр хүүхдэд өгдөг гэж
Арга замыг нь зааж өгье гээд
Ахлах жиндааны лам нар
Алиа хошин үг нэмэн зааж
Айл болгоноор бадар бариулж
Үдэш орой болтол явж
Үнэн үгийг эс олов.
Гэртээ буцаж Бандихайдаа хэлтэл
Гэнэн тэнэгээрээ жаахан загнуулав.
Дээд хүрээнд Бандихайтайгаа очиж
Дээдсийн өмнө шүүлгээ өгөв.
Дүйнхорийн багшдаа шавь орж
Дэргэд нь хамт нянба хийв.
Хүйтний ам цаашилж
Хөхүүрийн ам нээгдэх цагт
Гэгээнтний гүшиг дацангаас
Гүүгээ эхлэн барьж үрс гаргав
Урд тамирын захад лам нар
Унага татаж, сүүн цацал өргөн
Урдаас эхлэн нар зөв тойруулж
Сангийн толгой цөөн цод
Сайрийн овоо цөөн цод
Бүхэг цэнхэр цөөн цөд
Бүрдэнэ хоолой цөөн цөд
Майдар чулуу цөөн цод
Мааньтийн овоо цоон цод
Алтан овоо цөөн цод
Арцат хайрхан цөөн цод гэж

Зүг зүгтээ сүү цацал морьтой өргөж
Зүг зүгээс хүмүүс цугларч
Дэрвэлзсэн алаг асараа барьж
Дээдэс лам нар жигдрэн суув
Тунамал унзад лам гурван эрдэнэ гэх
Түрүү магнай дуу ая эгшиг өргөж
Дараалан ялгуугсан эрхт
Далай лам Даамай эх лхаму янжимаа зэрэг
Багш, ядам, чойжин хандийн
Бат оршилт аялгуу өргөв.
Гэтэл санаанаас гарахгүй
Гэнэт сонин зүйл болов

Хамт явсан лам нар халбагаа мартаж
Хаалгач Дамдинсүрэн гуай
Саахалтын хол газар болох
Сангийн толгой дээрээс
Хүрээ рүү харж зогсоод
Хүчирхэг бүдүүн хоолойгоор
Халбагаа аваад ирээ гэхэд
Хойноос дууг нь сонсож
Халбага барьсаар морьтон ирж билээ
Энэ их дууг урьд сонсоогүй бидний
Энэ өдрийн зугаа болон өнгөрөв.
Маргааш нь наадам товлож
Манай дацангаар гэгээн морилож
Зээглэн суусан лам хүүхдүүдийн өмнүүр
Зэрвэсхэн харж өнгөрөхдөө
Миний доор суусан Самбууг
Морио унуулахаар сонгов.

Амихандаа горидож суусан ч
Арваад хүүхэд аваад гарав.
Наадмын өдрийн өглөө болж
Нас насны морьдууд шушиг дүүрч
Үе үеийн хүүхдүүд гийн гоолж
Үнэхээр сэтгэл сайхан байлаа.
Булганы өвөр дуугаа өргөж
Буян хишгээ хайрхандаа даатгав
Армаг түмэн эх дуугаа эхлэж
Азарга морьдон бөх эхлэв.
Хэрээ Дэмбээ, нохой Гомбын
Хийц сайтай уран мэхийг
Хэн хүнгүй сайшаан магтана
Начин Давгийн баглааг харж
Наана цаана нь засуул гарч түргэлүүлнэ.
Сүр хүчтэй арслан заанууд
Сэгсүүргэн хурга шиг бөхчүүлийг хаяна
Гэвч тэд барилдааныхаа өмнө
Гэгээний сүлдэнд гурав мөргөнө
Анх давааны аранга бөхтэй
Аз зол нь гийсэн түрүү бөхтэй
Ахиад бас үзүүрлэх бөхтэй
Бүү эрт тааруулаарай гэж
Булган хангайдаа гурав мөргөдөгсөн

Асарт суугаа наадамчдын
Айл байдалыг нь харваас
Алаг эрээн зөгий үүрээ тойрон эргэх шиг
Айраг идээгээ зооглон гаран орон сууна
Ахиулан яриаг нь сонсвоос

Азарганд миний соёолон айрагдахгүй бол
Алаг ишигнээс худалдана гэж уяачид тэнд
Түрүүлэх нь ойлгомжтой наадамд
Түрүү бөхийнхөө байг зарна гэж бөхчүүд энд
Аатай зарим нь аархаж
Ам дамжин хөгжилдөнө
Азарга ирлээ гэж морь бариач
Амьтан хүмүүсэд дохио өгөв
Айл саахалтын зайнаас
Азрага цуван харагдана
Салхинд гүйцэгддэггүй шар цоохор зүстэй
Сааралгүй давхин тэргүүлэх азрага нь
Гэгээнтний цөм сүргийн манлай
Гэдгэр цоохорын унага байлаа
Морь унаж түрүүлүүлсэн хүү нь
Мөнөөх Д.Самбуу байваа.
Найз юм гэсэндээ тэрүү
Надад мөрийний чихрээс өгсөн
Асарын өндөр дуугаа эхэлж
Ажнай соёолон морь морьдож
Арслан заан хүчит бөхчүүл
Аархан илүүрхэн гурав давцгаав
Гавж нар цуглан айраг зооглож
Гэгээнтэнд бат-оршил өргөв.
Нагаадам гэх нь түвд гаралтай
Най-нь орон, гаадон нь хурим гэж
Нэгд нэггүй тайлбарлан сууцгаана
Өвгөчүүл билиг дэмбэрэл дэгнэж
Өдрийн сайныг магтан байна.
Уяачид өөр хоорондоо

Уралдах морьдийг шинжин
Уяа сойлогыг нь тааруулж
Үүл харан ажиглаж хүүрнэнэ.
Үнэхээр гярхай ажиглан сонжино Номтой иртэй гэвш нар
Ном хаялцан мэтгэлцэнэ
Номой дорой банди нар
Нилээн зайдуу сууцгаана
Эмэг өвөг хөгшчүүл
Эргэн тойрон гороолож
Маань мэгзэмээ уншиж
Мутарын адис гэгээнээс авна.
Удган жороо морьтонгууд
Урд хойгуур сүлжилдэж
Уртын урт дурдан бүс нь
Уяхан салхинд дэрвэлзэнэ.
Урд тамирын улиасанд
Усны цуваараа сүүдэр хийж
Хэсэг хэсгээрээ хүмүүс цугларч
Хоол цайгаа тухлан ууна
Борвитой айрагаа сөгнөж
Борцтой шөлөө ууцгаана
Өдөр хоног өнгөрсөөр
Өмссөн дээл гандаж
Унасан морь хүртэл гундаж
Удаан үргэлжлэх найр өндөрлөв.
Өвөөлзгөнө дугаравч өвлөөрөө
Хөхөө дугаравч хавраараа
Өвгөн намайг дуугарахаас нааш

Өөдтэй зун болохгүй гэж
Мэлхий гуагалдаг юм гэж
Маам гэлхайг хэлж суутал
Хар эсгий малгай хэт хутагтай
Харлага морьдоо ижилсүүлж
Хаа бараанаас ирж буй
Хайрт абуугаа би танин гүйдэгсэн
Үг сүггүй уйлах намайг
Өвөртөө дүүрч мордоод
Айлын том хүүхэд чинь
Арай ингэж болохгүй гээд
Толгойг минь удаан үнэрлэж
Товор товор алхуулсаар ирэв Бандихайнд
Цогчинд аав маань зэд барьж
Цуг явж өглөгийн эзэн болов.
Дүйнхорын багшид айраг барьж
Дүн нуруугаа асууж болгоолгов
Маргааш өглөө эрт босож
Майдарын дуганд чавир барьж
Манзан сүүнд хандив өргөв
Заяын хүрээний шүтээн бүрт
Заавал хадаг, дээж өргөв
Гонир ламаас зөвшөөрөл авч
Гэгээнтний симчэнд
Гэгээнд бараалхав
Ойрын зайнаас анхлан харахад
Орос баринтагтай байсан санагдана
Абуу минь бараалхсаны дараа
Араас нь дагаж гадаалаад
Морь харсан тэр шороог нь

Малгайдаа хийж рашаан гэж
Нандигнанхан боож авсан нь
Надад одоо хүртэл хадгалаж буй
Ах лам маам гэлхайгаа дагуулж
Абуу бид гурав хөдөөлөхөөр морьдов.
Сайвар алаг морьд нь хазаар даран
Сэвэлзэнхэн толгой хаялсаар
Хүрээ хийдийн их горломоос
Хөдөөг зорин бид гарлаа
Абуу гялхай хоёр яриа дэлгэн
Алсын замд дөрөө харшуулна

Ам дарах мориныхоо жолоог татаж
Ард нь нэг урд нь нэг гарсаар бид
Аанаа л донгийн даваа ойртов
Овоон дээр абуу түр зогсон
Олом жирмээ чангалах зуур
Маам гэлхай овоо тойрон
Манаран цэнхэртэх ууландаа залбирч
Хэдэн хором морьдоо амраагаад
Хүрээ нутаг уруудан хатируулав.
Хатирч харлаг жигдхэн ергүүлэхэд
Хүрээ гэлхайн бие асгадаж
Хатирч мориныхоо жолоог татав
Хажуудах бид хоёр бас дагаж гэлдрэв.
Гэлдэрч явсан маам гэлхай
Гэв гэнтхэн яриа үүсгэж
Даагын тал харагдахад
Домог түүхийг ингэж хүүрнэв
Зая гэгээнтнийг таалал барихад

Зарим шавь нь хаана төрөх тэмдэг асуухад
Баруун гараа дээш өргөхөд нь
Бүхэлдээ дөрвөн хуруу тэгшхэн байв гэнэ
Энэ бол бидэнд үзүүлсэн тэмдэг нь
Эндээс хойш даага эцэхгүй
Давхиад хүрэх газар гэж
Даагын тал нутгийг заагаад
Хүй дарах газар энэ гэж
Хүйсийн ам гэж нэрлэн.
Урагшаа хийгдэх үйлээ үз гэж
Урдах дал хайрхандаа
Үхэхэд минь хөрш нь зөөлөн гэж
Сүйж хайрхадаа тахь гэж
Үйлийн үрийг алсаас болгоон
Үнэнч шавь нартаа гэрээслэв гэж
Элдэвийг хүүрнэн ярих зуур
Эзэгийнтийн хужиртад ирэв.
Цоорхой зуслангийн хот айл уруу
Цогиж байснаа сайвар алхахад
Хоточ хойлог давхин ирснээ
Хүлэг морьд эздээ таниж
Хойгуур урдуур тоглон давхина
Үд хэвийж орой болон
Үнээн зэлэнд мал багширч
Үхэр тугалын мөөрөх дуулдаж
Үнэр танил бууц ханхална
Бидний ирж буйг харав бололтой
Бэлтгэсэн гэрт эсгий дэвсэж
Гэлхайг сугдан буулгаж
Гэртээ орон тухалцгаав

Хүрээ хийдийн сонин сонсохоор
Хүмүүс гаднаас гэрт цуглав.
Ээж минь намайг үнсэж
Элгэндээ хэсэг тэвэрснээ
Холын зочдод хоол унд барьж
Хойд гэрлүү зөөж одлоо
Жаргал дүү маань гуравхан настай
Жаал Даваажав ой хүрээгүй ч
Сааль сүүгээ алдалгүй саадаг
Саахалт хотондоо ажилсаг нэртэй
Хоолоо тухтай ч идэх завгүй
Хорвоогийн сайхан эжийн нэг миний ижий гэдэгсэн
Гахайн жаргал тохойдоо шиг
Гэртээ ирэх миний жаргал

Үрээхэн бороороо давхих сайхан
Үеийнхээ найз нарт хүрээрхэх сайхан
Үдэш болтол тоглох нэг сайхан
Үлгэр сонсонгоо унтах бүр сайхан
Өвөө эмээгээрээ хуврага гэж
Өөдөө залуулж хүндлүүлэх сайхан ч
Өвөл дөхүүлж намар хүрээлэх нь гэхээр
Өдөр хоног сум шиг хурдан өнгөрнө
Хөхөөн дуу дуугарах нь цөөрч
Хөхүүрийн ам цаашлах цагаар
Харамын сэтгэл оруулахгүй гэж абуу минь
Харанхуй шөнө адуугаа хурааж
Гүү унага салгахгүй шүү гэж
Гүүргийлж дундуур нь тасдаад
Хоёр хувааж адуугаа тууж

Харлага морьдоо бид хоёр унан
Хүрээ лүүгээ адуугаа тууж очин
Жи дацангийн даамалд өгч
Жиса тамгаас зэд болгон
Дацан болгонд манз цав барьж
Даатгал буяныг их хийдэгсэн
Харлаг халтар морьдоо хөтөлж
Хүрээ хөдөөд их зөөсөндөө абуу минь
Олон хавар намрыг үзэж
Овооч ном сурч эхэлж байтал
Хорвоогийн мөнх бусын жамаар
Халамжит абуу минь бурхан болов.
Одтой тэнгэр хөрвөх шиг болж
Онцгой гуниг цээжинд хурлаа
Ахмад гэх би арван тавтай
Араасаа дөрвөн нялх дүүтэй хоцорч
Ар гэрийн бүх ажил аяндаа
Абуугаа орлон үлдэвээ надад
Хүрээнд сууж ном үзэхийг
Хайрт эжий минь үглэн ятгавч
Хамаг ажлаа тэдэнд үүрүүлээ гэж
Хааяа хааяа явган гүйн очиж
Хоёр өртөө газрыг туулан
Харихдаа явган явсаар сурлаа
Хүргээд өгөх аав минь үгүй
Хөтлөөд морио буцаах хүнгүй тул
Өглөө заяын хүрээнээс гарч
Үдэш гэртээ ирдэгсэн
Зэд чаврайгаа нямбай хурааж
Чимхийг дутуулгүй ээждээ

Чихэр боов ховор идээг
Жижигхэн дүү нартаа өгдөгсөн
Гэтэл гадаад төрийн байдлаар
Гамин ирж Богдийг хорьж гэнэ гэх
Олны яриа гарах болов.
Орилоо наймаа гэх мэт хятад доншуур
Омог нь ихдэж ишгэн сүүл годойсон
Эзэн луухаан заларсан гэж
Эргүй тэнэг малаар нь загнаж
Энгийн ард түмнийг дайрч байв.
Удалгүй дараа зун нь
Усан бороо дэлгэр орж
Бороон жанжин хүрээг эзэлж
Богдыг шоронгоос гарган
Хааны ширээнд хоёр дахиа залахад
Хажууд нь манай гэгээн байсан гэдэг
Улс орон ингээд төвшин байтал
Улаан орос гэдэг хойноос ирж
Бүтэх бүтэлгүй хэдэн монголыг дэвэргэж
Большевик гэдэгт элсүүлж
Богдийг маань ширээнээс авч
Буруу. чиралбийн үзэл тулгаж
Бурхан шашиныг хорьж эхлэв
Нэг үхрийн эвэр дэлсвэл
Мянган үхрийн эвэр доргидог шиг
Газар газар хомоон гарч
Гавчиж эхлэв сүм хийдийг
Таван зуун мянга хүрэхгүй түмнийг
Тамын зовлонг амьдаар эдлүүлж
Эрдэмтэй гурван түмэн хуврагийг

Энд тэндээс сорлон түүж
Номтой гэж атаархсандаа ч тэрүү
Номой гэлэн гэж дээрэлхсэндээ ч тэрүү
Эсэргүү гэдэг ганцхан үгээр
Эрүүдэн байцааж тулган
Хонь хурга шиг хашиж байгаад
Хомроглон буудан алсан гэсэн
Булган хайрханы зүү суганд
Баахан лам нарыг хашиж байгаад
Зургадугаар морин хороо бүсэлж
Зургаа долоон цаг буудаж дуусгасныг харсан.
Дутаа алсан зарим нь орилож
Дээгүүр нь махчин шувууд эргэж
Улайны золбин ноход хүүр идэж
Улаан шаргал орхимж салхинд хийсэж
Ойртож очиход огидос хүрэн үнэртэхэд
Олиггүй хүмүүсийн үнэр хүртэл өмхий гэж
Олонд зар тарааж байж билээ
Омог уур хөдөлж очиж багшийнхаа шарилийг
Онгольё нохойд идүүлэхгүй гэж бат шийдэн
Орой шөнө болохыг бид гурав хүлээв
Унзад багшийн ойрын шавь
Унаган найз Цэдэн-иш Бадарч бид гурав
Уруудах гүн жалга даган явж
Удалгүй талааны газар ирэв.
Багшийнхаа цогцосыг хайж
Бадарч гурван мичид тохиоход л нэг олов.
Бид орхимжинд боогоод дамнаж
Бядтайгаараа би толгой талыг нь тэврэв.

Өгсөж бүдчиж будилж явсаар
Өрөөлдөн чөдөрлөсөн морьдондоо очвол
Хамар нь тачигнаж үргэн
Хавьтуулах янзгүй боловоо
Явган их тэвэрч явсан болохоор
Ядарч гар цуцаад байв
Үүр хаяарч гэгээ орсон тул
Үнэндээ бид ихээр айцгааж
Арцатын өвөр хавьцаа болбуу
Алд гүнзгий нүх ухаж
Цогцосыг хийж чулуугаар дараад
Цэвэрхэн мэдэхээргүй булж билээ.
Арван долоохон насандаа
Аймшигт тамыг бид үзэж
Тэрнээс хойш би шөнө явахдаа
Тэр нэгэн дүр зураг их бодогддогсон
Дүйнхорын багш Бандихай бид гурав
Дандаа нэг гэрт байх болов
Яасан ч авгай авч хар болохгүй
Яавал ч яаг гэж тэр хоёр шийдэв.

Хуралд хурж хийддээ очоогүй ч
Хүнтэй гэрлээгүй бол лам хэвээр
Хуврага ламын татвар гэж
Хуулиар албан журам төлж эхлэв
Хогшлоо зарж төлж байсан ч
Хойшид гурван хүний татварыг
Төлж дийлдэхгүй болохоор
Түлээ айлуудад буулган хөрөөдөж
Түр ч гэсэн би дарж байлаа

Энэ байдлын хэцүү байгааг
Эрдэмт багш минь ойлгоод
Намайг дагаж хөдөө гарав
Ногоон нуурт би байшин барьж өгөв
Багш гэж хэлбэл буруудах учир
Байшингийн лам гэж нутгынхан хэлдэг байв.
Аймагт албадан ажил хийж
Арай гэж багшийн татвар төлж байтал
Цэрэгт гэрт минь ч очуулалгүй
Чирч аваачаал татаж билээ.
Язава гэх данхар машинд
Яаядаа гэтэл чихэж суулгав
Машинд сууж үзээгүй бид
Малгайгаа бие биерүүгээ шидэн
Марзганаж явлаа найз нартайгаа
Холын замд хоол муутай
Хоёр хоног давхиад хүрээ оров.
Баруун талаас шар хөв давахад
Баахан гэрэл асаж сүртэй харагдав.
Үдэш орой юм сайн үзэгдэхгүй ч
Үйлгүй Богдийн өргөөг шууд танилаа
Өндөр хоршооны урдуур гарлаа л гэнэ
Явж явж нэг газар зогсов
Яалтгүй маахуур толгой гэлээ.
Коммисар буухыг тушааж
Хам хум бууж майханд орлоо.
Бүхлээрээ шахуу унтсан биднийг
Бүрээн дуугаар сэрээн жагсааж
Цээж нүцгэлэн усанд оруулж
Цэргийн хувцас тараан олгов

Ногоотой шөл талх зэрэг
Ноормын хоолондоо дасаж байтал

Бүрээ гэнэтхэн дуугарч
Бүхээгтэй машинд суулган
Баахан их газар явсаар
Баян түмний заставт очив
Баян түмний морин шумууланд
Булдруу болтлоо хазуулж
Тасгийн орос сургагчид дэглүүж
Танкийн саадыг өдөржин ухна
Ногоон нүдтэй Николай сургагч
Нечего давай, гэж орилоод
Нойр хоолгүй зүтгүүлдэгсэн
Нэрийг нь бид махлай гэдэг болов
Дорны талыг тарвага шиг ухаж
Долоон найман сар өнгөрөөд
Булан дэрсийн заставт ирж
Буу мөрлөж хил дээр зогсов.
Багш шүтээний хүч байсан байх
Байлдаан тулаанд нэг их ороогүй
Хөнгөн пулёматийн научик
Хоёр жил шахуу хийлээ

Агтан дээр жил гаран байхдаа
Адууны хашааны нүх ухаж
Хаалганы шонгийн ганц нүхийг
Хэдэн биендээ ялархаад орхив
Маргааш нь хашааг хамгаалалт авчээ
Маний орхисон шонгийн нүхнээс

Баартай том их мөнгө гарч
Баахан цэргүүд хамгаалж байв
Олз олох боломж байлаа
Олиггүй залхуугаас боллоо гэж гэмшив
Ар гэр болон багшийнхаа татварт
Арга эвийг нь олж мөнгө хураах санаатай
Ноормын тамхи, гурван янчааныг
Нандигнан хадгалж цуглуулан
Ээж дүү нартаа цөмд нь бэлэгтэй
Ээлжит халагдах хоногоо хүлээж байв.
Тамхины мөрийтэй модон морь хариаж
Түүн дээрээ малгай давхарлаж
Түрүүлэх гэж хэт мэрийснээс
Тулгуур гараа мулт алгадаж
Тархиараа харуулдаж хэсэг гэмтэв
Санхүүгийн сургууль төгсөөд ирсэн гэж
Самнасан халимагтай залуу Цэдэнбал ирж
Халх голын ойр орчимдох
Хилийн байдалыг таниулж
Эх орны төлөө эрэлхэг байхыг
Энхрий хайрт эх орон нам засаг
Эр цэрэг та бүхэнд даатгаж буйг ухуулж билээ.
Нэг их халуун өдөр байсандаг
Нэрээр минь намайг дуудаж
Эргэлтийн цаг олгов
Ээж биш байгаа гэж очтол
Хойд дацангийн манай зиндааны Аюуш
Ходок тэрэг ахлагч мүндииртэй
Хөх Цэдэн- Ишээс чамайг дууллаа
Комиссар танай суманд ирсэн гэв

Бид хоёр удаан хөөрөлдөж
Баяр цэнгэлээр нутгийн сонин ярилцав
Цэрэгт таван жил болоод
Цэргээс халагдах хоног тоолж байв.
Завханаас шинэ цэрэг ирж
Зарим нэг нь бооцоотой барилдав.
Хал цэргүүд давна гэж бодоод
Хамаг ноормынхоо тамхийг тавьчихав
Харахад бөх гэхээргүй нэг цэрэг
Хамгийг унагаан мөрийг авав.
Хожим сайн танилцахад
Хужаа нэртэй заан бөх байсан гэдэг.
Гэтэл нэг өдөр гэнэт
Гялгар хар машинтай
Баахан дарга нар ирж
Бүрээ татан түгшүүр зарлаж
Бүхээгтэй машинуудад суулган
Бичигтийн заставт аваачив
Халагдах нь битгий хэл
Хэзээ мөдгүй дайсан ирнэ гэж
Хориглох саадыг хоёр жил ухуулав.
Цэрэг хүн гэдэг бол
Цагаан ам даавуу ч өмчлөхгүй гэж
Халагдахаар цуглуулсан бэлгээ
Харамсмаар хураалгасандаа
Ногоон малгайт дэслэгч Дорж
Нэг өдөр биднийг жагсааж
Долоон жил алба хаасан
Домогт эрчүүд гэж магтаад
Сахил авч лам байсан цэргүүд

Салаан жагсаалаас гар гэхээр нь
Халж магадгүй гээд алхтал
Комаандлаж машинд суулгаад
Алс зайдуу яваад байхаар нь
Алах гэж байгаа юм болвуу гэж
Аминдаа бид түгшиж байв
Алсаас ганжар харагдаж
Арай нэг бид тайвшрав
Төлөөлөгч бууж ирэнгүүтээ
Түрэмгий зангаар хийдийг эвд гэв
Бид тушаал яалтгүй дагаж
Бүх юм нь бүрэн ёнзог хийдийн
Бурхан тахилыг зөөж гаргаад
Бэлтгэл склад болгосондоо
Үр ач та нартаа уламжлан
Үлдээж захих нэг зүйл нь
Егүзэр хутагтын хийдийг би
Ёр муугаар эвдэлцсэн хүн
Боломж нь олдвол та нар
Бүтээхэд нь оролцохыг захъяа гэдэгсэн
Тиймээс бид аавынхаа захиасаар
Тусгайлан Сүхбаатарын Эрдэнэцагаан орж
Эрхэм хутагтын сэргээгдсэн хийдэд
Элгэмсэг сэтгэлээр хандив өргөн
Мөнгөн тахил дэлгэн өргөж
Муу үйлий нь хариуг барьсан.
Аав минь долоон жил гурван сар
Ардын цэрэгт алба хааж байтал
Ашгүй Сүхбаатар жанжины гэргий
Ардын хуралд санал оруулж

Хийдэд хурдаг лам нар ч гэсэн ард
Хойноо ижий аавтай хүлээсэн ар гэртэй гэх
Янжмаа гуайн хүчин зүтгэлээр
Ямар ч байсан цэргээс халагдсан
Хожим учирьг нь дуулбал
Хүнийн гол орчмоор нутагтай
Дүйнхор тэргүүн, Махшар заан нар
Дээдэс гэгээнийг талсанд дүргүйцэж

Чуулган даргад заргын бичиг хийж
Чин сүжгээр өмгөөлсөн юм гэнэлээ.
Түүнд хорссон аймгийн төлөөлөгч
Толгой дарааллан буудан хороож
Шавь голдуу үлдсэн бүгдийг нь
Шар хувалзаар цоллон цэрэгт татсан гэдэг.
Эзэгийнтийн хужиртдаа ирлээ
Эжийтэйгээ амьд уулзлаа
Энхрий өнчин дүү нар минь
Эжид тустай овоо л том болжээ.
Үдэш орой ирсэн болохоор
Үд болтол унтаж амараад босоход
Богцтой баадантай юмыг минь
Бэлэг юу вэ гэж дүү нар минь харна
Босоод нүүрээ угааж цайгаа уугаад
Бушуухан бэлэгээ тэдэнд тараав
Ээждээ цай дээлийн өнгө
Эмэгтэй гурван дүүдээ алчуур сам даруулга
Ганц эрэгтэй дүү Жаргалдаа
Гаанс тамхи, буутай өгөв.

Сайд дарга ирсэн юм шиг
Сүрхий хүндэлж байлаа гэрийнхэн минь намайг
Адуугаа хурааж гүүгээ барихыг хүлээлгүй
Аргамжаатай морио эмээлэн унаж
Багшдаа золгохоор яаран давхилаа
Багш маань намайг ирнэ гэж мэдсэн юм шиг
Байшингийнхаа гадаа саравчлан угтав.
Багш шавь хоёр ингэж уулзав
Цаг төрийн байдлыг судлаад
Цэгцлэн гарсан хуулиудыг товчлоод надад өгч
Цэвүүн цаг нь ирж байгаа болохоор
Цаадуулынхаа эвийг олж эхнэр ав гэв
Жунай түвдийн өргөмөл охиныг
Журам төлөв хэмээн гэргийгээ болгов
Дээдэс өвгөдөөс үлдсэн мал хөрөнгөө
Дүү нартаа тэнцүүхэн хувааж
Өөртөө гэр засан өрх тусгаарлан
Өнчин ишиг ч өмчилж авалгүй
Эхнэр маань үйл үртэс оёж
Эмээлийн гөлөм, гутал, дээл хийж

Агент болж нааш цааш
Арилжаа наймаа хийсээр
Таван хүүхэд төрүүлж өсгөн
Таван хошуу малтай болж
Арав гаруй хайнаг хөллөж
Аян жинд оролцон явж
Алтанбулаг Сэлэнгээс гурил
Алс нийслэл УБ хотоос цай даавуу
Аймгаасаа түүхий нааш цааш тээж

Арав таван мөнгө цуглуулж
Айл саахалтынхандаа хүртэл
Ховор бараагаар нь хангаж
Хоёр хөл борви бохис хийлгүй ажилсаар
Түрүүчийн охин Хандаа сургуулийн нас хүрч
Тэмээ унаж Баян-Уулын бага сургуульд сурав
Тэнд бас байшин барьж өгсөн гэдэг
Тэр үед баруун зүүний нугалаа дуусаж
Байдал жаалхан ч гэсэн тогтворжиж
Барьж хорих нь гайгүй болов.
Баяжигтун хэмээх бодлого нь буруутаж
Байгаа мал хөрөнгийг минь
Бас л булааж гол харлуулав
Тавьхан толгой малтай болгож
Тавхан адуутай айраг уухаа больжээ.
Гүн ухааны ном үзсэний хэрэг юу билээ гээд
Гол хууль нэгдлийн дүрмийг багшийн бичсэний
дагуу судлаад
Сайн дурын үндсэн дээр юм чинь
Сум нэгдэлд орохгүй гэж заргалдахад Нэгдэлийн дарга,
хувьсгалч Цогзол ирж
Нээрээн та тийм санаатай бол
Үхэр босоогоороо хөлдөж үхдэг
Үргэлж мөнхийн цэвдэгтэй
Завханы тосонцэнгэл уруу
Заавал цөлнө гэж сүрдүүлэв.
Шар хувалз цолоо орхиж
Хар феодал цолоор шагнав
Багш маань намайг дуудаж
Баялаг хүнийг эвддэгийг сануулав

Баахан цааргалж байгаад би
Баян-Уулын нэгдэлийн хоньчин болов.
Шашинд орж хуврага болон хийдэд суувал
Шар хувалз гээд хааж боож хорино
Гэртээ очиж эжийдээ туслахаар
Гэргий аваагүй гэж ламын татвар авна
Хүрээ орж татвар төлөх ажил хийхээр
Хүчээр цэрэгт долоон жил хашраана
Азаар амьд халагдаад ирэхээр
Авгайгүйн татвар бас л авсаар
Айл гэр бүл хүүхэдтэй өнөр болж
Аймаг хот хооронд жин тээж
Арав таван малтай болохоор
Адлаж нударган гэж мал хураана
Бурхандаа зул хүж өргөхөөр
Буруу үзэлтэн гэж шийтгэнэ
Хайрхан уул усандаа сан тавихад
Харанхуй бүдүүлэг мухар сүсэгтэн гэнэ
Улаан номын үзэл бодол нь
Урьд хойд нас ерөөсөө үгүй
Хөдөлмөр гэдэг ажил хийвэл
Хүн болдог марксийн үзлээр
Үйлийн үр буян заяагаар
Үзүүр өндөр нам болсныг тооцохгүй
Нийтээр нь бүгдийг тайран тэгшилж
Нийгэм журамдаа оруулахыг зорьжээ
Идэр залуу оргил нас минь
Иймэрхүү амьдралыг тойрч биш дайрч гарлаа
Энхрий хэдэн үрс минь өсөж
Эхнээсээ хань бараатай боллоо.

Хуучин цагаа эргэн санавал
Хужиртын лхамын хуралын тахилга болж
Харлаг морьд зургааг аав бэлдэж
Хүрээнээс лам нарыг залав
Лхамын хуралын тахил балинг бэлдэж
Лам нар ирэхэд нутгийн хүн гэж моодгор байв.
Ар болон дунжа мөрөөр
Ах дүү нараа орхимжтой суулгаж
Хүрэн морь аав сэтэрлэж өргөв
Хүмүүс гороо эргэн мөргөв
Идээ будааны элбэгтэйг яана
Ирсэн хүмүүсийг сүсэгтэйг яана
Бууран даваагийн хүү Ширавсингийг
Баруун гэгээний хойд дүрээр тодруулан
Балдан лхамын тахилгын дараа
Синтийд залж мандал өргөв
Сүсэгтэн олонд мөргөл тавив.
Хурал сайхан болж өндөрлөв.
Хувь хишгийг нь би тарааж өгөв.
Сайхан цагаа санан дурсаж
Сэтгэл санаа гонсгордуухан ч
Малаа хариулж явахдаа би
Маань мэгзэмээ тасралтгүй уншиж
Бурханаа нууц далдхан шүтэн
Буян хишгээ даатган тахисаар ирсэн
Ачит багш аав ээжийнхээ араас
Арван буман маань ерөөл уншив.
Булавч бултайж даравч дардайж
Буян хишигт мал минь бас л өсөв
Бай тооллого ойртохоор бид нар

Баахан мал дарах гэж тэвддэгсэн
Ардын хувьсгалын 42 жилийн ой
Аймаг байгуулагдсаны 40 жилээр
Маршал Чойбалсан оролцоно
Маш сайн морьд уяхыг даалгав
Энэхүү наадамд уясан морийг
Эгшин төдий дурдахын тухайд
Өвөг дээдсийнхээ түүх үүхийг
Өчүүхэн төдий өгүүлбээсүү:
Харваач:
Мунижав өвөөгийн дээд өвөг
Манлай харваач Намхай гэж байжээ
Долоон хошуу даншигийн наадамд
Дараалан түрүүлсэн мэргэн байв.
Нэг удаа даншиг наадамд
Ноён харваачтай оноо тэнцэв
Цох харвахаас ноён айхад
Цолийг нь та ав мэргэн бол
Мөрийг нь би авъя гэж тохироод
Мөрийнийхээ даагаа хөтлөөд иржээ
Хаваржин даагаа уяж тойруулан
Хар хомоолыг гартал уяж оёнгийг нь гаргаад
Энэ жилийн түрүү манайх гэж
Эрэмгий байдлаараа аархахад
Хошуу олон нутаг газраас
Хүлгийн сор ирнэ тэгэхэд та зөнөж гэхэд
Нээрээн тиймээ сорууд ирнэ гэвч
Над шиг эзэн ховор гэсэн гэдэг
Тэгээд наадамд түрүүлсэн гэнэлээ
Түүний удам хөх борлогоо

Төрсөн дүү Жаргалтайгаа уяж
Төрийн том ойд түрүүлүүлж нэг баярлав.
Баярласандаа дүүгээ морьтойгоо буцаагаад
Бай шагналыг авахаар аав минь үлдэв гэнэ
Хуучин хүрээний хөршийндөө
Хорхойсож шатар тоглож байгаад
Арван завхай мөнгөн эмээл хазаартай
Айлын гаднаас борлог морио алдав.
Аймгийн сэргийлэхийн дарга
Ахмад Чулуунд өргөдөл өгөв гэтэл
Дэргэдэх өрөөнд суудаг
Дэслэгч Чулууны нутгын ах
Үлхий Лувсан гэдэг хулгайч
Үнэнээ хүлээж баригдсан ч
Нутгархаж удаашруулж байгаад
Нууцлан дараад өнгөрөвөө хөөрхий
Он жил улиран одож
Отгон хүү маань төрлөө
Баатар минжүүр санал гаргаж
Баян-уул сумыг тарааж
Батцэнгэлд суманд орлоо бид
Хоршоонд хамт жин тээж танилцсан
Хүрээнд цуг сууж байсан гээд
Батцэнгэл суманд танил олонтой тул
Би ч хэзээний хуучин хүн байв
Бөхийн барилдаан болохоор
Баян-Уулын баахан Самбуу нарыг
Байгаа хүмүүсэд таниулана.
Норовсамбуу, Борсамбуу, Томсамбуу, Дэнхэрсамбуу
Дэвэн дэвсээр гарч ирээд

Дээгүүр барилддаг бөхчүүд байв
Хүрээнийхээ хэдийг сэм авчраад
Хааяа хааяа хурал хурдаг байв.
Дэндгэр Сэнгэ гэлэнхай
Гялаан Дамбийхай гээд
Манайхаар байнга ирдэг
Номтой харчуул олон байв
Дамдин бишрэлт:
Аав Сингэхай хоёр гэртээ
Айраг ууж сууж байтал
Ганган морь тэрэг бараа болоочтой хөсөг
Гадаа нь ирээд зогсов гэнэ
Сингэхай аавд сайн айрагаа нуу
Шүүргий айргаа эдэнд өг гэв
Тэгж суутал ганган хувцастай
Том өндөр нуруу, шар царайтай
Махлагдуу биетэй нэгэн эр ороод ирэв
Мэнд амраа мэдэлцээд суув
Айраг аяглаад баритал
Алгадаад асгачихлаа хойморт нь
Толгойдоо юмгүй танхай этгээд гэж
Тэндээс Сингэхайг давшлахад
Танихгүй хүнд саам өгч
Танигдагтаа айраг өг гэж
Таны наад дэлгээтэй, номонд чинь байнуу
Танай нутгын ёс энэ үү гэж
Толгой түрүүгүй айрагны бүлүүрээр
Тэндэх хүмүүсийг нүдэж гарав.
Харамын сэтгэлээр зул өргөснөөс
Хол хаясан нь дээр гээд зулнуудыг унагав

Зул унасан ч жаргалгүй ассаар
Цохисон газар нь ямарч соривгүй байв

Ээжийг гүү саахаар гарахад
Ээ чи сүүгээ асгав гэхэд итгэж ядаж байтал
Эрэвгэр халиунд тангаруулж
Хувинтай сүүгээ асгаж
Хуруу гараа бас гэмтээв
Ээж гэртээ ирээд аавд
Энэ хүн энгүй хүн болохыг хэлэв
Энэ дэх уур амьсгал намжаж
Эхнээсээ манайхан шавь орж эхлэв
Гялаан Дамбийг олж ир гэсэнд
Гаднаас хүн явуулж авчрав
Дамбийхай ирээд уучлалт гуйж
Дамдин бишрэлт болохыг бидэнд хэлэв
Догшин дүрт хувилгааныг харж сэтгэлд минь сүжиг төрөв
Нэг их удалгүй байж байтал
Нэгдлээс зарлан дуудах ирэв
Гэр бүлийнхэн маань айж
Гяндан шоронд хийчихгүй байгаа гэж бодож
Зам зуураас сураг сонсвол
Зуу ламын хурал хийхээр
Гэгээрлийн хэлтэсийн Равдан
Гэгээрүүлхээр сар ухуулганд суулгав
Гэдсээ чирсэн гэлэнгүүд
Гэнэн нөхдийг мунхруулагчид
Айл хотоор айрагдаж явдаг
Ажлын садаа хөгжлийн уяа гэсэнд
Лам байсан хэдэн өвгөчүүл

Лхамсүрэн Галсанпунцаг, Чойдор, Сэнгэ
Дэчин, Ядамсүрэн, Гочоо, Пэрлийжамц
Доржжанцан, Базаржав, Ламжав гэх тэргүүт
Зуугаад өвгөчүүл зусах шахав суманд
Уйдсандаа тэд айрагны мухлагт очиж
Улаан мөнгөгүй тэд Базаррагчаагаас зээл ууж
Хөөргөө хүртэл барьцаанд тавьж
Хөглөж байснаа ярьдагсан
Цаашдаа маргаан ихдэх үеээр
Цагаан хөндийд албадан хадланд гаргав
Хадлан дээр Сингэхай
Хэдэн биендээ хоч өгөв
Жамбанд цохидог Жамъяангоо
Жажлуулж цохидог Ядамсүрэн
Сөөгдөж цохидог Сонжоохой
Садаг балдаг Сандаг гуай гэхэд нь
Харин та өөртөө нэр гэхээр нь
Хар тавхайгаар нь эргүүлдэг
Халзан Сингэ гэж хөгжөөдөг байв
Хэд хоноод биднийг ашгүй гэрт хариулав
Аавын эгч Сономжидийн хүү
Адъяасүрэн санхүүгийн сургууль төгсөж
Аймагт нягтлан хийж байгаад
Ажлаа буруу бодож шоронд оров.
Аль муу бүгдэд явдгаараа аав минь
Аймагаас хот руу хотоос хонхорт очиж
Адъяасүрэн ахыг эргэсэн гэдэг
Ааруул идээ мөнгө дээлээ ч тайлж өгөөд
Хот руу явган явж байтал
Хоосон шахуу том машинд гар өргөтөл

Түр зогсоор нь цонхоор нь хартал
Том шар орос жолооч байв гэнэ
Орос сургагчтай байсных гээд
Ойлголцох гэтэл пять гэх шиг болов
Тэгэхээр нь кабинд орж суув
Түжигнэж давхисаар хот оров
Түрүүвчнээсээ таван төгрөг авч өгөөд буутал
Түрүүлж буугаад бариад авав намайг
Түрийвчийг минь надаас булаагаад
Дөчин таван төгрөг аваад
Түй чорт гээд бусдыг нь шидчихэв
Уг нь надад Сорок пять гэснийг нь
Ухаарч ойлгохгүй пять гээд бодсон хэрэг
Энэ мэт хөгтэй үйл хөвөрсөөр
Эгэл миний нас жар хүрвээ
Хүргэн хүү Жамц, Хандсүрэн хоёр
Хот хүрээ рүү шилжиж
Олныг дагуулан сургуульд
Отгон хүүгээ эгчтэй нь хараатын хөтөл хүртэл үдэж билээ
Идэр гурван ес эхлэх хүйтнээр
Идшийг минь аваачиж өгөхөөр
Зам зуурын машин тосож
Зөндөө л их явсан даа аав минь
Ахыг минь жолооч болгох гэж
Аль байдгаа л барьж гүйдэгсэн
Металлистийн тмсийг бараг хамт төгсөж
Механик жолооч болгосондоо муу аав ээж хоёр минь
Дараа нь цэрэгт жолоочоор оруулж
Даргын тэрэг их барьсан
Хурандаа нарын тэрэг барих

Хоолонд нь хүргэж өгсөндөө муу аав ээж хоёр минь ахыг
Айл айлын хашаа дамжиж
Сургууль сургуульд шилжин байж
Арвангуравдугаар сургуульд аравдугаар ангиа
төгсөвөө би

Хичээлээ үзэж конкурсэндээ бэлтгэх зуураа
Хиам ихээр идэж байгаад
Хордлогонд орж мухар олгойдож
Конкурсэнд орж чадалгүй азгүйтлээ
Дээрхийн гэгээнтэн Далай ламын
Дээдлэн захисан 1000-ны сургаалд
Хийж бүтээх юм нь бүтэлгүйтэх нь
Хааяа маш их аз авчирдаг гэдэг шиг
Аавынхаа захиснаар явж
Арван буяны мөр хөөн
Арван наймтай Гандан хийдэд орсныгоо
Аз хишиг аав ээжийн ач гэж боддог
Дээд гурван эгч маань гэр бүлтэй болж
Дор дороо боловсрол эзэмшиж
Гарын таван хуруу шиг 5 хүүхдээ
Гарыг нь ганзаганд хүргэсэн ачтан та хоёр
Эмэгтэй гурав нь ээжийн сургаалиар
Эвлүүлж оёх бүх үйл үртэс
Эх хүн болох нандин увидас
Эдгээр бүгдийг уламжлан авчээ
Аав ээжий хоёр минь тэтгэвэрт гарч
Албаны мал хариулахаа больж
Нутгын захиргаанаас зам явах авч
Нүүдлийн шувуу шиг зам даган
Таньдаг Жүгдэрнамжалаар зөөлгөнө

Төрөл Даян, Норовсанбуу нарт дайгдана.
Танихгүйд ч өчнөөн гар өргөн сууна
Тамаан цайж хот ордогсон
Ууртай нэгийг нь аргадаж
Ухаангүй тэнэгт нь доромжлуулан
Агсан тавьсаныг нь тэвчин
Ая эвийг нь олж хот ордогсон
Хорин хоёрын товчоонд мөнгө өгөхгүй гэж
Хойгуур урдуур нь шөнө явган алхана

Угтаад авах хүн хотод үгүй болохоор
Уут ууттай идэш хүнсээ чирсээр
Айл айлын хашааны нохой хуцуулсаар
Аанайхан шөнө ирдэгсэн бидэндээ
Жаран нас хүрсэн аав минь
Жавар сөрөн тэнхээ зааж
Үстэй азарган нэхий дээлтэй
Үнэгэн малгай цантуулсаар
Алагхан хэдэн дэгдээхэйн төлөө
Амиа цөлөн дайрах шувуу шиг
Алс хотод суух бидэндээ өл залгуулхаар
Алжаал зүдрэлийг мартан ирдэгсэн
Бага наснаасаа эхлэн аав минь
Багшийг шүтэх ёсыг дээдлэн
Өөрийн хэдэн багшаан хаялгүй асарч
Өөрийн гар дээр бурхан болгосон гавьяатан
Ах лам гэлхай, аваг Бандихай
Арын багш, Дүйнхорын лам зэрэг багш
Дамбийхай, Сингэхай гэх лам өвгөчүүл
Дандаа л манайхаар байдаг хэдэн найз нар нь байв.

Хоёр хувилгаан, хорин гавжтай
Хайрхан суманд залрах
Хувилгаан Пүрэвжав багшдаа
Хангай ах, Бавуудай хоёрыг дагуулж
Хавар намартаа тогтмол очдог ба
Хотод байдаг зиндааны хэдэн өвгөчүүлийг
Хонон өнжин цуглуулж гүнцэг өргөж
Жил болгон тогтмолжуулан залж
Жиндаг болон хурал хуруулдагсан.
Бид хэдийн сарын зэд цалинг
Бага багаар нь хурааж байгаад
Хаврын дүйнхорын хурал хуруулж
Хамтдаа биднээр буян хийлгэж
Наандаж нас буян арвидана
Цаандаж шамбалд олбог тавина гэж
Холыг харж биднийг буянд дагуулан
Хоёргүй сэтгэлээр сүсэглэдэгсэн аав минь
Нэгэн удаа хүргэн ах дэвшихээр
Нэртэй том дарга гэртээ дайлав.
Хар тэрэг тоос татуулан ирж
Хашааны үүдэнд зогсон
Хаалга нь онгойж дарга гарч
Хажуугаар нь манайхан гүйлдэнэ
Зангиа зүүсэн том дарга
Зандрангуй харцаар эхэмсэг тухлана
Эгч маань хоол цайгаар дайлна
Ээж маань тос хайлж барив
Хаалга нээлттэй гэрийн үүдээр
Хааяа би даргийг харж гүйнэ

Ийм том дарга болохсон гэж
Инүүгээр түүгээр машиныг нь сонирхоно.
Тэгж байтал том дарга морь харангаа.
Тээр хойно байгаа жижиг гэр харж
Ахаас хэнийхийг асуухаар нь
Ах аавынх гэсэнд орж золгов
Жижигхэн дөрвөн ханатад
Жихүүдүү амьдардаг байв бид хэд
Дээшээ гэж хүндлэн даргыг залав
Дээж идээ цай цүү барив
Дарга аавтай хэсэг хуучлав
Дараа нь зулнаас болж маргалдав.
Бамбарлан асах олон зулыг харж
Баахан гайхаж дарга асуув
Хоцрогдсон шүтлэгийн төлөө
Хайран шар тос үрлээ гэхэд
Гэнэтхэн аавын гэд нь хөтөлж
Гуйж аваагүй чамаас илүү үгт минь
Таван малынхаа буянаар
Тос өргөж байна бурхандаа гэхэд
Чинирч нүүр нь улайгаад
Чичигнэж бие нь салаглав.
Ухар мөчид өвгөнд дийлдэхгүй гэж
Ухаанаа сийлж зангиагаа суллав
Марксизм Ленинизм мандаж байхад
Мухар сүсгээсээ салж чадахгүй тэнэг
Зөвлөлийн засагт холбоот улс
Зөвхөн бид нарын ах хань нөхөр
Хувьсгалын замаар бид хөгжиж
Хуурай газрын тавны нэгийг бүрхсэн

Хуучин сурталт муу лам нар
Хөгжлийг хойш татаж байна гэхээр нь аав
Мөнх юм гэж байдаггүй болохоор
Мөхөх цаг ирэх л байх гэхэд
Шуудхан гарч машиндаа сууж
Шороо татуулсаар давхин одов
Ээж минь аавыг зөнөснөөр нь дуудав
Эгч ах нар шоронд орохоор айлгав.
Гэмээ мэдсэн хүүхэд шиг
Гэрт ганцаар дүмбийх аавыгаа хараад
Хоёр нүднээс минь нулимс гарч
Хичнээн ихээр өрөвдөж билээ
Хэд хоног манайхан дүнсгэрдүү
Хэн хүнээс илүү ээж минь санаа зовсоор
Арваад хоногийн дараа бидэнд
Ах маань дарга болсноо хэлж
Баяр хөөрөөр дүүрэн болж
Байдал хэвийн боловоо
Хувьсгалч даргатай муудалцсан биш
Хүргэн ах маань дарга болвоо
Хичээл тарахыг минь хүлээж байгаад
Хөдөө нутагтаа очдогсон аав ээж хоёр минь
Эзгүй шахуу бригад дээр хураасан гэрээ барьж
Энд тэнд айлд тавьсан малаа цуглуулж
Эцэж турсан адуу малаа хараад
Элэг нь эмтэрдэгсэн аав минь
Эх болсон хужиртдаа ирж
Ээжий аавын минь сэтгэл сэргэдэгсэн
Хэдхэн хоногийн дотор
Хувин хувингаар сааль хурааж

Идээ цагаагаар элбэг дэлбэг
Ирэх зочиноор тасардаггүйсэн
Ээжийн дүү Жалцан ах
Элгэн садан найз багш нартайгаа
Зил 130 машины тэвш дүүрэн хүнтэй
Зун болгон ирж зусдагсан
Эдгээр зочдын хоол ундыг зайгүй хийж
Эцэж унаталаа л гүйдэгсэн ээж минь
Ахыг жолооч болгож өгөхийг гуйж
Аргаданхан байдагсан аав минь
Заримдаа би унтах газаргүй
Цунзаатай тэргэн дээр чиг л
Зулаад газар чиг л унтдагсан
Төлгөн хонь гаргахад гурав хонохгүй
Дөчийн бетон боорцог хийхэд
Дөнгөж хоёрхон хонодог тул
Дэлгүүр хоршоонд гурилын ацаг тавьдагсан
Тэгээд бас хажуугаар нь
Тарвага алж боодоглон аавыг байж ядуулна
Тогоо нэрүүлж архи уугаад
Томчуул нь хэрэлдэж ээжийг зовооно
Улаан хуйхуу шиг нөхдүүд ирээд
Удаан байхыг нь яана даа
Тавин толгой малын нь
Талыг нь идээд л явдагсандаа гэвч
Маань шиг үржин мал нь өсөж
Манийн үед дамжигдаж ирсэн
Буянт дээдсийн минь буян хишиг
Булаг шиг ундарсаар ирсэн билээ
Цэвүүн цагийн жавар эцсэлж

Цагаан морин жилийн ардчилал үрслэв
Далан жил хаагдсан бөглөөг
Даанч түргэн онгойлгосноор
Хөөргөн залуус дээр нь гарч хөвөн
Хөгшид дээдэс доор орж хутгалдав
Зөвийг нь түүгээд авч ч болохгүй
Зөрүүг нь буцаагаад орхиж ч болохгүй
Олуулаа хэлцвэл буруугүй гэж сонгосон
Олигаархи маягийн 76 мангас
Монголчууд хэтийдсэн муугаа
Мангасаар зүйрлэн хэлж
Арван таван толгойтой
Атигар хар мангас гэдэг бол
Манай төр толгой нь данхайж
Мэргэн үгээр мэхлэхдээ уургын морь
Ажил хийдэг бие ганц
Ахиж явахдаа яст мэлхий гэж
Хүмүүс үглэн муулахад
Харин аав минь баяраар угтсан
Өлсгөлөн зарласан залуусыг дэмжиж
Өвөг Ренбучи Пакула багшийг
Өөрөө талбай дээр очиж
Өөдрөг үйлийг адисласанд
Жинхэнэ хуврага гэлэн хүн юм
Жинхэнэ бодьсадба хүн юм гэж
Шавдуулан намайг дагуулан
Шавь орж шарга морь өргөв

Ардчилалын ажил үйлийг
Аав минь баяртай угтаж

Ажил үйл ярьж эхэлсэн юм
Хуучин сүмээ сэргээе гэж
Хэсэг нөхөдтэйгээ хамтран
Заяынхаа хүрээг нээж
Заяа тавилангаараа эргэн лам хувцсаа өмсөв
Унзад болж удаагүй байтал намайг
Урагшаа Энэтхэгт сурахыг тулгасаар
Далай багшийн намжираа дацанд
Дарамсалаад очихоор явбаа
Тэнд гурван жил сурч байтал
Тэр нэгэн шөнө аав минь
Хүү минь үүдээ гэх аавын дуу гарахад
Хааяа гэрээ санаад зүүдэлж байна гэж бодтол
Хажууд нь түвд хүн дуугарав
Хаалга онгойлгож босож харвал
Монгол дээл, гутал, шовгортой
Миний аав богцоо мөрөлсөөр зогсож байв.
Жар гарсан настай өвгөн
Жагарын халуун оронд
Хүүгээ гэсэн чин бодлоор
Хүрээд ирсэн юм аав минь наддаа
Би бөөн баяр хөөр болж
Багш, гэсгүй нараасаа зөвшөөрөл авч
Бөгс эргэх зай байхгүй ч өрөөндөө
Байрлуулж ор засаж өгөв аавдаа
Олон лам нарын ном хурах чимээ
Орой өглөө лам нарын цайны дохио
Энгийн олноос тусгай байдал
Эмх журамтай гэсгүй авир зэрэг
Хуучин заяын хүрээний байдал

Хичнээн их адилхан байгааг хэлдэгсэн
Аав минь надтай сар шахуу болж
Аргагүй виз нь дуусаж буцах дөхлөө
Дээрхийн гэгээн Далай багшдаа
Дэлгэрэнгүй бараалхал соёрхов
Зая гэгээнтний дүр тодруулах
Захиа бичгийг гардуулав
Аймгийн хийд, болон даргын бичиг
Ард олны хүслийг дамжуулав
Заавал тодруулж өгнө гэсэн
Зарлигийг нь сонсоод баярлаж билээ
Аавыг гаргаж Дели орохдоо
Адистэдтэй Дорждан бодьгаяа
Ражгари, ганга, гүши нагар гэх
Бурхан багшийн ном айлдсан
Бүхий л газарт очиж мөргөв
Бихарын гуйлагчингуудад мөнгө өгч
Бурханыг хүндлээгүйн үйлийн үр гэдэгсэн
Бараан царайтай Энэтхэгчүүдийг
Бие хаа гар гэж үдээрээ үдээр гэж
Биднийгээ бас инээлгэж явдагсан
Онгоцны буудал дээр гаргаж өгөх гэж
Олон юмандаа түүртэж явахад минь
Аав нь авьяа даа гэж хэлээд
Ачаа тээшээ хөнгөхөн аваад ордогсон
Жаран дөрвөн настай өвгөн аав минь
Жагар Энэтхэгийн оронд мөргөвөө
Хоёр жилийн дараа Монголд Далай багш
Ховор номын авшиг дүйнхорын ван айлдахад
Аав минь өглөгийн эзэн болж

Айраг идээгээ барьж хоёрдохоо золгов
Замбуулингийн таван дагшин оронд
Залбирч мөргөхөөр Энэтхэгт очин
Дараа нь хүүхдүүдээ дагуулж
Дайдү хот Бээжингээр дамжиж
Утайн таван үзүүрт ууланд
Утлаг уйгуулж хадаг өргөн мөргөөд
Богд ламын мэндэлсэн Гүмбүнд
Буцахдаа саатан хурал хуруулав
Тансан лам баруунд зорчсон шиг
Төрөл садан, хүүхдүүдээ дагуулан
Завгүй гээд буянаас ухрах нөхдийг
Заавал яв гэж биеээр эргэл мөргөл хийлгэн
Буян гэдэг амар бус гэдгийг
Биеээр мэдрүүлж явжээ аав минь
Тэвэр тохой өндөр Бурхан багш
Том ганжар бодь гөрөөс хоролын хамт
Ганжуурын 108 боть ёнзог бүрэн
Гадуур нь торгон баринтаг донтортой нь
Аймгийнхаа хийдэд зориулан
Ах дүү нар ам бүлээрээ нийлэн
Хойшдоо баригдах шинэ хийдэд
Хандив өргөл болгон барьж билээ
Манайханы удам 6-7 үеээрээ
Маань унших хуврагаар тасраагүй
Урагшаа Лхасад ном үзэн гэгээрч
Урьд дүрийн Заяын гэгээдийн
Бараа болооч сойвон гонироос эхлэн
Багш ёнзон нь хүртэл байсан юм гээд
Түвдийн Лхасад мөргөх санал тавьж

Танил хүмүүсээр дамжуулан сургалж
Бэлтгэлээ сайтар базаагаад
Бид хоёр лхасад мөргөж билээ
Сэнбэрээ гэсүмд хурал хуруулж
Сэнгээ гэвшийн хамцанд очиж
Сонин гойд түүхийг нь сонсон
Сэтгэл юугаа сэргээж явлаа
Зову бурханд дээж тавин
Зулын шар тосоор хандив өргөв
Өндөр газарт миний бие муудахад
Өвгөн аав минь намайг асарч тойгдон
Хэлгүй мөртлөө гадагш гарч
Хаанаас л юм бүү мэд мах авчирч
Хөтөч болон дагуулж яваа намайг
Хар шөл эмтэй уулгаж анагаа
Гадна байгаа эрээн бараан хүмүүсийг харж
Гахайн жаргал тохойдоо гэгчээр
Гайгүй жаргалтай харагдана
Гончигсүмийг шүтсэний буян гэдэгсэн
Бид хоёр лхасад хэд хоноод
Бээжингээр дамжин буцаваа
Хүрээ хийддээ хоёр бишгүүр
Хүүхнүүддээ үйтэн хуар торго
Хүүхдүүддээ цөмд нь бэлэгтэй ирлээ
Хаа явсан ч ингэж сурагсан даа
Хотоос хөдөөлөхдөө ч гэсэн
Хөдөөнийхөндөө бэлэг ганзагтай
Хүрээнийхэндээ зэдтэй очдогсон
Аав минь алсад явсан хүн бүрийг
Аяыг нь тааруулаж эргэдэгсэн

Цэцэрлэгт орсон хүүхдийг шагнадаг
Цэрэгт явсан хүн бүрийг эргэдэг
Энэтхэгт сурсан намайг
Эрхүүд сурсан Дагийг хүртэл
Боломж бололцоо бүрээрээ
Болвол эргэхийг боддогсон
Эрт багадаа хүрээнд сууж
Элэгээ бэтгэртэл гэрээ санаж
Ааваас эрт салж өнчирсөндөө ч тэрээ
Ах дүү нартаа амин хайртай нэгэн байлаа
Дөрвөн дүү нь том ах гэж хүндэлдэг
Дөрвүүлээ хань гэр бүлтэй ч гэсэн
Амьдралын нарийн ширийн зүүлээ
Ахтайгаа л зөвхөн ярьдагсан
Ааруул тосны сайн мууг
Айраг цагааныхаа эссэн эсэхийг
Ахаараа шалгуулж сэтгэл амардаг
Аашилж загнах тохиолдол бүрт
Аядуу хүлээцтэй хандаж сурсан
Аав ээжийг нь орлох амин ах нь аав байлаа
Нүүж суухаа ч гэсэн
Нүүдэл бэлчээрээ ч гэсэн
Амь амьдралын бүхий л зүйлээ
Ахдаан даатган сүжгэлдэг байв
Аавын маань ганц төрсөн дүү
Амаг хэмээх Цэрэнжаргал
Гэрээрээ дүүрэн үр ачаа тойруулж
Гэдгэр жорх, царай гэж хочлон
Инээд онигоогоор дүүрэн
Иймэрхүү нэгэн өвгөн байв

Ууцны голоо ааруултай боож
Улаан амгын арслан гэх боовтой
Сар шинийн үүц болгож
Жил болгоон илгээдэгсэн
Амаг : ар дагзандаа хонхор сорвитой л доо
Амгаа та яагаад ийм боловоо гэхэд
Японы самуураатай барцалдаад
Явруулчихсан юм винтовний бөгсөөр гэж инээлгэдэгсэн
Ааваас сүүлд учирьг нь асуухад
Адуунд өшиглүүчихсэн юм байна лээ дээ
Нүүж суугаад амаг гэртээ ороод
Нүүрийг нь тавиад бандан засаагүй оронд сууж
Хойшоо гэдэргээ тас саваад
Хоёр хөл нь дээш гозойгоод
Хананд толгой нь таарчихаад байтал
Хүүхэн нь гаднаас шагайж хараад
Хөлөө сэврээж байгаа юмуу ааваа гэсэн гэдэг
Нэг их цас унасан хүйтэн намар
Нилээд шөнө манайхыг андуурч
Хаалгаар согтуу ороод иртэл
Хай муу золиг яаж яваан гэх
Аавын дууг сонсмогцоо айгаад
Алга болоод олдодгүй
Хөлдөж үхнэ гэж шөнөжин эрээд олсонгүй
Харин өглөө болгоод хартал
Тугалын хашаанд шавхайн дээр
Тухлаад унтаж байсан гэдэг
Үнэхээр эрүүл, согтуу алиндаа ч
Үнэнч журмаар ахыгаа хүндэлдэг
Тэр журмаа насан эцэслтэлээ

Тавилгүй өнгөрсөн дүү нь байжээ
Нутагтаа миний аав минь
Наадам болгоны индэрт ерөөл хэлж
Нас насны морины цол дууддаг
Найр болгоны хойморт байж
Нээлт магнай дууг дуулдаг
Тод авьяасыг нь төр үнэлээгүй ч
Түмэндээ танигдсан сод хүн байжээ
Төлөг тавиулахаар ирэх хүн олон
Төрийн томчуулч бас цөөнгүй
Хот хөдөөнөөс гэр дүүрэн хүнтэй
Хоног өдрийг өнгөрөөдөгсөн
Шашны дээдийн манай зиндааны бурядуудыг
Шалгаж аав минь их тоглодогсон
Түрүүчээр манайд ирэхэд нь
Тонилгох ном үзэж байна уу?
Тонож идэх ном үзэж байна уу? гэхэд
Тонилгах гэдэг нь гүрэм засал
Тонож идэх гэдэг нь эм зурхайг хэлсэн
Ягт нэр байсан л даа
Баахан бодож байснаа тэд
Бавуу лам алийг нь ч үзээгүй гэхэд
Булат би ойлгоогүй гэж дүйвүүлэв
Балдан би мэдэхгүй байна гэхэд
Багш нар заана би сурна гэж
Бандид хамба маань хариулж
Аавд минь их таалагдаж
Айхтар содон буряд гэж билээ
Хожим Дамба хамба болоод
Хойшоо бурядад ирэхийг урьж

Урилга ёсоор аав бид хэд
Улан-Үде хотод зочлон очиж
Иволгийн дацанд хүндэт зочин болж
Их байгаль далайд дүлцэн өргөж
Зандан зууд очиж мөргөж
Замаараа олон дацанд очсон
Умраас умарт гэх Бурханы лүндэнчилэн
Улан-Үде бурядаар шашин дэлгэрч гэж
Аав минь сэтгэл хангалуун
Алтанбулаг нутаг уруугаа ирж билээ
Наян тавны нь ой нижгэр олон хүнтэй
Нутагтаа том найр хийж билээ
Зургаан насны морь уралдаж
Зуугаад бөхчүүл зодоглон барилдав
Түрүү морь бөхчүүлдээ
Таван ханатай гэрээр байлав
Төмөр очир дарга тэргүүтэй
Төрийн томчуул хүндэт медалиар шагнав

Бас аймаг хотын лам нар
Бат оршил мандал өргөв
Хот хөдөөнөөс олон гийчид ирж
Хоёр гурав хоног найрлав
Хол ойроос дуучид ирж
Хүндэтгэлийн аялгуу олныг өргөв
Аав маань Жамбацэрэн гэгээнтнийг
Арал толгойд морилон саатаж
Хүрээлэн буй хайрхан уулаа
Хүндэлэн тахисан түүхийг ярьж
Уртаас урт том гаансыг

Улаан өнгөтэй авдраас гаргаж
Тамхи шившэж байсныг
Тодхон санагдсанаа хэлэв
Энэхүү түүхэн дурсгалт газар
Эвийн суврага барихаар болж
Хот газраас урчуул авчирч
Ховор нандин шүншиг хийж
Хориод хоногийн дотор
Хийж бүтээж дүүргээд

Сая тодорсон Гэгээнээ залж
Сайтар тахилга равнай уншиж
Бэсрэг наадам зохиож
Бөх барилдаж, морь уралдав
Жил болгон аав минь мухар хужиртын рашаанд
Жижигхэн хүүхдүүдээ дагуулсаар очиж
Рашаан ууж амрахдаа биш
Адистэд жинлав хүртэхээр ирдэгсэн
Гавж Уртаатай удаан ярилцан
Гэргэн ламхайн үр ач болон
Зодвоо Цогоо гэх шавь нартайгаа
Зөвлөлдөн байж тэнд суврага бүтээв
Жинхэнэ ёсоор нь шүншиглэж
Жүнш гуай гаар урлуулсан энд ирэхдээ
Гэгээний мэндэлсэн рашаан уулгаж
Гэрийн буйрны шороог сахиуслан залдаг байв.
Зая Лувсанпэрэнлай гэгээнтний
Захиж өвлүүлсэн гурван адис нь
Суврага хайрханы арцаар утаарай
Сэжиг бузар бүгд ариусна

Гэрийн буйрны шороог минь зүүж яв
Гэг дотгор халдах учиргүй
Хүй угаасан рашаанд минь орж бай
Хат суулган бие эрүүлжих увидастай
Төрөл ойрхойн байя гэвэл та нар надтай
Түнрэв солдивийг минь унш гэж
Цэвүүн цагийн өөрийн шавь нартаа
Цонхны нар шиг үлдэх аргийг нь
Хэн хүнгүй дээдэлж явбал
Хэрэг зорилго бүтнэ гэдэгсэн аав минь
Бас нэгэн түүхийг дэлгэн
Бидэнд ингэж өгүүлэвээ:
Энгэрийн хуш модон олонч
Эн тэнцүү ургадаггүй шиг
Ээжий аавын хүүхдүүд
Элдэв янзын араншинтай
Заяын шавийн Зэхэр бөндгөр гэж
Зантай хулгайч сайн эр байжээ
Сайн эрчүүлээс илүү болох гэж
Санаа элдэвийг сэдэн байж

Даян дээрхийн бөөгийн онгон хүлэг хулгайлж
Даяр алдраа дурсгах санаа өвөрлөн
Бүтэн жил шахуу байх газар
Байдал авирийг сайн судалж
Өвөл цас зузаан орж
Өл хоол муудах цагаар нь
Өвс цуван тавьж хашаанд оруулаад
Өврөөсөө бугуйл гарган урхидаж

Исгэлэн эмнэг дээр нь
Ид шидтэй онгон хүлгийг
Чихдэж дарж хазаарлаад
Цоров хийгээд зайдан морьдсонд
Чарлан шээс алдан булигаад
Цасыг хашаанаас малтаад гаргасан мэт болгов гэнэ
Удсан ч үгүй хүмүүс ирэхээр нь
Унасан мориныхоо хүзүүнээс уяаад
Хар хурдаараа давхисаар
Харанхуй шөнө ойд орж унтав гэнэ
Гэтэл их зайрангууд уурлан
Гэнэт тэнгэрээс заль буулгасанд

Багш минь гэгээн минь гэж залбирсанд
Баруун чихийг нь шүргээд унажээ
Гэгээнтний шороог биедээ авч явснаас
Гэнэтийн аюулаас нэг аврагдсан ч
Арьс махны нь завсраар бөөгийн ховдол гүйж
Амь тавин өвтгөсөөр
Арай ядан нутгын зах орон
Ахан дүүсээ дуудаж гэртээ харьжээ
Ах гэлхайгаар гүрэм засал
Амин золиг гарган байж
Маарамба Даваагаар түрэм хийлгэж
Мах арьсны завсраас ховдолыг авч
Аяганд хийгээд тавьж харахад
Арзганаад хөдөлж байсан гэдэг
Харсан хүмүүс ам дамжуулан ярьж
Харин би ээжийгээсээ сонссон
Эмээгийн талыг дурсваасуу:

Мунижав өвөгийн ах лам
Маам гялхай гэдэг байжээ
Бага наснаасаа хүрээнд сууж
Багагүй эрдэм номтой болов.
Баруушаа ламын гэгээний хийдээс
Багадаа ирсэн үнэнч шавь нь
Багштайгаа нутагтаа очихыг
Байн байн гуйсаар явсан гэдэг
Тэнд хориод жил ном зааж
Тэнгэр бурхны авралаар хамба болов
Овоо ч хэдэн мал хөрөнгөтэй
Олны танил нэгэн болжээ
Санамсаргүй хөдөө явж байгаад
Саахлан буусан айлд орвол
Хижээлдүү насны аав ээж хоёр
Хэрэг шүүж, бэрээ хөөж байгаа болтой
Хүүхэн тайван уужуу зангаар
Хадам ээжий аавдаа хандан
Үхэх хүний үгийг сонс
Гаргах малын хишгийг ав гэж
Ардын ёсонд байдаг билээ
Ая дуграагаа өргөөд явъя даа гээд
Урт сайхан хүрэн
Уужим холоос гүйдэлтэй гэж

Уянгалуулан шуранхайлах дуунд
Уярсан хоёр аав ээж нь
Уйлан байж бэрээ хөөхөө болив гэнэ
Энэхүү үйлийг харсан хамбын
Элэг зүрх нь энэрэлээр шаналан

Нүүрэндээ үстэй урт сайхан хүрэн гүйгээд ирж байхад
Нэртэй зүстэй хүний үр яагаад
Нутаг ус элгэн саднаа бодохгүй гэж гээд
Ажлаа жам ёсоор нь өгөөд
Арван цагаан тэмээ хөсөгтэй
Азарга азаргаар адуу мал
Албат иргэд шавь нартайгаа
Төрсөн нутагтаа сар явж очин
Төмөртийн шил дээр үдлэн
Даагын талаар дамжин
Дөрөлжин дээр гарч ирээд
Аргал түүж буй охиноос
Айл асууя гэж дуудаад
Аргатай аргалаас нь авч өвөрлөөд
Мунижавынх хаана вэ гэхэд
Манайх гээд аавын ээж дагуулж ирсэн гэдэг
Олон жил уулзаагүй ах дүүс
Оргилуун баяр хөөрөөр уулзав
Хөсөг малаа төвхнүүлэж
Хэдэн өдөр хууч дэлгэв
Анхдугаар Зая гэгээний үеээс манай хан
Арваад гавж эрдэмтэй лам нар
Түүний дотроос дөрвөн лам нь
Түвд явж эрдэм сурсан гэдэг
Хамгийн олон жил ном үзсэн нь
Хясааны урьд талын ламхай мэндэлдэгт мэндэлсэн
Лхасад 13 жил ном үзэн
Лхаарамбын мяндаг авсан
Зая Лувсанжигмид дорж гэгээний багш
Зурхайч Цэвээн ламхайгаас та долоон жил илүү

Хол газар харьд байж хатуужиж
Хамгийн анхны хамба цолтон болж
Хамаатан ураг садан бидний
Хийморийг сэргээсэн гэж
Ам амандаа сайшаан магтаж
Арав тав хоног болоход
Ах лам нь авчирсан мал хөрөнгөө
Ах дүүдээ тараасан гэдэг
Түүнээс хойш манайхан
Төл мал арвинтай ламын гэгээний угшалтай болж
Хамбыг дагаж ирсэн албатаар
Хонь малаа харуулж туслуулдаг
Хэд хэдэн хамжлагтай байсан гэдэг
Энэхүү түүх намтарыг бидэндээ ярьж
Элгэн садандаа тустай явахыг захиж
Сал эвдэрвэл далайн ерөөл
Тал эвдэрвэл тамын ерөөл
Ах дүү нартай эвтэй явж
Ариун бурхдад сүсэгтэй бай.
Дүйнхорын шашин дэлгэрнэ
Дүйнхорын хуралыг бүү тасал
Хоолоо дуран дээр нь болж сур
Хөгшрөх тутам хүнс аягаа багасаг
Аавынхаа нэг муу үйлийг заавал хорьж бай
Арав таван малаа бүү тасал гэж
Захиасаа бүгдийг хэлээд
Замбуулинг орхисондоо аав минь.
Бид боломжоороо буян хийж
Буман маань хэвлэн тараан уншуулаж
Гэртээ Лхагвасүрэн унзад тэргүүтэй лам нар залж

Гүнрэг бурханы чого дэлгэр уншуулав
Хойд мөрийг нь Далай багш, Богдод айлтгуулав
Хөсөг жуузанд хүндлэн залж
Баруун түрүүний зүүн хунхад
Бэлтгэлээ сайтар базаан
Намжираа дацангийн Жамц багшаараа ламтуулан
Нийт гучаад лам нар цугларан гал мандал өргөн
Бурханч лам Пүрэвбатаар чобонботуулан
Бүгд дор бүрнээ маань хөгжөөн уншиж
Үнс чандрууг нь бумбанд түүн авч сувраглан
Үлдсэн хэсгийг нь нутагтана залж билээ


Дараа нь бид бодь суварга бүтээн
Дансүрэн толгойд залан байрлуулав
Хавар цаг хүйтэн байсан боловч
Харин биднийг очиход дулаарсаныг
Хайрхан уулс төгрсөн нутаг нь
Хайрт аавыг минь хүлээж авсан шинж гэж ойлгодог
Хожим нь миний зүүдэнд ирж
Хонон өнжин хөөрөлдсөнийг
Маргааш өглөө нь би босож буян хийж
Маань ерөөл ганданд айлтгуулав
Тэр өдөртөө шүлгийн үг сэтгэлд орж
Тэгсгээд ая олж дуу хийснийгээ толилуулъя
Гүн шөнийн нойрон дунд
Гүйгээд ирэх юм аав минь наддаа
Гийх үүрийн гэгээн цолмонгоор
Гэрт минь алга би зүүдэллээ
Буяныг дагсан буурал аав минь
Бурханы орондоо лавтай залраадаа

Бусдын төлөө энэрэнгүй сэтгэлээрээ
Буурай хүүгээ санаж л суунуу та
Эргэх орчлонгийн манан буданд
Эргүү хурга шиг төөрөх намайгаа
Элдэв раншинт энэхэн замбуу дээр
Эерэгээр хөтлөх бурхан л байжээ та
Хожимоо гэмших тэнэгхэн үр тань
Хойдын буянд нь суварга л бүтээлээ
Хойшдоо гэмшилгүй байхын төлөө
Хамтдаа л байхдаа ачийг нь хариулаарай
Энэхүү бэсрэг найраглал маань
Ээжий ааваа дурсах сэтгэл минь байлаа

Архангай Батцэнгэл сумын улсын сайн малчин
Т.Балжиржанцангийн хонио хариулж яваад сэтгэлд нь онгод орж
Улаанбаатар хотод байгаа надад утсаар хэлсэн шүлэг :

МӨСӨН ШАГАЙН ХАРВАА

Мөрөн тамирын гол нь
Мөсөө хадаан толиолоход
Мөрөөдөн хүлээсэн харваачид
Мөсөн дээрээ жаргалтай
Имэрч тавьсан захны
Исгэрэн шуугих чимээ
Эрчлэн оноход уухайлах нь
Эртний авиаг санагдуулам
Хоёр тамирын бэлчирт
Харваачид цугладаг жамтай
Хойд тамирын харваачид
Хол харвадаг нь учиртай
Улсын мэргэн харваачид
Уухай хадаан хурайлана
Урьд тамирын мэргэд
Удаа дараалан хушигдана
Гэрэл асааж харвадаг
Гэгээнтэн таалсан наадам
Гэгээ ормогц цуглардаг
Гийчин олонтой тэмцээн
Дуужаа харвадаг ахмад
Дурлаж ирсэн залуус
Лус савдагаа баярлуулж
Уул усаа цэнгүүлнэ



Батцэнгэл сумын 90 жилийн ойг тохиолдуулан
босгосон бүтээн байгуулалт

АГУЙТ ХАЛЗАН ХАЙРХАН

Архангай аймгийн Батцэнгэл сумын Цац багийн нутагт орших "Агуйт халзан" хэмээх уулын талаар цухас дурьдбаасуу:

Бурхан багш 2500 жилийн тэртээ Энэтхэгт тас цогцолсон ууланд билэг барамидын ном номлож байхад Архад Гамбуу бээр Дияан бясалгалд орж энэхүү агуйд ирт хувилгаанаар залран сууж байжээ. Тэгээд Бурханы гэгээнээс хойш 300 жилийн дараа 500 Архад цугларах гэтэл нэг Архад дутжээ. Түүнийг хаана байгааг сунтаг шүүлвээс энэхүү агуйд байна хэмээн мэдэж Архад нар ирж Дияанаас сэрээвээс: Даажамба Архад Гамбу бээр сэрээд Бурхан багш ямар ном номлож байна гэхэд нирваанаас хагацсаныг өчвөл, Монголжийбуу, Шаарийбуу нарыг асуув.

Бас л нирваан дүр барьсан гэхэд миний цаг болжээ хэмээн энэхүү агуйдаа нирваан дүр барьжээ.

Ганжуурын Винайн "Га" ботиос ишлэв.

Энэхүү адистэдтэй газарт нутгийн уугуул Д.Ганбаатарын гэр бүлээс бодь суврага бүтээн нирваан дүр барьсан аав Дэчинбалжир, ээж Долгор нарын хойдын буянд зориулан босгосон энэхүү бодь суварганд өглөгийн эзэн Давгадорж, Цэрэнчимэд нар хандив өргөн бүтээв.



Агуйн дотор талын байдал



Агуйн гадна талын байдал



Архангай аймаг, Батцэнгэл сум, Баян-Уул багийн Солбийн даваан дээрх Хүннүгийн үеийн овоонд Модун хааны 9 хөлт цагаан сүлдийг залж сэргээв.

With bad advisors forever left behind,
From paths of evil he departs for eternity,
Soon to see the Buddha of Limitless Light
And perfect Samantabhadra's Supreme Vows.

The supreme and endless blessings
of Samantabhadra's deeds,
I now universally transfer.
May every living being, drowning and adrift,
Soon return to the Pure Land of Limitless Light!

*** The Vows of Samantabhadra ***

I vow that when my life approaches its end,
All obstructions will be swept away;
I will see Amitabha Buddha,
And be born in His Western Pure Land of
Ultimate Bliss and Peace.

When reborn in the Western Pure Land,
I will perfect and completely fulfill
Without exception these Great Vows,
To delight and benefit all beings.

*** The Vows of Samantabhadra Avatamsaka Sutra ***

DEDICATION OF MERIT

May the merit and virtue
accrued from this work
adorn Amitabha Buddha's Pure Land,
repay the four great kindnesses above,
and relieve the suffering of
those on the three paths below.
May those who see or hear of these efforts
generate Bodhi-mind,
spend their lives devoted to the Buddha Dharma,
and finally be reborn together in
the Land of Ultimate Bliss.
Homage to Amita Buddha!

NAMO AMITABHA

南無阿彌陀佛

《外蒙文：宗教及佛教之發展》

財團法人佛陀教育基金會 印贈

台北市杭州南路一段五十五號十一樓

Printed and donated for free distribution by

The Corporate Body of the Buddha Educational Foundation

11F, No. 55, Sec. 1, Hang Chow South Road, Taipei, Taiwan, R.O.C.

Tel: 886-2-23951198 , Fax: 886-2-23913415

Email: overseas@budaedu.org

Website: <http://www.budaedu.org>

Mobile Web: m.budaedu.org

This book is strictly for free distribution, it is not to be sold.

ЗАРЖ БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО

Printed in Taiwan

3,500 copies; September 2018

MO036 - 16014